



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

СОЁЛЫН ЯАМ

СОЁЛЫН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЭМХЭТГЭЛ (цахим хувилбар)

2022 он

**СОЁЛЫН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ЭМХЭТГЭЛ**

№	Гарчиг	Дугаар
Нэг. СОЁЛЫН САЛБАРЫН ХУУЛЬ		
1.1.	Үндсэн хууль	4-19
1.2.	Соёлын тухай	20-34
1.3.	Соёлын өвийг хамгаалах тухай хууль	35-57
1.4.	Номын сангийн тухай хууль	58-65
1.5.	Монгол хэлний тухай	66-72
1.6.	Музейн тухай	73-78
1.7.	Кино урлагийг дэмжих тухай	79-87
Хоёр. СОЁЛЫН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОХ ХУУЛЬ		
2.1.	Авто замын тухай	88
2.2.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай	88-89
2.3.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай	89
2.4.	Амьтны тухай	89
2.5.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай	90
2.6.	Ахмад настны тухай	91
2.7.	Ашигт малтмалын тухай	91
2.8.	Аялал жуулчлалын тухай	91-92
2.9.	Бага, дунд боловсролын тухай	92
2.10.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай	92
2.11.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай	93
2.12.	Байгаль орчныг хамгаалах тухай	93
2.13.	Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай	94
2.14.	Барилгын тухай	94
2.15.	Биеийн тамир, спортын тухай	94
2.16.	Боловсролын тухай	94-95
2.17.	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай	95
2.18.	Гаалийн тухай	95
2.19.	Газрын тосны тухай	96
2.20.	Газрын төлбөрийн тухай	96
2.21.	Газрын тухай	96
2.22.	Газрын хэвлийн тухай	97
2.23.	Галт зэвсгийн албан татварын тухай	97
2.24.	Гамшгаас хамгаалах тухай	97
2.25.	Геодези, зураг зүйн тухай	98
2.26.	Гэр бүлийн тухай	98
2.27.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай	98
2.28.	Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай	99
2.29.	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай	99-100
2.30.	Зар сурталчилгааны тухай хууль	100-101
2.31.	Засгийн газрын тусгай сангийн тухай	101-102
2.32.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай	102-103
2.33.	Зөрчлийн тухай	103-106
2.34.	Зөвшөөрлийн тухай хууль	106
2.35.	Иргэний хууль	106-107
2.36.	Малын генетик нөөцийн тухай	107

2.37.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай	107-108
2.38.	Монгол Улсын батлан хамгаалах тухай	108
2.39.	Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай	108
2.40.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай	108-109
2.41.	Монгол Улсын засгийн газрын тухай	109-110
2.42.	Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай	110
2.43.	Монгол Улсын их хурлын тухай	110
2.44.	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай	110
2.45.	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай	110-111
2.46.	Монгол Улсын хилийн тухай	111
2.47.	Нийтийн сонголын тухай	111
2.48.	Нийгээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай	111
2.49.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай	111-112
2.50.	Олон нийтийн радио, телевизийн тухай	112
2.51.	Өргөн нэвтрүүлгийн тухай	112-113
2.52.	Өрсөлдөөний тухай	114
2.53.	Садар самуун явдалтай тэмцэх тухай	115-114
2.54.	Статистикийн тухай	114
2.55.	Тамхины хяналтын тухай	114-115
2.56.	Төр, сүм хийдийн харилцааны тухай	115
2.57.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай	115
2.58.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай	115-116
2.59.	Төсвийн тухай	116
2.60.	Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай	116-117
2.61.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай	117-111
2.62.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай	118-119
2.63.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай	119
2.64.	Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай	119
2.65.	Үндэсний аюулгүй байдлын тухай	120
2.66.	Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай	120
2.67.	Хот байгуулалтын тухай	120-121
2.68.	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай	121
2.69.	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай	121
2.70.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай	121-122
2.71.	Хөдөлмөрийн тухай	122
2.72.	Хувь хүний орлогын албан татварын тухай	122
2.73.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	122-123
2.74.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай	123
2.75.	Хүүхдийн эрхийн тухай	123
2.76.	Хүүхэд хамгааллын тухай	123
2.77.	Цагдаагийн албаны тухай	124
2.78.	Шинжлэх ухаан, технологийн тухай	124
2.79.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай	124
2.80.	Шүүхийн шинжилгээний тухай	124
2.81.	Эрдэнэсийн сангийн тухай	125
2.82.	Эрүүгийн хууль	126-127
2.83.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай	127

Гурав. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

3.1.	Монгол Улсын олон улсын гэрээ (Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай конвенц)	128-135
3.2.	Монгол Улсын олон улсын гэрээ (Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт)	136-140
3.3.	Монгол Улсын олон улсын гэрээ (Соёлын үнэт зүйлийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенц)	141-146
3.4.	Монгол Улсын олон улсын гэрээ (Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенц)	147-165
3.5.	Монгол Улсын олон улсын гэрээ (Зохиогчийн эрхийн тухай дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ)	166-171
3.6.	Монгол Улсын олон улсын гэрээ (Тоглолт болон дуу авианы бичлэгийн тухай дэлхийн өмчийн байгууллагын гэрээ)	172-178
3.7.	Монгол Улсын олон улсын гэрээ (Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцыг батлах тухай)	179-180
3.8.	Монгол Улсын олон улсын гэрээ (Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай)	181
3.9.	Монгол Улсын олон улсын гэрээ (Хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай марракешийн гэрээг соёрхон батлах тухай)	182-190

Дөрөв. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

4.1.	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай	190-202
4.2.	Улсын Их хурлын тогтоол- Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал батлах тухай	203-208
4.3.	Улсын Их хурлын тогтоол- “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай	209
4.4.	Монгол Улсын их хурлын тогтоол-Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай	210
4.5.	Монгол Улсын их хурлын тогтоол- Монгол Улсын засгийн газрын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай	211
4.6.	Монгол Улсын их хурлын тогтоол-Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай	212

Нэг. СОЁЛЫН САЛБАРЫН ХУУЛЬ**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ**

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Монголын ард түмэн бид:**-улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,****-хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,****-төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,****-хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,****-эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.****Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна.****НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
МОНГОЛ УЛСЫН БҮРЭН ЭРХТ БАЙДАЛ****Нэгдүгээр зүйл.**

- 1.Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.
- 2.Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.

Хоёрдугаар зүйл.

- 1.Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.
- 2.Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана.

Гуравдугаар зүйл.

- 1.Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.
- 2.Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно.

Дөрөвдүгээр зүйл.

- 1.Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна.
- 2.Монгол Улсын хилийг хуулиар бататгана.
- 3.Хууль гаргахгүйгээр гадаадын цэргийн хүчнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэхээр улсын хил нэвтрүүлэхийг хориглоно.

Тавдугаар зүйл.

- 1.Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.
- 2.Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.
- 3.Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.
- 4.Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.

5.Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна.

Зургадугаар зүйл.

- 1.Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.
- 2.Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн.

Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.

Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

[/Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан./](#)

3.Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй. Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно.

4.Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно.

5.Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.

Долдугаар зүйл.

- 1.Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.
- 2.Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн.

Наймдугаар зүйл.

- 1.Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн.
- 2.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө.

Есдүгээр зүйл.

- 1.Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ.
- 2.Төрийн байгууллага шашны, сүм хийд улс төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй.
- 3.Төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна.

Аравдугаар зүйл.

- 1.Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна.
- 2.Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.
- 3.Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.
- 4.Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй.

Арван нэгдүгээр зүйл.

- 1.Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.
- 2.Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно.

Арван хоёрдугаар зүйл.

- 1.Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал мөн.

2.Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ.

3.Төрийн сүлд нь ариун цагаан өнгийн бадам цэцэг суурьтай, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээгээр хөвөөлсөн, мөнх тэнгэрийг бэлгэдсэн дугариг хөх дэвсгэртэй байна. Сүлдний төв хэсэгт Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн алтан соёмбо, эрдэнийн хүлгийг хослуулан дүрсэлсэн байна. Сүлдний хүрээний магнайн хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийг бэлгэдсэн хүслийг хангагч чандмань эрдэнэ, доод хэсэгт эх газрыг төлөөлсөн ногоон өнгийн уулан хээ, ашид дэвжихийн өлзий хутаг оршсон хүрдийг тус тус дүрсэлнэ. Хүрдийг хадгаар дээдлэн сүлжсэн байна.

4.Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан туг нь Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл мөн.

5.Монгол Улсын төрийн далбаа нь улаан, хөх, улаан хосолсон өнгөтэй байна. Далбааны гурав хуваасны нэгийн хэмжээтэй дундах хэсэг нь мөнх тэнгэрийн хөх, түүний хоёр тал нь мандан бадрахын бэлгэдэл улаан өнгөтэй байна. Далбааны ишин талын улаан дэвсгэрийн төв хэсэгт алтан соёмбо байрлуулна. Далбааны өргөн, урт нь 1:2-ын харьцаатай байна.

6.Төрийн тамга дөрвөлжин хэлбэртэй, голдоо төрийн сүлдтэй, сүлдний хоёр талаар Монгол Улс гэсэн бичээстэй, арслангийн дүрс бүхий бариултай байна. Төрийн тамгыг Монгол Улсын Ерөнхийлөгч барина.

7.Төрийн бэлгэ тэмдгийг дээдлэн хэрэглэх журам, төрийн дууллын үг, аяг хуулиар бататгана.

Арван гуравдугаар зүйл.

1.Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн.

2.Монгол Улсын нийслэлийн эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

Арван дөрөвдүгээр зүйл.

1.Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

2.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.

Арван тавдугаар зүйл.

1.Монгол Улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно.

2.Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно.

Арван зургадугаар зүйл.

Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

1/амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно;

2/эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;

3/хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;

4/ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;

5/өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;

6/эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно;

7/сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;

8/соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;

9/шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;

10/нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;

11/улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;

12/төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;

13/халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;

14/Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;

15/шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй;

16/итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;

17/төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;

18/улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.

Арван долдугаар зүйл.

1.Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараахь үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ:

1/Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;

2/хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

3/хуулиар ногдуулсан албан татвар төлөх;

4/эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах.

2.Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.

Арван наймдугаар зүйл.

1.Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно.

2.Монгол Улс олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална.

3.Монгол Улс нутаг дэвсгэртээ байгаа харьяалалгүй хүний эрх, үүргийг өөрийн хуулиар тогтооно.

4.Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно.

5.Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болно.

Арван есдүгээр зүйл.

1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

2.Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.

3.Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.

Арван ес¹ дүгээр зүйл.

[Энэ зүйлийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн.](#)

1.Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.

2.Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна.

[Энэ хэсгийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

3.Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛ НЭГ. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

Хорьдугаар зүйл.

Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.

Хорин нэгдүгээр зүйл.

1.Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна.

2.Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

3.Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.

4.Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

[Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.](#)

Хорин хоёрдугаар зүйл.

1.Улсын нийт нутаг дэвсгэр буюу зарим хэсгийг нь хамарсан гэнэтийн аюул тохиолдсон, дайны ба нийтийн эмх замбараагүй байдал үүссэн зэрэг онцгой нөхцөлийн улмаас ээлжит сонгууль явуулах боломжгүй бол мөнхүү нөхцөл арилж, шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

2.Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзэж, эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөж санал болгосон бол Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар өөрөө тарах шийдвэр гаргаж болно.

[Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн бөгөөд уг нэмэлтийг Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон. Мөн хэсгийг 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн. Мөн хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.](#)

3.Ерөнхийлөгч Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд анх оруулснаас хойш дөчин тав хоногийн дотор, эсхүл Үндсэн хуулийн дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулснаас, түүнчлэн дөчин дөрөвдүгээр

зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцорсонд тооцсоноос хойш гуч хоногийн дотор Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилоогүй бол Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах шийдвэр гаргана.

[Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн.](#)

4.Энэ зүйлийн 2, эсхүл 3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр гаргаснаас хойш Улсын Их Хурал арав хоногийн дотор сонгуулийг товлон зарлаж, жар хоногийн дотор явуулна. Шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хадгална.

[Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн.](#)

Хорин гуравдугаар зүйл.

1.Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.

2.Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно.

Хорин дөрөвдүгээр зүйл.

1.Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно.

[Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан, 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Үндсэн Хуулийн Цэцийн 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон, 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.](#)

2.Улсын Их Хурлын дарга, дэд даргын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байх бөгөөд хуульд заасан үндэслэлээр хугацаанаас нь өмнө чөлөөлж, огцруулж болно.

Хорин тавдугаар зүйл.

1.Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:

1/хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

2/төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох;

3/Ерөнхийлөгчийн ба Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах;

4/Улсын Их Хурлын Байнгын хороо, Засгийн газар, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох, өөрчлөх;

5/Ерөнхийлөгчийг сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргах, чөлөөлөх, огцруулах;

6/Ерөнхий сайд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах;

[Энэ заалтад 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөлт оруулсан.](#)

7/ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах; Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.

Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно.

Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно;

[Энэ заалтыг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.](#)

8/хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах;

- 9/улсын хил тогтоох;
 10/Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг тогтоох;
 11/Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг батлах, өөрчлөх;
 12/нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох;
 13/улсын цол, одон, медаль, цэргийн дээд цол бий болгох, төрийн албаны зарим тусгай салбарын албан тушаалын зэрэг дэвийг тогтоох;
 14/өршөөл үзүүлэх шийдвэр гаргах;
 15/Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах;
 16/ ард нийтийн санал асуулга явуулах. Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд мөнхүү зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно; Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ;

[Энэ заалтад 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 2 дахь өгүүлбэр нэмсэн.](#)

- 17/Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд бусад улсаас аюул занал учруулж, зэвсэглэн халдвал дайн бүхий байдал зарлах, цуцлах;
 18/энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөлд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, эсхүл энэ тухай гаргасан Ерөнхийлөгчийн зарлигийг батлах, хүчингүй болгох.
 2.Дараахь онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно:
 1/улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон;
 2/Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон.
 3.Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь нийтийн эмх замбараагүй байдал үүсч, зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн, тийм мөргөлдөөн гарах бодит аюул бий болсон, бусад улсаас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан, эсхүл тийнхүү халдах нь бодитой болсон үед дайны байдал зарлаж болно.
 4.Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

Хорин зургадугаар зүйл.

1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно.

[Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.](#)

2.Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна.

3.Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол нийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

Хорин долдугаар зүйл.

- 1.Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.
 2.Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа далан таваас доошгүй ажлын өдөр чуулна.

[Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд үг өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон. Мөн хэсгийг 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан. Мөн хэсэгт 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөлт оруулсан.](#)

3.Улсын Их Хурлын гишүүдийн гуравны нэгээс дээшхийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын санаачилгаар ээлжит бус чуулган чуулж болно.

- 4.Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг сонгууль явуулсан өдрөөс хойш гуч хоногийн дотор Ерөнхийлөгч, бусад чуулганыг Улсын Их Хурлын дарга товлон зарлана.
 5.Ерөнхийлөгч онц болон дайны байдал зарлавал түүнээс хойш далан хоёр цагийн дотор Улсын Их Хурал онцгой чуулганаа тусгайлан товлохгүйгээр чуулна.
 6.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
 Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар хуулийг эцэслэн батална.

[Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд үг өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон. Мөн хэсгийг 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан. Мөн хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.](#)

7.Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хууль, бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн бол нууц санал хураалт явуулна.

[Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн.](#)

Хорин наймдугаар зүйл.

- 1.Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа зохих салбар, чиглэлээр Байнгын хороодтой байна.
 2.Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.
 Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

[Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.](#)

Хорин есдүгээр зүйл.

1.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.

[Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан, 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Үндсэн Хуулийн Цэцийн 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон, 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.](#)

2.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.

3.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.

[Энэ хэсэгт 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 1 дэх өгүүлбэр нэмсэн.](#)

ХОЁР.МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Гучдугаар зүйл.

- 1.Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.
 2.Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.

[Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.](#)

Гучин нэгдүгээр зүйл.

1.Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна.

2.Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлнэ.

3.Анхан шатны сонгуульд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож, Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн талаар саналаа нууцаар гаргана.

4.Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана.

5.Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхийн санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна. Дахин санал хураалтаар сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана.

6.Хэрэв хоёр дахь санал хураалтаар Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхийн санал аваагүй бол дахин сонгууль явуулна.

7. /Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хүчингүй болсонд тооцсон./

8.Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй. Хэрэв Ерөнхийлөгч өөр ажил, албан тушаал эрхэлж байгаа бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн уул үүргээс чөлөөлөгдөнө.

Гучин хоёрдугаар зүйл.

1.Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөснөөр эхэлж, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болно.

2.Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш гуч хоногийн дотор "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглая" хэмээн Улсын Их Хуралд тангараг өргөнө.

Гучин гуравдугаар зүйл.

1.Ерөнхийлөгч дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ;

2/ /Энэ заалтыг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд уг өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон. Мөн заалтыг 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан. Мөн заалтыг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хүчингүй болсонд тооцсон./

3/өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх. Энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно;

4/гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах;

5/Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах;

6/Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах;

7/улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах;

8/уучлал үзүүлэх;

9/Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэх;

10/Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх;

11/бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах;

12/Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь

онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгөх. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.

2.Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.

3.Ерөнхийлөгч Улсын Их Хуралд болон ард түмэндээ хандан илгээлт гаргаж, чуулганд өөрийн тааллаар оролцон улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлж, саналаа оруулж болно.

4.Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно.

[/Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан./](#)

Гучин дөрөвдүгээр зүйл.

1.Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд нийцүүлэн зарлиг гаргана.

2.Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Ерөнхийлөгч өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.

Гучин тавдугаар зүйл.

1.Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцна.

2.Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна.

Гучин зургадугаар зүйл.

1.Ерөнхийлөгчийн бие, өргөө, унаа халдашгүй дархан байна.

2.Ерөнхийлөгчийн нэр төр, халдашгүй байдлыг хуулиар хамгаална.

Гучин долдугаар зүйл.

1.Ерөнхийлөгчийг түр эзгүйд бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлнэ.

2.Ерөнхийлөгч огцорсон, нас нөгчсөн, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн бол Ерөнхийлөгч шинээр сонгогдож тангараг өргөх хүртэл бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн сонгуулийг дөрвөн сарын дотор зарлан явуулна.

3.Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэх журмыг хуулиар тогтооно.

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Гучин наймдугаар зүйл.

1.Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.

2.Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах;

2/шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх;

3/салбарын ба салбар хоорондын, түүнчлэн бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх;

4/хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах;

5/төрийн захиргааны төв байгууллагыг шуурхай удирдаж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;

6/улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах;

7/хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

8/төрийн гадаад бодлого хэрэгжүүлэх;

9/Улсын Их Хуралтай зөвшилцөж дараа соёрхон батлуулахаар Монгол Улсын олон улсын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, түүнчлэн Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, цуцлах.

3.Засгийн газрын тодорхой бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

Гучин есдүгээр зүйл.

[Энэ зүйлийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.](#)

1.Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.

[Энэ хэсгийн "... Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно." гэснийг 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсон.](#)

2.Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн олонхийг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг; бусад тохиолдолд Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхийг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна.

3.Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхий сайд энэ асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ.

4.Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.

Дөчдүгээр зүйл.

1.Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

2.Засгийн газрын бүрэн эрх Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно.

Дөчин нэгдүгээр зүйл.

1.Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.

2.Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана.

Дөчин хоёрдугаар зүйл.

Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.

Дөчин гуравдугаар зүйл.

[Энэ зүйлийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.](#)

1.Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи уг саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно.

2.Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.

Дөчин дөрөвдүгээр зүйл.

[Энэ зүйлийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.](#)

1.Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулбал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ.

2.Улсын Их Хурал тогтоолыг баталсан бол Ерөнхий сайдад итгэл үзүүлж, тухайн асуудлыг дэмжсэнд тооцно. Тогтоолыг батлаагүй бол Ерөнхий сайдыг огцорсонд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно.

Дөчин тавдугаар зүйл.

1.Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна.

2.Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.

Дөчин зургадугаар зүйл.

1.Монгол Улсын яам, төрийн бусад албан газрыг хуулийн дагуу байгуулна.

2.Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана.

3.Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно.

ДӨРӨВ. ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ

Дөчин долдугаар зүйл.

1.Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.

2.Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.

3.Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна.

Дөчин наймдугаар зүйл.

1.Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.

[Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.](#)

2.Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

3.Шүүх улсын төсвөөс санхүүжинэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.

Дөчин есдүгээр зүйл.

1.Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.

2.Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.

3.Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана.

4.Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ.

5.Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.

[Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.](#)

6.Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.

[Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн.](#)

Тавьдугаар зүйл.

1.Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэг, эрх зүйн маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

2/давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;

3/хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх;

4/Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;

5/хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх.

2.Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ.

3.Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй.

Тавин нэгдүгээр зүйл.

1.Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.

2.Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.

3.Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно.

4.Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.

Тавин хоёрдугаар зүйл.

1.Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.

2.Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна.

3.Хуульд тусгайлан зүйлчилж заасан зарим хэргийг шүүгч дангаар хянан шийдвэрлэж болно.

Тавин гуравдугаар зүйл.

1.Шүүн таслах ажиллагааг монгол хэлээр явуулна.

2.Монгол хэл мэдэхгүй хүнд хэргийн баримт сэлтийг хэлмэрчлүүлэн бүрэн танилцуулах бөгөөд шүүх хуралдаан дээр эх хэлээр нь үг хэлэх эрх олгоно.

Тавин дөрөвдүгээр зүйл.

Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэнэ.

Тавин тавдугаар зүйл.

1.Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй.

2.Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.

Тавин зургадугаар зүйл.

1.Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.

2.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.

3.Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА

Тавин долдугаар зүйл.

1.Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.

2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан./](#)

3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан, тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан./](#)

Тавин наймдугаар зүйл.

1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.

2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.

Тавин есдүгээр зүйл.

1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.

2.Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно.

[/Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан./](#)

3.Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно.

Жардугаар зүйл.

1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ.

2.Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно.

3.Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга доод шатныхаа нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална.

Жаран нэгдүгээр зүйл.

1.Засаг дарга тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцна.

2.Засаг дарга тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй.

3.Тавьсан хоригийг нь Хурал өөрийн төлөөлөгчдийн олонхийн саналаар няцаасан нөхцөлд Засаг дарга уул шийдвэрийг биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ зохих Хурал, Ерөнхий сайд буюу харьяалах дээд шатны Засаг даргад гаргаж болно.

4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар мөн. Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно.

Жаран хоёрдугаар зүйл.

1.Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.

2.Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд

байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.

3.Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад шилжүүлж болно.

Жаран гуравдугаар зүйл.

1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурал эрх хэмжээнийхээ дотор тогтоол, Засаг дарга захирамж гаргана.

2.Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байх бөгөөд түүнийг тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.

3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын эрх хэмжээ, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

ТАВДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

Жаран дөрөвдүгээр зүйл.

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.

2.Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.

3.Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.

Жаран тавдугаар зүйл.

1.Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.

2.Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно.

3.Үндсэн хуулийн цэцийн даргаар есөн гишүүний аль нэгийг гурван жилийн хугацаагаар гишүүдийн олонхийн саналаар сонгоно. Түүнийг нэг удаа улируулан сонгож болно.

4.Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн хууль зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно.

5.Үндсэн хуулийн цэцийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч орж үл болно.

Жаран зургадугаар зүйл.

1.Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.

2.Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна:

1/хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

2/ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

3/Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх;

4/Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана.

4.Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно.

Жаран долдугаар зүйл.

Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

Жаран наймдугаар зүйл.

1.Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.

2.Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно. Санал асуулгыг Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д заасан үндэслэлийн дагуу явуулна.

Жаран есдүгээр зүйл.

1.Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар батална.

2.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хуралд хоёр удаа авч хэлэлцэхэд ийнхүү нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн санал авч эс чадвал уул төслийг ээлжит сонгуулиар сонгогдсон Улсын Их Хурлын шинэ бүрэлдэхүүн ажлаа эхэлтэл дахин авч хэлэлцэхгүй.

3.Улсын Их Хурал ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно.

4.Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй байна.

Далдугаар зүйл.

1.Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.

2.Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны хоёрдугаар сарын 12-ны өдрийн 12 цаг буюу арван долдугаар жарны усан бичин жилийн хаврын тэргүүн хар барс сарын шинийн есний идрийн барилдлагаатай өлзийт сайн шар морин өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө.

Мэдэгтүн, сахигтун!

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРАЛ

1992 оны нэгдүгээр сарын 13-ны өдрийн 11 цаг 35 минут Улаанбаатар хот



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 сарын 02 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

СОЁЛЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төрөөс соёлын талаар баримтлах бодлого, зарчмыг тодорхойлж, соёлын үйл ажиллагаа эрхлэх, түүний удирдлага, зохион байгуулалт, оролцогчдын эрх, үүрэг, эдийн засгийн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Соёлын хууль тогтоомж

2.1.Соёлын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:
3.1.1."соёлын үнэт зүйл" гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах, эсхүл хүний оюун санаа, үйлдэхүйн үр дүнд бий болсон соёлын агуулга бүхий биет болон биет бус илэрхийллийг;
3.1.2."соёлын байгууллага" гэж энэ хуульд заасан журмын дагуу соёлын үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг;
3.1.3."соёлын ажилтан" гэж соёлын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хамт олон, бүлэг хүнийг;
3.1.4."соёлын бүтээгдэхүүн" гэж соёлын үнэт зүйл, түүнтэй холбоотой үйлчилгээг агуулсан, эдийн засгийн нэмүү өртөг шингэсэн биет болон биет бус зүйлийг;
3.1.5."соёлын үйлчилгээ" гэж арилжааны үнэ цэнээс үл хамааран, хүний соёлын хэрэгцээг хангах зорилгоор үзүүлж байгаа соёлын илэрхийллийг агуулсан үйлчилгээг;
3.1.6."соёлын бүтээлч үйлдвэрлэл" гэж хүний бүтээлч сэтгэлгээ, авьяас билэг, ур чадварын үр дүнд техник технологи, инновац, оюуны өмчид суурилсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох үйл явцыг;
3.1.7."уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлэг" гэж уран сайхны кино, теле жүжиг, телевизийн олон ангит кино, хөгжөөнт хөтөлбөр, тоглолт, баримтат болон хүүхэлдэйн кино, газар зүй, түүх, соёл, зан заншил, хэл зохиол, зан үйл, соёлын өвийг тайлбарлан таниулсан аливаа бүтээл ба сэтгүүл зүйн бусад төрлийн бүтээлийг;
3.1.8."үндэсний нэвтрүүлэг" гэж телевиз, радио, кабелийн сувгаар дамжуулж байгаа тухайн нэвтрүүлгийн зохиолч, ерөнхий найруулагч, продюсерын аль нэг нь Монгол Улсын иргэн байх, эсхүл зураг авалт, дуу бичлэг, сурвалжлах багийн бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байх бүх төрлийн бүтээлийг.

4 дүгээр зүйл.Төрөөс соёлын талаар баримтлах бодлого

4.1.Төрөөс соёлын талаар дараах бодлого хэрэгжүүлнэ:
4.1.1.соёлын өвийг төрийн онцгой анхаарал, ивээлд байлгах;

4.1.2.эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил зэрэг үндэсний үнэт зүйлийг эрхэмлэн хөгжүүлэх, нандигнан өвлүүлэх замаар үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх;
4.1.3.соёлын илэрхийллийн олон төрөлд хүндэтгэлтэй хандах, хамгаалах, дэмжих;
4.1.4.соёлын үнэт зүйлийг судлах, өвлөх, уламжлуулах нөхцөл бүрдүүлэх замаар соёлын дархлаа бүхий монгол хүнийг төлөвшүүлэх;
4.1.5.соёлын үнэт зүйлийг бүтээн туурвих таатай орчныг бий болгох, эдийн засаг, нийгмийн хөгжилд соёлын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, соёлын байгууллагын бие даасан, санхүүгийн тогтвортой байдлыг хангах;
4.1.6.хувь хүний бүтээлч хөгжил, авьяас, ур чадварыг хөгжүүлэхэд соёлын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, соёлын боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих, иргэнийг соён гэгээрүүлэх;
4.1.7.салбар хоорондын хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх, төр, хуулийн этгээд, иргэний нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх;
4.1.8.соёлын үйл ажиллагаа, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийг хөрөнгө оруулалт, зээл, татварын бодлого болон бусад хэлбэрээр дэмжих;
4.1.9.соёлын үнэт зүйлийг олон улсад нээлттэй сурталчлан таниулах.

5 дугаар зүйл.Соёлын бодлого, үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчим

5.1.Соёлын бодлого, үйл ажиллагаанд дараах үндсэн зарчим баримтална:
5.1.1.үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;
5.1.2.нэгдмэл цогц, харилцан уялдаатай, бүх нийтийн оролцоонд тулгуурласан байх;
5.1.3.төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах;
5.1.4.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн, дэвшилтэт техник технологи, инновацад тулгуурласан байх;
5.1.5.ил тод, нээлттэй байх;
5.1.6.тэгш, хүртээмжтэй байх;
5.1.7.соёлын үйл ажиллагааны чиглэл, хэлбэрийг хөндлөнгийн оролцоогүй, чөлөөтэй сонгох.

ХОЁРДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙГ ЭРХЛЭХ

6 дугаар зүйл.Соёлын үйл ажиллагаа

6.1.Соёлын үйл ажиллагаа соёлын үнэт зүйлийг бүтээн туурвих, судлан шинжлэх, хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэхтэй холбоотой бүхий л үйл ажиллагаанаас бүрдэнэ.
6.2.Соёлын үйл ажиллагаа бүх нийтийн оролцоонд тулгуурлана.

7 дугаар зүйл.Соёлын үйл ажиллагаанд оролцох, соёлын үйл ажиллагаа эрхлэх

7.1.Иргэн хуулиар хориглосноос бусад тохиолдолд соёлын үйлчилгээ, арга хэмжээнд чөлөөтэй оролцож, соёлын үйл ажиллагаа эрхэлнэ.
7.2.Соёлын байгууллагыг өмчийн аль ч хэлбэрт үндэслэн үүсгэн байгуулж болно.
7.3.Соёлын байгууллагыг Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу байгуулна.
7.4.Соёлын байгууллагын үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээг үүсгэн байгуулагч тогтооно.
7.5.Олон улсын байгууллага Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу салбар, төлөөлөгчийн газар байгуулсны үндсэн дээр Монгол Улсын нутаг дэвсгэрт соёлын үйл ажиллагаа эрхэлнэ.
7.6.Соёлын байгууллагыг үйл ажиллагааны чадавх, нөхцөлийг нь харгалзан Үндэсний соёлын байгууллагаар тогтооно. Үндэсний соёлын байгууллагад тооцох шалгуур үзүүлэлт, холбогдох журмыг Засгийн газар батална.
7.7.Үндэсний соёлын байгууллага өөрийн эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр соёлын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх мэргэшсэн байгууллага байна.
7.8.Үндэсний соёлын байгууллага Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд заасны дагуу соёлын болон эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхлэх бөгөөд дэргэдээ судалгааны нэгж, лаборатори ажиллуулж болно.

7.9.Гадаад улсад монголын соёлын төв байгуулах, Монгол Улсад гадаад улсын соёлын төв байгуулах асуудлыг Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд шийдвэрлэнэ.

8 дугаар зүйл.Төрөөс тусгайлан дэмжлэг үзүүлэх соёлын үйл ажиллагааны чиглэл

8.1.Байгаль орчин, уламжлалт ахуйтайгаа харилцан шүтэлцсэн нүүдлийн соёл иргэншлийн онцлогийг хадгалсан орон зай, газар нутгийг тогтоох, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

8.2.Нүүдлийн соёл иргэншлийн дурсгалт газарт уламжлалт ахуйг хамгаалах тааламжтай нөхцөлийг бүрдүүлж, хуульд зааснаас бусад дэглэмийг тогтоох, уламжлалт ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.

8.3.Монголын ард түмний оюун санааны нэгдмэл байдлыг илэрхийлэх бэлгэ тэмдэг болсон түүхэн суут хүний алдар, дүр төрхийг эрхэмлэн, хүндэтгэлтэй хандаж, хамгаалах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

8.4.Үндэсний өв уламжлал, гэр бүлийн соёл, хүмүүжлийн зан заншлыг эрхэмлэн, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх арга хэмжээг орон даяар зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

8.5.Монголын соёлын давтагдашгүй хэв шинж, уламжлалт мэдлэг, сэтгэлгээний илэрхийлэл болсон соёлын өвийг хамгаалж, баталгаажуулна.

8.6.Хүүхэд, залуучуудын авьяас, ур чадвар, бүтээлч үйл ажиллагааг урамшуулж, соёлын боловсрол олгох арга хэмжээг дэмжинэ.

8.7.Соёлын үнэт зүйлийг устах эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх, сэргээх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

9 дүгээр зүйл.Соёлын үйл ажиллагааны чиглэл

9.1.Соёлын үйл ажиллагааг дараах чиглэлээр явуулна:

9.1.1.соёлын өвийг хамгаалахтай холбоотой үйл ажиллагаа;

9.1.2.музейн үйл ажиллагаа;

9.1.3.номын сангийн үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагаа;

9.1.4.ном, утга зохиолын бүтээл туурвих, түгээхтэй холбоотой үйл ажиллагаа;

9.1.5.хөгжмийн урлагийн бүтээл туурвих, үйлдвэрлэх, түгээхтэй холбоотой үйл ажиллагаа;

9.1.6.тайзны урлагийн бүтээл туурвих, тоглох, түгээхтэй холбоотой үйл ажиллагаа;

9.1.7.дүрслэх урлаг, уран сайхны гэрэл зураг, гар урлал, хэрэглээний урлагийн бүтээл туурвих, түгээхтэй холбоотой үйл ажиллагаа;

9.1.8.кино урлаг, дуу-дүрсний уран бүтээл туурвих, түгээхтэй холбоотой үйл ажиллагаа;

9.1.9.интернэт орчин, тоон технологид суурилсан соёлын агуулга, харилцаа бүхий цахим уран бүтээл туурвих, түгээхтэй холбоотой үйл ажиллагаа;

9.1.10.дизайн, архитектурын бүтээл туурвихтай холбоотой үйл ажиллагаа;

9.1.11.соёл, урлагийн арга хэмжээ, тоглолт, наадам зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаа;

9.1.12.соёлын боловсрол олгохтой холбоотой үйл ажиллагаа;

9.1.13.соёл судлалын үйл ажиллагаа.

9.2.Соёлын өвийг хамгаалахтай холбогдсон харилцааг Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

9.3.Музейн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Музейн тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

9.4.Номын сангийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Номын сангийн тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

9.5.Кино урлагтай холбогдсон харилцааг Кино урлагийг дэмжих тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

10 дугаар зүйл.Соёл судлалын үйл ажиллагаа

10.1.Соёл судлалын үйл ажиллагаа нь соёлын үнэт зүйлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр танин мэдэх, хадгалж хамгаалах, бүтээн туурвих, судалгааны үр дүнг хэрэглээнд нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд чиглэгдэнэ.

10.2.Төрөөс соёл судлалын үйл ажиллагааг дэмжиж хөгжүүлнэ.

10.3.Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, арга хэмжээ нь соёл судлалын үйл ажиллагааны үр дүнд үндэслэнэ.

10.4.Соёлын салбарын хөгжлийн стратеги, төлөвлөлт, бодлогын суурь судалгаа хийх, судалгааны мэдээллээр хангах байгууллагыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллуулна.

11 дүгээр зүйл.Соёлын боловсрол олгох үйл ажиллагаа

11.1.Соёлын боловсрол хүнийг соён гэгээрүүлэх, авьяас, ур чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх, үндэсний соёлын үнэт зүйлийг эрхэмлэн дээдлэх, хүндэтгэх, хамгаалах дадал, чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

11.2.Хүүхэд өөрийн хүсэл, сонирхолд нийцсэн соёлын боловсрол эзэмших эрхтэй ба эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн хүсэл, сонирхолд нийцүүлж соёлын боловсрол олгох үүрэгтэй.

11.3.Соёлын боловсрол олгох үйл ажиллагааг боловсролын албан болон албан бус хэлбэрээр дамжуулж олгох зарчмыг баримтална.

11.4.Соёлын боловсрол олгоход дэмжлэг үзүүлэх арга хэмжээ, төлөвлөгөөг Засгийн газар батлах бөгөөд уг арга хэмжээ, төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгана:

11.4.1.иргэний соёлын боловсролыг дээшлүүлэх;

11.4.2.соёлын боловсрол олгох багшийг мэргэшүүлэх;

11.4.3.соёлын ажилтныг мэргэжил эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх;

11.4.4.соёлын боловсролын судалгаа, шинжилгээ явуулах;

11.4.5.соёлын боловсрол олгох сургалтын хөтөлбөр, агуулгыг тодорхойлох;

11.4.6.соёлын боловсрол олгох сургалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих;

11.4.7.соёлын боловсрол олгох төрийн өмчийн сургалтын байгууллагын барилга байгууламж, түүний ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээ, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх;

11.4.8.соёлын боловсролыг дэмжих бусад асуудал.

11.5.Боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн заавал судлах уран бүтээлийн жагсаалт, түүнийг судлахтай холбогдсон журмыг боловсролын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

11.6.Соёлын байгууллага өөрийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд соёлын боловсрол олгох хөтөлбөр, арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлнэ.

11.7.Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг сургалтын хөтөлбөр, агуулгад нь тусгагдсан соёлын боловсрол олгохтой холбоотой сургалтын орчин, техник, тоног төхөөрөмж, хүний нөөц, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах арга хэмжээг төрөөс авна.

12 дугаар зүйл.Соёлын үнэт зүйлийн бүртгэл

12.1.Соёлын үнэт зүйлийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах чиг үүргийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

12.2.Соёлын үнэт зүйлийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.3.Соёлын үнэт зүйлийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан соёлын үйл ажиллагааны чиглэл тус бүрээр төрөлжсөн мэдээллийн сангаас бүрдэх бөгөөд төрөлжсөн мэдээллийн сангийн үйл ажиллагааг холбогдох хууль болон энэ хуулийн 12.2-т заасан журмаар зохицуулна.

12.4.Гадаад улсад байгаа монголын түүх, соёлд холбогдох соёлын үнэт зүйлийг үндэсний бүртгэл, мэдээллийн санд бүртгэж болно.

13 дугаар зүйл.Соёлын үнэт зүйлийн үнэлгээ

13.1.Соёлын үнэт зүйлийг Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан журмын дагуу үнэлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ИРГЭН, СОЁЛЫН АЖИЛТНЫ ЭРХ, ҮҮРЭГ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ОЛОН НИЙГИЙН ОРОЛЦОО

14 дүгээр зүйл.Соёлын талаарх иргэний эрх, үүрэг

14.1.Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн соёлын талаар дараах эрх эдэлнэ:

- 14.1.1.авьяас, ур чадвар, уламжлалт мэдлэг, итгэл үнэмшилдээ тулгуурлан амьдралын хэв маяг, соёлын үйл ажиллагааны чиглэлийг чөлөөтэй сонгох;
 - 14.1.2.соёлын үнэт зүйлтэй танилцах, хүн төрөлхтний болон үндэсний соёл иргэншлийн ололт, соёлын үйл ажиллагааны үр шимийг хүртэх;
 - 14.1.3.уран бүтээлийн сэдэв, төрөл зүйл, арга барил, дэг сургууль, урсгал чиглэлийг чөлөөтэй сонгож, бүтээл туурвих, ур чадварынхаа нууцыг хамгаалуулах;
 - 14.1.4.соёлын үнэт зүйлийг бүтээн туурвих, соёлын үйл ажиллагаа эрхлэх, тэдгээрийн үр шимийг хүртэх;
 - 14.1.5.Монгол Улсын болон тухайн улсын хууль тогтоомжоор хориглосноос бусад соёлын үйл ажиллагааг гадаад улсад явуулах, түүнд оролцох;
 - 14.1.6.эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил, үнэт зүйлийг өвлөн хөгжүүлэх;
 - 14.1.7.соёлын байгууллагын үйл ажиллагаанд оролцох, хамтарч ажиллах;
 - 14.1.8.соёлын үйл ажиллагаа эрхлэх, эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах зорилгоор төрийн бус байгууллага байгуулах, эвлэлдэн нэгдэх.
- 14.2.Монгол Улсын иргэн соёлын талаар дараах үүрэг хүлээнэ:
- 14.2.1.эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил, үнэт зүйлийг хамгаалах, хойч үедээ өвлүүлэх;
 - 14.2.2.соёлын илэрхийллийн олон төрлийг хүндэтгэх, соёлын үнэт зүйлийг хамгаалах;
 - 14.2.3.гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэн хөгжүүлж, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх;
 - 14.2.4.соёлын үнэт зүйлийг хууль бус халдлагаас хамгаалах.
- 14.3.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн 14.2.2, 14.2.4-т заасан үүрэг хүлээнэ.

15 дугаар зүйл.Соёлын ажилтны эрх, үүрэг

- 15.1.Соёлын ажилтан дараах эрх эдэлнэ:
- 15.1.1.хууль тогтоомжийн хүрээнд соёлын үйл ажиллагаа эрхлэх нөхцөл, бололцоогоор хангуулах;
 - 15.1.2.төрийн болон төрийн бус байгууллага, түүний удирдлага, иргэнд эрхэлж байгаа соёлын үйл ажиллагааны чиглэлийн асуудлаар зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, шаардлага тавих;
 - 15.1.3.соёл, урлагийн наадам, уралдаан, тэмцээнд оролцох;
 - 15.1.4.мэргэжлийн төрийн бус байгууллагад гишүүнээр элсэх;
 - 15.1.5.уран бүтээлээ бодитойгоор үнэлүүлж, тохирсон шагнал, урамшуулал хүртэх, хөнгөлөлт эдлэх;
 - 15.1.6.мэдлэг боловсрол, ур чадвараа бие даан болон байгууллагын дэмжлэгтэйгээр дээшлүүлэх, давтан сургалтад хамрагдах;
 - 15.1.7.уран бүтээл туурвихдаа архив, номын сангийн үйлчилгээг чөлөөтэй авах;
 - 15.1.8.албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөлөөр хангуулах, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх;
 - 15.1.9.оюуны өмч, зохиогчийн эрхээ хамгаалах, эрх бүхий байгууллагын дэмжлэг, туслалцаа авах.
- 15.2.Соёлын ажилтан дараах үүрэг хүлээнэ:
- 15.2.1.мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх;
 - 15.2.2.эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил, үнэт зүйлийг хамгаалах, хойч үедээ өвлүүлэхэд идэвх санаачилгатай ажиллах;

- 15.2.3.оролцож байгаа соёлын арга хэмжээний журам болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;
- 15.2.4.эрхэлж байгаа чиглэлийн хүрээнд соёлын үйлчилгээ хүргэх, иргэнийг соён гэгээрүүлэх, соёлын боловсрол олгох чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах;
- 15.2.5.эрдэм шинжилгээний ажил эрхлэх;
- 15.2.6.соёлын үйлчилгээг мэргэжлийн түвшинд чанартай хүргэх;
- 15.2.7.соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэхэд аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах.

16 дугаар зүйл.Соёлын үйл ажиллагааг дэмжих талаарх аж ахуйн нэгж, байгууллагын оролцоо

- 16.1.Соёлын үйл ажиллагааг дэмжих талаар аж ахуйн нэгж, байгууллага дараах хэлбэрээр оролцоотой байна:
- 16.1.1.соёлын илэрхийллийн олон төрлийг хүндэтгэх, соёлын үнэт зүйлийг хадгалж хамгаалах;
 - 16.1.2.ажиллагсдын урлаг, уран сайхны мэдрэмж, авьяас, ур чадварыг хөгжүүлэх, соёлын боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулах, шаардагдах хөрөнгийг жил бүр төсөв, төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх;
 - 16.1.3.ажиллагсдын оюуны болон соёлын хэрэгцээг хангах зорилгоор соёлын үйлчилгээ явуулах, соёлын үйл ажиллагаа эрхлэх нэгж байгуулж, ажиллуулах;
 - 16.1.4.соёлын үйл ажиллагаанд тусламж, дэмжлэг үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулалт хийх, хандив өгөх;
 - 16.1.5.үйлдвэрлэл, үйлчилгээний соёл, гоо зүй, дизайн бүхий орчныг бүрдүүлж, хөгжүүлэх.
- 16.2.Аж ахуйн нэгж, байгууллага тухайн орон нутгийн соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг тэргүүн ээлжид худалдан авах зарчмыг баримтална.

17 дугаар зүйл.Соёлын үйл ажиллагааг дэмжих талаарх төрийн бус байгууллагын оролцоо

- 17.1.Соёлын үйл ажиллагааг дэмжих талаар мэргэжлийн төрийн бус байгууллага дараах үйл ажиллагааг явуулж болно:
- 17.1.1.соёлын хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
 - 17.1.2.соёлын илэрхийллийн олон төрөл, үндэсний соёлын үнэт зүйлийг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах;
 - 17.1.3.соёлын боловсрол олгох ажлыг дангаар болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулах.
- 17.2.Соёлын үнэт зүйлийг ашиглах, хамгаалах онцгой эрхийг хэрэгжүүлэх зорилго бүхий ашгийн төлөө бус хамтын удирдлагын байгууллагын саналыг салбарын хууль тогтоомж боловсруулахад харгалзан үзэж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж болно.

18 дугаар зүйл.Соёлын байгууллагын эрх, үүрэг, удирдлага

- 18.1.Соёлын байгууллага дараах нийтлэг эрх, үүрэгтэй:
- 18.1.1.хуулиар хориглосноос бусад үйл ажиллагааны чиглэл, төрлийг чөлөөтэй сонгох, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх;
 - 18.1.2.дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрт хамрагдах, бусад байгууллагатай мэргэжлийн чиглэлээр хамтран ажиллах;
 - 18.1.3.соёлын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн ур чадвар, үйлчилгээний стандарт хангасан түвшинд явуулах;
 - 18.1.4.төсөв, төсөл болон хандивын хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах;
 - 18.1.5.соёлын ажилтны ур чадвар, мэргэжлийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг нь хангах;
 - 18.1.6.зориулалтын барилга байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь эрүүл ахуйн болон стандартын шаардлага хангасан, соёлын ажилтны хөдөлмөрийн онцлогт тохирсон, аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрдүүлсэн байх;
 - 18.1.7.соёлын үйл ажиллагааны стандартыг мөрдөн ажиллах;
 - 18.1.8.үйл ажиллагааны чиглэл, статистик мэдээллийг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх.
- 18.2.Аймаг, нийслэлийн соёлын газрын удирдлагыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

18.3.Төрийн өмчийн соёлын байгууллагын удирдлагыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн соёлын байгууллагын удирдлагыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга, сум, дүүргийн соёлын байгууллагын удирдлагыг аймаг, нийслэлийн соёлын газрын удирдлагатай зөвшилцөн сум, дүүргийн Засаг дарга тус тус томилж, чөлөөлнө.

18.4.Энэ хуулийн 18.3-т зааснаас бусад соёлын байгууллагын удирдлагыг үүсгэн байгуулагч нь томилж, чөлөөлнө.

18.5.Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллага нь мэргэжлийн холбоод, иргэний төлөөллийг оролцуулсан олон нийтийн зөвлөлтэй байж болно. Олон нийтийн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ СОЁЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮРЭН ЭРХ

19 дүгээр зүйл.Соёлын үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо

19.1.Соёлын үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо нь Засгийн газар, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, соёлын байгууллагын удирдлагаас бүрдэнэ.

20 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

20.1.Монгол Улсын Засгийн газар соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 20.1.1.соёлын хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;
- 20.1.2.соёлын төлөв байдлын тайланг хоёр жил тутам Улсын Их Хуралд танилцуулах;
- 20.1.3.соёлын цогцолбор байгуулж хөгжүүлэх, үйл ажиллагааг нь зохион байгуулах;
- 20.1.4.хүүхдийн соёл, урлагийн цогцолбор байгуулах, хүүхдэд зориулсан уран бүтээлийг дэмжих;
- 20.1.5.соёлын үйл ажиллагааны чиглэлээр хөтөлбөр, арга хэмжээ, төлөвлөгөөг батлах;
- 20.1.6.үндэсний бахархлыг тодорхойлох, тогтоох;
- 20.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

21 дүгээр зүйл.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

21.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 21.1.1.соёлын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;
- 21.1.2.хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд соёлын үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журмыг баталж, хэрэгжүүлэх;
- 21.1.3.соёлын үйл ажиллагааны чиглэлээр захиалгат судалгаа, шинжилгээ хийх, инновац нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- 21.1.4.соёлын барилга байгууламж, техник, тоног төхөөрөмж, үйлчилгээний орчны шаардлагыг боловсруулж, батлуулах;
- 21.1.5.соёлын байгууллагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх;
- 21.1.6.төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллагын оновчтой тогтолцоо, бүтцийг бий болгож ажиллуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах;
- 21.1.7.соёлын гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, соёлын үнэт зүйлийг сурталчлах ажлыг зохион байгуулах;
- 21.1.8.соёлын салбарт хүний нөөц бэлтгэх, соёлын байгууллагыг мэргэжлийн ажиллах хүчнээр хангахад дэмжлэг үзүүлэх;

21.1.9.соёлын ажилтны нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх;

21.1.10.соёл судлалын үйл ажиллагааг дэмжих;

21.1.11.соёлын боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулах;

21.1.12.хуульд заасан бусад бүрэн эрх.

22 дугаар зүйл.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

22.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 22.1.1.соёлын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;
- 22.1.2.дайн, түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан соёлын үйл ажиллагаа эрхлэхийг хориглох арга хэмжээг авах;
- 22.1.3.соёлын статистик мэдээллийг нэгтгэн гаргаж, дүн шинжилгээ хийх;
- 22.1.4.соёлын үнэт зүйлийг хадгалах, хамгаалах ажлыг зохицуулах, үндэсний соёл, дизайны уламжлалыг дэмжин хөгжүүлэх;
- 22.1.5.түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах болон дотоод, гадаадад үзэсгэлэн гаргахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих;
- 22.1.6.соёлын салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах;
- 22.1.7.соёл, урлагийн мэргэжлийн холбоод, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- 22.1.8.хуульд заасан бусад бүрэн эрх.

23 дугаар зүйл.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

[/Энэ зүйлийн гарчигт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

23.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

- 23.1.1.харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд соёлын боловсрол олгох, орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр баталж, хэрэгжилтийг хангуулах;
- 23.1.2.тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд соёлын талаар дэвшүүлсэн зорилтын биелэлтийг дүгнэж, хөгжлийн хэтийн төлөв байдлыг тодорхойлж, хяналт тавих;
- 23.1.3.уран бүтээл туурвихад бүх талын дэмжлэг үзүүлэх.

24 дүгээр зүйл.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

[/Энэ зүйлийн гарчигт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

24.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

- 24.1.1.орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, брэнд бий болгох, баяжуулан хөгжүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах;
- 24.1.2.орон нутгийн өмчийн соёлын байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах.

25 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн соёлын газар, сум, дүүргийн соёлын төв, соёлын ордны чиг үүрэг

25.1.Аймаг, нийслэлийн соёлын газар соёлын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 25.1.1.соёлын хууль тогтоомжийн дагуу соёл, урлагийг хөгжүүлэх, иргэний соёлын эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 25.1.2.соёлын байгууллагын үйл ажиллагааг зохицуулж, хууль тогтоомжид заасны дагуу төрөөс санхүүжүүлэх, тэдгээрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх, ажиллагсдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээг авах;

- 25.1.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан соёлын зорилтыг хэрэгжүүлэх ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах;
- 25.1.4.харьяалах нутаг дэвсгэрийн соёлын байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих;
- 25.1.5.соёлын статистик мэдээлэл, соёлын байгууллагын тайланг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэх.
- 25.2.Сум, дүүргийн соёлын төв, соёлын ордон нь тухайн орон нутгийн иргэний соёлын үйл ажиллагаа эрхлэх, бүтээл туурвих, соёлын ололт, үр шимийг хүртэх нөхцөлийг хангах, орон нутгийн байгаль, түүх, соёлын үнэт зүйлийг сурталчлах, номын сангийн үйлчилгээ хүргэх чиг үүрэгтэй соёлын боловсрол олгох анхан шатны байгууллага бөгөөд соёл, мэдээллийн төв байна.
- 25.3.Сум, дүүргийн соёлын төв, соёлын ордны үйл ажиллагааны жишиг дүрмийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 25.4.Энэ хуулийн 25.2-т заасан байгууллага үйл ажиллагаагаа дангаараа болон бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, олон нийтийн төлөөлөлтэй хамтран явуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН САЛБАРЫН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

26 дугаар зүйл.Соёлын салбарын түншлэл

- 26.1.Соёлын салбарын түншлэл нь соёлын үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүх хэлбэрийг хангасан байх ба оюуны бүтээлч үйл ажиллагаа, санхүү, шинжлэх ухаан, технологийн болон хүний нөөцийг багтаасан, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэний үр ашигтай, хамтын ажиллагааг дэмжихэд чиглэгдэнэ.
- 26.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын салбарын бүтээн байгуулалтад болон нийгмийн ач холбогдол бүхий, эсхүл хувийн хэвшил дангаараа хэрэгжүүлэх боломжгүй, төрийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулахыг төрөөс дэмжинэ.
- 26.3.Энэ хуулийн 26.2-т заасан төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг Засгийн газар батална.
- 26.4.Соёлын салбарын зарим ажил, үйлчилгээг мэргэжлийн төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлж болох бөгөөд уг байгууллагад тавих нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт болон холбогдох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

27 дугаар зүйл.Олон улсын хамтын ажиллагаа

- 27.1.Олон улсын хамтын ажиллагааг дараах чиглэлээр дэмжиж, хөгжүүлнэ:
- 27.1.1.монголын түүх, соёлд холбогдох соёлын өвийг сурвалжлан олох, судалж шинжлэх, хадгалж хамгаалах талаар уг өв байгаа улстай хамтран ажиллах;
- 27.1.2.монголын түүх, соёлд холбогдох соёлын үнэт зүйлийн хуулбарыг авчрах;
- 27.1.3.хууль бусаар алдагдсан соёлын өвийг эргүүлэн авчрах;
- 27.1.4.монголын түүх, соёлыг гадаадад сурталчлах;
- 27.1.5.соёлын биет өвийг сэргээн засварлах;
- 27.1.6.уран бүтээл хамтран бүтээх, солилцох;
- 27.1.7.соёлын ажилтныг сургах, мэргэшүүлэх;
- 27.1.8.соёлын үйл ажиллагаанд шинэ техник технологи, инновац, тоног төхөөрөмж нэвтрүүлэх;
- 27.1.9.соёлын боловсрол олгох сургалтын арга зүй, сургалтын хөтөлбөрийг харилцан солилцох.
- 27.2.Төрийн холбогдох байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд энэ хуулийн 27.1-д заасан чиглэлийн дагуу үйл ажиллагаа эрхэлнэ.

28 дугаар зүйл.Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын иргэнийг соёлын үйл ажиллагаанд оролцуулах

- 28.1.Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын иргэнд эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил, соёлын үнэт зүйлийг таниулахад чиглэсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг гадаад харилцаа, санхүү, төсвийн болон соёл, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж, хэрэгжүүлнэ.
- 28.2.Олон улсад танигдсан, гадаад улсад соёлын үйл ажиллагаа эрхэлж байгаа Монгол Улсын иргэнийг эх орондоо соёлын үйл ажиллагаа эрхлэх, хамтарч уран бүтээл туурвихад төрийн болон төрийн бус байгууллага, соёлын байгууллага дэмжиж ажиллана.
- 28.3.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд гадаад улсад соёлын үйл ажиллагаа эрхлэхэд төрийн холбогдох байгууллага зохион байгуулалт, санхүүгийн болон бусад дэмжлэгийг үзүүлж болно.

29 дүгээр зүйл.Соёлын үйл ажиллагааг олон улсад сурталчлахад иргэнийг оролцуулах

- 29.1.Монгол Улсын соёлын үнэт зүйл, соёлын үйл ажиллагааг сурталчлах, олон улсын дэмжлэгийг татах зорилгоор урлаг, спорт, шинжлэх ухааны болон бусад салбарын нэр хүндтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн иргэнийг хоёр жилийн хугацаатайгаар соёлын элчээр томилон ажиллуулж болно.
- 29.2.Соёлын элчийн ажиллах журмыг Засгийн газар батална.

30 дугаар зүйл.Соёлын орчин, орон зайг хөгжүүлэх

- 30.1.Аймаг, сум, нийслэл, дүүрэгт түүх, соёл, урлаг, эсхүл соёлын үнэт зүйлийг төлөөлж, илэрхийлэх соёлын орчин, орон зайг бүрдүүлж, хөгжүүлнэ.
- [/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 30.2.Энэ хуулийн 30.1-д заасан соёлын орчин, орон зайг бүрдүүлэх, хөгжүүлэх чиг үүргийг Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллага хэрэгжүүлнэ. Иргэн, хуулийн этгээд соёлын орчин, орон зайг бий болгох, санал санаачилгыг гаргаж, тухайн шатны Засаг даргад уламжлан шийдвэрлүүлнэ.
- [/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 30.3.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн онцлог бүхий соёлын орчин, орон зайг тодорхойлж, хот, суурин газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж, батална.
- 30.4.Түүх, урлаг,уран сайхны үнэт ач холбогдолтой, эсхүл өвөрмөц хийцтэй, үндэсний хэв загварыг хадгалсан салангид буюу цогцолбор барилга байгууламж, түүний тодорхой хэсэг, хөшөө, сүрлэг чимэглэлийн уран баримал, уран зургийн бүтээлийг хадгалж, хамгаална.
- 30.5.Энэ хуулийн 30.4-т заасан барилга байгууламж, хөшөө, урлагийн бүтээлийн жагсаалтыг Засаг даргын санал, эрдэм шинжилгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ЭДИЙН ЗАСАГ, ҮЙЛДВЭРЛЭЛ

31 дүгээр зүйл.Өмч

- 31.1.Соёлын байгууллагын өмчтэй холбогдсон харилцааг Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна.
- 31.2.Соёлын зориулалтаар ашиглаж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламж, эзэмшил газрыг тухайн байгууллагын үндсэн чиг үүрэгт нь харшлах өөр зориулалтаар ашиглуулах, эзэмшүүлэхийг хориглоно.

32 дугаар зүйл.Соёлын үйл ажиллагааны санхүүжилт

- 32.1.Соёлын үйл ажиллагааны санхүүжилтийн тогтолцоо нь иргэнд тэгш, хүртээмжтэй, чанартай соёлын үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэнэ.
- 32.2.Соёлын үйл ажиллагааны төсөв нь улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын хандив, соёлын байгууллагын төлбөртэй үйлчилгээ, дотоод, гадаадад зохион байгуулсан соёл, урлагийн арга хэмжээнээс олсон орлого, өөрийн үйл ажиллагааны орлого, хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.
- 32.3.Соёлын үйл ажиллагааны зардлыг улсын болон орон нутгийн төсөвт бие даасан хөтөлбөр болгож батална.

32.4.Төрийн өмчит соёлын байгууллагын улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийг өөрийн үйл ажиллагааны орлого болон байгууллага, иргэний хандивын хэмжээгээр багасгаж төлөвлөх, соёлын үйл ажиллагаанд зориулсан төсвийн хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

32.5.Төрийн өмчийн соёлын байгууллагаас бусад ашгийн төлөө бус соёлын байгууллагад тодорхой төслийг үндэслэн төрөөс санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлж болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

32.6.Соёлын үйл ажиллагааг дэмжих, соёлын өвийг хамгаалах зорилгоор иргэн, хуулийн этгээдээс оруулсан хандив, хөрөнгө оруулалтад албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх журмыг холбогдох хуулиар тогтооно.

32.7.Хөгжим, дүрслэх урлаг, утга зохиолын шилдэг бүтээлийг улсын санд худалдан авна. Шилдэг бүтээл шалгаруулах, худалдан авах, хадгалах, ашиглах журмыг Засгийн газар батална.

32.8.Үндэсний болон сонгодог урлагийн бүтээл, хүүхдэд зориулсан уран бүтээлд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

32.9.Соёлын ажилтныг олон улсын хэмжээний соёл, урлагийн наадам, уралдаан тэмцээнд оролцоход төрөөс дэмжлэг үзүүлж, онцгой амжилт гаргасан соёлын ажилтанд мөнгөн шагнал олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

32.10.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага соёлын үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг ивээн тэтгэж болно.

32.11.Нийтийн ашиг тусын тулд чиглэсэн соёлын үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах дотоодод үйлдвэрлэдэггүй тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, түүхий эд материал, урвалж бодисыг улсын хилээр нэвтрүүлэхэд татвараас хөнгөлж, чөлөөлнө.

32.12.Соёлын арга хэмжээний шагналын орлогыг татвараас чөлөөлнө.

32.13.Энэ хуулийн 32.11, 32.12-г заасан татвараас хөнгөлж, чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

33 дугаар зүйл.Соёлын ажилтны үнэлэмж, нийгмийн баталгаа

33.1.Соёлын салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө, арга хэмжээг Засгийн газар батална.

33.2.Соёлын ажилтан соёлын үйл ажиллагаа эрхлэн, үүсгэн байгуулагчаас тогтоосон цалин, нэмэгдэл хөлс авна.

33.3.Соёлын ажилтанд мэргэшлийн зэрэг, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

33.4.Мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох хөрөнгийг үүсгэн байгуулагч өөрийн байгууллагын төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

33.5.Соёлын ажилтан хөдөлмөрийн шинж чанар, мэргэжлийн онцлогт тохирсон цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, нөхөх олговор, шагнал урамшуулал авч, хуульд заасан бусад хөнгөлөлт эдэлнэ.

33.6.Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллагын ажилтны нэмэгдэл хөлс, нийгмийн баталгааг Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулиар зохицуулна.

33.7.Энэ хуулийн 33.6-д зааснаас бусад соёлын байгууллагын ажилтны нийгмийн баталгааг үүсгэн байгуулагч хариуцна.

33.8.Соёлын ажилтан ажлын онцлогоос хамаарч мэргэжлийн хөдөлмөрийн чадвараа эрт алдсан тохиолдолд түүний хүсэлтийг нь үндэслэн дотоодын их, дээд сургууль, урт, дунд, богино хугацааны тусгай мэргэжил эзэмших сургалтын зардлыг төр хариуцна.

33.9.Тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд 5 жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгоно.

34 дүгээр зүйл.Соёлын бүтээлч үйлдвэрлэл, үйлчилгээ

34.1.Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийг Засгийн газар батална.

34.2.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийг тогтооход дэвшилтэт технологи, инновацад суурилсан үндэсний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, экспортлоход чиглүүлэх, нөөцийг оновчтой байршуулах, төрийн дэмжлэгийн үр ашгийг нэмэгдүүлэх зарчмыг баримтална.

34.3.Төрөөс соёлын бүтээлч үйлдвэрлэлд дараах дэмжлэг үзүүлнэ:

34.3.1.соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх;

34.3.2.соёлын бүтээлч үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт төвлөрүүлэх, дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох;

34.3.3.инновац шингэсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

34.3.4.соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

34.3.5.соёлын арга хэмжээ, соёлын бараа, үйлчилгээг үйлдвэрлэх, түгээх, хуваарилах арга хэлбэрийг сайжруулж, хүртээмжтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлэх.

34.4.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээг Засгийн газар батална.

34.5.Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллага Төсвийн тухай хуульд нийцүүлэн худалдаа, үйлчилгээ эрхэлж болно.

35 дугаар зүйл.Мерчандайзийн гэрээ

35.1.Иргэний хуулийн 338¹ дүгээр зүйлийн дагуу мерчандайзийн гэрээгээр өмчлөгч, түүний зөвшөөрснөөр эзэмшигч соёлын үнэт зүйлийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг үйлдвэрлэгч, борлуулагчид олгох ба үйлдвэрлэгч, борлуулагч нь үйл ажиллагаа явуулж, эзэмшигчид борлуулалтын орлогоос соёлын үнэт зүйл ашигласны төлбөр төлөх үүрэг хүлээнэ.

35.2.Мерчандайз нь зохиогчийн эрх, барааны тэмдэг, бүтээгдэхүүний загварын эрхээр хамгаалагдана.

35.3.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг олгоно:

35.3.1.төрийн өмчийн соёлын байгууллагын эзэмшиж байгаа соёлын үнэт зүйл, урлагийн бүтээл, соёлын биет өв;

35.3.2.төрийн өмчийн музейд хадгалагдаж байгаа үзмэр;

35.3.3.түүх, соёлын үл хөдлөх дурсгал.

35.4.Энэ хуулийн 35.3-т зааснаас бусад орон нутгийн өмчийн соёлын үнэт зүйл, урлагийн бүтээлийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг тухайн шатны Засаг дарга олгоно.

35.5.Энэ хуулийн 35.3-т зааснаас бусад төрийн өмчийн байгууллагын эзэмшиж байгаа соёлын үнэт зүйл, урлагийн бүтээлийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

35.6.Хууль, гэрээнд өөрөөр заагаагүй бол мерчандайзийн гэрээг Иргэний хуулийн дагуу бичгээр байгуулж, дараах зүйлийг тусгана:

35.6.1.мерчандайзийн зүйлийн хэмжээ, загвар, өнгө, материалын дэлгэрэнгүй тодорхойлолт;

35.6.2.мерчандайзийн гэрээний дагуу үйлдвэрлэх, борлуулах бүтээгдэхүүний тоо хэмжээ;

35.6.3.үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах борлуулагч, борлуулах цэгийн мэдээлэл;

35.6.4.мерчандайзийн зүйлийг үйлдвэрлэх, борлуулахад шаардлагатай санхүүжилтийн хэлбэр, нөхцөл;

35.6.5.мерчандайзийн зүйлийг гэрээнд заасны дагуу үйлдвэрлэх, борлуулах болон чанарын баталгаа;

35.6.6.загвар ашигласны төлбөрийн хэмжээ, нөхцөл;

35.6.7.мерчандайзийн гэрээний хугацааг сунгах, гэрээний эрх, үүргийг шилжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, мерчандайзийн гэрээ ба холбогдох бусад гэрээ хоорондын харилцаа, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, үүргээ биелүүлээгүй тохиолдол, гэрээ цуцлах, дуусгавар болох үндэслэл, маргаан шийдвэрлэх журам;

35.6.8.талууд харилцан тохиролцсон бусад зүйл.

36 дугаар зүйл.Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөр, хөнгөлөлт

36.1.Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллага нь бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрийн хэмжээг үүсгэн байгуулагчтай зөвшилцсөний үндсэн дээр тогтооно.

36.2.Энэ хуулийн 36.1-д зааснаас бусад соёлын байгууллага бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ төлбөрийг өөрөө бие дааж тогтооно.

36.3.Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллага нь хүүхэд, өндөр настан, хугацаат цэргийн алба хаагч, хөгжлийн бэрхшээлтэй хүний соёлын үйл ажиллагаанд оролцох сонирхлыг нь дэмжих бөгөөд төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ЗӨВШӨӨРӨЛ, ХЯНАЛТ, ХЯЗГААРЛАЛТ

37 дугаар зүйл.Соёлын үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага

37.1.Соёлын үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн эрхэлнэ.

37.2.Соёлын байгууллагын үйлчилгээний болон барилга байгууламж, орчны стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу боловсруулан баталж, мөрдүүлнэ.

37.3.Соёлын үйлчилгээ эрхлэх барилга байгууламж, танхим, талбай нь стандарт, эрүүл ахуйн болон хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байна.

37.4.Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын үйлчилгээ үзүүлэх барилга байгууламж, талбайн зориулалтыг өөрчлөхийг хориглоно. Хувьчлах болон тухайн барилга байгууламж, талбайг буулгаж, шинээр барих тохиолдолд зориулалтыг хэвээр хадгална.

37.5.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга соёлын үйл ажиллагаа эрхлэх зориулалт бүхий хувийн өмчийн барилга байгууламжийг ашиглан иргэнд соёлын үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж болно.

[*/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*](#)

37.6.Сум, дүүргийн соёлын төв, соёлын ордны үйл ажиллагааг үнэлэх аргачлалыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

37.7.Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээг хуулиар хориглосноос бусад нөхцөлд хүн бүрд нээлттэй байлгаж, соёлын үнэт зүйлтэй танилцах боломжоор хангана.

37.8.Соёлын байгууллага үйл ажиллагаа, үйлчилгээний жагсаалт, нөхцөлийг нэгдсэн журмаар тогтоож, иргэний мэдээлэл авах боломжийг бүрэн хангасан байна.

37.9.Соёлын байгууллагын үйлчилгээг зөврийн болон нүүдлийн хэлбэрээр хүргэх, хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил соёлын үйлчилгээ авахад зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг авна.

38 дугаар зүйл.Зөвшөөрөл

38.1.Соёлын зуучлал нь соёлын үнэт зүйлийн болон соёлын ажилтны зуучлалын хэлбэртэй байна.

38.2.Соёлын үнэт зүйлийн зуучлалыг Иргэний хууль, Оюуны өмчийн тухай хуульд заасны дагуу эрхэлнэ.

38.3.Соёлын ажилтныг олон улсын түвшинд соёлын үйл ажиллагаанд оролцуулах, санал болгох, түүний ашиг сонирхлыг төлөөлөн хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, менежментийн үүрэг гүйцэтгэх соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагааг зөвшөөрөл бүхий иргэн, хуулийн этгээд эрхэлнэ.

38.4.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох бөгөөд холбогдох журмыг батална.

38.5.Соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь зөвшөөрлийн холбогдох хуульд заасан баримт бичгээс гадна зөвшөөрөл хүсэгч иргэний, хуулийн этгээд бол удирдах, шийдвэр гаргах, соёлын ажилтантай шууд харилцан ажиллах иргэний хууль, эрх зүй, эдийн засаг, менежментийн талаарх мэдлэгийг нотлох баримт бичиг, эдийн засаг, хүний эрүүл мэнд, хүч хэрэглэсэн гэмт хэрэгт холбогдож байгаагүй талаарх тодорхойлолтыг өргөдөлд хавсаргана.

38.6.Соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч нь ажилтан тус бүртэй бичгээр гэрээ байгуулна.

38.7.Соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага, менежер өөрчлөгдөхөд зөвшөөрөл олгогч байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.

38.8.Соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч нь уран бүтээлчийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхүйц нөхцөлд ажиллуулахаар явуулахгүй байх бөгөөд зуучлан ажиллуулах газрыг урьдчилан судалсан байна.

38.9.Соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч нь хүүхдийг согтууруулах ундаа борлуулах, худалдах, түүгээр үйлчлэх орчинд ажиллуулахаар явуулахыг хориглоно.

38.10.Соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 22¹.1.6-д заасны дагуу хураамж төлнө.

39 дугаар зүйл.Соёлын үйл ажиллагаанд тавих хяналт, хязгаарлалт

39.1.Соёлын үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтын байгууллага, соёлын хяналтын улсын байцаагч хяналт тавина.

39.2.Аймаг, дүүргийн мэргэжлийн хяналтын байгууллагад соёлын хяналтын улсын байцаагч ажиллана.

39.3.Хууль тогтоомжоор хориглоогүй соёлын үйл ажиллагаа эрхлэхэд төрийн болон бусад байгууллага, улс төрийн нам, эвсэл, холбоо, тэдгээрийн албан тушаалтан хөндлөнгөөс оролцох, дарамт шахалт үзүүлэхийг хориглоно.

39.4.Угсаатны соёлын үнэт зүйлийн өвөрмөц илэрхийллийг ялгаварлан гадуурхахыг хориглоно.

39.5.Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулж болзошгүй болон дайн түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах соёлын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

39.6.Уран бүтээлчийн анхдагч санаа, ур чадварын нууцыг түүний зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглоно.

39.7.Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлж байгаа уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 60 хувиас доошгүй нь, хүүхдэд зориулсан уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн 70 хувиас доошгүй нь үндэсний нэвтрүүлэг байна.

39.8.Олон нийтийн телевизээс бусад Монгол Улсад бүртгэлтэй өргөн нэвтрүүлгийн телевиз, радио, кабелийн сувгаар дамжуулж байгаа уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 50 хувиас доошгүй нь, хүүхдэд зориулсан уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 60 хувиас доошгүй нь үндэсний нэвтрүүлэг байна.

39.9.Театр, үзвэрийн цэгээр сар тутам түгээх кинонд үндэсний киноны эзлэх хувь, интернэт протоколд суурилсан телевиз /Ай-Пи телевиз/-ийн уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн видео санд байршсан нийт хөтөлбөрт үндэсний кино, нэвтрүүлгийн цагийн эзлэх хувь 40 хувиас доошгүй байна.

39.10.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс нь зөвшөөрөл аваагүй, холбогдох даатгалд даатгуулаагүй тохиолдолд соёлын гадаад үйл ажиллагаанд насанд хүрээгүй хүнийг оролцуулахыг хориглоно.

39.11.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хөшөө дурсгалын цогцолбор байгуулах, соёлын байгууллага байгуулах, соёлын үнэт зүйлийг тогтоож хамгаалалтад авах тухай шийдвэр гаргахад соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, мэргэжлийн холбоодын саналыг авна.

[*/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*](#)

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

40 дүгээр зүйл.Соёлын хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

40.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

41 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

40.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

**СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, сэргээн уламжлуулах, өвлүүлэх, өмчлөх, эзэмших, ашиглах, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж

2.1.Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Соёлын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."соёлын өв" гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өвийг;

3.1.2."соёлын биет өв" гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгалыг;

3.1.3."түүх, соёлын үл хөдлөх дурсгал" гэж унаган газартаа хүрээлэн байгаа орчны хамт үнэ цэнэ, ач холбогдол нь илэрхийлэгдэх дангаар болон цогцолбор байдлаар орших дурсгалыг;

/Энэ заалтад 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

3.1.4."түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл" гэж тодорхой орон зайд шилжүүлэн байрлуулах боломжтой дурсгалыг;

3.1.5."соёлын биет бус өв" гэж хамт олон, бүлэг, хувь хүн соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн зан заншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, уламжлалт мэдлэг, арга барил, тэдгээртэй холбоотой эд өлгийн зүйл, зэмсэг, урлагийн бүтээл, соёлын орон зайг;

3.1.6."соёлын өвийн дурсгалт газар" гэж соёлын биет болон биет бус өв нь байгаль орчин, уламжлалт ахуйтайгаа харилцан шүтэлцсэн соёлын орон зай, газар нутгийг;

3.1.7."түүх, соёлын дурсгалт газар" гэж энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан түүх, соёлын үл хөдлөх дурсгал бүхий газар, түүний хэвлийг;

3.1.8."соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч" гэж соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн, түүнийгээ олны хүртээл болгож, дараагийн үедээ өвлүүлэн уламжлуулж байгаа хамт олон, бүлэг, хувь хүнийг;

3.1.9."шавь сургалт" гэж соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчаас тодорхой мэдлэг, арга ухаан, ур чадварыг шавьдаа биечлэн заан сургаж, эзэмшүүлдэг сургалтын арга барилыг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ӨВИЙН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

4 дүгээр зүйл.Соёлын өвийн ангилал

- 4.1.Соёлын өвийг биет ба биет бус гэж ангилна.
- 4.2.Соёлын биет өвийг түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл гэж ангилна.
- 4.3.Түүх, соёлын үл хөдлөх дурсгал нь дангаар болон цогцолбор байдлаар оршино.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

5 дугаар зүйл.Түүх, соёлын үл хөдлөх дурсгал

- 5.1.Дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамааруулна:
 - 5.1.1.эртний ургамал, амьтны олдворт газар;

[/Энэ заалтад 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

- 5.1.2.эртний хүний оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соёлт давхарга;
- 5.1.3.чулуун зэвсгийн олдворт газар;
- 5.1.4.хадны зураг, бичээс;
- 5.1.5.булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж;
- 5.1.6.эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгал;

[/Энэ заалтад 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

- 5.1.7.хөшөө дурсгал;
- 5.1.8.эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулж үйлдвэрлэл, газар тариалан эрхэлж байсан газар, түүнд холбогдох чулуун дурсгал;
- 5.1.9.тахилгат газар;
- 5.1.10.түүхэн үйл явдал болсон дурсгалт газар;
- 5.1.11.бусад түүх, соёлын үл хөдлөх дурсгал.

6 дугаар зүйл.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл

- 6.1.Дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд хамааруулна:
 - 6.1.1.ховор эрдэс;
 - 6.1.2.эрдэнийн чулууны ховор олдвор;
 - 6.1.3.солир;
 - 6.1.4.ховор болон ховордсон ургамлын хатаамал цуглуулга, амьтны чихмэл;
 - 6.1.5.эртний ургамал, амьтны олдвор;
 - 6.1.6.археологийн олдвор;
 - 6.1.7.угсаатны хувцас, чимэглэл;
 - 6.1.8.уламжлалт аж ахуйн тоног хэрэгсэл, хөдөлмөрийн багаж зэвсэг;
 - 6.1.9.угсаатан, ястны уламжлалт хөгжмийн зэмсэг, эд өлгийн зүйл;
 - 6.1.10.уламжлалт тоглоом, наадгай;
 - 6.1.11.уламжлалт шашин, шүтлэгийн холбогдолтой эд өлгийн зүйл;
 - 6.1.12.бичгийн дурсгалт зүйл;
 - 6.1.13.дүрс, дуу авианы баримт;
 - 6.1.14.дүрслэх урлагийн бүх төрлийн бүтээл, холбогдох эд өлгийн зүйл;
 - 6.1.15.уламжлалт монгол эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэрэглэгдэхүүн, тэдгээрт холбогдох эд өлгийн зүйл;
 - 6.1.16.гэр, сууц, тэдгээрт холбогдох эд өлгийн зүйл;

6.1.17.бусад түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл.

[/Энэ заалтад 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

6.2.Энэ хуулийн 5.1.1, 6.1.1-6.1.3-т зааснаас бусад байгалийн өвийг хамгаалах асуудлыг холбогдох бусад хуулиар зохицуулна.

[/Энэ хэсэгт 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

7 дугаар зүйл.Соёлын биет бус өв

- 7.1.Дараах соёлын өвийг соёлын биет бус өвд хамааруулна:
 - 7.1.1.эх хэл, бичиг, түүний хүрээний соёл;
 - 7.1.2.аман зохиолын уламжлал, түүнийг илэрхийлэх хэлбэр;
 - 7.1.3.урлагийн тоглох үзүүлбэр;
 - 7.1.4.үндэсний хөгжмийн зэмсгийг урлах, хөгжимдөх, аялгуу тэмдэглэх арга барил;
 - 7.1.5.уламжлалт гар урлалын дэг сургууль, арга барил;
 - 7.1.6.ардын ёс заншил, зан үйл;
 - 7.1.7.ардын уламжлалт мэдлэг, арга ухаан;
 - 7.1.8.ардын бэлгэдэх ёсны уламжлал;
 - 7.1.9.үндэсний наадам, уламжлалт тоглоом, наадгайн зан үйл;
 - 7.1.10.ардын уламжлалт технологи;
 - 7.1.11.угийн бичиг хөтлөх уламжлал;
 - 7.1.12.гэрийн дэг сургуулийн шилдэг өв уламжлал;
 - 7.1.13.уламжлалт шашин, шүтлэгийн зан үйл, ёс заншил;
 - 7.1.14.газар, усны уламжлалт нэр;
 - 7.1.15.бусад соёлын биет бус өв.

8 дугаар зүйл.Соёлын өвийн зэрэглэл

8.1.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эх төрх бүрэн бүтэн байдал, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтын зэрэглэл тогтооно.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

8.2.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн эх төрх бүрэн бүтэн байдал, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан үнэт, хосгүй үнэт зэрэглэл тогтооно.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

8.3.Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлийг дараах шалгуураар тогтооно:

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

8.3.1.түүх, соёл, урлаг, гоо зүй, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол;

8.3.2.хөдлөгдөх цаг үе;

8.3.3.дахин давтагдангүй байдал;

8.3.4.ур хийц, дэг сургууль;

8.3.5.үнэт металлын өрц, эрдэнийн чулууны хэмжээ.

8.4.Соёлын биет бус өвийг түүх, соёл, урлаг, гоо зүйн болон шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний жагсаалт болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний жагсаалтад бүртгэнэ.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

8.5.Энэ хуулийн 8.4-т заасан жагсаалтад оруулах соёлын биет бус өвийг дараах шалгуураар тогтооно:

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

8.5.1.түүх, соёл, заншил, уламжлалыг илэрхийлэх байдал;

8.5.2.хөвөрдөө, уетсан, эрдэлд өрсөн байдал.

8.6.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам, соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх журмыг Засгийн газар батална.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

8.7.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

8.8.Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан зэрэглэлийг шатлан дэвшүүлэх зарчмаар тогтоох бөгөөд давхардуулж тогтоохгүй.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

9 дүгээр зүйл.Соёлын биет өвийн үнэлгээ

[/Энэ зүйлийн гарчигт 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

9.1.Нийтийн өмчийн соёлын биет өвд үнэлгээ тогтоох журмыг санхүү, төсвийн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

[/Энэ хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

9.2.Нийтийн өмчийн соёлын биет өвийн үнэлгээг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тогтоох мэргэжлийн зөвлөл төдөрхөйлнө.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

9.3.Өмчлөгчийн хүсэлтээр хувийн өмчийн соёлын биет өвд энэ хуулийн 9.1-д заасан журмын дагуу үнэлгээ тогтоож болно.

[/Энэ хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

10 дугаар зүйл.Соёлын биет өвийн даатгал

10.1.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг үзэсгэлэнд оролцуулах, сэргээн засварлах, судалгаа шинжилгээ хийлгэх зорилгоор Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд заавал даатгуулна.

10.2.Энэ хуулийн 10.1-д зааснаас бусад тохиолдолд соёлын биет өвийг даатгуулж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

СОЁЛЫН ӨВИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

11 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх

11.1.Монгол Улсын Ерөнхийлөгч соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.Их эзэн Чингис хаан, монголын хаад, хатдын булш, бунхан, дурсгалын орчин болон олдворыг судлах, хамгаалах, мэдээлэх ажлыг хэрэгжүүлэх талаар холбогдох этгээдэд чиглэл өгөх;

11.1.2.хууль бусаар алдагдсан соёлын өвийг Монгол Улсыг төлөөлөн гадаад улс, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нэхэмжлэх эрхийг итгэмжлэлээр олгох, итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох;

11.1.3.Ерөнхийлөгчийн ивээл доор хамгаалж болох соёлын өвийг зарлах, уул, усыг төрийн тахилгатай болгох шийдвэр гаргах;

11.1.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

12 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

12.1.Улсын Их Хурал соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1.төрөөс соёлын өвийг хамгаалах талаар баримтлах бодлогыг тодорхойлох;

[/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

12.1.2.соёлын өвийг хамгаалах, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас зохион байгуулж байгаа ажилд хяналт тавих;

12.1.3.Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёлын өвийн дурсгалт газрыг улсын тусгай хамгаалалтад авах, түүний хилийн заагийг тогтоох;

12.1.4.соёлын өвийг хамгаалахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээг батлах;

12.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

13 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

13.1.Засгийн газар соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1.соёлын өвийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

~~13.1.2.соёлын өвийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх;~~

[/Энэ заалтад 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

13.1.3.соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоо, дүрмийг батлах;

13.1.4.язгуур гарал үүсэл нэг, илэрхийлэгдэх шинжээрээ нийтлэг, монгол угсаатны түүхэнд ач холбогдол бүхий соёлын өвийг хамгаалах талаар уг өв хадгалагдаж буй гадаад улстай хэлэлцээр хийх, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

13.1.5.улсын хилээр гарч алдагдсан соёлын биет өвийг эргүүлэн авчрах ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагад чиглэл өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;

13.1.6.соёлын өвийн үзлэг, тооллого хийх, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журмыг тус тус батлах;

13.1.7.улсын хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батлах;

[/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

13.1.8.түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг батлах;

[/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

13.1.9.Дэлхийн өвийн үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;

13.1.10.соёлын өвийг хувиан олшруулах, хуулбарлах, бүтээгдэхүүний загварт оруулах, кино, дүрс бичлэг хийх, гэрэл зураг авах, марк, ил захидал, цомог хийх журам батлах;

13.1.11.соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам батлах;

13.1.12.түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон дурсгалт газарт хамгаалалтын бүс тогтоох, өөрчлөх, цуцлах;

[/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

~~13.1.13.соёлын өвийг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэхээр нэр дэвшүүлэх болон Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн соёлын өвийг хадгалж хамгаалах, өвлөн уламжлуулах, түүхэн дэлгэрүүлэхтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх;~~

[/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

13.1.14.соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалт болон соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалтыг тус тус батлах;

[/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.1.15.хуульд заасан бусад бүрэн эрх.

[/Энэ заалтын дугаарт 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

14 дүгээр зүйл.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

14.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журам, зааврыг баталж, хэрэгжилтийг хангах;

~~14.1.2.соёлын өвийн улсын үзлэг, тооллогыг хуулиар тогтоосон хугацаанд явуулж, дүнг Засгийн газарт тайлагнах;~~

[/Энэ заалтыг 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

~~14.1.3.соёлын өвийг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, бүртгэгдсэн өвийг хадгалж хамгаалах арга хэмжээ авах;~~

[/Энэ заалтыг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

14.1.4.соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журам, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх журмыг тус тус батлах;

14.1.5.аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батлах;

[/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

14.1.6.түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг батлах;

~~14.1.7.соёлын өвийг хувилах, бүтээгдэхүүний загварт оруулж, зах зээлд нийлүүлэх эрх авсан байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих;~~

[/Энэ заалтыг 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

~~14.1.8.дуудлага худалдаагаар худалдах соёлын биет өвийн бүртгэлийг хөтлөх, тайланг хүлээн авах, хяналт тавих;~~

[/Энэ заалтыг 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

~~14.1.9.нийтийн өмчийн соёлын өвийг хадгалах, бүртгэх ажлыг мэргэжлийн ажилтнаар гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;~~

[/Энэ заалтыг 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

~~14.1.10.устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээг боловруулж, улс, орон нутгийн төсвийн болон хандивын хөрөнгөөр санхүүжүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;~~

[/Энэ заалтыг 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

14.1.11.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх, палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх зөвшөөрөл олгох;

[/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

14.1.12.мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;

[/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

14.1.13.соёлын өвийг бүртгэл мэдээллийн санд бүртгэх журам батлах;

14.1.14.соёлын өвийн дурсгалт газрын менежментийн төлөвлөгөөг батлах;

14.1.15.соёлын өвийг хамгаалах, сурталчлах үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

14.1.16.соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргааны удирдлагыг томилж, чөлөөлөх;

14.1.17.түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалт болон Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх, соёлын биет бус өвийг ЮНЕСКО-ийн төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

[/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

14.1.18.хуульд заасан бусад бүрэн эрх.

[/Энэ заалтын дугаарт 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

14¹дүгээр зүйл.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

14¹.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага соёлын өвийг хамгаалах чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14¹.1.1.төрөөс соёлын өвийг хамгаалах талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

14¹.1.2.соёлын өвийн улсын үзлэг, тооллогыг хуулиар тогтоосон хугацаанд явуулж, дүнг Засгийн газарт тайлагнах;

14¹.1.3.соёлын өвийг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, бүртгэгдсэн өвийг хадгалж хамгаалах арга хэмжээ авах;

~~14¹.1.4.соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх;~~

[/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

14¹.1.5.соёлын өвийг хувилах, бүтээгдэхүүний загварт оруулж, зах зээлд нийлүүлэх эрх авсан байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих;

14¹.1.6.дуудлага худалдаагаар худалдах соёлын биет өвийн бүртгэлийг хөтлөх, тайланг хүлээн авах, хяналт тавих;

14¹.1.7.нийтийн өмчийн соёлын өвийг хадгалах, бүртгэх ажлыг мэргэжлийн ажилтнаар гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

14¹.1.8.устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээг боловсруулж, улс, орон нутгийн төсвийн болон хандивын хөрөнгөөр санхүүжүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

~~14¹.1.9.соёлын өвийн бүртгэл мэдээллийн санд хөтлөх;~~

[/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

14¹.1.10.дэлхийн өвийн урьдчилсан жагсаалт болон Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эх төрх, бүрэн бүтэн байдлыг хамгаалах, сэргээн засварлах, ЮНЕСКО-ийн төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлсэн соёлын биет бус өвийн оршин тогтнох чадварыг хамгаалж, бэхжүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;

[/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

14¹.1.11.хуульд заасан бусад бүрэн эрх.

[/Энэ заалтын дугаарт 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ зүйлийг 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

15 дугаар зүйл.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

[/Энэ зүйлийн гарчигт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

15.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал соёлын өвийг хамгаалах талаар дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

15.1.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд соёлын өвийг хамгаалах дунд хугацааны бодлого, үндсэн чиглэлийг батлах;

[/Энэ заалтыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

15.1.2.соёлын өвийг хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах төсвийг батлах;

[/Энэ заалтыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

15.1.3.соёлын өвийг хамгаалах болон соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр Засаг даргад чиглэл өгч, биелэлтийг хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгөх;

[/Энэ заалтыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

15.1.4.харьяалах нутаг дэвсгэр дэх түүх, соёлын дурсгалт газрыг хамгаалах чиглэлээр санал гаргах;

[/Энэ заалтад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

15.1.5.хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу орон нутгийн хамгаалалтад байгаа түүх, соёлын дурсгалт газрыг аялал жуулчлалын байгууллагад гэрээгээр ашиглуулах шийдвэр гаргах;

[/Энэ хэсгийг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

15.1.6.устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах, сэргээн уламжлуулах арга хэмжээ авах;

[/Энэ хэсгийг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

15.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

15.2.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батална.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

16 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

16.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

[/Энэ заалтад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

16.1.2.соёлын өвийг хамгаалах, зохистой ашиглах ажлыг зохион байгуулах;

[/Энэ заалтад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

16.1.3.соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, хамгаалах, хяналт тавих ажлыг зохион байгуулах;

16.1.4.соёлын өвийн судалгаа, тайлан мэдээллийг зохих журмын дагуу гаргаж, аймаг, нийслэл, улсын бүртгэл, мэдээллийн санд хүргүүлэх;

16.1.5.хуульд заасан журмын дагуу соёлын өвийн үзлэг, тооллого хийх;

[/Энэ заалтад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

16.1.6.соёлын өвд эрсдэл учруулахуйц аливаа үйл ажиллагааг таслан зогсоож, хуульд заасны дагуу арга хэмжээ авах;

16.1.7.палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага, багт дэмжлэг үзүүлэх;

16.1.8.соёлын өвийг сурталчлах;

16.1.9.дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын бүс тогтоох ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

16.1.10.соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, хуульд заасан дэмжлэг үзүүлэх;

16.1.11.түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хууль бус малтлагыг таслан зогсоох, соёлын өвийн зөрчлийн талаарх мэдээллийн мөрөөр арга хэмжээ авах ажлыг удирдан зохион байгуулах;

16.1.12.соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг олж тогтоох, олон нийтэд таниулах, дэмжлэг үзүүлэх, өвлөн уламжлуулах ажлыг зохион байгуулах;

16.1.13.устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах, сэргээн уламжлуулах арга хэмжээ авах;

[/Энэ заалтыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

16.1.14.хуульд заасан бусад бүрэн эрх.

[/Энэ заалтын дугаарт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

17 дугаар зүйл.Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

17.1.Сум, дүүргийн Засаг дарга соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

[/Энэ заалтад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

17.1.2.соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, хамгаалах, хяналт тавих ажлыг зохион байгуулах;

17.1.3.палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага, багт зориулалт бүхий газрыг ашиглуулах;

17.1.4.палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгааны ажил дууссаны дараа судалгаа явуулсан байгууллагаас уг газрыг аюул осолгүй болгохыг шаардах, хүлээн авах.

17.1.5.харьяалах нутаг дэвсгэртэй үйл ажиллагаа явуулж байгаа дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

[/Энэ заалтыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

17.1.6.сум, дүүргийн хамгаалалтад байгаа түүх, соёлын дурсгалт газрыг аялал жуулчлалын байгууллагад гэрээгээр ашиглуулах;

[/Энэ заалтыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

17.1.7.устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах, сэргээн уламжлуулах арга хэмжээ авах.

[/Энэ заалтыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

18 дугаар зүйл.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын бүрэн эрх

18.1.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.1.соёлын өвийг хамгаалахад олон нийтийг татан оролцуулах;

18.1.2.соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх саналыг дээд шатны хуралд хүргүүлэх;

18.1.3.хуульд заасан бусад бүрэн эрх.

19 дүгээр зүйл.Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх

19.1.Баг, хорооны Засаг дарга соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, иргэдийн Нийтийн Хурал болон дээд шатны хурал, Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

19.1.2.соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд иргэдийг татан оролцуулах;

[/Энэ заалтыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

19.1.3.түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүний орчныг цэвэр үзэмжтэй байлгах, хог хаягдлыг цэвэрлэхэд иргэдийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах;

19.1.4.соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хуульд заасны дагуу урамшуулах, дэмжлэг үзүүлэх, дээд шатны байгууллагад уламжлах;

19.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ

20 дугаар зүйл.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо

20.1.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь дараах тогтолцоотой байна:

20.1.1.байгууллагын бүртгэл, мэдээллийн сан;

20.1.2.сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан;

20.1.3.аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан;

20.1.4.улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан.

20.2.Сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санг соёлын төвд; аймгийн бүртгэл, мэдээллийн санг орон нутгийн музейд; нийслэлийн бүртгэл, мэдээллийн санг нийслэлийн Засаг даргын дэргэдэх соёлын асуудал хариуцсан нэгжид; улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг Соёлын өвийн үндэсний төвд тус тус бүрдүүлж, хадгална.

20.3.Соёлын өвийн үндэсний төв нь соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалах, сэргээн засварлах, авран хамгаалах, сурталчлах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

20.4.Төрийн болон орон нутгийн музей нь тухайн нутаг дэвсгэрт орших соёлын өвийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна.

[/Энэ хэсэгт 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

20.5.Сум, дүүргийн соёлын төв нь тухайн нутаг дэвсгэрт орших соёлын өвийг бүртгэн баримтжуулах, хамгаалах үүргийг гүйцэтгэнэ.

20.6.Дараах аж ахуйн нэгж, байгууллага бүртгэл, мэдээллийн санг заавал бүрдүүлнэ:

20.6.1.Монголбанк;

20.6.2.дурсгалт газрын хамгаалалтын захиргаа;

20.6.3.музей, галерей, номын сан, сүм хийд;

20.6.4.эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны лаборатори.

20.6.5.үндэсний төв архив.

[/Энэ заалтыг 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

20.7.Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд иргэн, хуулийн этгээд өөрийн өмчилж, эзэмшиж байгаа соёлын өвийг бүртгүүлж болно.

20.8.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх бөгөөд түүнд агуулагдах мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байна.

20.9.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь төрийн өмчид байна.

20.10.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн байрлал, нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг тухайн санг бүрдүүлсэн байгууллага хариуцна.

21 дүгээр зүйл.Соёлын өвийн бүртгэлийн бүрдэл

21.1.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь соёлын өвийг эвдэрч гэмтсэн, устсан, мартагдсан тохиолдолд тэдгээрийг сэргээхэд шаардагдах бүрэн мэдээллийг агуулсан байвал зохино.

21.2.Соёлын өвийн бүртгэл нь дараах дагалдах хэрэглэгдэхүүнээс бүрдэнэ:

21.2.1.соёлын өвийн тодорхойлолт;

21.2.2.судалгаа, шинжилгээний ажлын тайлан;

21.2.3.сэргээн засварласан ажлын тайлан;

21.2.4.үзлэг, тооллого хийхэд хөтөлсөн баримт;

21.2.5.дотоод, гадаадад гаргасан үзэсгэлэнтэй холбоотой баримт;

21.2.6.гэрэл зураг, түүнийг агуулсан хальс, зээрэнцэг;

21.2.7.дуу, дүрс агуулсан бүх төрлийн бичлэг;

21.2.8.хэв, хуулбар, дардас;

21.2.9.соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн талаарх мэдээлэл;

21.2.10.сэргээн засварлах ажлын хэмжилт, судалгаа, зураг төсөл;

21.2.11.бүртгэлд холбогдох бусад хэрэглэгдэхүүн.

21.3.Соёлын өвийн бүртгэл, түүнд дагалдах хэрэглэгдэхүүн нь лавлагаа, мэдээллийн хувьд нэгдмэл цогц байх нөхцөлийг бүрдүүлнэ.

21.4.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн бүртгэлийг хуульд зааснаас бусад үндэслэлээр дамжуулах, ашиглуулах, хувилах, үрэгдүүлэх болон стандартын бус орчинд хадгалахыг хориглоно.

21.5.Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийг архивын байгууллагад хадгалуулна.

22 дугаар зүйл.Соёлын өвийг бүртгэх

22.1.Соёлын өвийг бүртгэл, мэдээллийн санд бүртгэх, мэдээллийг ашиглах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг бүртгэх журмыг Монголбанкны Ерөнхийлөгч, соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

[/Энэ хэсэгт 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

22.2.Нийтийн өмчийн соёлын биет өвийн талаарх мэдээллийг бүртгэл, мэдээллийн санд заавал бүртгэнэ.

22.3.Энэ хуулийн 22.2-т зааснаас бусад соёлын биет өвийг өмчлөгч, эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн зохих шатны бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлж болно. Бүртгүүлсэн мэдээллийн нууцлал, хадгалалтын нөхцөлийг гэрээгээр зохицуулна.

22.4.Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн тухай мэдээллийг соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэнэ.

22.5.Соёлын өв устсан, үрэгдсэн тохиолдолд Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр төрийн болон орон нутгийн өмчөөс хасна.

22.6.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангаас мэдээлэл хасахыг хориглоно.

23 дугаар зүйл.Соёлын өвийг бүртгэх хугацаа

23.1.Соёлын өвийг нээж, илрүүлсэн байгууллага, иргэн тухайн нутаг дэвсгэрийн бүртгэл, мэдээллийн санд 15 хоногийн дотор мэдэгдэж, анхан шатны бүртгэл хийлгэнэ.

23.2.Байгууллагын бүртгэл, мэдээллийн сан нь жилд дөрвөн удаа сум, дүүргийн, сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан нь жилд хоёр удаа аймаг, нийслэлийн, аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан нь жилд нэг удаа улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд тус тус тайлангаа хүргүүлнэ.

23.3.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд болон гадаадын байгууллага, иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын соёлын өвтэй холбоотой зүйлийг өөрийн санаачилгаар төрийн өмчид өгсөн тохиолдолд уг дурсгалыг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэж, түүнийг хадгалах үүрэг бүхий байгууллагад шилжүүлнэ.

24 дүгээр зүйл.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах

24.1.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийг эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр иргэн, хуулийн этгээдэд ашиглуулж болно. Мэдээллийг ашиглуулахдаа өмчлөгч, эзэмшигчийн хууль ёсны эрх ашгийг хөндөж үл болно.

24.2.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн соёлын өвийн мэдээллээр нийтэд зориулан сурталчилгааны хялбаршуулсан бүтээл гаргаж болно.

24.3.Соёлын биет өв алдагдсан тохиолдолд соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг хариуцсан байгууллага холбогдох мэдээллийг хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагад нэн даруй хүргүүлэх арга хэмжээ авна.

25 дугаар зүйл.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын кадастр, өмчлөх, эзэмших эрхийн бүртгэл

25.1.Түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүний оршин байгаа газрыг өмчлөгч, эзэмшигч нь эд хөрөнгийн эрхийн болон газрын кадастрын улсын бүртгэлд бүртгүүлнэ.

25.2.Энэ хуулийн 25.1-д заасан бүртгэлийг Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд хадгална.

26 дугаар зүйл.Соёлын өвийн үзлэг, тооллого

26.1.Соёлын биет бус өвийн үзлэгийг гурван жил тутамд, түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллогыг таван жил тутамд, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг дөрвөн жил тутамд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран зохион байгуулна.

[/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

26.2.Соёлын өвийг эзэмшигч нь тооллогоор илэрсэн зөрчлийг арилгах талаар тухайн шатны нутгийн захиргааны байгууллага болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран нэн даруй арга хэмжээ авна.

[/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

ТАВДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ӨВИЙН СУДАЛГАА

27 дугаар зүйл.Соёлын өвийн судалгаа

27.1.Соёлын биет өвийн судалгаа, шинжилгээг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага хийнэ.

27.2.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа нь эрдэм шинжилгээний болон авран хамгаалах үндсэн чиглэлтэй байна.

27.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх болон соёлын биет бус өвийн судалгаа хийх зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх харьяалах Мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

27.4.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журмыг соёлын болон шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

[/Энэ хэсэгт 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

27.5.Эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрлийг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагад олгоно.

~~27.6.Авран хамгаалах хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрлийг мэргэжлийн судлаачдын багт олгож болно.~~

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

27.7.Соёлын биет өвийг таньж тогтоох судалгаа, шинжилгээг өмчийн бүх хэлбэрийн эрдэм шинжилгээний лабораторид хийж болно.

27.8.Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна.

27.9.Урьдчилан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцна.

27.10.Урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулаагүй нь газар эзэмшүүлэх шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно.

27.11.Соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалж шинжлэх ажлыг холбогдох журмын дагуу мэргэжлийн соёл, урлаг, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээд эрхлэн явуулна.

28 дугаар зүйл.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийхэд хориглох зүйл

28.1.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийхэд дараах зүйлийг хориглоно:

28.1.1.геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, усны эх, рашаан, булаг, бүрд зэрэг байгалийн унаган тогтоц, эмзэг хэсгийг гэмтээх;

28.1.2.тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх;

28.1.3.судалгааны үр дүнд хохирол учруулж болзошгүй техник, тоног төхөөрөмж ашиглах;

28.1.4.малтлага, судалгааны явцад үүссэн нүх, хонхор болон хүрээлэн байгаа орчны үзэмжийг эвдсэн элс, шороо, чулуун овоолго үлдээх.

29 дүгээр зүйл.Соёлын өвийн судалгааны ажлын тайлан

29.1.Соёлын өвийн судалгааны ажлын дэлгэрэнгүй тайлангийн нэг хувийг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шилжүүлнэ.

29.2.Тайлан бүрэн эхээрээ нийтлэгдээгүй тохиолдолд түүнийг ашиглах асуудлыг Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

30 дугаар зүйл.Олдвор

30.1.Түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий үнэт зүйл оршин байгаа нутаг дэвсгэр, газрын хэвлий нь төрийн хамгаалалтад байх бөгөөд аливаа олдвор нь төрийн өмч мөн.

30.2.Олдворыг хадгалах, хамгаалах, судлахдаа түүний эх төрх, бүрэн бүтэн байдал, хэлбэр, шинж чанарыг алдагдуулж гэмтээхийг хориглоно.

[/Энэ хэсэгт 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

30.3.Олдворыг стандартын шаардлага хангаагүй өрөө тасалгаа, орчинд хадгалахыг хориглоно.

30.4.Олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор тухайн сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

30.5.Олдворыг эзэмшүүлэх, түр хадгалах зорилгоор музей, эрдэм шинжилгээний байгууллага болон холбогдох бусад байгууллагад шилжүүлэх асуудлыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олдворыг анх илрүүлсэн эрдэм шинжилгээний байгууллага, судлаачийн саналыг харгалзан шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

30.6.Олдворыг хадгалж, ашиглахдаа гарал үүслийн нэгдмэл цогц байдлыг хангана.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ӨВИЙГ ЭЗЭМШИХ, АШИГЛАХ, ӨМЧЛӨХ

31 дүгээр зүйл.Соёлын биет өвийг эзэмших

31.1.Нийтийн өмчийн соёлын биет өвийг төрийн болон орон нутгийн, шашны, олон нийтийн байгууллага өмчлөгчийн тогтоосон нөхцөлөөр тус тус эзэмшинэ.

31.2.Доор дурдсан байгууллага, хуулийн этгээд нийтийн өмчийн соёлын биет өвийг эзэмшинэ:

31.2.1.төрийн болон орон нутгийн музей;

[/Энэ хэсэгт 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

31.2.2.галерей;

31.2.3.эрдэм шинжилгээний байгууллага;

31.2.4.үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн номын сан;

31.2.5.үндэсний төв архив, аймаг, нийслэлийн архив;

31.2.6.шашны байгууллага;

31.2.7.хууль тогтоомжоор соёлын өвийг хадгалж, хамгаалах үүрэг хүлээлгэсэн бусад байгууллага.

32 дугаар зүйл.Төрийн өмчийн соёлын биет өвийг эзэмшигчийн эрх, үүрэг

32.1.Соёлын биет өвийг эзэмшигч дараах эрх эдэлнэ:

32.1.1.өмчлөгчтэй тохиролцсоны дагуу нийтэд дэлгэн үзүүлэх, сурталчлах, үзэсгэлэнд оролцуулах, түүнээс олсон орлогын тодорхой хувийг авах;

32.1.2.ангилал, зэрэглэлийг харгалзан холбогдох журмын дагуу тэдгээрийг түр солилцох, түрээслэх, худалдаж авах;

32.1.3.сурвалжлан олж цуглуулах, судалж шинжлэх, эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах;

32.1.4.стандартын шаардлага хангасан байр, лаборатори, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдах;

32.1.5.соёлын биет өвийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлүүлэх.

32.2.Соёлын биет өвийг эзэмшигч дараах үүрэг хүлээнэ:

32.2.1.соёлын өвийн бүртгэл хөтөлж, бүртгэл, мэдээллийн сан үүсгэх;

32.2.2.дээд шатны бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх;

32.2.3.бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн соёлын өвийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг бүртгэх;

32.2.4.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр гаргахад зохих журмын дагуу зөвшөөрөл авах;

32.2.5.соёлын биет өв алдагдсан, үрэгдсэн тохиолдолд тухайн шатны бүртгэл, мэдээллийн сан, Засаг дарга, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэх;

32.2.6.өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр соёлын биет өвийг сэргээн засварлах, бусдад ашиглуулахгүй байх.

33 дугаар зүйл.Соёлын биет өвийг өмчлөгчийн эрх, үүрэг

33.1.Соёлын биет өвийг өмчлөгч иргэн, хуулийн этгээд дараах эрх эдэлнэ:

33.1.1.язгуур зориулалтаар ашиглах;

33.1.2.нийтэд дэлгэн үзүүлэх, сурталчлах, үзэсгэлэнд тавих, түүнээс олсон орлогоос авах;

33.1.3.зайлшгүй сэргээн засварлах шаардлагатай тохиолдолд зохих журмын дагуу улсаас санхүүгийн дэмжлэг авах;

33.1.4.түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг өөрийн хүсэлтээр төрд худалдсан тохиолдолд татварын хөнгөлөлт эдлэх;

33.1.5.музей, галерей байгуулах.

33.2.Соёлын биет өвийг өмчлөгч иргэн, хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ:

33.2.1.соёлын өвийн гарал үүслийн байдлыг тодорхойлох;

33.2.2.харьяалах аймаг, нийслэлийн Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх;

[/Энэ заалтад 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

33.2.3.худалдах, бэлэглэх, өвлүүлэх зэргээр өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдолд тухайн шатны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд мэдэгдэх;

33.2.4.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр гаргахад зохих журмын дагуу зөвшөөрөл авах;

33.2.5.алдагдаж, үрэгдсэн тохиолдолд нэн даруй тухайн шатны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан, Засаг дарга, цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

33.2.6.түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах анхны саналыг төрд тавих;

33.2.7.түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд бэлэглэх, өвлүүлэх зэргээр түүний өмчлөлд шилжүүлэхгүй байх.

34 дүгээр зүйл.Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн эрх, үүрэг

34.1.Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нь дараах эрх эдэлнэ:

34.1.1.соёлын биет бус өвийг яаралтай хамгаалах, өвлүүлэх, сэргээн уламжлуулах зайлшгүй тохиолдолд санхүүгийн дэмжлэг авах.

34.2.Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нь дараах үүрэг хүлээнэ:

34.2.1.соёлын биет бус өвийг хойч үедээ өвлүүлэх, шавь сургах;

34.2.2.соёлын биет бус өвийг сурталчилж, түгээн дэлгэрүүлэх;

34.2.3.соёлын биет бус өвийн бүртгэл хийх, мэдээлэл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

35 дугаар зүйл.Соёлын биет өвийг худалдах, худалдан авах

35.1.Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

35.2.Соёлын биет өвийг худалдан авах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, улс, орон нутгийн музей, номын сан олон нийтэд нээлттэй, ил тод хэлбэрээр зохион байгуулна.

[/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

35.3.Соёлын биет өвийг худалдан авсан байгууллага жил бүр үзэсгэлэн зохион байгуулж, нийтэд сурталчилна.

35.4.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд худалдахыг хориглоно.

35.5.Палеонтологи, археологийн олдворыг худалдахыг хориглоно.

36 дугаар зүйл.Соёлын биет өвийг ашиглах

36.1.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана.

36.2.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа гэмтээх, үрэгдүүлэхийг хориглоно.

36.3.Төрийн өмчид байгаа соёлын биет өвийг язгуур зориулалтаар ашиглахыг хориглоно. Энэ хэсгийн заалт нь түүх, соёлын дурсгалт барилга, байшинд хамаарахгүй.

ДОЛООДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТОГТООЛЦОО

37 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тогтолцоо

37.1.Соёлын өвийг хамгаалах асуудлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага болон бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, энэ хуулиар үүрэг хүлээсэн байгууллага, эрх бүхий этгээд хариуцна.

[/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

37.2.Соёлын өвийн хамгаалалтад соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга, соёлын өвийн хяналтын улсын байцаагч, гэрээт харуул, хуулиар эрх олгосон байгууллага, албан тушаалтан хяналт тавина.

[/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

37.3.Соёлын өвийн анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулахгүйгээр тухайн орон нутагт нь хадгалах зарчим баримтална. Хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах зорилгоор соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрлөөр төрийн болон, орон нутгийн музейд шилжүүлэн хадгалж болно.

[/Энэ хэсэгт 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

37.4.Сум, дүүргийн Засаг дарга түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах үүргийг гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

37.5.Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дэргэд тухайн дурсгалын талаарх мэдээллийг агуулсан танилцуулга, тайлбар, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулна. Танилцуулга, тайлбар, тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу хийж, байрлуулах ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.

37.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга хот, суурин газарт орших түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын харагдах сүр барааг хадгалах зорилгоор түүний эргэн тойронд шинээр барих барилга байгууламжид өндрийн хязгаар тогтооно. Өндрийн хязгаар тогтоох шалгуур үзүүлэлтийг хот байгуулалтын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

38 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалахтай холбоотой хориглох үйл ажиллагаа

38.1.Соёлын өвд хохирол учруулж болзошгүй дараах үйл ажиллагааг хориглоно:

38.1.1.түүх, соёлын дурсгалт газар түүний орчны бүсэд дэд бүтцийн барилга байгууламж барих, уул уурхай, газар тариалан эрхлэх, үйлдвэрлэл явуулах;

38.1.2.палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэхгүйгээр хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, тариалангийн талбай олгох, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулж газар олгох;

38.1.3.хуульд зааснаас бусад тохиолдолд нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөр байгууллага, орчинд шилжүүлэн хадгалах, зөөж тээвэрлэх, хөдөлгөх;

38.1.4.улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалд зар сурталчилгааны самбар, бичиг хадах, анхны хэлбэр төрх, хийц, бүтээцийг өөрчлөх.

38.2.Палеонтологи, археологи, угсаатны урьдчилсан хайгуул, судалгааны ажлын дүгнэлтээр соёлын өвд эрсдэл учирч болзошгүй байгаа нь тогтоогдсон бол аж ахуйн үйл ажиллагааг зогсоох үндэслэл болно.

38.3.Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

39 дүгээр зүйл.Соёлын биет бус өвийг өвлөн уламжлуулах

39.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бүх шатны Засаг дарга соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг тухайн угсаатан ястны түүх, уламжлал, ёс заншил, ахуй нөхцөлтэй нь уялдаатайгаар судалж, сурталчлах, өвлөн уламжлуулах, хадгалж хамгаалах асуудлыг хариуцна.

[/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

39.2.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, түүнийг өвлөн уламжлагчийг тодруулах, алдаршуулах, авьяас билгийг хөгжүүлэх, олон нийтэд сурталчлан түгээн дэлгэрүүлэх зорилгоор гурван жил тутам улсын хэмжээнд соёлын биет бус өвийн их наадмыг зохион байгуулна.

[/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

39.3.Соёлын биет бус өвийг хамгаалах, биет бус өвийг өвлөн уламжлагчийг урамшуулах, шавь сургалт зохион байгуулах асуудлыг бүх шатны Засаг дарга зохион байгуулна.

40. дүгээр зүйл.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах

40.1.Соёлын өвийг сурвалжлан олсон, нээлт хийсэн, соёлын өвийн сан хөмрөгийг баяжуулах, авран хамгаалах, түүнийг олон нийтэд сурталчлан таниулах, сэргээн уламжлуулах, сэргээн засварлахад идэвх санаачилгатай ажилласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулна.

40.2.Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, захиргааны зөрчлийг илрүүлэхэд хувь нэмэр оруулсан иргэнийг төрөөс алдаршуулж, урамшуулна.

40.3.Энэ хуульд заасан шаардлагыг зөрчсөн этгээдийг илрүүлсэн, соёлын өвийг хуулбарласан, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан тухай мэдээлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, улсын байцаагч, гэрээт харуулд борлуулалтын орлогын 15 хувийг аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга олгоно.

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

40.4.Зөрчлийн тухай мэдээллийг худалдан авах журмыг Засгийн газар батална. Мэдээллийн нууцлалыг хууль тогтоомжийн дагуу чандлан хадгална.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

40.5.Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчийг жил бүр тодруулж, мөнгөн шагнал олгох бөгөөд мөнгөн шагнал олгох журмыг Засгийн газар батална.

41 дүгээр зүйл.Соёлын өвийн санхүүжилт

41.1.Соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг доор дурдсан эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

41.1.1.улсын төсөв;

41.1.2.орон нутгийн төсөв;

41.1.3.Монгол Улсын болон гадаадын иргэн, олон улсын байгууллага, хуулийн этгээдээс олгосон хөрөнгө, хандив, тусламж;

41.1.4.бусад эх үүсвэр.

НАЙМДУГААР БҮЛЭГ ДУРСГАЛТ ГАЗРЫГ ХАМГААЛАХ

42 дугаар зүйл.Соёлын өвийн дурсгалт газар

42.1.Улсын Их Хурал соёлын өвийн дурсгалт газрын унаган төрх, соёлын үнэт зүйлийн язгуур шинжийг хамгаалах зорилгоор тусгай хамгаалалтад авах тухай шийдвэр гаргаж, хилийн заагийг батална.

42.2.Соёлын өвийн дурсгалт газар байгуулах саналыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газарт өргөн мэдүүлнэ. Саналд тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг харгалзан үзэж болно.

42.3.Соёлын өвийн дурсгалт газарт үндэсний болон дэлхийн өвийн дурсгалт газар хамаарна.

42.4.Соёлын өвийн дурсгалт газрыг дараах бүсэд хуваана:

42.4.1.хамгаалалтын бүс;

42.4.2.орчны бүс.

42.5.Соёлын өвийн дурсгалт газарт хэд хэдэн түүх, соёлын дурсгалт газар байрлаж болно.

42.6.Хамгаалалтын болон орчны бүсэд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр байгаль, соёлын өвд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж болно.

42.7.Соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын менежментийг хариуцан хэрэгжүүлэх үүрэг бүхий хамгаалалтын захиргаа ажиллана.

42.8.Соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргаа энэ хуулийн 43, 44-т заасан үйл ажиллагаатай уялдуулан нэмэлт дэглэм тогтоож болно.

42.9.Соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргаанд хэд хэдэн дурсгалт газрын хамгаалалтын асуудлыг харьяалуулж болно.

43 дугаар зүйл.Хамгаалалтын бүсийн дэглэм

43.1.Хамгаалалтын бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

43.1.1.онцгой байдал үүссэнээс бусад тохиолдолд нисэх онгоц буулгах;

43.1.2.ашигт малтмал эрэх, хайх, ашиглах;

43.1.3.мод, элс, хайрга, чулуу авах зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх;

43.1.4.хот суурин, цахилгаан станц байгуулах;

43.1.5.тэсэлгээ хийх;

43.1.6.шинээр барилга байгууламж барих.

44 дүгээр зүйл.Орчны бүсийн дэглэм

44.1.Орчны бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

44.1.1.ашигт малтмал эрэх, хайх, ашиглах;

44.1.2.хот суурин, цахилгаан станц байгуулах;

44.1.3.тэсэлгээ хийх.

45 дугаар зүйл.Түүх, соёлын дурсгалт газар

45.1.Засгийн газар түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах, харагдах сүр барааг хадгалах зорилгоор хамгаалалтын бүс тогтооно. Хамгаалалтын бүсийн хилийн заагийг тогтоох шалгуур үзүүлэлтийг хот байгуулалтын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

[/Энэ хэсэгт 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

45.2.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 45.1-д заасны дагуу хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газарт гэрээт харуул томилж ажиллуулна.

45.3.Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

45.3.1.газар, түүний хэвлийг хөндөх;

45.3.2.мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүй мод бут, төрөл бүрийн ургамал тарих;

45.3.3.энэ хуулийн 45.5-д зааснаас бусад зорилгоор гэр, сууц, барилга, байгууламж барих;

[/Энэ заалтад 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

45.3.4.мал бэлчээх;

45.3.5.онцгой байдал үүссэнээс бусад тохиолдолд өөрөө явагч хэрэгсэл нэвтрүүлэх, нисэх онгоц буулгах;

45.3.6.ашигт малтмал эрэх, хайх, ашиглах;

45.3.7.мод, элс, хайрга, чулуу авах.

45.4.Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд судалгаа шинжилгээ хийх, сэргээн засварлах, аялал жуулчлалын зорилгоор сурталчлах үйл ажиллагаа явуулж болно.

45.5.Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд байгаа үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтын байдлыг сайжруулах зорилгоор түүний эх төрх, бүрэн бүтэн байдалд нь хохирол учруулахгүй байх хэлбэрээр шинээр барилга байгууламж барьж, судалгаа, сурталчилгааны зориулалтаар ашиглаж болно.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

45.6.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор энэ хуулийн 45.1-д заасан хамгаалалтын бүсийн эргэн тойронд Соёлын тухай хуульд нийцүүлэн соёлын орчин, орон зайг бий болгож болно.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ СОЁЛЫН ӨВИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ

46 дугаар зүйл.Соёлын биет өвийг сэргээн засварлах байгууллага

46.1.Соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг судалгаа, шинжилгээний үндсэн дээр боловсруулсан сэргээн засварлах зураг төслийн дагуу соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага, иргэн гэрээгээр гүйцэтгэнэ.

46.2.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөл ажиллана. Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

46.3.Мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн соёлын биет өвийг сэргээн засварлах зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

46.4.Хуульд өөрөөр заагаагүй бол соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага соёлын биет өвийг сэргээн засварлаж болно.

46.5.Соёлын биет өвийг зөвшөөрөлгүй сэргээн засварлахыг хориглоно.

~~46.6.Монгол Улсын хэмжээнд соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа Соёлын биет өвийг сэргээн засварлах газар гүйцэтгэнэ.~~

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

46.7.Соёлын биет өвийг сэргээн засварлах ажилд туслан гүйцэтгэгчийг гэрээгээр ажиллуулж болно.

47 дугаар зүйл.Соёлын биет өвийг сэргээн засварлах үйл ажиллагаа

47.1.Соёлын биет өвийг сэргээн засварлахад дараах зарчмыг баримтална:

47.1.1.анхны төрх, хийц бүтээцийг хадгалж үлдээх; 47.1.2.аюулгүй, удаан хугацаанд хадгалах нөхцөлийг хангах.

47.2.Соёлын биет өвийг сэргээн засварлах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах журмыг соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

47.3.Соёлын биет өвийг сэргээн засварласан ажлын дэлгэрэнгүй тайланг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан, архивт шилжүүлнэ.

48 дугаар зүйл.Соёлын биет бус өвийг сэргээн уламжлуулах

48.1.Соёлын биет бус өв устсан, мартагдсан тохиолдолд сэргээн уламжлуулах арга хэмжээг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох бүртгэл, мэдээллийг үндэслэн зохион байгуулна.

[/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

48.2.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Мэргэжлийн зөвлөл соёлын биет бус өвийг сэргээгдсэнд тооцож, дүгнэлт гаргана.

АРАВДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ӨВИЙГ СУРТАЛЧЛАХ

49 дүгээр зүйл.Соёлын өвийн боловсрол

49.1.Соёлын өвийн талаарх мэдлэг олгох, түүнийг хамгаалах, сурталчлах арга хэмжээг гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлал болон боловсролын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

49.2.Соёлын өвийн боловсрол эзэмшүүлэх ажлыг дараах байдлаар зохион байгуулна:

49.2.1.соёлын өв, түүнийг хамгаалах мэдлэгийг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн боловсролын сургалтын стандартад тусгах;

49.2.2.коллеж, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалтын байгууллагын суралцагчид соёлын өвийг хамгаалах, ашиглах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй боловсрол эзэмшүүлэх;

49.2.3.олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр соёлын өвийг хамгаалах, өв уламжлал, ёс заншил, хууль тогтоомжийг сурталчлан таниулах.

50 дугаар зүйл.Соёлын өвийн үзэсгэлэн

50.1.Төрийн болон орон нутгийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлээр гадаадад үзэсгэлэн гаргах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллага зохион байгуулна. Энэ заалт хувь хүн, хуулийн этгээд хувийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлээр гадаадад үзэсгэлэн гаргахад хамаарахгүй.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

50.2.Энэ хуулийн 50.1-д заасан эрх бүхий байгууллага соёлын биет өвийг эзэмшигчтэй гэрээ байгуулна. Гэрээнд биет өвийг ашиглах нөхцөл, хугацаа, даатгалын баталгааны хэмжээ, түрээсийн төлбөр, ашиглагч этгээдийн хүлээх хариуцлага, хамгаалалтын болон эрсдэлийн баталгааны нөхцөлийг тусгана.

50.3.Хувийн өмчийн соёлын өвийг өмчлөгч, эзэмшигчтэй нь байгуулсан гэрээний үндсэн дээр үзэсгэлэнд оролцуулж болно.

50.4.Соёлын биет өвийг гадаадад үзэсгэлэнд гаргах гэрээг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянана.

50.5.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй палеонтологи, археологийн олдвор, дурсгалаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үзэсгэлэн гаргах, музей байгуулахыг хориглоно.

51 дүгээр зүйл.Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх

51.1.Соёлын биет өвийг хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг бүрэн хангасны үндсэн дээр зөөж тээвэрлэнэ.

51.2.Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журмыг Засгийн газар тогтооно.

52 дугаар зүйл.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх

[/Энэ зүйлийн гарчигт 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

52.1.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг, сэргээн засварлах, сурталчлах зорилгоор түүний хадгалалт, хамгаалалтын найдвартай нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр Засгийн газрын зөвшөөрлөөр нэг жилээс

дээшгүй хугацаагаар улсын хилээр нэвтрүүлнэ. Энэ хэсгийн заалт нь түүний хувилсан эх хуулбарт хамаарахгүй.

[/Энэ хэсэгт 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

52.2.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журмыг соёлын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

52.3.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 52.1-д зааснаас бусад нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг дараах зорилгоор эргүүлэн авчрах нөхцөлтэйгөөр улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

52.3.1.палеонтологи, археологийн олдворыг судалж шинжлүүлэх;

52.3.2.сэргээн засварлах;

52.3.3.гадаад улсад үзэсгэлэнд гаргах;

52.3.4.өмчлөгч өөрөө язгуур зориулалтаар нь ашиглах.

[/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

52.4.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хоёр жилээс дээшгүй хугацаагаар улсын хилээр нэвтрүүлнэ. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас уг хугацааг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн нэг удаа 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

52.5.Энэ хуулийн 52.3-т заасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлж байгаа этгээд түүний хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангасан байна.

52.6.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхэд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан маягтын дагуу мэдээллийг үйлдэж, хадгалалтын байдлын тайлан, гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулан соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалуулна.

52.7.Хууль бусаар гадаадад гаргасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, эсхүл энэ хуулийн 52.1, 52.3-т заасны дагуу улсын хилээр гаргасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл алдагдсан, үрэгдсэн тохиолдолд тэдгээрийг Монгол Улсын өмч болохыг зарлах бөгөөд эргүүлж авчрах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон цагдаагийн байгууллага хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулна.

[Энэ хэсэгт 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

52.8.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр төрийн өмчлөлд шилжүүлсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг холбогдох журмын дагуу музей, эрдэм шинжилгээний байгууллагад шилжүүлнэ.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

52.9.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хувийн өмчид байгаа түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийг дурсгалт зүйлийг өмчлөгч, эсхүл өмчлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгоно. Улсын хилээр нэвтрүүлэх түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл нь энэ хуулийн 20.7, 32.2.2-т заасан бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

53 дугаар зүйл.Соёлын өвийг хувилах

53.1.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрөлгүйгээр нийтийн өмчийн соёлын биет өвийг 1:1 масштабаар хувиран олшруулахыг хориглоно.

53.2.Энэ хуулийн 53.1-д зааснаас өөр масштабаар хувиран олшруулах эрхийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

53.3.Соёлын өвийг хувилах болон бүтээгдэхүүний загварт оруулж, зах зээлд нийлүүлэх эрх авсан байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

[/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

54 дүгээр зүйл.Соёлын өвийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх

[/Энэ зүйлийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

54.1.Энэ хуулийн 53.2-т заасан зөвшөөрөл авсан этгээдтэй мерчандайзийн гэрээг зөвхөн төрийн болон орон нутгийн музей, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон соёлын бусад байгууллага байгуулна.

[/Энэ заалтад 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

54.2.Төрийн болон орон нутгийн музей болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон соёлын бусад байгууллага нь бүтээгдэхүүний борлуулагч байж болно.

[/Энэ заалтад 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

54.3.Төрийн болон орон нутгийн музей болон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, борлуулагч нь мерчандайзийн гэрээ байгуулна. Гэрээний загварыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсэгт 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ МЕРЧАНДАЙЗИЙН ГЭРЭЭ

55 дугаар зүйл.Мерчандайзийн гэрээ

[/Энэ зүйлийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

55.1.Иргэний хуулийн 338¹ дүгээр зүйлийн дагуу мерчандайзийн гэрээгээр өмчлөгч, түүний зөвшөөрөнөөр эзэмшигч нийтийн өмчийн соёлын өвийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг үйлдвэрлэгч, борлуулагчид олгох ба үйлдвэрлэгч, борлуулагч нь эзэмшигчид борлуулалтын орлогоос соёлын өвийн загвар ашигласны төлбөр төлөх үүрэг хүлээнэ.

55.2.Мерчандайз нь барааны тэмдэг, бүтээгдэхүүний загварын эрхээр хамгаалагдана.

56 дугаар зүйл.Мерчандайзийн гэрээний талууд

[/Энэ зүйлийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

56.1.Дараах этгээд мерчандайзийн гэрээний тал байна:

56.1.1.нийтийн болон хувийн өмчийг өмчлөгч;

56.1.2.төрийн болон, орон нутгийн музей, соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс эрх олгосон соёлын бусад байгууллага;

[/Энэ заалтад 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

56.1.3.эрх олгосон үйлдвэрлэгч, борлуулагч.

57 дугаар зүйл.Мерчандайзийн гэрээний нөхцөл

[/Энэ зүйлийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

57.1.Хууль, гэрээнд өөрөөр заагаагүй бол мерчандайзийн гэрээг Иргэний хуулийн дагуу бичгээр байгуулж дараах зүйлийг тусгана:

57.1.1.мерчандайзийн зүйлийн хэмжээ, загвар, онго, материалын дэлгэрэнгүй тодорхойлолт;

57.1.2.мерчандайзийн гэрээний дагуу үйлдвэрлэх, борлуулах бүтээгдэхүүний төв хэмжээ;

- 57.1.3.үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах борлуулагч, борлуулах цэгийн мэдээлэл;
- 57.1.4.мерчандайзийн зүйлийг үйлдвэрлэх, борлуулахад шаардлагатай санхүүжилтийн хэлбэр, нөхцөл;
- 57.1.5.мерчандайзийн зүйлийг гэрээнд заасны дагуу үйлдвэрлэх, борлуулах болон чанарын баталгаа;
- 57.1.6.соёлын өвийн загвар ашигласны төлбөрийн хэмжээ, нөхцөл;
- 57.1.7.мерчандайзийн гэрээний хугацааг сунгах, гэрээний эрх, үүргийг шилжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, мерчандайзийн гэрээ ба холбогдох бусад гэрээ хоорондын харилцаа, гэнэтийн буюу давагдангүй хүчин зүйл, үүргээ биелүүлээгүй тохиолдол ба гэрээ цуцлах, дуусгавар болох үндэслэл, маргаан шийдвэрлэх журам;
- 57.1.8.талууд харилцан тохиролцсон бусад зүйл.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ӨВИЙН ХЯНАЛТ

58 дугаар зүйл.Соёлын өвийн хяналт

58.1.Соёлын өвийн хяналтыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга, улсын байцаагч, гэрээт харуул хэрэгжүүлнэ.

[/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

58.2.Соёлын өвийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллага нь соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, дүрэм журам, түүнтэй холбогдсон норм, стандартын хэрэгжилтэд хяналт тавина.

58.3.Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтад соёлын болон байгаль орчны хяналтын улсын байцаагч хяналт тавина.

[/Энэ хэсэгт 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

58.4.Соёлын өвийн хяналтын улсын байцаагчийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

58.5.Соёлын өвийн гэрээт харуулыг сум, дүүргийн Засаг дарга томилно.

59 дүгээр зүйл.Соёлын өвийн гэрээт харуулын эрх, үүрэг

59.1.Соёлын өвийн гэрээт харуул нь дараах эрх, үүрэгтэй:

- 59.1.1.түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаарх мэдээлэл, хамгаалалтын хэрэгслээр хангагдах, цалин хөлс, урамшуулал авах;
- 59.1.2.түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүрэн бүтэн байдал, эвдрэл гэмтлийг засварлах, авран хамгаалах талаар эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх;
- 59.1.3.түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг үзэж сонирхох, судлахаар ирсэн иргэнийг бүртгэх, тэдний багаж хэрэгслийг шалгах, соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийг тайлбарлаж таниулах;
- 59.1.4.түүх, соёлын үл хөдлөх дурсгалын орчинд зөвшөөрөлгүйгээр металл хайгч, тусгай багаж ашиглуулахгүй байх;
- 59.1.5.хууль бус хайгуул, малтлага хийхийг хориглох, таслан зогсоох, үйл ажиллагааг нь баримтжуулах, мэдээлэх;
- 59.1.6.хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн этгээдийг улсын байцаагч болон холбогдох хуулийн байгууллагад мэдээлэх;
- 59.1.7.хамгаалж байгаа соёлын өвийн ойролцоо байнга оршин суух.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

60 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

60.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

60.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

[/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

61 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

61.1.Энэ хуулийг 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс, мөн хуулийн 20.3, 20.4, 20.5, 46.6, 58.1 дэх хэсгийг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 12 сарын 19 өдөр

Улаанбаатар хот

НОМЫН САНГИЙН ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь номын сангийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, номын сангийн төрөл, зохион байгуулалт, чиг үүргийг тодорхойлж, уншигчийн эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Номын сангийн тухай хууль тогтоомж

2.1.Номын сангийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, энэ хууль болон бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."номын сан" гэж уншигчид тодорхой хугацаанд ашиглуулах зориулалттай сан хөмрөг бүхий мэдээлэл, соёл, боловсролын үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, нэгжийг;

3.1.2."номын сангийн үйл ажиллагаа" гэж уншигчид ном, ном зүйн мэдээллийн үйлчилгээг хүргэх болон номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагааг;

3.1.3."сан хөмрөг" гэж уншигчийн эрэлт, хэрэгцээг хангах зорилгоор бүрдүүлсэн хэвлэлийн бүтээгдэхүүн болон мэдээллийн бусад эх сурвалжийн хадгаламжийг;

3.1.4."цахим уншлагын үйлчилгээ" гэж уншигч цахим сүлжээг ашиглан эх сурвалжийг ашиглах үйлчилгээг;

3.1.5."номын татгалзал" гэж номын сангийн сан хөмрөгт байхгүй, эсхүл уншлагад хүрэлцдэггүйгээс уншигчийн хүсэлтэд удаа дараа татгалзсан хариу өгсөн номын бүртгэлийг;

3.1.6."уншигч" гэж номын сангийн үйлчилгээг хүртэгч иргэн, хуулийн этгээдийг;

3.1.7."тусгай бүлгийн уншигч" гэж хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон номын санд биеэр ирж үйлчлүүлэх боломжгүй иргэнийг;

3.1.8."хэвлэн нийтлэлийн мэдээ" гэж тухайн хэвлэлийн бүтээгдэхүүнийг эрхлэн гаргасан байгууллага, зохиогч, гаралтын болон тооны мэдээ, олон улсын стандартын дугаар бүхий мэдээллийг.

4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

4.1.Энэ хууль номын санд өмчийн хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр адил тэгш үйлчилнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭД, ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

5 дугаар зүйл.Номын сангийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг үүсгэн байгуулах, татан буулгах

5.1.Номын сангийн үйл ажиллагааг номын сангийн орчны стандартыг хангасан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, төрийн бус байгууллага, иргэн эрхэлж болно.

5.2.Төрийн өмчийн номын санг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу үүсгэн байгуулна.

5.3.Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг нийтийн номын санг татан буулгах, хувьчлахгүй байх зарчмыг баримтална.

5.4.Энэ хуулийн 5.3-т зааснаас бусад эх үүсвэрээс санхүүждэг номын сан үйл ажиллагаагаа бүрмөсөн зогсоох тохиолдолд сан хөмрөгийг өмчлөгчийн саналыг харгалзан аль нэгэн нийтийн номын санд шилжүүлж болно.

5.5.Номын сангийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь уншлага үйлчилгээний чанарыг сайжруулах, хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэхэд олон нийтийн дэмжлэгийг авах, тэдний зүгээс номын сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах зорилгоор соёл, боловсрол, хүүхэд, залуучуудын болон олон нийтийн байгууллага, иргэдийн төлөөлөл бүхий орон тооны бус номын сангийн зөвлөл ажиллуулж болно.

6 дугаар зүйл.Номын сангийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн эрх, үүрэг

6.1.Номын сангийн үйл ажиллагаа эрхлэх этгээд дараах эрхтэй байна:

6.1.1.соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан номын сангийн үлгэрчилсэн дүрмийг үндэслэн үйлчилгээний журмыг батлах;

6.1.2.дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрт хамрагдах, бусад байгууллагатай мэргэжлийн чиглэлээр хамтран ажиллах;

6.1.3.уншигчийн номын санд учруулсан хохирлыг зохих журмын дагуу нөхөн төлүүлэх.

6.2.Номын сангийн үйл ажиллагаа эрхлэх этгээд дараах үүрэгтэй байна:

6.2.1.стандартад нийцсэн орчин нөхцөлд зохих үйлчилгээг уншигчид үзүүлэх;

6.2.2.уншигчид уншлагын үйлчилгээг зохих журмын дагуу хүргэх;

6.2.3.номын сангийн сан хөмрөгийн бүрэн бүтэн байдлыг хангах;

6.2.4.номын сангийн сан хөмрөгийн эргэлтэд байнга судалгаа хийж, бүрдүүлэлтийн чанарыг сайжруулах арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

6.2.5.Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах судар болон хуучин ном, гар бичмэлийг сурвалжлан олох, нөхөн бүрдүүлэх, олон нийтэд сурталчлах, хадгалах, хамгаалах хэвийн нөхцөлийг хангаж ажиллах;

6.2.6.номын сан, ном зүйн мэдээллийг автоматжуулах, үйл ажиллагаандаа орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, цахим мэдээллийн санг бий болгох;

6.2.7.номын сангийн үйл ажиллагааны тайлан, мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад үнэн зөв гаргаж өгөх;

6.2.8.дотоод, гадаадын номын сан, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

7 дугаар зүйл.Үндэсний номын сангийн эрх зүйн байдал

7.1.Монгол Улсын Үндэсний номын сан /цаашид "Үндэсний номын сан" гэх/ нь монголын ард түмний бичиг үсгийн дурсгалыг хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үүрэг бүхий байгууллага байна.

7.2.Үндэсний номын сан нь төрөөс үүсгэн байгуулсан хуулийн этгээд бөгөөд тогтоосон загвараар хийсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

7.3.Үндэсний номын сан нь өөрийн билэгдэлтэй байж болно.

7.4.Үндэсний номын сан нь эртний гар бичмэл, ном, судар, хэвлэлийн бүтээгдэхүүнийг сэргээн засварлах үндэсний хэмжээний төв лабораторитой байж болно.

7.5.Үндэсний номын сангийн сан хөмрөг төрийн хамгаалалтад байна.

7.6.Үндэсний номын сан нь бусад номын санг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

8 дугаар зүйл.Үндэсний номын сангийн зөвлөл

8.1.Үндэсний номын сангийн дэргэд орон тооны бус Эрдмийн зөвлөл болон Мэргэжлийн зөвлөл ажиллах бөгөөд Эрдмийн зөвлөл болон Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.2.Эрдмийн зөвлөл нь салбарын эрдэм шинжилгээ-судалгааны ажлын чиглэлийг тогтоох, эртний ном судар, гар бичмэлийг судалгааны эргэлтэд оруулах, номын сан-ном зүй судлал, арга зүйн чиглэлээр зөвлөгөө өгч ажиллана.

8.3.Мэргэжлийн зөвлөл нь мэргэжлийн гарын авлага, ном, сурах бичигт дүгнэлт өгөх, уншлага үйлчилгээний чанарыг сайжруулах, номын сангийн ном бүрдүүлэлтэд дүн шинжилгээ хийх, уншигчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн баяжилт хийх, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх талаар төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний номын сангийн удирдлагад санал оруулна.

9 дүгээр зүйл. Үндэсний номын сангийн үүрэг

9.1. Үндэсний номын сан энэ хуулийн 7.1-д зааснаас гадна үндэсний ном зүйн нэгдсэн мэдээллийн санг байгуулах ажлыг зохион байгуулах, бусад номын санг эрдэм шинжилгээ-судалгаа, мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, хэвлэлийн бүтээгдэхүүнийг сэргээн засварлах ажлыг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

9.2. Үндэсний ном зүйн нэгдсэн санг зохион байгуулах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

9.2.1. ном зүйн нэгдсэн лавлагаа, мэдээллийн санг цаасан ба цахим хэлбэрээр бүрдүүлж, бусад номын сангийн сан хөмрөгийн мэдээллийг хадгалах;

9.2.2. ном зүйн мэдээллийн сан хөмрөг бий болгох зорилгоор уншлага үйлчилгээнд ашиглуулахгүйгээр зайлшгүй хадгалах шаардлагатай хэвлэлийн бүтээгдэхүүний архивын сан хөмрөг бүрдүүлэх.

9.3. Эрдэм шинжилгээ-судалгаа, мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

9.3.1. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн дагуу эрдэм шинжилгээ-судалгааны ажлыг гүйцэтгэх;

9.3.2. ном зүйн мэдээллийн хэрэглэгдэхүүн бэлтгэх, улсын нэгдсэн каталоги, үндэсний ном зүйг эрхлэн гаргах;

9.3.3. нийгэмд номын сангийн гүйцэтгэх үүрэг, ном хэвлэлийн ач холбогдлыг сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах;

9.3.4. гадаад, дотоодын номын сан, ном хэвлэлийн байгууллагатай хамтран ажиллах;

9.3.5. бүх төрлийн номын сангийн сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтын чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх.

9.4. Ганц хувь бүтээл, гар бичмэл, барын ном, судрын хадгалалт, хамгаалалтын ажлыг зохион байгуулах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

9.4.1. түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах ном, судрыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу бүртгүүлж, хамгаалах;

9.4.2. энэ хуулийн 9.4.1-д зааснаас бусад гар бичмэл, ном, судар, бусад зүйлийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу хадгалах, хамгаалах, ашиглах;

9.4.3. шаардлагатай бол орон нутагт номын сангийн стандартын шаардлага хангаагүй орчинд хадгалагдаж байгаа ганц хувь бүтээл, ном, гар бичмэл, барын ном, судар, бусад зүйлийг эзэмшигч байгууллагын хүсэлтээр хадгалах.

9.5. Үндэсний номын сан нь бусад номын санд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор жил бүр номын санчийн гарын авлага бэлтгэн гаргаж, гурав хүртэлх хувийг үнэ төлбөргүй түгээнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ НОМЫН САНГИЙН ТӨРӨЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, ЭРХ, ҮҮРЭГ

10 дугаар зүйл. Номын сангийн төрөл

10.1. Номын сан нийтийн, сургалтын, хүүхдийн, эрдэм шинжилгээний болон бусад төрөлтэй байна.

/Энэ хэсэгт 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

10.2. Нийтийн номын сан нийгмийн бүх гишүүнд үйлчилгээ үзүүлнэ.

10.3. Бүх шатны боловсролын байгууллага сургалтын номын сантай байх бөгөөд сургалтын номын сан нь багш, суралцагчийн сурч, хөгжих үйл явцыг дэмжихэд чиглэсэн үйлчилгээ үзүүлнэ.

10.4. Эрдэм шинжилгээний номын сан судалгаа шинжилгээ, мэдээллийн түшиц газар байж, судалгаа шинжилгээний үйл ажиллагааг дэмжих зорилго бүхий үйлчилгээ үзүүлнэ.

10.5. Хүүхдийн номын сан нь хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон ном, мэдээллийн үйлчилгээг үзүүлнэ.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./

10.6. Бүх төрлийн номын сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, салбарын хөгжлийн бодлого боловсруулахад санал, дүгнэлт өгөх үүрэг бүхий орон тооны бус Номын сангийн Үндэсний зөвлөл соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана. Уг зөвлөлийн ажиллах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./

11 дүгээр зүйл. Номын сангийн үйлчилгээ

11.1. Номын сангийн үйлчилгээ нь үндсэн ба нэмэлт үйлчилгээнээс бүрдэнэ.

11.2. Номын сан нь уншигчид дараах хэлбэрээр үйлчилгээ үзүүлнэ:

11.2.1. уншлагын танхимын үйлчилгээ;

11.2.2. гэрээр ном олгох үйлчилгээ;

11.2.3. зөөврийн номын сангийн үйлчилгээ;

11.2.4. цахим уншлагын үйлчилгээ;

11.2.5. ном зүйн үйлчилгээ;

11.2.6. тусгай бүлгийн уншигчийн хэрэгцээг хангахад чиглэсэн үйлчилгээ;

11.2.7. бусад.

11.3. Номын сангийн үндсэн үйлчилгээ нь энэ хуулийн 11.2.1-д заасан үйлчилгээ байна.

12 дугаар зүйл. Зөөврийн номын сангийн үйлчилгээ

12.1. Номын сан нь алслагдсан нутаг дэвсгэрийн иргэдэд соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлэх журмын дагуу зөөврийн номын сангийн үйлчилгээг үзүүлнэ.

12.2. Номын сан нь сан хөмрөгтөө хадгалагдаж байгаа ном, хэвлэлийн нэгдсэн жагсаалтыг орон нутгийн засаг захиргааны нэгж, байгууллагад хүргүүлэн уншигчаас шаардлагатай судалгаа, захиалгыг авсны үндсэн дээр үйлчилнэ.

12.3. Зөөврийн номын сангийн үйлчилгээ болон гэрээр ном олгох үйлчилгээгээр үнэт ховор ном, лавлах материал, гурав хүртэлх хувьтай ном, тогтмол хэвлэлийг олгохгүй.

13 дугаар зүйл. Цахим уншлагын үйлчилгээ

13.1. Цахим уншлагын үйлчилгээ үзүүлэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

13.2. Номын сан нь зохиогчийн эрх эзэмшигчтэй гэрээ байгуулсны үндсэн дээр өөрийн сан хөмрөгт байгаа ном хэвлэлийг бүрэн болон хэсэгчлэн цахим хэлбэрт оруулж цахим уншлагын үйлчилгээг үзүүлнэ.

13.3. Энэ хуулийн 13.2-т заасан шаардлага нь зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрх хуульд заасан үндэслэлээр төрд шилжсэн ном хэвлэлийг улсын болон орон нутгийн номын сан цахим хэлбэрт шилжүүлэн цахим уншлагын үйлчилгээ үзүүлэхэд хамаарахгүй.

14 дүгээр зүйл. Номын сангийн уншигчийн эрх, үүрэг

14.1. Уншигч нь Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлд хамаарах болон ганц хувь бүтээл, гар бичмэл, зохиогчийн эрхэд хамаарах эрхээр хамгаалагдах бүтээлээс бусад хэвлэлийн бүтээгдэхүүнийг чөлөөтэй ашиглана.

14.2. Энэ хуулийн 14.1-д заасан хэвлэлийн бүтээгдэхүүнийг ашиглах асуудлыг Соёлын өвийг хамгаалах тухай, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

14.3. Уншигч дараах эрх, үүрэгтэй:

14.3.1. төрийн болон орон нутгийн өмчийн номын сангийн үндсэн үйлчилгээг үнэ төлбөргүй авах;

14.3.2. стандартад нийцсэн орчин нөхцөлд зохих үйлчилгээг авах;

14.3.3. номын сан хоорондын солилцоогоор ном болон түүний хуулбараар үйлчлүүлэх;

14.3.4. уншигчийн эрх зөрчигдвөл холбогдох байгууллагад гомдол гаргах;

14.3.5. номын сангаас зохиож байгаа соёл, олон нийтийн ажилд оролцох, номын сангийн үйлчилгээний талаар санал оруулах;

14.3.6. ном, хэвлэлийг гэмтээж, үрэгдүүлбэл соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан алдагдсан буюу гэмтээгдсэн ном, хэвлэлийг төлүүлэх журмын дагуу хохирлыг нөхөн төлөх;

14.3.7. номын сангийн үйл ажиллагаанд номын сангийн зөвлөл, холбоогоор дамжуулан оролцох;

- 14.3.8.номын сангийн дүрэм, журмыг сахиж мөрдөх;
 14.3.9.ганцаарчилсан болон бүлгээр ажиллах боломжоор хангагдах.
15 дугаар зүйл.Тусгай бүлгийн уншигчийн эрх, үүрэг
 15.1.Тусгай бүлгийн уншигч энэ хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас гадна дараах эрхтэй:

- 15.1.1.харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэн тусгай форматад хөрвүүлсэн брайлын, сонсдог ном хэвлэлээр үйлчлүүлэх;
 15.1.2.номын санд биеэр ирж үйлчлүүлэх боломжгүй өндөр настай, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэрээр ном олгох үйлчилгээг авах;
 15.1.3.цэргийн анги, асрамжийн газар, хорих байгууллага номын сангийн үндсэн болон зөөврийн номын сангийн үйлчилгээ авах.

ТАВДУГААР БҮЛЭГ НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГ

16 дугаар зүйл.Номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт

- 16.1.Номын сангийн сан хөмрөг нь хэвлэн нийтлэлийн мэдээг бүрэн агуулсан хэвлэмэл болон хэвлэмэл бус хэвлэлийн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.
 16.2.Номын сан нь сан хөмрөгийг доор дурдсанаар бүрдүүлнэ:
 16.2.1.заавал авах хувь;
 16.2.2.худалдан авах;
 16.2.3.нөхөн бүрдүүлэх;
 16.2.4.ном солилцох;
 16.2.5.хандив, тусламж;
 16.2.6.өв залгамжлал;
 16.2.7.бусад.

17 дугаар зүйл.Номын сангийн заавал авах хувь

- 17.1.Оюуны бүтээлийн архив, үндэсний хэмжээний ном хэвлэлийн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор захиалагч болон зохиогч нь доор дурдсан хэвлэлийн бүтээгдэхүүнийг хэвлэгдэн гарснаас хойш 30 хоногийн дотор номын санд тодорхой хувийг үнэ төлбөргүйгээр хүлээлгэж өгнө:
 17.1.1.улсын төсвийн хөрөнгөөр хэвлүүлсэн хэвлэлийн бүтээгдэхүүнээс таван ширхгийг, эрдмийн зэрэг хамгаалсан бүтээлээс хоёр хүртэл ширхгийг, Монгол Улсын соёлын өвд хамаарах зүйлийн талаарх судалгааны бүтээлийг санхүүжилтын эх үүсвэр, хэвлэгдсэн хэл, газрыг харгалзахгүйгээр хоёр хүртэл ширхгийг тус тус Монгол Улсын Үндэсний номын санд;
 17.1.2.орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэвлүүлсэн хэвлэлийн бүтээгдэхүүн тус бүрээс гурван ширхгийг орон нутгийн номын санд.
 17.2.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэвлүүлсэн хэвлэлийн бүтээгдэхүүнийг эрхлэн гаргасан байгууллага, иргэн нь хэвлүүлснээс хойш нэг сарын дотор энэ хуулийн 17.1-д заасан номын санд шилжүүлнэ.
 17.3.Хүүхдэд зориулсан хэвлэлийн бүтээгдэхүүн тус бүрээс хоёр ширхгийг Хүүхдийн төв номын санд авч болно.

18 дугаар зүйл.Худалдан авах

- 18.1.Улсын болон орон нутгийн номын сан нь тухайн жилд зайлшгүй худалдан авах шаардлагатай номыг төсөвт өртөгтөө багтаан худалдан авах ажиллагааг зохион байгуулна.

[/Энэ хэсэгт 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

- 18.2.Хэвлэлийн бүтээгдэхүүний үндэсний сан хөмрөг бүрдүүлэх зорилгоор баримтат өвийн зайлшгүй хадгалах сан хөмрөгийг Үндэсний номын санд бүрдүүлж байршуулах бөгөөд үндэсний сан хөмрөг бүрдүүлэхэд энэ хуулийн 17 дугаар зүйлд зааснаас бусад хэвлэлийн бүтээгдэхүүн тус бүрээс хоёр ширхгийг авна. Зохиогч хүсэлт гаргасан тохиолдолд хоёр ширхгийг хэвлэлтийн өртгөөр нь худалдан авахад шаардагдах зардлыг төр хариуцна.

- 18.3.Сургууль, цэцэрлэгийн сургалтын номын сан нь хүүхдийн хөгжил, төлөвшил, сэтгэхүйн онцлогт нийцсэн байдлыг харгалзан боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жагсаалтыг үндэслэн худалдан авах ажлыг зохион байгуулна.
 18.4.Энэ хуулийн 18.1-д заасан номыг худалдан авахдаа номын татгалзал, номын борлуулалтын судалгаа болон цахим санал асуулгын дүнг үндэслэн худалдан авна.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

- 18.5.Дайн, түрэмгийлэл, садар самууныг сурталчилсан хэвлэлийн бүтээгдэхүүнийг худалдан авахыг хориглоно.
 18.6.Номын сан нь энэ хуулийн 18.1, 18.5-д зааснаас бусад ном, хэвлэлийг чөлөөтэй сонгож авна.
19 дүгээр зүйл.Номын сангийн сан хөмрөгийн бүртгэл, тооллого
 19.1.Номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа ном хэвлэлийн тооллого хийх хугацааг номын сангийн төрөл, сан хөмрөгийн хэмжээ, зориулалтаас хамааран тогтооно.
 19.2.Номын сангийн сан хөмрөгийн бүртгэл, тооллого хийх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20 дугаар зүйл.Номын сангийн сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт

- 20.1.Номын сангийн сан хөмрөгийг стандартын шаардлага хангасан зориулалтын байранд хадгална.
 20.2.Түүх, соёлын дурсгалт зүйлийн хосгүй үнэт, үнэт зэрэглэлд хамаарах болон ганц хувь бүтээлийг цахим хэлбэрт оруулж баримтын хамгаалалтын хувь хийж, эх баримтаас тусад нь хадгална.
 20.3.Түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах болон ганц хувь бүтээл, гар бичмэлийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу бүртгүүлж, хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг хангасан байх бөгөөд энэхүү шаардлагыг хангах боломжгүй тохиолдолд Үндэсний номын санд нэн даруй шилжүүлэн хадгалуулж, хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг бүрдүүлсний дараа буцаан шилжүүлнэ.
 20.4.Номын сангийн сан хөмрөг нь гамшиг болон аюул, үймээн самуун, гэмт халдлагын үед устаж үрэгдэж болзошгүй бусад нөлөөллөөс хамгаалагдсан байна.

[/Энэ хэсэгт 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

- 20.5.Улсын болон орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг гамшиг болон аюулын үед нүүлгэн шилжүүлэх журмыг Засгийн газар батална.

[/Энэ хэсэгт 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

- 20.6.Номын сан нь гамшиг болон аюулын үед ажиллах төлөвлөгөөтэй байна.

[/Энэ хэсэгт 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

- 20.7.Номын сангийн сан хөмрөгийг даатгуулж болно.

21 дүгээр зүйл.Түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах болон ганц хувь бүтээл, гар бичмэлийг ашиглуулах

- 21.1.Түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах болон ганц хувь бүтээл, гар бичмэлийг цахим болон хуулбар хэлбэрээр уншуулна.
~~21.2.Түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах болон ганц хувь бүтээл, гар бичмэлийн эх хувийг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах тохиолдолд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийн үндсэн дээр сонирхогч этгээдтэй гэрээ байгуулан ашиглуулна.~~

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

22 дугаар зүйл.Сэргээн засварлах, нөхөн бүрдүүлэх

- 22.1.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь номын сангийн саналыг харгалзан нэн яаралтай хамгаалалтад авах шаардлагатай хэвлэлийн бүтээгдэхүүний жагсаалтыг батлах ба жагсаалтаар батлагдсан хэвлэлийн бүтээгдэхүүнийг сэргээн засварлах, хэвлэх зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгана. Үндэсний судлаачдын судлаагүй хэвлэлийн бүтээгдэхүүнийг сэргээн засварлах, хэвлүүлэх зөвшөөрлийг гадаадын байгууллага, иргэнд олгохгүй.
 22.2.Номын сангийн сан хөмрөгт байхгүй, түүх болон судалгаа, шинжилгээний ач холбогдол бүхий ном, судрыг нөхөн бүрдүүлнэ. Нөхөн бүрдүүлэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ
НОМЫН САНГИЙН САНХҮҮЖИЛТ, ДЭМЖЛЭГ**

23 дугаар зүйл. Номын сангийн санхүүжилт

23.1. Номын сангийн санхүүжилт нь улсын төсвийн болон гадаад, дотоодын байгууллага, иргэний хандив, тусламж, өөрийн үйл ажиллагааны орлого зэргээс бүрдэнэ.

23.2. Төрийн болон орон нутгийн өмчийн номын сангийн орчны стандартыг хангах, сан хөмрөгийн бүрдүүлэлтэд шаардагдах төсвийг төр хариуцна. Тусгай бүлгийн уншигчид зориулсан номын сангийн үйлчилгээнд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

23.3. Номын сан өөрийн үйл ажиллагааны орлоготой холбоотой хэвлэх цех, дэлгүүр ажиллуулж болох бөгөөд өөрийн үйл ажиллагааны орлогыг захиран зарцуулна.

24 дүгээр зүйл. Номын сангийн үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэг

24.1. Засгийн газар гадаадын номын санд хадгалагдаж байгаа монголын түүхэнд холбогдох ном, гар бичмэл болон түүний хуулбарыг Монгол Улсад авчрах, монгол судлалын чиглэлээр гадаадад хэвлэгдсэн ном, хэвлэлийн бүтээгдэхүүнийг Үндэсний номын сангийн сан хөмрөгт нөхөн бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

[/Энэ хэсэгт 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

24.2. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь уншлагыг дэмжих олон талт арга хэмжээг зохион байгуулах, уншлагыг дэмжих журам боловсруулан хэрэгжүүлэх, тэргүүний уншигч-иргэн, гэр бүл, байгууллагыг сурталчилна.

24.3. Хувийн номын сангийн сан хөмрөгт чухал ач холбогдол бүхий ганц хувь бүтээл байгаа тохиолдолд тухайн номын санд дэмжлэг үзүүлэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

24.4. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ иргэдэд номын сангийн үйлчилгээг хүргэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

24.4.1. номын сангийн сан хөмрөгийг баяжуулах, сэргээн засварлах, хамгаалах, номын сангийн үйлчилгээ хүргэх төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;

[/Энэ заалтыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

24.4.2. зөврийн номын сангийн үйлчилгээг малчид, тариаланчид, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх арга хэмжээг зохион байгуулах;

[/Энэ заалтыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

24.4.3. уншлагыг дэмжих олон талт арга хэмжээ, үйлчилгээг зохион байгуулахад төсөв, санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх;

[/Энэ заалтыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

24.4.4. номын сангийн үйлчилгээний стандарт, норм, нормативыг сахин мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих;

[/Энэ заалтыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

24.4.5. номын сангийн сан хөмрөгийг хадгалах, хамгаалах, цахим үйлчилгээ нэвтрүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, холбогдох зардлыг төсөвт тусгах.

[/Энэ заалтыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

24.5. Энэ хуулийн 24.1-д заасан зардлыг төр хариуцна.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

25 дугаар зүйл. Төлбөртэй үйлчилгээ үзүүлэх

25.1. Номын сан нь Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн дараах тохиолдолд төлбөртэй үйлчилгээ үзүүлж болно:

25.1.1. нэмэлт үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд;

25.1.2. гэрээний үндсэн дээр тодорхой нэг салбарын мэдээллийн үйлчилгээ үзүүлэх.

25.2. Улсын болон орон нутгийн номын сангийн нэмэлт үйлчилгээ үзүүлэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**ДОЛООДУГААР БҮЛЭГ
БУСАД**

26 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

26.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

26.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

[/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 2 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ ХЭЛНИЙ ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Монгол хэлний тухай хууль тогтоомж

2.1.Монгол хэлний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол уг гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бусад хуулийн этгээдэд хамаарна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."төрийн албан ёсны хэл" гэж төрийн байгууллага, хуулийн этгээдийн аливаа үйл ажиллагаа явуулах, албан хэрэг хөтлөх орчин цагийн утга зохиолын монгол хэлийг;

4.1.2."монгол хэлний хэм хэмжээ" гэж орчин цагийн утга зохиолын монгол хэлний найруулан бичих, зөв дуудах ёс, зүй тогтол, зөв бичих дүрмийг;

4.1.3."үндэсний бичиг" гэж уламжлалт монгол бичгийг;

4.1.4."монгол хэл, бичиг" гэж монгол хэл, кирил болон үндэсний бичгийг.

5 дугаар зүйл.Хуулийн үндсэн зарчим

5.1.Монгол хэл нь монгол үндэстний оюуны соёлын үнэт өв, үндэсний соёл иргэншлийн язгуур үндэс, улс орны нэгдмэл байдал, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын нэгэн баталгаа мөн.

5.2.Монгол хэл, бичиг үсгийг эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах нь төрийн үүрэг мөн.

5.3.Монгол Улсын иргэн бүр монгол хэл, бичиг үсгээ сурах, монгол хэлээр мэдээлэл авах, өвлөх, өвлүүлэх, хамгаалах, хөгжүүлэх боломж, нөхцөлөөр хангагдах эрхтэй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ ХЭЛИЙГ ХЭРЭГЛЭХ

6 дугаар зүйл.Монгол хэлийг хэрэглэх

6.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт дараах үйл ажиллагаа, албан хэргийг монгол хэлээр хөтлөн явуулна:

6.1.1.төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлт;

6.1.2.төрөөс олгосон зөвшөөрлийн дагуу гадаад хэлээр сургалт явуулдаг байгууллагаас бусад бүх шатны боловсролын байгууллагын сургалт;

6.1.3.бүх шатны шүүн таслах ажиллагааны тэмдэглэл, архивын холбогдох баримт бичиг;

6.1.4.Монгол Улсын олон улсын гэрээ;

6.1.5.Монгол Улсаас гадаад улс, дипломат төлөөлөгчийн газарт илгээх албан ёсны ноот бичиг;

6.1.6.Монгол Улсын иргэний үнэмлэх, төрсний болон гэрлэлтийн гэрчилгээ, үндэсний гадаад паспорт, боловсролын баримт бичиг;

6.1.7.газар нутаг, засаг захиргааны нэгж, гудамж, зам, талбай, хуулийн этгээдийн нэр, хаяг;

6.1.8.Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх бичиг, захидал хүлээн авагч, илгээгчийн хаяг;

6.1.9.төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас хэвлэн гаргах мэдээлэл, товхимол;

6.1.10.олон нийтэд зориулсан зар;

6.1.11.албан байгууллага, барилга, байгууламж, нийтийн тээврийн хэрэгсэлд байрлуулах зааварчилгаа, мэдээлэл, аюулгүй ажиллагааны санамж.

6.2.Энэ хуулийн 6.1.4-6.1.6, 6.1.9-6.1.11-т заасан үйл ажиллагаа явуулах, албан хэрэг хөтлөхөд олон улсын харилцааны хэрэгцээ, шаардлагыг харгалзан гадаад хэл давхар хэрэглэж болно.

6.3.Төрөөс олгосон зөвшөөрлийн дагуу гадаад хэлээр сургалт явуулдаг болон гадаад хэл заах тусгай зөвшөөрөл бүхий ерөнхий боловсролын сургуулиас бусад ерөнхий боловсролын сургуульд гадаад хэлийг тавдугаар ангиас эхлэн зааж болно.

6.4.Газар нутаг, гудамж, зам, талбайд гадаад нэр оноох асуудлыг нутгийн өөрөө удирдах байгууллага энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагатай зөвшилцөн шийдвэрлэнэ.

6.5.Бүх шатны сургалт, эрдэм шинжилгээний ажилд шинжлэх ухааны нэр томъёог монгол хэлнээ орчуулан хэрэглэхийг эрхэмлэнэ.

6.6.Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар болон олон улсын байгууллага Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд гадаад хэлээр хандах бол монгол орчуулгыг хавсаргана.

6.7.Монгол Улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаадын хуулийн этгээд, төрийн бус байгууллага Монгол Улсын төрийн байгууллага, иргэнтэй монгол хэлээр харилцаж, санхүү, татвар, хөдөлмөр, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой баримт бичиг, мэдээллийг монгол хэлээр үйлдэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БИЧИГ ҮСЭГ СОНГОН ХЭРЭГЛЭХ

7 дугаар зүйл.Бичиг үсэг сонгон хэрэглэх

7.1.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, хуулийн этгээд албан хэргээ кирил бичгээр хөтлөн явуулна.

7.2.Энэ хуулийн 11.1.2-т заасан үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна.

7.3.Өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад үндэсний бичгийг зургаадугаар ангиас эхлэн төгсгөл тусгайлсан хөтөлбөрөөр заана.

7.4.Их, дээд сургуульд элсэгчдээс авах элсэлтийн ерөнхий шалгалт болон төрийн албанд анх орох иргэнээс авах монгол хэлний шалгалтын агуулгын дөрөвний нэгээс доошгүй хувь нь үндэсний бичгийн мэдлэгийг үнэлэхэд чиглэнэ.

7.5.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдаас гадаад улсын адил төвшний албан тушаалтанд илгээх албан бичиг, захидлыг үндэсний бичгээр үйлдэж гадаад хэлээрх орчуулгыг хавсаргана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МОНГОЛ ХЭЛНИЙ ЗӨВ БИЧИХ ДҮРЭМ, ТОЛЬ БИЧИГ

8 дугаар зүйл.Монгол хэлний зөв бичих дүрэм, толь бичиг

8.1.Монгол Улсын хэмжээнд кирил болон үндэсний бичгийн зөв бичих тус тусын нэгдмэл дүрэмтэй байх бөгөөд иргэн, хуулийн этгээд уг дүрмийг дагаж мөрдөнө.

8.2.Кирил болон үндэсний бичгийн зөв бичих дүрэм, түүний өөрчлөлтийг энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллага хариуцан боловсруулж, 21.1-д заасан эрх бүхий байгууллага баталснаар хүчин төгөлдөр болно.

8.3.Кирил болон үндэсний бичгийн зөв бичих дүрмийг баримтлан зохиосон толь бичгийг энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллага хянаж, 21.1-д заасан эрх бүхий байгууллага хэлэлцэн батална.

ТАВДУГААР БҮЛЭГ **ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮҮРЭГ**

9 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгч

9.1.Монгол Улсын Ерөнхийлөгч монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар дараах үүрэг хүлээнэ:

9.1.1.монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэхтэй холбоотой төрийн бодлогын талаарх саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

9.1.2.монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажил, анхаарах асуудлын талаар хоёр жил тутам Улсын Их Хуралд мэдээлэл хийх;

9.1.3.монгол хэл, бичиг үсгээ хэрэглэх, эзэмших, хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр зарлиг гаргах, төрийн холбогдох байгууллагад чиглэл өгөх;

9.1.4.энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагын бүрэлдэхүүнийг томилж, чөлөөлөх;

9.1.5.монгол хэл, бичиг үсгээ хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гаргасан иргэн, хуулийн этгээдэд дөрвөн жил тутамд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал олгох;

9.1.6.хуульд заасан бусад үүрэг.

10 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурал

10.1.Монгол Улсын Их Хурал монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар дараах үүрэг хүлээнэ:

10.1.1.монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

10.1.2.монгол хэл, бичиг үсгийг хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх улс төр, эдийн засгийн баталгааг бүрдүүлэх;

10.1.3.монгол хэл, бичиг үсгийг хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэхтэй холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

10.1.4.хуульд заасан бусад үүрэг.

11 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газар

11.1.Монгол Улсын Засгийн газар монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар дараах үүрэг хүлээнэ:

11.1.1.монгол хэлний талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хангах;

11.1.2.монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулж хэрэгжүүлэх;

11.1.3.гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэн, түүний гэр бүлд монгол хэл, бичиг үсэг, уламжлалт зан заншил, түүх соёлын мэдлэг эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

11.1.4.төрийн захиргааны бүх шатны байгууллагын төрийн албан хэрэгт кирил болон үндэсний бичгийн хэлний хэм хэмжээг мөрдүүлж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах;

11.1.5.хуульд заасан бусад үүрэг.

12 дугаар зүйл.Төрийн албаны төв байгууллага

12.1.Төрийн албаны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

12.1.1.төрийн албанд анх орох иргэнээс авах монгол хэлний шалгалтыг энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагаас баталсан агуулгын дагуу зохион байгуулж, холбогдох мэдээллийн сан бүрдүүлэх;

12.1.2.хуульд заасан бусад үүрэг.

13 дугаар зүйл.Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

13.1.Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

13.1.1.бүх шатны боловсролын сургалтын байгууллагын монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын хичээлийн агуулга, хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөг энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагын саналыг тусган батлах;

13.1.2.их, дээд сургуульд элсэгчдээс авах элсэлтийн ерөнхий шалгалтын монгол хэлний шалгалтын агуулгыг энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагын саналыг тусган батлах;

13.1.3.сурган хүмүүжүүлэх ухаан, хэл шинжлэл, уран зохиол, сэтгүүл зүйн чиглэлээр их, дээд сургуульд элсэгчдээс авах монгол хэл, бичгийн шалгалтын тусгайлан журам боловсруулах;

13.1.4.суралцагчдын дийлэнх олонх хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх байвал сургалтыг хос хэлний хөтөлбөрөөр явуулах бөгөөд хос хэлний хөтөлбөрийн агуулгыг батлах;

13.1.5.үндэстний цөөнх монгол хэл болон эх хэл дээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

13.1.6.хуульд заасан бусад үүрэг.

14 дүгээр зүйл.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

14.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

14.1.1.монгол хэл, бичгийн соёлын өвийг хамгаалах, үндэсний монгол бичгээрх оюуны өв сан, ардын аман зохиол болон монгол утга зохиолын судалгаа, сургалтыг өргөжүүлэх ажлыг боловсролын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

14.1.2.хуульд заасан бусад үүрэг.

15 дугаар зүйл.Мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага *[/Энэ зүйлийн гарчигт 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)*

15.1.Мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

[/Энэ хэсэгт 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

15.1.1.цахим орчинд монгол хэл, бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх;

15.1.2.латин үсэг хэрэглэх загварчилсан дүрэм, журмыг мөрдүүлэх ажлыг энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллага, холбогдох бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

15.1.3.энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагын баталсан кирил болон үндэсний бичгийн хооронд харилцан хөрвүүлэг хийх, зөв бичих дүрмийн алдаа хянах болон бусад холбогдох программын хэрэглээг нэмэгдүүлэх, цахим орчинд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

15.1.4.хуульд заасан бусад үүрэг.

16 дугаар зүйл.Ерөнхий боловсролын сургууль

16.1.Ерөнхий боловсролын сургууль дараах үүрэг хүлээнэ:

16.1.1.суралцагчдад монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын хичээлийг эрх бүхий байгууллагаас баталсан хөтөлбөр, агуулга, стандартын дагуу тасалдалгүй явуулах;

16.1.2.хуульд заасан бусад үүрэг.

16.2.Энэ хуулийн 16.1.1 дэх заалт эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр гадаад хэлээр сургалт явуулдаг ерөнхий боловсролын сургуульд нэгэн адил хамаарна.

17 дугаар зүйл.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга *[/Энэ зүйлийн гарчигт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)*

17.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга дараах үүрэг хүлээнэ:

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

17.1.1.харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд энэ хуулийн хэрэгжилтийг хангах, түүнтэй холбоотой үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

17.1.2.харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд албан байгууллага, гудамж, талбайн нэр хаягийг кирил болон үндэсний бичгээр хослуулан, эсхүл дангаар нь бичиж хэвших ажлыг зохион байгуулах;

17.1.3.үндэсний бичгийн хэрэглээг түгээн дэлгэрүүлэхэд идэвх санаачилга гарган ажиллаж байгаа иргэн, хуулийн этгээдийг урамшуулах ажлыг зохион байгуулах;

17.1.4.хуульд заасан бусад үүрэг.

18 дугаар зүйл.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага

18.1.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага дараах үүрэг хүлээнэ:

18.1.1.энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчлийг холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэх, үр дүнг шуурхай мэдээлэх;

18.1.2.хуульд заасан бусад үүрэг.

19 дүгээр зүйл.Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага

19.1.Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага дараах үүрэг хүлээнэ:

19.1.1.монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээг чанд баримтлах;

19.1.2.сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны мэргэжлийн ур чадварын шалгалтад монгол хэл, бичгийн мэдлэгийн шалгуур тогтоосон байх;

19.1.3.хуульд заасан бусад үүрэг.

20 дугаар зүйл.Монгол Улсын иргэн

20.1.Монгол Улсын иргэн дараах эрх эдэлнэ:

20.1.1.монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, монгол хэлээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар санаачилга гаргах;

20.1.2.хуульд заасан бусад эрх.

20.2.Монгол Улсын иргэн дараах журамт үүрэг хүлээнэ:

20.2.1.монгол хэлний хэм хэмжээг дагаж мөрдөх;

20.2.2.хуульд заасан бусад үүрэг.

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ
ХЭЛНИЙ БОДЛОГЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ****21 дүгээр зүйл.Хэлний бодлогын үндэсний зөвлөл**

21.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд монгол хэлийг хамгаалах, хөгжүүлэх үндсэн үүрэг бүхий Хэлний бодлогын үндэсний зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ ажиллана.

21.2.Зөвлөл есөн гишүүнтэй байна. Гишүүдийг Монгол Улсын Ерөнхийлөгч монгол хэл, утга зохиолын эрдэмтэн, хэвлэл мэдээлэл, боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын мэргэжлийн төлөөллөөс сонгож, зургаан жилийн хугацаагаар томилно. Зөвлөлийн дарга, гишүүн хүндэтгэх шалтгаанаар ажлаа үргэлжлүүлэх боломжгүй болсон нөхцөлд Монгол Улсын Ерөнхийлөгч нөхөн томилно.

21.3.Зөвлөлийн даргыг Монгол Улсын Ерөнхийлөгч Зөвлөлийн гишүүдийн дотроос сонгож, гурван жилийн хугацаатай томилно. Зөвлөлийн даргыг хоёроос дээшгүй удаа улируулан томилж болно.

21.4.Зөвлөл жилд хоёр удаа тогтсон хугацаанд хуралдах бөгөөд зайлшгүй шаардлага үүссэн нөхцөлд ээлжит бус хурлыг Зөвлөлийн даргын шийдвэрээр зарлан хуралдуулна.

21.5.Зөвлөл орон тооны ажлын албатай байх ба түүний өдөр тутмын үйл ажиллагааг ажлын албаны дарга удирдан явуулна.

21.6.Зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийг Зөвлөлийн бүх гишүүдийн хурлаар батална.

21.7.Зөвлөл дараах үүрэг хүлээнэ:

21.7.1.монгол хэл, бичиг үсгийг хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэхтэй холбоотой бодлого боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх;

21.7.2.үндэстний цөөнхийн хэл, монгол угсаатны аман аялгууг судлах, хамгаалах, хөгжүүлэх, гадаад оронд суугаа монгол үндэстнүүд, олон улсын хэмжээнд монгол хэл, бичиг үсгийн хэрэглээ, сургалт судалгааг өргөжүүлэх, дэмжих чиглэлээр бодлого боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх;

21.7.3.энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллагаас боловсруулсан, дүгнэлт гаргасан кирил болон үндэсний бичгийн зөв бичих дүрэм, түүний өөрчлөлтийг хэлэлцэн батлах;

21.7.4.энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллагын дүгнэлтэд үндэслэн кирил болон үндэсний бичгийн зөв бичих дүрмийн толь, үгийн сангийн толь болон бусад холбогдох толь бичгийг хэлэлцэн батлах;

21.7.5.энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллагаас боловсруулсан гадаад нэр томьёоны орчуулга, монгол хэлний үгийн санд оруулах шинэ нэр томьёог хэлэлцэн батлах;

21.7.6.газар нутаг, гудамж, зам, талбайд гадаад нэр оноох эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргаж нутгийн өөрөө удирдах байгууллагад илгээх;

21.7.7.төрийн албанд анх орох иргэнээс авах монгол хэлний төвшин тогтоох шалгалтын агуулгыг энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагаас ирүүлсний дагуу хэлэлцэн батлах;

21.7.8.энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллагын дүгнэлтэд үндэслэн кирил болон үндэсний бичиг рүү харилцан хөрвүүлэх, зөв бичих дүрмийн алдаа хянах программыг хэлэлцэн батлах;

21.7.9.төрийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага монгол хэлний хэм хэмжээг баримталж байгаа эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах;

21.7.10.энэ хуулийн хэрэгжилтэд жил бүр үнэлгээ хийж, үр дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид тайлагнах;

21.7.11.энэ хуулийн хэрэгжилт, зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авч, холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх;

21.7.12.энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг хэрэгжүүлэх.

**ДОЛООДУГААР БҮЛЭГ
ЭРХ БҮХИЙ СУДАЛГААНЫ БАЙГУУЛЛАГА****22 дугаар зүйл.Эрх бүхий судалгааны байгууллага**

22.1.Монгол Улсын Шинжлэх ухааны академийн бүтцэд монгол хэл, түүний хэрэглээ, хөгжлийг судлах, монгол хэлний хэм хэмжээ, үгийн сангийн өөрчлөлттэй холбоотой санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий монгол хэл шинжлэлийн хүрээлэн /цаашид "эрх бүхий судалгааны байгууллага" гэх/ ажиллана.

22.2.Эрх бүхий судалгааны байгууллага дараах үүрэг хүлээнэ:

22.2.1.монгол хэлний зөв бичих дүрэм боловсруулж, түүнд өөрчлөлт оруулах асуудлаар санал дэвшүүлэх;

22.2.2.эрдэмтэн судлаачид, эрдэм шинжилгээний бусад байгууллагаас боловсруулсан бичиг үсгийн дүрмийн гарын авлага, монгол хэлний үгийн сангийн болон мэргэжлийн хэлний толь бичиг, бусад холбогдох толь бичиг монгол хэлний зөв бичих дүрэмд нийцэж байгаа эсэхийг хянаж, дүгнэлт гаргах;

22.2.3.холбогдох мэргэжлийн байгууллагын туслалцаатайгаар гадаад нэр томьёог монгол хэлнээ орчуулах;

22.2.4.газар нутгийн оноосон нэрийг толь бичигт оруулах, жигдлэх, олон улсын газар зүйн нэрийн тольд бүртгүүлэх талаар энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагад санал гаргах;

22.2.5.төрийн албанд анх орох иргэнээс болон гадаадын иргэнээс авах монгол хэлний төвшин тогтоох шалгалтын агуулга боловсруулах ажлыг зохион байгуулах;

22.2.6.монгол хэл, бичгийн зөв бичих дүрэм, хэрэглээтэй холбоотой стандартыг боловсруулж, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9.1-д заасны дагуу батлуулах;

[/Энэ заалтад 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

22.2.7.нэр томьёоны талаар иргэн, хуулийн этгээдийн санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх.

**НАЙМДУГААР БҮЛЭГ
БУСАД****23 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

23.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

23.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

[/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

24 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

24.1.Энэ хуулийг 2015 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

24.2.Энэ хуулийн 7.2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 01 сарын 29 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

МУЗЕЙН ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь музейн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндсийг тогтоох, музейн сан хөмрөг бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Музейн хууль тогтоомж

2.1.Музейн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт музейн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүй үйлчилнэ.

3.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийн галерейн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."музей" гэж соёлын үнэт зүйлийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө бус соёл, эрдэм шинжилгээний байгууллагыг;

4.1.2."музейн үзэл баримтлал" гэж музейн төрөл, үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, цуглуулгын болон үзүүлэгийн бодлогыг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.3."ерөнхий бүртгэл" гэж үзмэрийн хувийн дугаар, нэр, тоо, хэмжээ, тодорхойлолт бүхий бүртгэл, мэдээллийн баримт бичгийг;

4.1.4."үзмэр" гэж ерөнхий бүртгэлд бүртгэгдсэн музейн өмчийн соёлын үнэт зүйлийг;

4.1.5."цуглуулга" гэж нэг болон хэд хэдэн шинжээрээ харилцан холбоотой, тодорхой цаг үеийг төлөөлөх шинжлэх ухаан, урлаг, танин мэдэхүйн ач холбогдолтой үзмэрийн бүрдэл хэсгийг;

4.1.6."музейн сан хөмрөг" гэж үзмэр, цуглуулга, түүний хадгалалт хамгаалалтын нөхцөлийг бүрдүүлсэн орон зайг;

4.1.7."үзүүлэл" гэж үзмэр, цуглуулгыг шинжлэх ухааны үндэслэлтэй, уран сайхны аргаар дэглэн үзүүлсэн орон зайг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МУЗЕЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

5 дугаар зүйл Музей байгуулах

5.1.Музейг төрийн болон орон нутгийн, хувийн өмчийн хэлбэрээр Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байгуулна.

5.2.Музейн үзэл баримтлалыг үүсгэн байгуулагч нь батлах бөгөөд орон нутгийн болон хувийн өмчийн музейн үзэл баримтлалыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөнө.

5.3.Музейн үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл авсан иргэн, хуулийн этгээд эрхэлнэ.

[/Энэ хэсэгт "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" гэснийг "Зөвшөөрлийн тухай" гэж 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

5.4.Музейн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

5.5.Музейн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг найман жилийн хугацаатайгаар олгоно.

5.6.Тусгай зөвшөөрөл сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

[/Энэ хэсэгт "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" гэснийг "Зөвшөөрлийн тухай" гэж 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

5.7.Музейн дүрэмд заасан бол музейн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий олон нийтийн зөвлөл ажиллаж болно. Зөвлөлийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6 дугаар зүйл Музейн зэрэглэл

6.1.Засгийн газар Төрийн өмчийн музейд үндэсний, улсын, бүс нутгийн зэрэглэл тогтооно.

6.2.Үндэсний музей нь төрөл, үйл ажиллагааны чиглэлээр бусад музейг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана.

6.3.Үндэсний болон улсын зэрэглэлийн музей төрийн хамгаалалтад байна.

6.4.Аймаг, сум, нийслэлийн музей орон нутгийн байгаль, түүх, соёлын үнэт зүйлийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах болон түгээн дэлгэрүүлэх чиг үүрэгтэй байна.

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

7 дугаар зүйл Музейн үйл ажиллагааны чиглэл

7.1.Музей нь үзэл баримтлалын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

7.1.1.соёлын үнэт зүйлийг эрэн сурвалжлах, нээж илрүүлэх, олж авах;

7.1.2.үзмэрийг бүртгэх, баримтжуулах, музейн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх;

7.1.3.Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасны дагуу бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх;

7.1.4.үзүүлэг дэглэх, үйлчлэх;

7.1.5.гадаад, дотоодод үзэсгэлэн зохион байгуулах;

7.1.6.боловсрол, танин мэдэхүйн ажил зохион байгуулах;

7.1.7.сургалт зохион байгуулах;

7.1.8.эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, үр дүнг хэвлүүлэх, түгээх;

7.1.9.гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;

7.1.10.үзмэрийг гадаад, дотоодын үзэсгэлэнд оролцуулах;

7.1.11.иргэн, хуулийн этгээдийн эзэмшлийн соёлын үнэт зүйлийг түр хугацаагаар үзэсгэлэн, үзүүлэгт дэглэж ашиглах;

7.1.12.музей хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

7.1.13.хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

7.2.Музей нь Төсвийн тухай хуульд нийцүүлэн худалдаа, үйлчилгээ эрхэлж болно.

7.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулдаг музейн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор дөрвөн жил тутам хараат бус хуулийн этгээдээр үнэлгээ хийлгэнэ.

7.4.Энэ хуулийн 7.3-т заасан үнэлгээ хийх аргачлал, үнэлгээ хийх этгээдэд тавих шалгуурыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.5.Аймаг,нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 7.3-т заасан үнэлгээний тайланг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

7.6.Музейн үүсгэн байгуулагч музейн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг санхүүжүүлэх үүрэгтэй.

7.7.Музей нь үйл ажиллагаагаа санхүүжүүлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдээс хуулийн хүрээнд хандив, тусламж авч болох бөгөөд зарцуулалт, тайлагналт нь ил тод, нээлттэй байна.

7.8.Музейн санхүүжилт, хандив тусламжийн эх үүсвэр нь хуульд нийцсэн байна.

7.9.Соёлын өвд хамаарах үзмэрийг судлах, сурталчлах зорилгоор музей хооронд түр солилцох асуудлыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 35.1-д заасны дагуу зохицуулна.

8 дугаар зүйл Музейн үзүүлэг, дэглэлт

8.1.Музей нь үзмэр, цуглуулгыг эргэлтэд оруулах, мэдлэг мэдээлэл түгээх, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх зорилгоор үзүүлэг, дэглэлтийг байнга шинэчлэх зарчим баримтална.

8.2.Музей нь үзэл баримтлалын хүрээнд зургаан жил тутам үзүүлэг, дэглэлтээ шинэчлэх төлөвлөгөөний төслийг боловсруулна.

8.3.Төрийн өмчийн музейн үзүүлэг, дэглэлтийг шинэчлэх төлөвлөгөөг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн өмчийн музейн үзүүлэг, дэглэлтийг шинэчлэх төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Засаг дарга соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн батална. Хувийн музейн үзүүлэг, дэглэлтийг шинэчлэх төлөвлөгөөг үүсгэн байгуулагч нь батална.

8.4.Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгал болон археологи, палеонтологийн дурсгалыг түшиглэн байгуулсан музейд энэ хуулийн 8.2 дахь хэсэг хамаарахгүй.

9 дүгээр зүйл Музейн үйлчилгээний төлбөр

9.1.Монгол Улсын харьяат 16 хүртэлх насны хүүхэд музейн үзүүлэгийн танхимаар үнэ төлбөргүй үйлчлүүлнэ.

9.2.Энэ хуулийн 9.1-д зааснаас бусад үйлчилгээ төлбөртэй байж болох бөгөөд уг төлбөрийн хэмжээг үүсгэн байгуулагчтай зөвшилцсөний үндсэн дээр музейн захирал тогтооно.

9.3.Музейн захирал дараах иргэнийг үзүүлэгийн танхимаар үйлчлүүлэхэд үйлчилгээний төлбөрийн хөнгөлөлт үзүүлнэ:

9.3.1.Ахмад настны тухай хуулийн 3.1-д заасан иргэн;

9.3.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д заасан иргэн.

9.4.Төрөөс энэ хуулийн 9.1-д заасан үйлчилгээ үзүүлсэнтэй холбогдох зардлыг хувийн музейд нөхөн олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ МУЗЕЙН САН ХӨМРӨГ

10 дугаар зүйл Музейн сан хөмрөгийн төрөл

10.1.Музей нь үндсэн болон туслах сан хөмрөгтэй байна.

10.2.Үндсэн сан хөмрөгт музейн үзэл баримтлалын хүрээнд цуглуулсан түүх, соёл, урлаг, шинжлэх ухаан, танин мэдэхүй, гоо зүйн үнэ цэнэ бүхий үзмэр хамаарна.

10.3.Энэ хуулийн 10.2-т зааснаас бусад үзмэр туслах сан хөмрөгт хамаарна.

10.4.Музейн сан хөмрөгийг үзмэрийн материал, хэмжээ зэрэг онцлог шинжийг харгалзан төрөлжүүлж зохион байгуулна.

10.5.Музейн сан хөмрөгт үзмэр оруулах, гаргах хөдөлгөөнийг дүрмээр зохицуулах бөгөөд уг дүрмийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.6.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаас бусад соёлын өвд хамаарахгүй музейн үзмэр, цуглуулгыг даатгуулж болно.

10.7.Музейн сан хөмрөгт байгаа түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах үзмэрийн үнэлгээг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 9.1-д заасан журмын дагуу үнэлнэ.

10.8.Энэ хуулийн 10.7-д хамаарахгүй үзмэрийг үнэлэх асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулиар зохицуулна.

11 дүгээр зүйл Музейн сан хөмрөгийн бүртгэл

- 11.1.Музейн сан хөмрөгийн бүртгэл, мэдээллийн үндсэн баримт бичиг нь ерөнхий бүртгэл байна.
- 11.2.Музейн бүх үзмэр нь сан хөмрөгт авсан он, музейн захирлын шийдвэрийн дугаар, тухайн шийдвэрт заасан дэсийн дугаар бүхий хувийн дугаартай байна.
- 11.3.Музейн ерөнхий бүртгэлд үндэслэн үндсэн болон туслах сан хөмрөгийн бүртгэлийг үйлдэнэ.
- 11.4.Энэ хуулийн 11.1, 11.3-т заасан бүртгэлийг музейн бүртгэл, мэдээллийн санч гараар бичиж хөтөлнө.
- 11.5.Энэ хуулийн 11.4-т заасан бүртгэлийг музейн бүртгэл, мэдээллийн санч хариуцан хадгалах бөгөөд музейгээс өөр газарт хадгалах, музейн захирлын зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах, хэсэгчлэн болон бүтнээр нь хувиран олшруулах, засварлахыг хориглоно.
- 12 дугаар зүйл Музейн сан хөмрөгт соёлын үнэт зүйлийг цуглуулах**
- 12.1.Музейн сан хөмрөгт соёлын үнэт зүйлийг цуглуулах үйл ажиллагааг сан хөмрөгийн зөвлөл зохион байгуулах бөгөөд уг зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан үлгэрчилсэн журмыг үндэслэн музейн захирал баталж, мөрдүүлнэ.
- 12.2.Музей нь соёлын үнэт зүйлийг дараах хэлбэрээр сан хөмрөгт цуглуулна:
- 12.2.1.музейн хайгуул, малтлага, судалгааны ажлын үр дүнд олж авах;
- 12.2.2.худалдаж авах;
- 12.2.3.өв, бэлэглэлийн журмаар авах;
- 12.2.4.эрх бүхий байгууллагын шийдвэрээр шилжүүлж авах;
- 12.2.5.өөрийн хөрөнгөөр бүтээлгэх;
- 12.2.6.хандив, тусламжаар авах;
- 12.2.7.хуулиар хориглоогүй бусад.
- 12.3.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд заасан зохиогчийн эрхээр хамгаалах бүтээлийг музейн сан хөмрөгт авахдаа оюуны өмч, зохиогчийн эрхийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна.
- 12.4.Төрийн болон орон нутгийн өмчийн музейн сан хөмрөгт соёлын үнэт зүйл худалдан авах журмыг Засгийн газар батална.
- 12.5.Төрийн болон орон нутгийн музейн үзмэр, цуглуулгыг барьцаалахыг хориглоно.
- 13 дугаар зүйл Музейн сан хөмрөгөөс үзмэр хасах**
- 13.1.Төрийн болон орон нутгийн өмчийн музейн сан хөмрөгөөс соёлын өвд хамаарах үзмэрийг хасах тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар зохицуулна.
- 13.2.Энэ хуулийн 13.1-д хамаарахгүй үзмэрийг хасах тохиолдолд Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тус тус зохицуулна.
- 13.3.Хувийн өмчийн музей нь сан хөмрөгөөс үзмэр хасах тохиолдолд соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд урьдчилан мэдэгдэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МУЗЕЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

14 дүгээр зүйл Музейн аюулгүй байдлын хангах

- 14.1.Музей дараах аюулгүй байдлыг хангасан байна:
- 14.1.1.музейн орчны;
- 14.1.2.барилга байгууламжийн;
- 14.1.3.сан хөмрөгийн.
- 14.2.Энэ хуулийн 14.1-д заасан аюулгүй байдлын стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу баталж, мөрдүүлнэ.
- 14.3.Үүсгэн байгуулагч нь харьяалах нутаг дэвсгэрийн онцгой байдлын болон цагдаа, тагнуул, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран музейн аюулгүй байдлыг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:
- 14.3.1.гамшгийн үед сан хөмрөгийг аврах, үйлчлүүлэгч, музейн ажилтныг гамшгаас хамгаалах болон гамшгийн үеийн үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох, бэлэн байдлыг хангуулах;

- 14.3.2.гамшигт өртөж болох эрсдэлийг тооцоолж, эрсдэлийн үнэлгээ /геологийн, газар зүйн, цаг уурын, барилга байгууламжийн, ашиглалт үйлчилгээний гэх мэт/-г хийлгэх, эрсдэлийг эрэмбэлэх ажлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан байгууллагаар гүйцэтгүүлэх;
- 14.3.3.олон улсад шинээр нэвтрүүлж байгаа дэвшилтэт техник, технологийг судалж нэвтрүүлэх.
- 14.4.Музейн сан хөмрөгийг гамшиг болон аюулын үед нүүлгэн шилжүүлэх журмыг Засгийн газар батална.
- 14.5.Музей гамшиг болон аюулын үед ажиллах нарийвчилсан төлөвлөгөөтэй байна.
- 14.6.Музейн барилга байгууламжаас 500 метрийн дотор шатахуун хадгалах, түгээх, тэсэрч дэлбэрэх, дэгдэмхий бодис хадгалах болон хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохыг хориглоно.

ТАВДУГААР БҮЛЭГ МУЗЕЙН АЖИЛТАН

15 дугаар зүйл Музейн ажилтан

- 15.1.Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтны жагсаалтыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 15.2.Төрийн болон орон нутгийн өмчийн музейн захирал энэ хуулийн 15.1-д заасан албан тушаалд төрөл, садангийн хүнийг томилж ажиллуулахыг хориглоно.
- 15.3.Энэ хуулийн 15.1-д заасан үзмэртэй шууд харьцах албан тушаалтанд найман жил тутам нэг жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.
- 16 дугаар зүйл Музейн сан хөмрөгч**
- 16.1.Музей сан хөмрөгчтэй байна.
- 16.2.Төрийн болон орон нутгийн өмчийн музейн сан хөмрөгчөөр дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг томилно:
- 16.2.1.дээд боловсролтой, музей, соёлын өвийг хамгаалах чиглэлээр мэргэшсэн;
- 16.2.2.гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;
- 16.2.3.музейн ажилтны ёс зүйн нийтлэг хэм хэмжээг зөрчиж, хариуцлага хүлээж байгаагүй;
- 16.2.4.сан хөмрөгчид нэр дэвших үед гэмт хэрэгт холбогдоогүй буюу сэжигтэн, яллагдагчаар татагдаагүй, бусдад хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх;
- 16.2.5.давхар ажил эрхэлдэггүй байх.
- 17 дугаар зүйл, Музейн ажилтны ёс зүйн нийтлэг хэм хэмжээ**
- 17.1.Музейн ажилтан дараах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг дагаж мөрдөнө:
- 17.1.1.албаны шугамаар олж авсан соёлын үнэт зүйлийн талаарх мэдээллийг бусдад задруулахгүй байх;
- 17.1.2.музейн сан хөмрөгт үзмэр худалдан авах үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, эсхүл бусдад давуу байдал олгохгүй байх;
- 17.1.3.музейн төрөл, үйл ажиллагааны чиглэлд хамаарах соёлын үнэт зүйлийг хувьдаа цуглуулахгүй байх;
- 17.1.4.соёлын үнэт зүйлийн хууль бус худалдаанд оролцохгүй байх;
- 17.1.5.албаны шугамаар олж авсан мэдээллийг ашиг олох зорилгоор бусдад дамжуулах, дамлан худалдахгүй байх;
- 17.1.6.албан үүргээ гүйцэтгэсний төлөө бусдаас шан харамж авах, эсхүл шан харамж авахаар санал тавих, шаардахгүй байх.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ МУЗЕЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

18 дугаар зүйл Музейн үйл ажиллагаанд хяналт тавих

- 18.1.Музейн үйл ажиллагаанд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, Мэргэжлийн хяналтын байгууллага болон улсын байцаагч хяналт тавина.

18.2.Музейн үйл ажиллагаанд олон нийтийн зөвлөл хяналт тавьж болно.

19 дүгээр зүйл .Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

19.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд, хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

20 дугаар зүйл Хууль хүчин төгөлдөр болох

20.1.Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 сарын 02 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

**КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь кино үйлдвэрлэх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, Монгол Улсад кино бүтээх таатай орчныг бий болгох, кино урлагийг хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Кино урлагийг дэмжих хууль тогтоомж

2.1.Кино урлагийг дэмжих хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Соёлын тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд

3.1.Энэ хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт кино үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхэлж байгаа Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, олон улсын кино наадамд оролцож байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд хамаарна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."кино" гэж техник технологи ашиглан олон нийтэд түгээх зорилгоор дуу авиа дагалдсан эсэхээс үл хамааран хоорондоо холбоотой цуврал дүрсийг хөдөлгөөнт хэлбэрт оруулан үзэх боломжтой аргаар туурвисан бүтээлийг;

4.1.2."монгол кино" гэж Монгол Улсын иргэн, хуулийн этгээд нь тухайн киноны зохиогч, эрх эзэмшигч, кино продюсер байх, эсхүл Монгол Улсын иргэн ерөнхий найруулагчаар ажилласан киног;

4.1.3."хамтарсан кино" гэж талуудын эрх, үүрэг, санхүүжилтийн асуудал, хамтын ажиллагааны хүрээг тодорхойлсон хэлцлийн үндсэн дээр гадаад улсын иргэн, хуулийн этгээдтэй хамтран бүтээсэн киног;

4.1.4."гадаад кино" гэж энэ хуулийн 4.1.2, 4.1.3-т зааснаас бусад киног;

4.1.5."кино үйлдвэрлэл" гэж кино бүтээх, түгээхтэй холбоотой цогц үйл ажиллагааг;

4.1.6."кино бүтээх" гэж кино төсөл боловсруулах, кино зохиол бичих, зураг авалт, эвлүүлэг, дуу, дүрсний найруулга хийх зэрэг кино түгээх хүртэлх бүтээлч үйл ажиллагааг;

4.1.7."зохиогч" гэж Зохиогчийн эрхийн тухай хуулийн 4.1.1-д заасан этгээдийг;

4.1.8."эрх эзэмшигч" гэж Зохиогчийн эрхийн тухай хуулийн 4.1.2-т заасан этгээдийг;

4.1.9."кино түгээх" гэж киног техник технологи ашиглан олон нийтэд үзүүлэх үйл ажиллагааг;

4.1.10."кино продюсер" гэж киног бүтээх үйл ажиллагааг санаачлан зохион байгуулсан, уг бүтээлтэй холбоотой эрх эдэлж, үүрэг хүлээх хувь хүн, хуулийн этгээдийг;

4.1.11."кино зуучлагч" гэж Зохиогчийн эрхийн тухай хуулийн дагуу киног нийтэд түгээх үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийг;

4.1.12."кино үйлдвэрлэлийн дэд бүтэц" гэж кино үйлдвэрлэл эрхлэх нөхцөлийг бүрдүүлсэн барилга байгууламж, мэдээллийн сүлжээ, техник, программ хангамж, мэдээллийн санг;

4.1.13."тоон гарын үсэг" гэж Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.2-т заасныг;

4.1.14."цахим баримт бичиг" гэж Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.4-т заасныг.

5 дугаар зүйл. Кино урлагийг дэмжих чиглэл, зарчим

5.1.Төрөөс кино урлагийг дэмжихэд дараах чиглэл баримтална:

5.1.1.уран бүтээлчийн хөгжлийг дэмжих, дотоод, гадаадад сургах, мэргэшүүлэх;

5.1.2.кино үйлдвэрлэлд шаардагдах дэд бүтцийг бий болгох, техник технологийг сайжруулахад хөрөнгө оруулалт, татвар, санхүү болон бусад хэлбэрээр дэмжлэг үзүүлэх;

5.1.3.кино урлагийн салбарт оруулах дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.

5.2.Кино урлагийг дэмжихэд дараах зарчим баримтална:

5.2.1.ил тод, шударга, тэгш өрсөлдөх боломжтой байх;

5.2.2.хялбаршуулсан зохицуулалт бүхий, хэрэгжихүйц, тодорхой байх;

5.2.3.уран бүтээлчийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг нь хязгаарлахгүй байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

6.1.Засгийн газар кино урлагийг дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.кино урлагийг дэмжих, хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх;

6.1.2.кино үйлдвэрлэлд шаардагдах дэд бүтцийг бий болгох, барилга байгууламж барих, техник технологийг сайжруулахад татвар, санхүү болон бусад хэлбэрээр дэмжлэг үзүүлэх;

6.1.3.кино бүтээх чиглэлээр уран бүтээлч, ажилтныг сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;

6.1.4.энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан Кино урлагийн зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвшүүлэх болон зөвлөлийн ажиллах журмыг батлах;

6.1.5.энэ хуулийн 9.11-д заасан ажлын албаны бүтэц, орон тоо, дүрмийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д заасны дагуу батлах;

6.1.6.хуульд заасан бусад бүрэн эрх.

7 дугаар зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

7.1.Кино урлагийг дэмжих талаар соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.дотоод, гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

7.1.2.кино үйлдвэрлэх үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журмыг батлах;

7.1.3.кино үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн стандарт, норм, нормативыг боловсруулж, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9.1-д заасны дагуу батлуулах;

7.1.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

8 дугаар зүйл. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

8.1.Кино урлагийг дэмжих талаар соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.кино үйлдвэрлэлийн салбарт зохиогчийн эрхийг хамгаалах талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах, дэмжих;

8.1.2.олон улсын кино арга хэмжээнд монгол киног оролцуулах, Монгол Улсад олон улсын кино наадам зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.

9 дүгээр зүйл. Кино урлагийн зөвлөлийн бүтэц, бүрэн эрх

9.1.Кино урлагийн зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ нь кино урлагийг дэмжих бодлого, шийдвэрийн төсөлд санал өгөх, гадаадын иргэн, хуулийн этгээдэд Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авах зөвшөөрөл олгох,

тусгай сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ болон кино бүтээх зардлын буцаан олголтын үйл ажиллагаанд санал, дүгнэлт гаргах чиг үүрэгтэй байна.

9.2.Зөвлөл нь дарга, орон тооны бус 10 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллах бөгөөд үйл ажиллагаандаа хараат бус байх зарчмыг баримтална.

9.3.Зөвлөлийн гишүүний 30-аас доошгүй хувь нь соёл, оюуны өмч, төсөв, санхүүгийн салбарын төрийн байгууллагын төлөөлөл байх ба бусад гишүүн нь кино үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа уран бүтээлч, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөлөл байна.

9.4.Мэргэжлийн төрийн бус байгууллага кино урлагийн чиглэлээр мэргэшсэн, таваас доошгүй жил ажилласан туршлагатай иргэнийг энэ хуулийн 6.1.4-т заасан журмын дагуу нэр дэвшүүлнэ.

9.5.Кино урлагийн чиглэлээр мэргэшсэн, таваас доошгүй жил ажилласан туршлагатай уран бүтээлч нь энэ хуулийн 6.1.4-т заасан журмын дагуу бие даан болон мэргэжлийн төрийн бус байгууллагаас нэр дэвшинэ.

9.6.Энэ хуулийн 9.3, 9.4, 9.5-д заасан албан тушаалтан, иргэнийг Зөвлөлийн гишүүнээр соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, чөлөөлнө.

9.7.Зөвлөлийн дарга төрийн албан хаагч байх бөгөөд түүнийг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

9.8.Зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байх бөгөөд уг хугацааг нэг удаа сунгаж болно.

9.9.Зөвлөлийн дарга, гишүүн нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр хүсэлт гаргагч, хүлээн авагч этгээдтэй нэгдмэл сонирхолгүй байна.

9.10.Зөвлөлийн дарга, гишүүн нь шийдвэр, санал, дүгнэлт гаргах үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчилд орж болох нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ.

9.11.Зөвлөл ажлын албатай байх бөгөөд өөрийн үйл ажиллагаа, төсвийн хөрөнгө, бусад орлогоос санхүүжнэ.

9.12.Зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрх дараах тохиолдолд энэ хуулийн 9.8-д заасан хугацаанаас өмнө дуусгавар болно:

9.12.1.нас барсан;

9.12.2.чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан;

9.12.3.өөр ажил, албан тушаалд томилогдсон, эсхүл сонгогдсон;

9.12.4.гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

9.12.5.хуульд заасан бусад үндэслэл.

9.13.Зөвлөл асуудлыг хуралдаанаараа хэлэлцэж, олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

9.14.Зөвлөл санхүүгийн тайлангаа жил бүр аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлнэ.

9.15.Эрх бүхий этгээдээс кино үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбогдсон журам батлах, өөрчлөх, хүчингүй болгох тохиолдолд Зөвлөл 30-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

9.16.Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.16.1.кино үйлдвэрлэлийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн төсөлд санал өгөх;

9.16.2.энэ хуулийн 20.1-д заасан зөвшөөрлийг олгох;

9.16.3.кино үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэх;

9.16.4.кино бүтээх зардлын тодорхой хувийг буцаан олгох үйл ажиллагааг зохион байгуулах, санал, дүгнэлт гаргах;

9.16.5.Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт, зээл олгох арга хэмжээг зохион байгуулах, санал, дүгнэлт гаргах;

9.16.6.төсөл, арга хэмжээний санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, тайланг холбогдох байгууллагаас гаргуулан авч, дүгнэлт хийх;

9.16.7.кино түгээлтэд баримтлах насны ангилал тогтоох;

9.16.8.залуу уран бүтээлчид дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх;

- 9.16.9.олон улсын кино арга хэмжээнд монгол киног нэр дэвшүүлэх, оролцуулахад санал өгөх, Монгол Улсад олон улсын кино наадам зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- 9.16.10.мэдээллийн сан, цахим үйлчилгээний мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хяналт тавих;
- 9.16.11.хуульд заасан бусад бүрэн эрх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

КИНО УРЛАГИЙН МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ НЭВТРҮҮЛЭХ

10 дугаар зүйл.Мэдээллийн сан бүрдүүлэх

- 10.1.Соёлын тухай хуульд заасан журмын дагуу кино үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд холбогдох мэдээллийг бүрдүүлэх, дамжуулах, ашиглах, хадгалах, цахим үйлчилгээ үзүүлэх төрөлжсөн мэдээллийн сантай байх бөгөөд уг санг Зөвлөл эрхлэн хөтөлнө.
- 10.2.Энэ хуулийн 10.1-д заасан төрөлжсөн мэдээллийн санд дараах мэдээллийг бүрдүүлнэ:
- 10.2.1.кино үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, эрх зүйн бусад баримт бичиг;
- 10.2.2.кино урлагийн статистик мэдээлэл;
- 10.2.3.тухайн жилд улсын захиалгаар бүтээх болон санхүүгийн дэмжлэг үзүүлэхтэй холбоотой мэдээлэл;
- 10.2.4.зохиогчийн эрхээр хамгаалагдах бүтээлийг эзэмших, ашиглах, түгээхтэй холбоотой мэдээлэл;
- 10.2.5.кино урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хүний нөөцтэй холбоотой мэдээлэл;
- 10.2.6.монгол болон хамтарсан кинотой холбоотой мэдээлэл;
- 10.2.7.Монгол Улсын нутаг дэвсгэрт зураг авалт хийсэн гадаадын кинотой холбоотой мэдээлэл;
- 10.2.8.кино урлагийн шүүмж, судлалын мэдээлэл;
- 10.2.9.кино урлагийг дэмжих төсөв, зардал, түүний зарцуулалт;
- 10.2.10.кино бүтээх зардлын буцаан олголтын талаар;
- 10.2.11.зохиогчийн эрхээр үл хамгаалах болон нууцад хамааруулаагүй бусад мэдээлэл.
- 10.3.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бүтээгдсэн киног Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасны дагуу төрийн архивд шилжүүлж, хадгалж, хамгаална.
- 10.4.Зөвлөл энэ хуулийн 10.3-т зааснаас бусад кино болон кино үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд холбогдох баримтыг хадгалж болно.

11 дүгээр зүйл.Цахим үйлчилгээ нэвтрүүлэх

- 11.1.Төрөөс кино үйлдвэрлэлтэй холбоотой үйл ажиллагаанд цахим үйлчилгээ нэвтрүүлнэ.
- 11.2.Цахим үйлчилгээ үзүүлэхэд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийн 6.4-т заасан журмыг баримтална.
- 11.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэн, хуулийн этгээдэд кино зураг авалт хийх зөвшөөрөл олгох болон кино бүтээх зардлын буцаан олголтын баримт бичгийг бүрдүүлэх, хүлээн авах, шийдвэрлэхэд тавих бусад шаардлагыг энэ хуулийн 13.5, 17.6-д заасан журамд тусгана.
- 11.4.Зөвлөлийн ажлын алба цахим үйлчилгээ үзүүлэх болон цахим баримт бичиг хөтлөлт, тоон гарын үсэг хэрэглэх, мэдээллийн системийн найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

КИНО УРЛАГИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

12 дугаар зүйл.Кино урлагийг дэмжих санхүүжилт

- 12.1.Кино бүтээх үйл ажиллагааг төрөөс дэмжих зориулалт бүхий Кино урлагийг дэмжих сантай байна.
- 12.2.Кино урлагийг дэмжих сан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан эх үүсвэрээс бүрдэх бөгөөд уг сангаас дараах хэлбэрээр дэмжлэг үзүүлнэ:
- 12.2.1.эргэн төлөх нөхцөлгүй олгох санхүүжилт;
- 12.2.2.эргэн төлөгдөх хөнгөлөлттэй зээл олгох.

12.3.Энэ хуулийн 12.2-т заасан хэлбэрээр дэмжлэг үзүүлэхэд улсын төсвөөс шаардагдах хөрөнгийн хэмжээг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, тухайн жилийн улсын төсөвт тусгаж батална.

12.4.Энэ хуулийн 12.2-т заасан санхүүжилтийн хувь, хэмжээг Засгийн газар тогтооно.

13 дугаар зүйл.Кино урлагийг дэмжих сангийн зарцуулалт

13.1.Кино урлагийг дэмжих сангийн эргэн төлөх нөхцөлгүй олгох санхүүжилтийг дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд олгоно:

13.1.1.монголын түүх, соёл, ахуй амьдралыг харуулах, эсхүл хүүхэд, залуучуудын хүмүүжил, төлөвшил, нийгмийн эрүүл мэнд, эрүүл, зөв амьдрах дадал зуршил хэвшүүлэхэд эергээр нөлөөлөх, эсхүл олон улсын кино наадамд өрсөлдөх зорилготой найруулагчийн хувийн бүтээлч чанар, гоо зүйн үнэлэмж, үзэл бодлын илэрхийллийг харуулсан кино бүтээх;

13.1.2.монгол киног хадгалах, сэргээн хөрвүүлэх;

13.1.3.олон улсын кино наадам, үзэсгэлэнд монгол киногоор оролцох, Монгол Улсад олон улсын кино наадам зохион байгуулах;

13.1.4.кино урлагийн уран бүтээлч, ажилтныг хөгжүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.

13.2.Кино урлагийг дэмжих сангийн эргэн төлөгдөх хөнгөлөлттэй зээлийг дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд олгоно:

13.2.1.энэ хуулийн 13.1.1-д зааснаас бусад кино бүтээх;

13.2.2.кино үйлдвэрлэлд шаардлагатай дэд бүтцийг сайжруулахад чиглэсэн техник технологи, программ хангамж, инновац нэвтрүүлэх.

13.3.Энэ хуулийн 13.2-т заасан хөнгөлөлттэй зээлийг банкаар дамжуулж олгоно. Банкныг сонгон шалгаруулалтаар сонгоно.

13.4.Энэ хуулийн 13.2-т заасан хөнгөлөлттэй зээлийг дараах этгээдэд олгохгүй:

13.4.1.сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй;

13.4.2.сангаас авсан зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон;

13.4.3.төсөл хүлээн авах сүүлийн өдрийн байдлаар нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй.

13.5.Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банканд тавих шалгуур, банкныг сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, эргэн төлөх, хяналт тавих журмыг Засгийн газар батална.

14 дүгээр зүйл.Иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх бусад дэмжлэг

14.1.Иргэн, хуулийн этгээдэд кино үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай татварын дэмжлэг үзүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

14.2.Давхар татвар, хөрөнгө оруулалттай холбоотой олон улсын гэрээг кино үйлдвэрлэлээр тэргүүлэгч орнуудтай байгуулах, хэлэлцээ хийх арга хэмжээг Засгийн газар зохион байгуулна.

14.3.Кино зураг авах зориулалттай төрийн өмчийн барилга байгууламж, шаардлагатай тоног төхөөрөмжийг монгол болон хамтарсан кино бүтээхэд хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулна. Хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах журмыг соёл, боловсрол болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

14.4.Олон улсын кино арга хэмжээнд амжилт гаргасан уран бүтээлчид Соёлын тухай хуульд заасан мөнгөн шагнал олгоно.

14.5.Монгол Улсын нутаг дэвсгэрт кино бүтээх зорилгоор ирэх гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тусгай ангиллын виз олгох бөгөөд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.1-д заасан журмаар тогтооно.

ТАВДУГААР БҮЛЭГ

КИНО БҮТЭЭХ ЗАРДЛЫН БУЦААН ОЛГОЛТ, ТАВИХ ШААРДЛАГА

15 дугаар зүйл.Кино бүтээх зардлын тодорхой хувийг буцаан олгоход тавих шаардлага

15.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын хуулийн этгээд дангаараа болон Монгол Улсын хуулийн этгээдтэй хамтран олон улсад түгээх зорилгоор кино бүтээх тохиолдолд зардлын тодорхой хувийг буцаан олгоно.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан зардлыг олон улсын жишигт нийцсэн байдлаар төлөвлөж, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, тухайн жилийн улсын төсөвт тусгах бөгөөд уг зардлыг өмнөх оны төсөвт тусгагдсанаас бууруулахгүй байна.

15.3.Энэ хуулийн 15.1-д заасан зардлыг зориулалтын бусаар зарцуулахыг хориглох бөгөөд тухайн төсвийн жилд ашиглагдаагүй төсвийн үлдэгдлийг дараагийн төсвийн жилд үргэлжлүүлэн зарцуулна.

15.4.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын хуулийн этгээд кино зураг авалт хийхэд 500 000 америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгийг шаардлага хангасан дараах зардалд зарцуулсан нь буцаан олголт тооцох урьдчилсан нөхцөл болно:

15.4.1.Монгол Улсад татвар төлөгч иргэн, хуулийн этгээдээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний зардал;

15.4.2.Монгол Улсад байхгүй нь нотлогдсон мэргэжлийн техник, тоног төхөөрөмжийг гадаад улсаас түрээслэн ашигласны зардал;

15.4.3.Монгол Улсад төлсөн татвар.

15.5.Уран бүтээлийн болон зураг авалтын багийн цалин хөлс нь энэ хуулийн 15.4-т заасан нийт зардлын 40 хувиас хэтрэхгүй байна.

16 дугаар зүйл.Шаардлага хангасан зардлыг тодорхойлох

16.1.Кино зураг авалт хийх зардалд найруулагч, зураглаач, ерөнхий зураач, кино продюсер болон уран бүтээл, зураг авалтын багийн цалин хөлс, үйлчилгээ, түрээс, бусад зардал багтах бөгөөд шаардлага хангасан зардлын дэлгэрэнгүй жагсаалтыг Засгийн газар энэ хуулийн 17.6-д заасан журамд тусгана.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан шаардлага хангасан зардалд дараах зардлыг тооцохгүй:

16.2.1.кино павильон, студийн дэд бүтэц, үл хөдлөх хөрөнгө худалдан авах зардал;

16.2.2.хууль зүйн туслалцаа, санхүүгийн болон бусад зөвлөгөө авах зардал;

16.2.3.торгууль, алданги, банкны баталгаа, зээл, түүний хүү, хураамж;

16.2.4.шүүх, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой зардал;

16.2.5.харилцан өмчлөлд шилжүүлсэн тодорхой хөрөнгө;

16.2.6.нэмэгдсэн өртгийн албан татвар;

16.2.7.улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөс олгосон зардал;

16.2.8.хандив;

16.2.9.санхүүгийн түрээсийн /лизинг/ гэрээ байгуулах зардал, хүүгийн зардал;

16.2.10.кино бүтээхэд хамаарахгүй программ хангамжийг худалдан авах, хөгжүүлэх зардал;

16.2.11.бусад зардал.

17 дугаар зүйл.Буцаан олголтын хувь тооцох

17.1.Энэ хуулийн 15.4-т заасан этгээдэд зардлынх нь 30 хувийг буцаан олгоно.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан этгээд эвлүүлэг, дуу, дүрсний найруулгыг Монгол Улсын нутаг дэвсгэрт хийхэд багийн бүрэлдэхүүний 50-аас доошгүй хувь нь Монгол Улсын уран бүтээлч, ажилтан оролцсон бол тухайн эвлүүлэг, дуу, дүрсний найруулгын зардлын 30 хувийг буцаан олгоно.

17.3.Энэ хуулийн 17.1-д заасан этгээдийн бүтээсэн кино Засгийн газраас баталсан соёлын шалгуур хангасан бол энэ хуулийн 15.4-т заасан зардлын 10 хувийг нэмж олгоно.

17.4.Энэ хуулийн 15.4-т заасан кино зураг авалтад оролцсон гадаад улсын уран бүтээлийн болон зураг авалтын багийн Монгол Улсад ажилласан хоногийн цалин хөлсний 5 хувийг буцаан олгоно.

17.5.Монгол Улсыг олон улсад эргээр сурталчлан таниулсан монгол киноны эрх эзэмшигчид тухайн кино бүтээх зардлын 20 хүртэлх хувийг энэ хуулийн 15-19 дүгээр зүйлд заасан зарчим, журмыг баримтлан буцаан олгож болно.

17.6.Кино бүтээх зардлын буцаан олголтын хүсэлт гаргах, төслийг хянах, бүртгэх, гэрээ байгуулах, үнэлэх, тайлагнах, зардлын тодорхой хувийг буцаан олгохтой холбогдсон журмыг Засгийн газар батална.

18 дугаар зүйл.Хүсэлт гаргах, төсөл бүртгүүлэх

18.1.Кино зураг авалт хийх зардлын тодорхой хувийг буцаан олгохтой холбоотой төсөв, шалгуур, холбогдох мэдээллийг монгол болон гадаад хэлээр бэлтгэн, энэ хуулийн 17.6-д заасан журмын дагуу олон улсад нээлттэй, тогтмол мэдээлнэ.

18.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийх зардлын тодорхой хувийг буцаан авах нөхцөлтэйгээр хүсэлт /цаашид "хүсэлт" гэх/ гаргах этгээд нь Монгол Улсын хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

18.3.Энэ хуулийн 18.2-т заасан этгээдийн гаргасан хүсэлт, хэрэгжүүлэх төсөл нь Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчөөгүй, монголын түүхийг илт гуйвуулах болон дайн, түрэмгийлэл, садар самуун, хүчирхийллийг сурталчлах агуулгагүй байна.

18.4.Зөвлөл хүсэлтийг хүлээн авч, төслийг хянана. Хүсэлт, төсөл нь энэ хуулийн 17.6, 18.3-т заасан шаардлага хангаагүй тохиолдолд хүлээн авахаас татгалзана.

18.5.Зөвлөл шаардлага хангасан хүсэлт, төслийг бүртгэн гэрчилгээ олгоно. Гэрчилгээг хоёроос дөрөв хүртэлх жилийн хугацаатай олгож, кино зураг авалт хийх зардлын тодорхой хувийг буцаан олгох гэрээ байгуулна.

18.6.Гэрээ байгуулсан өдрөөс хойш зарцуулсан зардлыг буцаан олгох зардалд тооцно.

18.7.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал, урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсөл хэрэгжих боломжгүй болсон тохиолдолд хүсэлт гаргагч этгээд Зөвлөлд нэн даруй мэдэгдэх бөгөөд ийнхүү мэдэгдсэнээр гэрчилгээ хүчингүй болж, гэрээ цуцлагдсанд тооцно.

19 дүгээр зүйл.Мэдүүлэг гаргах, үнэлгээ хийх

19.1.Энэ хуулийн 18.5-д заасан этгээд нь кино зураг авалтын зардлын тодорхой хувийг буцаан авах мэдүүлгийг гаргана.

19.2.Зөвлөл мэдүүлгийг хүлээн авч үнэлнэ.

19.3.Мэдүүлэг гаргагч олон улсын байгууллагаар аудит хийлгэсэн тайлан, нягтлан бодох бүртгэлийн эх баримтыг гарган өгч, зардлыг шалгах эрхийг олгоно.

19.4.Зөвлөл татварын байгууллагаас тухайн зардлыг Монгол Улсад зарцуулсан талаар мэдээлэл авах ажиллагааг зохион байгуулна.

19.5.Зөвлөл зардлын баримтыг шалгаж, буцаан олголтын хувь тооцох дүгнэлт гаргаж, соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

19.6.Зөвлөлийн хувь тооцсон дүгнэлтийг үндэслэн, соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн зардлын тодорхой хувийг буцаан олгох шийдвэр гаргаж, гэрээнд заасан дансанд шилжүүлнэ. Буцаан олголтыг хуваан шилжүүлж болно.

19.7.Энэ хуулийн 19.6-д заасан зардлын буцаан олголтыг дараах тохиолдолд олгохгүй:

19.7.1.мэдүүлэг гаргагч хууль тогтоомж, энэ хуулийн 18.5-д заасан гэрээг зөрчсөн;

19.7.2.мэдүүлэг гаргагч холбогдох баримт бичиг, аудиторын дүгнэлт ирүүлээгүй, зардал шалгах зөвшөөрөл олгоогүй, эсхүл журамд заасан хугацаанд гаргаж өгөөгүй;

19.7.3.зардлын баримт нь хууль тогтоомжид заасан шаардлага, хугацаа, үйл ажиллагаа, эсхүл төслийн зорилттой нийцэхгүй байх;

19.7.4.гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй, гарсан зардал болон түүний төлбөрийг баталгаажуулаагүй;

19.7.5.хүсэлт гаргагч дампуурсан, салбар, төлөөлөгчийн газар нь татан буугдсан.

19.8.Зөвлөл кино бүтээх зардлын буцаан олголт авсан этгээд, төслийн нэр, дүнгийн талаарх товч мэдээллийг энэ хуулийн 10.1-д заасан төрөлжсөн мэдээллийн санд байршуулж, сурталчилна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

КИНО ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ШААРДЛАГА

20 дугаар зүйл.Кино зураг авалт хийх зөвшөөрөл

20.1.Кино бүтээх зорилгоор гадаадын иргэн, хуулийн этгээдэд Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийхэд зөвшөөрөл олгоно.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан этгээд дараах баримт бичгийг бүрдүүлэн кино зураг авалт эхлэхээс 14-өөс доошгүй хоногийн өмнө Зөвлөлд хүсэлт гаргана:

20.2.1.кино зохиолын товч агуулга, кино продюсерын танилцуулга, Монголын талаас хамтран ажиллах этгээдийн мэдээлэл;

20.2.2.ажлын хуваарь, төлөвлөгөө;

20.2.3.байршлын болон орчин тойронд сөрөг нөлөөлөл үзүүлэх эсэх талаарх мэдээлэл;

20.2.4.хуульд заасан бусад.

20.3.Зөвлөл энэ хуулийн 20.2-т заасан хүсэлтийг хянан үзэж, 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

20.4.Энэ хуулийн 20.1-д заасан зөвшөөрөлгүй этгээд кино зураг авалт хийхийг хориглоно.

20.5.Кино зураг авалт хийх зөвшөөрөлд заасан байршил, хугацаа, агуулгыг өөрчлөх тохиолдолд энэ хуулийн 20.7-д заасан журмын дагуу Зөвлөлд мэдэгдэнэ.

20.6.Түүх, соёлын дурсгалт газар, тусгай хамгаалалттай газар нутагт кино зураг авалт хийхэд Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан журмыг баримтална.

20.7.Гадаадын иргэн, хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийх зөвшөөрөл авах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20.8.Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийх зөвшөөрөл хүсэгч Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 221.1.7-д заасны дагуу хураамж төлнө.

21 дүгээр зүйл. Кино түгээх ангилал

21.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт кино түгээхэд дараах насны ангилал тогтооно:

21.1.1.бүх насныханд зөвшөөрөх;

21.1.2.13 ба түүнээс дээш насныханд зөвшөөрөх;

21.1.3.18 ба түүнээс дээш насныханд зөвшөөрөх.

21.2.Энэ хуулийн 21.1.3-т заасан 18 ба түүнээс дээш насныханд зөвшөөрөх ангиллын киног өдрийн цагаар буюу 06.00-22.00 цагт өргөн нэвтрүүлгийн болон кабелийн телевизээр нэвтрүүлэхийг, кино театр, үзвэрийн цэг, үзвэрийн танхимаар насанд хүрээгүй хүнд үзүүлэхийг хориглоно.

21.3.Энэ хуулийн 21.1-д заасан ангилал тогтоох шалгуур, кино түгээхэд баримтлах журмыг олон улсын стандартын дагуу соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

[/Энэ хэсэгт 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

22 дугаар зүйл. Кино түгээлтийн мэдээлэл

22.1.Кино театрын үйлчилгээ үзүүлж байгаа этгээд кино зуучлагч, киноны нэр, төрөл болон түүний үргэлжлэх хугацааны талаарх түгээлтийн мэдээллийг Зөвлөлд долоо хоног бүр хүргүүлнэ.

22.2.Кино түгээлтийн мэдээлэл гаргах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

22.3.Кино театр хөгжлийн бэрхшээлтэй хүн болон ахмад настанд зориулсан тоноглол, тэмдэглэгээг стандартын дагуу хийж, хүртээмжийг нэмэгдүүлэх үүрэгтэй байна.

ДОЛДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

23 дугаар зүйл. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих

23.1.Кино урлагийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилтэд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Зөвлөл болон мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина.

24 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

24.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

24.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

25 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

25.1.Энэ хуулийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНД

Хоёр. СОЁЛЫН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОХ ХУУЛЬ

(цагаан толгойн дарааллаар)



Авто замын тухай хуулиас

19 дүгээр зүйл. Авто зам, замын байгууламжийн зураг төсөл

19.2.Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд тавигдах шаардлага:

19.2.2.зорчигчдын эрүүл ахуй, хөдөлгөөний аюулгүй байдал, байгаль орчин, түүх, соёлын дурсгалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг хангасан байх;



Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиас

4.1.1.“аж ахуйн нэгж” гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээд болон үндсэн үйл ажиллагаа нь ашгийн бус боловч бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлж орлого олсон дотоод, гадаадын хуулийн этгээдийг

4.1.4.“гадаад улсаас олсон орлого” гэж энэ хуулийн 5.3-т заасан албан татвар төлөгч, төлөөний газрын энэ хуулийн 4.1.6, 4.1.7-д зааснаас бусад орлого;

4.1.7.б.энэ хуулийн 5.5.2-т заасан гадаадын аж ахуйн нэгжийн Монгол Улсад зохион байгуулсан урлаг, соёл, спортын болон бусад арга хэмжээнээс олсон орлого;

5.1.Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл орлого олоогүй боловч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий аж ахуйн нэгж нь албан татвар төлөгч байна.

5.3.Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчид дараах аж ахуйн нэгж хамаарна:

5.3.1.Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж;

5.3.2.удирдах байгууллага нь Монгол Улсад байрладаг гадаадын аж ахуйн нэгж.

5.5.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид дараах аж ахуйн нэгж хамаарна:

5.5.1.өөрийн төлөөний газраар дамжуулан Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж;

5.5.2.энэ хуулийн 5.5.1-д зааснаас бусад хэлбэрээр Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгж.

7.3.Энэ хуулийн 5.5.2-т заасан албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод албан татвар ногдоно.

18.6.Дараах орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо албан татвар ногдох тухайн орлогын төрөл тус бүрийн нийт дүнгээр тооцно:

18.6.1.эрхийн шимтгэлийн орлого;

18.6.2.ногдол ашгийн орлого;

18.6.3.хүүгийн орлого;

18.6.4.үл хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;

18.6.5.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалаанаас хожсон орлого;

18.6.6.тухайн татварын жилд төлөөний газраас өөрийн толгой аж ахуйн нэгжид шилжүүлсэн ашиг;

18.6.7.энэ хуулийн 11.1.5, 11.1.6-д заасан орлого;

18.6.8.энэ хуулийн 6.10-т заасан журмын дагуу бүртгүүлсэн төлөөний газраас бусад Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн энэ хуулийн 4.1.6, 4.1.7, 8.3-т заасан орлого.

20 дугаар зүйл.Албан татварын хувь, хэмжээ

20.1.Энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасны дагуу тодорхойлоход 0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар

ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар нэмж албан татвар ногдуулна.

20.2.Албан татвар төлөгчийн дараах албан татвар ногдуулах орлогод доор дурдсан хувиар тооцож албан татвар ногдуулна:

20.2.1.энэ хуулийн 18.6.1, 18.6.2, 18.6.3, 18.6.7, 18.7-д заасан орлогод 10 хувиар;

20.2.2.энэ хуулийн 18.6.4-т заасан албан татвар ногдуулах орлогод 2 хувиар;

20.2.3.энэ хуулийн 18.6.5-д заасан орлогод 40 хувиар;

20.2.4.энэ хуулийн 18.6.6, 18.6.8-д заасан орлогод 20 хувиар;

20.2.5.ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй /Үүнд энэ хуулийн 4.1.12, 30.1-д заасан этгээд мөн хамаарна./ Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалах өрийн хэрэгсэл, нэгж эрх худалдан авсан албан татвар төлөгчийн хүүгийн орлогод 5 хувиар;

20.2.6.Монгол Улсын арилжааны банкны гадаад, дотоодын эх үүсвэрээс татсан зээл, өрийн хэрэгслийн хүүгийн орлогод 5 хувиар;

20.2.7.энэ хуулийн 20.1-д заасныг үл харгалзан энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан жилийн 300 сая төгрөг хүртэл албан татвар ногдох орлого олсон, энэ хуулийн 22.1.1, 22.1.2, 22.1.3-т зааснаас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн тухайн албан татвар ногдуулах орлогод 1 хувиар.

20.2.8.оюуны өмчийн эрх борлуулсны орлогод 5 хувиар.



Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулиас

43.3.Дараах байгууллага, хуулийн этгээд нь сонгуулийн уулзалт, хурал, цуглаан хийхэд нь зориулж өөрийн эзэмшиж байгаа соёлын төв, биеийн тамирын болон хурлын заал, бусад байр, танхимыг үнэ төлбөргүйгээр ашиглуулах үүрэгтэй:

43.3.1.төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага;

43.3.2.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

43.3.3.төрийн болон орон нутгийн өмчийн 51 хувь ба түүнээс дээш оролцоотой хуулийн этгээд.

43.4.Энэ хуульд заасны дагуу санал авах байр болгон бэлтгэсэн, эсхүл сонгуулийн хороод тухайн байр, танхимд үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд энэ хуулийн 43.3 дахь хэсэг хамаарахгүй.

69.1.Санал авах өдөр дараах үйл ажиллагааг хориглох бөгөөд аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох шийдвэр гарган хяналт тавьж ажиллана:

69.1.2.соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах;



Амьтны тухай хуулиас

15.1.Гэмтээлгүйгээр хууль болон гэрээнд заасны дагуу амьтны аль нэг ашигтай шинж чанарыг ашиглах үйл ажиллагааг амьтныг ашиглах гэнэ.

15.2.Амьтныг дор дурдсан хэлбэрээр ашиглаж болно:

15.2.1.эрдэм шинжилгээний ажил, соёл урлаг, гоо зүйн зориулалтаар ашиглах;

29.1.Тусгай төлбөр төлсөн иргэнд энэ хуулийн 24.3.3-т заасан зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

29.2.Агнуурын амьтныг тусгай зориулалтаар агнах, барих тусгай зөвшөөрөл нь дараах төрөлтэй байна:

29.2.1.агнуурын амьтныг эрдэм шинжилгээ, соёл урлаг, эмчилгээний зориулалтаар;



Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулиас

6.1.Архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.1.17.гадаад улсад байгаа Монгол Улсын үндэсний түүх, соёлд холбогдох архивын баримтыг судалж илрүүлэх, шилжүүлж авах ажлыг зохион байгуулах;

11.7.Хосгүй үнэт архивын баримтыг тодорхойлох, тэдгээрийн бүртгэл хөтлөх, хадгалах, хамгаалах, ашиглах журмыг соёлын болон архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

10.1.Үндэсний архивын сан хөмрөг нь төрийн ой санамж, Монгол Улсын түүх, соёлын өв болохын хувьд өмчийн хэлбэрээс үл хамааран төрийн хамгаалалтад байна

11.1.Архивын баримтыг хосгүй үнэт, нэн үнэт, үнэт, ердийн гэж зэрэглэнэ.

11.2.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.3-т заасан шалгуурыг хангасан архивын баримтыг хосгүй үнэт баримтад хамруулна.

11.3.Түүх, соёлын болон шинжлэх ухааны хувьд онцгой ач холбогдолтой, бүртгэл, хадгалалт, ашиглалтын тусгай нөхцөл шаардагдах архивын баримтыг нэн үнэт баримтад хамруулна.

11.4.Үнэт баримтад хосгүй үнэт, нэн үнэт баримт гэж тогтоосноос бусад буюу энэ хуулийн 6.1.11-д заасан жагсаалтад байнга хадгалахаар тусгасан архивын баримт хамаарна.

11.5.Энэ хуулийн 6.1.11-д заасан жагсаалтад түр хугацаагаар хадгалахаар тусгасан архивын баримт нь ердийн зэрэглэлд хамаарна.

11.6.Хосгүй үнэт, нэн үнэт баримтын шинж чанарт үзлэг хийх, сэлбэн засах, сэргээн шинэтгэх, хамгаалалтын хуулбар хувь үйлдэхээс бусад байдлаар ашиглахыг хориглоно.

11.7.Хосгүй үнэт архивын баримтыг тодорхойлох, тэдгээрийн бүртгэл хөтлөх, хадгалах, хамгаалах, ашиглах журмыг соёлын болон архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

11.8.Нэн үнэт архивын баримтыг тодорхойлох, тэдгээрийн бүртгэл хөтлөх, хадгалах, хамгаалах, ашиглах асуудлыг энэ хуулийн 15.6.6-д заасан журмаар зохицуулна.

11.9.Хосгүй үнэт архивын баримттай холбогдох энэ хуульд заагаагүй бусад асуудлыг Соёлын өвийг хамгаалах тухай хуульд зааснаар зохицуулна.

27.2.Дараах байнга хадгалах баримтыг доор дурдсан хугацаанд байгууллагын архивт хадгалж, уг хугацаа дууссаны дараа харьяалах төрийн архивт шилжүүлнэ:

27.2.1.төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд холбогдох шинжлэх ухаан, технологи, патентын холбогдолтой баримтын эх хувийг-5 жил;

27.2.2.улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулж бүтээгдсэн кино, гэрэл зураг, дуу авиа, дүрс бичлэгийн баримтын эх хувийг-1 жил.

28.12.Музей, номын сан болон төрийн бус байгууллага нь төрийн архивын сан хөмрөгт хамаарах эх баримтаар бүрдүүлэлт хийхийг хориглоно.

28.4.Энэ хуулийн 23.3-т заасан журмын дагуу байгууллагын архив нь цахим баримт бичиг, кино, гэрэл зураг, дуу авиа, дүрс бичлэгийн баримтыг төрийн архивт шилжүүлэхийн өмнө тэдгээрийн хадгалалтын байдал техникийн чанарын үзлэг хийнэ.

32.1.Хууль тогтоомжийн дагуу, эсхүл архивын баримт өмчлөгч /эзэмшигч/-тэй байгуулсан гэрээний дагуу ашиглалт нь хязгаарлагдсанаас бусад үндэсний архивын сан хөмрөгийн баримтыг энэ хуулийн 5.2.5-д заасны дагуу гадаад улсад түр гаргаж болно.

32.2.Хууль тогтоомжийн дагуу, эсхүл архивын баримт өмчлөгч /эзэмшигч/-тэй байгуулсан гэрээний дагуу ашиглалт нь хязгаарлагдсанаас бусад үндэсний архивын сан хөмрөгийн баримтыг гадаад улсад түр гаргах, хуулийн дагуу олж авсан гадаад улсад байгаа архивын баримтыг Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулах талаар энэ хуульд заагаагүй бусад асуудлыг Соёлын өвийг хамгаалах тухай хуульд зааснаар зохицуулна.



Ахмад настны тухай хуулиас

11 дүгээр зүйл. Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих

11.1.Ахмад настны хөгжил, оролцоог төрөөс дараахь байдлаар дэмжинэ:

11.1.2.нутгийн захиргааны байгууллага нь ахмад настанд биеийн тамир, спорт, соёл, урлагийн барилга, байгууламж, талбайг үнэ төлбөргүй ашиглуулах, ахмад настны дунд биеийн тамир, спорт, урлаг, соёлын арга хэмжээг зохион байгуулах, ахмадын баг, хамтлаг, клубыг үйл ажиллагаа явуулах байраар үнэ төлбөргүй хангах үүрэг хүлээх;



Ашигт малтмалын тухай хуулиас

40¹ дүгээр зүйл.Соёлын өвийг хамгаалах

40¹.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 402, 46 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлнэ.

40¹.2.Ашигт малтмалын хайгуул хийхдээ палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авахгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно.

40² дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг

40².1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь соёлын өвийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

40².1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан, улсын хяналтын байцаагчид хайгуулын талбайд нэвтрэн орох, газар дээр нь шалгалт хийх бололцоо олгох;

40².1.2.ашигт малтмал эрэх, хайх явцад олж илрүүлсэн соёлын өвийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хуульд заасны дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх ба тухайн өвийг холбогдох байгууллагад хадгалуулахаар шилжүүлэх үүрэг хүлээнэ.

41 дүгээр зүйл. Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх

41.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна.

43.3.Энэ хуулийн 43.2-т заасан төлбөрийг тухайн сум, дүүргийн төсөвт төвлөрүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох, боловсролын болон эрүүл мэндийн салбарт зарцуулах бөгөөд энэ талаархи журмыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

56 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг цуцлах

56.1.Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг дараахь үндэслэлээр цуцална:

56.1.7.хайгуулын талбайд соёлын өв байгаа нь тогтоогдсон



Аялал жуулчлалын тухай хуулиас

3.1.3. "аялал жуулчлалын бүс нутаг" гэж Монгол Улсад аялал жуулчлал хөгжүүлэхэд тохирсон байгаль, түүх, соёлын нөөц бүхий газар нутгийг;

8 дугаар зүйл. Аялал жуулчлалын байгууллагын бүрэн эрх

8.1. Аялал жуулчлалын байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.4. Монгол Улсын нийгэм, эдийн засаг, төрийн байгуулалт, түүх соёл, ёс заншил, зан үйлийн талаар жуулчдад үнэн бодит мэдээлэл өгөх;

8.1.5. байгаль, түүх, соёлын нэн ховор зүйлсийг хайрлан хамгаалахад өөрийн зүгээс шаардагдах арга хэмжээ авах, гарсан зөрчлийн талаар холбогдох байгууллагад мэдэгдэх;

13.1. Хөтөч-тайлбарлагч нь дараах эрх, үүрэгтэй.

13.1.3. Монгол Улсын нийгэм эдийн засаг, төрийн байгуулал, байгаль, түүх, соёл, ард түмний зан заншлын талаар жуулчдад бодит мэдээлэл өгөх, улс, хувь хүн, байгууллагын нууцад хамаарах мэдээллийн нууцыг задруулахгүй байх

23.2. Аялал жуулчлалын улсын байцаагч дараахь үүрэг хүлээнэ:

23.2.4. аялал жуулчлалын байгууллага, хөтөч-тайлбарлагч нь Монгол Улсын нийгэм, эдийн засаг, төрийн байгуулалт, түүх, соёл, ард түмний зан заншлын талаар жуулчдад бодитой мэдээлэл өгч байгаа эсэхэд хяналт тавих.



Бага, дунд боловсролын тухай хуулиас

4.1.Бага боловсролын агуулга нь дараахь зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ:

4.1.1.эх хэлээрээ зөв ярьж, бодол санаагаа ойлгомжтой илэрхийлэх, уншиж, бичиж сургах;

4.1.4.гоо зүй, хүмүүнлэг, үндэсний дэвшилт, ёс заншил, соёлын өв уламжлал, эрүүл ахуйн зохих шатны мэдлэг, чадвар эзэмшүүлэх;

5.1.Суурь боловсролын агуулга нь дараахь зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ:

5.1.1.эх болон гадаад хэл, математик, мэдээлэл зүй, шинжлэх ухаан, эрх зүйн зохих шатны мэдлэг, өөрийн авьяас, чадварт тулгуурлан бие даан амьдрахад шаардлагатай чадвар, дадал эзэмшүүлэх;

5.1.2.гоо зүй, ёс суртахууны соёлтой, эрүүл чийрэг, иргэний үүргээ ухамсарласан, үнэнч шударга, хамтач, энэрэнгүй, эх оронч, хууль ёсыг дээдлэн сахидаг, үндэсний болон хүн төрөлхтний дэвшилт ёс заншил, соёлын үнэт зүйлсийг хүндлэн хайрладаг болгон төлөвшүүлэх;

5.1.3.эрүүл аж төрөх ёс, гэр бүлийн амьдралын анхан шатны ойлголт, соёлын төсөөлөл эзэмшүүлэх;

18 дугаар зүйл.Хичээлээс гадуурх сургалтын ажил

18.1.Хичээлээс гадуурх сургалтын ажил нь суралцагчийн танхимд эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, баяжуулах, тэдний авьяас, сонирхлыг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чиглэнэ.

18.2.Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тогтооно.

18.3.Сургуулийн захиргаа нь хичээлээс гадуурх сургалтын ажлыг дугуйлан, түр сургалт, соёл, урлаг, спортын арга хэмжээ зэрэг хэлбэрээр үлгэрчилсэн хөтөлбөр, хуваарийн дагуу холбогдох байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, иргэдтэй хамтран зохион байгуулна.



Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиас

8 дугаар зүйл.Ан амьтны нөөц ашигласны төлбөр ногдох зүйл

8.1.Төлбөр ногдох зүйл нь дор дурдсан зориулалтаар ашигласан ан амьтан байна:

8.1.3.тусгай зориулалтаар агнасан, барьсан /соёл, шинжлэх ухаан, тусгай төлбөртэй/.

12.1.Ан амьтны нөөц ашигласны төлбөрийг дараах үзүүлэлтээр тооцно:

12.1.1.үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар барьсан загасны төлбөрийг килограммаар;

17.1.Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн доод, дээд хязгаарыг дараах байдлаар тогтооно:

17.1.1.үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар барьсан загасны төлбөрийг килограмм тутамд 700-1000 төгрөгөөр;

17.1.2.ахуйн, үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнасан бусад ан амьтны төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40 хувиар;

22.2.Тодорхой нутаг дэвсгэрт ан амьтны тоог сийрэгжүүлэх, хүйсийн харьцааг зохицуулах, заазлах зорилгоор болон соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнахад төлбөрийг 80 хувь хүртэл хөнгөлж болно.



Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиас

3.1.4.“байгаль орчны төлөв байдлын үнэлгээ” гэж аливаа төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг;

4.1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гэдэгт дор дурдсан үнэлгээ хамаарна:

4.1.1.байгаль орчны стратегийн үнэлгээ /цаашид “стратегийн үнэлгээ” гэх/;

4.1.2.байгаль орчны төлөв байдлын үнэлгээ /цаашид “төлөв байдлын үнэлгээ” гэх/;

4.1.3.байгаль орчны нөлөөллийн үнэлгээ /цаашид “нөлөөллийн үнэлгээ гэх/;

4.1.4.хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ.

8.2.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу эрх авсан дотоодын аж ахуйн нэгж гүйцэтгэнэ.

8.3.Энэ хуулийн 8.2-т заасан эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгээр тайлан бэлтгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна.

8.4.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд дараах асуудлыг тусгана:

8.4.9.төсөл хэрэгжих газрын түүх соёлын үнэт зүйлс, төслийн онцлогтой уялдан бусад асуудал.



Байгаль орчныг хамгаалах тухай

3 дугаар зүйл.Хуулиар хамгаалах объект, түүнтэй холбогдсон нэр томъёо

1.Энэ хуулиар байгалийн дор дурдсан объектыг байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалж, байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлнэ:

1/газар, түүний хөрс;

2/газрын хэвлий, түүний баялаг;

3/ус;

4/ургамал;

5/амьтан;

6/агаар.

2.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

8/“байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл” гэж /цаашид “нөхөрлөл” гэх/ нутгийн иргэдэд байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх эрхийг олгож, нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс гарсан үр ашгийг иргэдэд тэнцүү хуваарилах зорилготой нөхөрлөлийг;

45 дугаар зүйл.Байгалийн нөөцийн хамтын менежмент

1.Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан нутгийн иргэдэд байгалийн нөөцийг дундаа хариуцан хамгаалах, зохистой ашиглах болон нөхөн сэргээх эрхийг олгож, нутгийн иргэд нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс нийгэм, эдийн засгийн ашиг тусыг хүртэж байх үйл явцыг байгалийн нөөцийн хамтын менежмент гэнэ.

47 дугаар зүйл.Байгалийн нөөцийн хамтын менежментийн хамрах хүрээ

1.Нөхөрлөлийн хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх объектэд энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгалийн нөөцөөс гадна дэлхийн болон үндэсний байгаль, соёлын өвд хамаарагдах газар нутаг орно.

50 дугаар зүйл.Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл

1.Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд тухайн орон нутгийн иргэд энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдан оролцож болох бөгөөд гэрээний үндсэн дээр хамтын менежментээр хариуцаж байгаа нутаг дэвсгэрийнхээ тодорхой төрлийн байгалийн нөөцийг хуулийн хүрээнд гэрээнд заасны дагуу зохистой ашиглах давуу эрхтэй байна.



Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулиас

5 дугаар зүйл. Барааны тэмдэгт тавих шаардлага

- 5.1. Ялгагдах шинж чанар агуулаагүй дараахь зүйлийг барааны тэмдэгт тооцохгүй:
- 5.1.4. Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлийн нэр, дүрс дангаараа байвал;
- 5.1.5. Монгол Улсын түүхэн хүмүүсийн бүтэн нэр, зохиомол нэр, хөрөг, зураг, тэдгээрт шууд хамаарах төсөөллийн нэр дангаараа байвал.
- 5.2.2. Монгол Улсын нэрд гарсан хүний бүтэн нэр, эсхүл зохиомол нэр, хөрөг, зургаас бүрдсэн илэрхийллийг тухайн хүний буюу түүний өв залгамжлагчийн зөвшөөрөлгүй ашигласан;
- 5.4. Энэ хуулийн 5.1.5, 5.2.2-т заасан Монгол Улсын түүхэн, нэрд гарсан хүмүүсийг тодорхойлох болон барааны тэмдгийн мэдүүлэг гаргах, шүүлт хийх журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/ баталж мөрдүүлнэ.



Барилгын тухай хуулиас

37 дугаар зүйл. Захиалагчийн чиг үүрэг

- 37.1. Барилгын ажлын захиалагч дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 37.1.11. түүх, археологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэх, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах;
- 40 дүгээр зүйл. Барилгын ажил гүйцэтгэгчийн чиг үүрэг**
- 40.1. Барилгын ажил гүйцэтгэгч дараахь чиг үүрэгтэй:
- 40.1.4. барилгын ажлын талбайд гал, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны горимыг мөрдөж, байгаль орчин, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах;
- 46 дугаар зүйл. Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг**
- 46.1. Барилга байгууламжийн ашиглалтын явцад өмчлөгч, эзэмшигч дараахь үүргийг хүлээнэ:
- 46.1.6. байгаль орчин, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах;



Биений тамир, спортын тухай хуулиас

- 4.1.5. “үндэсний спорт” гэж ард түмний уламжлал, зан заншилд тулгуурлан хөгжсөн үндэсний онцлог шинжийг агуулсан спортыг;
- 4.1.7. “спортын наадам” гэж нэгдсэн хэлбэрээр зохион байгуулж байгаа спортын тэмцээн, соёл урлагийн арга хэмжээний нэгдлийг;
- 6.1. Засгийн газар нь биений тамир, спортыг хөгжүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 6.1.4. үндэсний спорт, багийн спортын төрлийг хөгжүүлэх хөтөлбөр батлах;



Боловсролын тухай хуулиас

- 10.3. Бүх шатны боловсролын хөтөлбөрт монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний төлөвшил, хөгжил, гэр бүл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл,

суралцагчийн гүйцэтгэх сайн дурын үйл ажиллагааны төрөл, агуулгыг заавал тусгаж, музей, номын сан, кино зэрэг соёл, урлаг, спортын байгууллагын боломжийг ашиглахаар зохион байгуулна

28 дугаар зүйл. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

- 28.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 28.1.26. гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, соёл, ёс заншил зааж сургахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- 30.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 30.1.12. үндэсний цөөнхийн боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;
- 41.4. Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, ёс заншил, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлж болох бөгөөд дэмжлэг үзүүлэх нөхцөл, шаардлага, хэмжээг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна.
- 43.2. Суралцагч нийгмийн дараахь баталгаагаар хангагдана:
- 43.2.6. Засгийн газраас тогтоосон журмын дагуу эмнэлэг, нийтийн хоол, соёл, урлагийн болон ахуйн үйлчилгээгээр үйлчлэх зардлыг хөнгөлөх;
- 45.1. Суралцагч дараахь эрхтэй:
- 45.1.8. уламжлалт соёл, зан заншлыг өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах.



Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулиас

- 4.1. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:
- 4.1.1. үндэсний эрх ашгийг эрхэмлэн дээдлэх;
- 4.1.2. бүс нутгийн нийгэм, соёлын харьцангуй жигд хөгжлийг хангахад чиглэсэн эдийн засгийн нэгдмэл орчныг бүрдүүлэх;
- 4.1.3. хүн амын нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, соёл, боловсролын үйлчилгээг тухайн бүс дотор нь аймаг, орон нутгийн чадавхид түшиглэн цогцолбороор шийдвэрлэх;



Гаалийн тухай хуулиас

- 209.1. Дор дурдсанаас бусад барааг устгах горимд байршуулж болно:
- 209.1.1. түүх, соёлын дурсгалт зүйл;
- 209.1.2. амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйл, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн /хүн, малын гоц халдварт өвчин гарснаас бусад тохиолдолд/;
- 246.5. Гаалийн байгууллага, албан тушаалтан нь дараахь барааг мэдүүлэгчийг байлцуулахгүйгээр шалгаж болно:
- 246.5.1. нийтийн аюулгүй байдал, хүн ам, ургамал, амьтан, хүрээлэн буй орчинд аюул учруулж болохуйц тэсэрч дэлбэрэх, түргэн шатах бараа, цацраг идэвхт бодис, химийн хорт болон аюултай бодис, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, түүх, соёлын үнэт зүйлс;



Газрын тосны тухай хуулиас

4.1.11.“гэрээлэгч” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулсан компанийг;

11.2.Гэрээлэгч дараах үүрэг хүлээнэ: 11.2.15.үйл ажиллагааных нь явцад түүх, соёлын олдвор, эд өлгийн зүйл илэрсэн тохиолдолд тухайн газарт явуулж байгаа үйл ажиллагаагаа зогсоон, нэн даруй холбогдох байгууллагад мэдэгдэх;

40.1.Гэрээлэгч нь хайгуул, ашиглалтын явцад худаг, өвөлжөө, намаржаа, хаваржаа, хувийн болон нийтийн зориулалттай орон байр, бусад барилга байгууламж, түүх, соёлын дурсгалт зүйл зэрэг бусдын өмчлөл, эзэмшлийн эд хөрөнгөд хохирол учруулсан бол хохирлыг нь бүрэн хэмжээгээр нөхөн төлнө.

40.2.Гэрээлэгч энэ хуулийн 40.1-д заасан барилга байгууламж, эд хөрөнгийг шилжүүлэн байрлуулахтай холбоотой зардлыг бүрэн хариуцна.

40.3.Энэ хуулийн 40.1-д заасан эд хөрөнгийн хариуцлагыг гэрээлэгч биелүүлээгүй тохиолдолд Иргэний хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.



Газрын төлбөрийн тухай хуулиас

8 дугаар зүйл. Газрын төлбөрөөс чөлөөлөх

1. Дараахь төлбөр төлөгчийг дор дурдсан газрыг эзэмшиж, ашигласны төлбөрөөс чөлөөлнө:

4/хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газар, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх төрлийн соёлын байгууллагыг болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг байгаль, түүх, соёлын дурсгалт зүйл, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалах, хамгаалахад зориулан эзэмшиж, ашиглаж байгаа газрынх нь;



Газрын тухай хуулиас

5.1.Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмч мөн.

5.2.Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно.

16 дугаар зүйл.Тусгай хэрэгцээний газар

16.1.Монгол Улс тусгай хэрэгцээний газартай байна. Улсын тусгай хэрэгцээний газарт дараахь газар хамаарна:

16.1.1.улсын тусгай хамгаалалттай газар;

16.1.15.хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газар.

50.1.Газар эзэмшигч, ашиглагч нь газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаар дараахь шаардлагыг биелүүлнэ:

50.1.4.ойн төгөл, ховор, ховордсон амьтан, ургамал, түүх, соёлын дурсгалт зүйл бүхий газрыг хамгаалах;



Газрын хэвлийн тухай хуулиас

20 дугаар зүйл.Газрын хэвлийг ашиглагчийн үндсэн эрх, үүрэг

1.Ашиглагч нь газрын хэвлийг олгосон зориулалтын дагуу ашиглах үүрэг, эрхтэй.

2.Газрын хэвлийг ашиглагч нь дор дурдсан шаардлагыг хангах үүрэгтэй:

3/газрын хэвлийг ашиглахад үүсч болзошгүй хортой нөлөөнөөс хий мандлын агаар, газар, ой, ус, рашаан, мал ан амьтан, байгаль орчны бусад объект, барилга байгууламжийг найдвартай хамгаалах, түүнчлэн тусгай хамгаалалттай газар, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтыг хангах;

5/газрын хэвлийг ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу болон шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах.

43 дугаар зүйл.Шинжлэх ухаан, түүх, соёлын онцгой үнэт зүйлийг агуулсан газрын хэвлийн хэсгийг хамгаалах

1.Геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, палеонтологийн болон шинжлэх ухаан, түүх, соёлын хувьд онцгой үнэт зүйл бүхий газрын хэвлийн хэсгийг төрийн хамгаалалтад авна. Төрийн хамгаалалтад авсан газрын хэвлийн хэсгийн бүрэн бүтэн байдалд харшлах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

2.Газрын хэвлийг ашиглах явцад геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, солир, палеонтологи, археологийн болон шинжлэх ухаан, түүх соёлын хувьд сонирхол татах бусад зүйл илэрвэл газрын хэвлийг ашиглагчид ажлаа зогсоож, энэ тухай төрийн зохих байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.



Галт зэвсгийн албан татварын тухай хуулиас

4 дүгээр зүйл. Албан татвараас чөлөөлөх

4.1.Дараах галт зэвсгийг албан татвараас чөлөөлнө:

4.1.1.музейн үзмэр, иргэний болон харуул хамгаалалтын зориулалтаар ашиглах боломжгүй, хөнөөх чадваргүй болсныг цагдаагийн байгууллага тогтоож гэрчилгээ олгосон;



Гамшгаас хамгаалах тухай хуулиас

4.1.1.“гамшиг” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;

4.1.5.“аюул” гэж хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг

4.1.10.“эрэн хайх, аврах ажиллагаа” гэж голомтын бүсэд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх арга хэмжээг; 10.4.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед энэ хуулийн 10.3-т зааснаас гадна тухайн нөхцөл байдалд нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

10.4.6.соёл урлаг, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарлах, цуцлах, хориглох;

19 дүгээр зүйл. Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх

19.1.Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргаж, хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйлийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлнэ.



Геодези, зураг зүйн тухай хуулиас

- 3.1.5."газар зүйн нэр" гэж газрын гадарга дээрх байгалийн болон барьж байгуулсан объектуудыг өөр хооронд нь ялган таних зорилгоор тогтоосон нэрийг;
- 11.4.Газар зүйн хуучин нэрийг тодотгох, шинээр тогтоохдоо лавлагааны болон түүхийн эх сурвалжид үндэслэх бөгөөд аливаа эх сурвалж байхгүй бол нутгийн уугуул иргэд, мэргэжлийн хүмүүс, судлаачдын саналыг үндэслэн тогтооно.
- 11.6.Газар зүйн нэрийг дараахь онцгой тохиолдолд өөрчилж болно:
- 11.6.1.адил төрлийн хэд хэдэн объектын ижил нэр нь зам, тээвэр, харилцаа холбоо, бусад байгууллагын ажилд хүндрэл учруулахаар байвал;
- 11.6.2.уугуул иргэд нь нэрлэж заншсан уламжлалт нэрийг сэргээх хүсэлт тавьсан;
- 11.6.3.тухайн объектын мөн чанарт тохирохгүй, этгээд хэллэгээр нэрлэгдсэн байвал.
- 11.7.Шинээр нэрлэх, өөрчлөх газар зүйн нэр дараахь шаардлагыг хангасан байна:
- 11.7.1.хүрээлэн буй орчин, газар зүйн объектын тодорхой шинж, түүх, соёл, ахуйн онцлогийг тусгасан байх;
- 11.7.2.монгол хэлний бичлэг, хэллэгт тохиромжтой гурваас илүүгүй үгээс бүтсэн байх.



Гэр бүлийн тухай хуулиас

10.3.Гэрлэгчид нь бие биедээ үнэнч байх, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүд нь бие биеэ халамжлах, хүндэтгэх, тэжээн тэтгэх, туслах, гэр бүлд шаардагдах эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх, хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй, бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх, угийн бичиг хөтлөх үүргийг адил хүлээнэ.

10.4. Угийн бичиг хөтлөх журмыг Засгийн газар батална. Угийн бичиг хөтлөх журмыг соёлын өв, хүн ам, архивын бодлого, үйл ажиллагаатай уялдуулсан байна.



Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиас

7.3.Хохирогчийг хуульд заасан эрхээ эдлэхэд түүний шашин шүтлэг, соёл, зан заншлын хэм хэмжээтэй холбогдуулан аливаа хязгаарлалт тогтоохыг хориглоно.

16 дугаар зүйл. Соёл, урлагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

16.1.Соёл, урлагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

16.1.1.хүний эрх, эрх чөлөө, эрх тэгш байдлыг хүндэтгэсэн, гэр бүлийн тэнцвэрт харилцааг дэмжсэн эерэг зан үйл, хандлагыг нийгэмд төлөвшүүлэхэд чиглэсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавих, сурталчлах ажлыг зохион байгуулах;

16.1.2.хүчирхийллийг илэрхийлж, сурталчилсан агуулга бүхий соёл, урлагийн арга хэмжээ, аливаа уран бүтээл, утга зохиолыг нийгэд түгээхээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хязгаарлалт тогтоох;

16.1.3.хуульд заасан бусад.



Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай

10.2.Суралцагчид мэдээлэл, нийгэм, соёл, эрүүл мэнд, биеийн тамирын үйлчилгээг хөнгөлөлттэй нөхцөлөөр үйлчлэхийг дэмжих нэгдсэн бодлогыг Засгийн газар боловсруулж, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангана.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулиас

9 дүгээр зүйл.Сургуулийн хоол зүйчийн эрх, үүрэг

9.2.Хоол зүйч шим тэжээлийн мэдлэгийг суралцагчид дараах чиглэлээр эзэмшүүлнэ:

9.2.3.уламжлалт хоолны соёл;

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиас

5.1.1.жендэрийн тэгш эрхийн зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялгаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцөлийг хангах;

6.1.Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглоно.

12 дугаар зүйл.Соёл, боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа

12.1.Эрэгтэй, эмэгтэй хүн сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсрол эзэмших, албан ба албан бус сургалтад хамрагдах ба мэргэжил дээшлүүлэх, мэргэших, арга зүйн зөвлөгөө авах, мөн сургалтын тэтгэлэг авах тэгш эрх, тэгш боломжтой байна.



Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиас

7.1.Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг дараахь чиглэлээр зохион байгуулна:

7.1.2.боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан;

8.1.Залуучуудын хувь хүний хөгжлийг дараахь чиглэлээр дэмжинэ:

8.1.3.түүх, соёлоо мэддэг, эх оронч үзэлтэй, бие дааж амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд чиглэсэн амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хөтөлбөрийн дагуу цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны залуучуудыг хамруулах;

9 дүгээр зүйл.Залуучуудын боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих

9.1.Залуучуудын хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй, чанартай боловсрол эзэмшүүлэхийг дараахь чиглэлээр дэмжинэ:

9.1.1.үндэстний цөөнх, шилжин суурьшигч, зорилтот бүлгийн залуучуудын боловсролын хэрэгцээнд суурилсан сургалтыг насан туршийн боловсролын хөтөлбөрийн дагуу эзэмшүүлэх;

9.1.3.номын сангийн үйлчилгээг залуучуудад хүртээмжтэй болгох арга хэмжээ авч, цахим номын сан хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

9.2.Энэ хуулийн 9.1.1, 9.1.2, 9.1.3-т заасан хөтөлбөрийг залуучуудын болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлнэ.

9.6.Залуучуудыг соёл, урлаг, шинжлэх ухааны шинэ бүтээл туурвихыг дэмжинэ.

9.7.Шинжлэх ухаан, өндөр технологи, инноваци, шинжилгээ, судалгааны чиглэлээр үндэсний тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ.

9.8.Энэ хуулийн 9.6, 9.7-д заасан үйл ажиллагааг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж, Залуучуудын хөгжлийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

12 дугаар зүйл.Аюулгүй амьдрах, хөгжих орчныг бүрдүүлэх

12.1.Залуучуудын аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг дараахь чиглэлээр дэмжинэ:

12.1.3.хорих болон засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож байгаа залуучуудад зориулсан сэтгэл заслын үйлчилгээ, соёл, спорт, хүмүүжлийн арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотой зохион байгуулах;

12.2.Энэ хуулийн 12.1.2, 12.1.3, 12.1.4, 12.1.5-д заасан үйл ажиллагааг залуучуудын болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ.

12.3.Залуучуудын өөрийгөө хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг дараахь чиглэлээр дэмжинэ:

12.3.1.залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн, соёл, урлаг, биеийн тамир, спортын цогцолбор, хөгжлийн төв, цэцэрлэгт хүрээлэн, дэд бүтцийг шинээр барьж байгуулах, өргөтгөх төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх;

12.3.2.залуучуудын авьяас чадвар, бие бялдар, сэтгэхүйг хөгжүүлэхэд шашин болон улс төрөөс ангид урлаг, соёл, спортын арга хэмжээнд залуучууд оролцох, эдгээр арга хэмжээг зохион байгуулсан хуулийн этгээдийг дэмжих;

12.3.3.түүх, соёлын өвийг хамгаалах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ардын урлаг, ёс заншил, уламжлалт зан үйлийг хөгжүүлэхэд залуучуудын оролцоог хангах;

12.3.4.залуучуудын дунд гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэх, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх, сурталчлах үйл ажиллагааг дэмжих;

12.3.5.байгаль орчныг хамгаалах ардын зан үйлийг сурталчлах, төлөвшүүлэх санаачилгыг дэмжих.

12.4.Энэ хуулийн 12.3.1, 12.3.2, 12.3.3, 12.3.4, 12.3.5-д заасан үйл ажиллагааг бүх шатны Засаг дарга нар хэрэгжүүлнэ.



Зар сурталчилгааны тухай хуулиас

7.4.Дараахь зар сурталчилгааг ёс суртахуунд үл нийцсэнд тооцно:

7.4.1.бусдын бүтээгдэхүүнийг гутаан доромжилсон;

7.4.2.Монгол Улсын болон бусад улсын төрийн бэлгэ тэмдэг, түүхэн алдарт хүн, үндэсний мөнгөн тэмдэгт, шашин шүтлэгийг гутаан доромжилсон;

7.4.3.төрийн тусгай алба хаагчийн дүрэмт хувцас, билэгдлийг дүрмийн бус, гаж хэлбэрээр ашигласан;

7.4.4.үндэсний болон түүх, соёлын үнэт зүйлсийн бүртгэлд орсон урлагийн бүтээлийг гутаан доромжилсон;

7.4.5.үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, нас, хүйс, мэргэжил боловсрол, шашин шүтлэг, үзэл бодлыг гутаан доромжилсон үг хэллэг, харьцуулалт, дүрслэл зэргийг ашигласан;

7.4.6.хүнлэг ёс, ёс суртахуун, Монгол хүний эрхэмлэн дээдэлдэг зан заншлын ёс горимыг зөрчсөн.

7.5.Энэ хуулийн 6.1-д заасныг зөрчсөн, хэрэглэгчийн ухамсарт шууд бусаар нөлөөлөх зар сурталчилгааг далд зар сурталчилгаа гэж тооцно.

7.6.Шүүх энэ хуулийн агуулга, зарчимд нийцүүлэн энэ хуулийн 7 дугаар зүйлд зааснаас бусад үндэслэлээр зар сурталчилгааг хууль бус гэж тооцож болно.

7.7.Хууль бус зар сурталчилгаа захиалах, бүтээх, түгээхийг хориглоно.

24 дүгээр зүйл.Төрөөс зар сурталчилгаанд тавих хяналт

24.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт зар сурталчилгаанд тавих хяналтыг оюуны өмчийн улсын хяналтын алба, Өрсөлдөөний тухай хуульд заасан асуудлаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар хэрэгжүүлнэ.

24.3.Оюуны өмчийн улсын хяналтын алба, Өрсөлдөөний тухай хуульд заасан асуудлаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.3.1.өөрийн санаачилгаар, эсхүл бусад этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, шаардлага, мэдээллийг судалсны үндсэн дээр зар сурталчилгаа захиалах, бүтээх, түгээх ажилд шалгалт хийх;

24.3.2.тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд зар сурталчилгаанд хяналт тавих орон нутгийн байгууллага, албан тушаалтныг арга зүйн удирдлагаар хангаж;

24.3.3.зар сурталчилгаа бүтээх, байрлуулах, түгээхэд баримтлах зөвлөмж, гэрээний үлгэрчилсэн загварыг батлах;

24.3.4.зар сурталчилгааны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн үйл ажиллагааны зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл цуцлах саналыг уг зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллагад тавих;

24.3.5.зар сурталчилгааны тухай хууль тогтоомж зөрчсөнтэй холбогдуулан шүүхэд нэхэмжлэл гаргах;

24.3.6.тухайн зар сурталчилгаа хуульд заасан шаардлагыг зөрчсөн эсэхийг тогтоох, түүнийг бүтээх, түгээхийг түдгэлзүүлэх, зөрчлийг арилгахыг шаардах.

24.4.Оюуны өмчийн улсын хяналтын албаны байцаагч, Өрсөлдөөний тухай хуульд заасан асуудлаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д зааснаас гадна дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

24.4.4.хууль тогтоомж зөрчсөн зар сурталчилгааг түгээхийг зогсоох;



Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиас

3.2.Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сан, Зэвсэгт хүчний хөгжлийн сан, Улсын авто замын сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын онцлогтой холбогдсон харилцааг тусгай хуулиар, нийтлэг харилцааг энэ хуулиар зохицуулна.

/Энэ хэсэгт “Мэргэжлийн” гэсний өмнө “Кино урлагийг дэмжих сан,” гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

5.1.Тусгай сангийн орлого, зарлагын тайлан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.

5.2.Тусгай санг хуулиар байгуулж, татан буулгана.

5.3.Тусгай сан дараах төрөлтэй байна:

5.3.9.Кино урлагийг дэмжих сан;

5.3.13.Соёл, урлагийг дэмжих сан;

6 дугаар зүйл.Тусгай санг бүрдүүлэх нийтлэг эх үүсвэр

6.1.Тусгай сан нь дараах нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ:

6.1.1.улсын төсвийн хөрөнгө;

6.1.2.хандив, тусламж;

6.1.3.тусгай сангийн өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого;

6.1.4.зээлийн хүүгийн орлого.

6.2.Энэ хуулийн 6.1.1-д заасан улсын төсвийн хөрөнгө дараах төрөлтэй байна:

6.2.1.эргэн төлөгдөх зээл;

6.2.2.эргэн төлөгдөх нөхцөлгүй олгосон эх үүсвэр.

6.3.Энэ хуулийн 6.1.2-т заасан хандив, тусламжид гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламж хамаарна.

6.4.Энэ хуулийн 6.1.3-т заасан орлогод тусгай сангийн үндсэн болон туслах үйл ажиллагаанаас олсон орлого хамаарна.

13 дугаар зүйл.Соёл, урлагийг дэмжих сан

13.1.Соёл, урлагийг дэмжих сан нь соёл, урлагийг хөгжүүлэх, сурталчлан таниулах, соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зориулалттай байна.

13.2.Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1-д заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

13.3.Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

13.3.1.соёлын өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, баяжуулах;

13.3.2.урлаг, утга зохиолын шинэ уран бүтээл туурвих, нийтийн хүртээл болгох төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

13.3.3.төсвийн хөрөнгөөр бүтээх үндэсний уламжлалт болон сонгодог урлагийн бүтээл туурвих;

13.3.4.соёлын өв, үндэсний соёл, урлагийг гадаадад болон өөрийн оронд сурталчилсан дуу авианы бичлэг хийх, ном хэвлүүлэх, соёл, урлагийн мэргэжлийн сонин, сэтгүүл гаргахад дэмжлэг үзүүлэх;

13.3.5.соёл, урлагийн тоглолт хийх, түүх, соёлын дурсгалт зүйл, уран бүтээлийн үзэсгэлэнг гадаадад болон өөрийн оронд зохион байгуулах;

13.3.6.хүүхдэд уран сайхан, гоо зүйн мэдлэг олгох уран бүтээл туурвих, соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулах;

13.3.7.соёл, урлагийн байгууллагад онцгой шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсэг худалдан авах;

13.3.8.хөгжмийн том хэмжээний болон дүрслэх урлаг, ном хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах;

13.3.9.олон улсын хэмжээний соёл, урлагийн наадам, тэмцээн, үзэсгэлэн, номын яармагт уран бүтээлчийг оролцуулах, түүнд онцгой амжилт гаргасан соёлын ажилтан, уран бүтээлчийг шагнаж урамшуулах;

13.3.10.үндэсний соёл, урлагийг хөгжүүлэх, соёлын өвийг хадгалж хамгаалахад хувь нэмэр оруулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг алдаршуулах;

13.3.11.монгол судлаачийг бэлтгэх, монгол судлаач, эрдэмтний шилдэг бүтээлийг шалгаруулж, хэвлүүлэх, сурталчлахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

13.4.Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

23.1.Энэ хуулийн 3.2-т заасан тусгай сан болон энэ хуулийн 5.3.2, 5.3.5, 5.3.6, 5.3.19-д зааснаас бусад тусгай сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийг үндэслэн дараах хэлбэрээр олгоно:

23.1.1.урьдчилгаа олгож гүйцэтгэлээр санхүүжүүлэх буюу тухайн ажил, үйлчилгээний онцлог, шаардагдах хөрөнгийн хэмжээтэй уялдуулан үе шаттайгаар санхүүжүүлэх;

23.1.2.шууд санхүүжүүлэх буюу ажил, үйлчилгээг гүйцэтгэсний дараа санхүүжилтийг бүрэн хэмжээгээр нэг удаа олгох.

23.2.Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, гүйцэтгэх ажил, үйлчилгээний онцлог, зарцуулах хөрөнгийн хэмжээг харгалзан санхүүжилтийн хэлбэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

23.3.Засгийн газрын нөөц сангаас олгох санхүүжилтийг тухайн төсөл, арга хэмжээ, ажил, үйлчилгээг хэрэгжүүлж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүний харилцах дансанд шууд шилжүүлэхийг хориглоно.



Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиас

4.5 дугаар зүйл.Эд зүйл, баримт бичиг хураан авах

1.Эрх бүхий албан тушаалтан зөрчлийг шалган тогтоох зорилгоор зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, эд зүйл, зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, уналга, эсхүл зөрчил шалгах ажиллагаанд ач холбогдолтой эд зүйл, баримт бичгийг хураан авна.

4.Зарим онцлох эд зүйл, үнэт эдлэл, түүх, соёлын дурсгалт зүйл, тэсэрч дэлбэрэх, хордуулах бодисыг хураан авах ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулж, эсхүл мэргэжлийн байгууллагад хандан гүйцэтгүүлж болно.

1.8 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал

6.Дараахь эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ:
6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.11, 5.12 дугаар зүйл, 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь, 5.15 дугаар зүйл, 6.26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.7, 6.8, 6.9, 6.10, 6.11, 6.12, 6.13, 6.14, 6.15, 6.16, 6.17 дугаар зүйл, 6.18 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг, 6.19, 6.20 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 6.23, 6.24, 6.25, 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.6, 7.7, 7.8, 7.9, 7.10, 7.11, 7.12, 7.13, 7.14, 7.15 дугаар зүйл, 7.16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 7.17, 8.1, 8.2, 9.1, 9.2, 9.3 дугаар зүйл, 9.4 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг, 9.5, 9.6, 9.7, 9.9 дүгээр зүйл, 9.10 дугаар зүйлийн 2.2, 2.3 дахь заалт, 3 дахь хэсэг, 9.11, 9.12, 10.2, 10.3, 10.4, 10.12, 10.13, 10.14, 10.15, 10.16, 10.17, 10.19, 10.22, 10.24, 10.25, 10.27, 11.2, 11.22 дугаар зүйл, 11.25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6, 12.7, 12.8, 12.9, 12.10, 12.11, 12.12, 13.1, 13.2, 13.4,

13.5, 13.7, 13.9, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.11 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 16.4 дүгээр зүйл, 17.1 дүгээр зүйлийн 14, 15, 17, 20 дахь хэсэгт заасан зөрчил;

6.12.татварын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.5 дугаар зүйл, 7.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 10.6 дугаар зүйл, 11.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 11.19, 11.24 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16.4 дүгээр зүйл, 17.1 дүгээр зүйлийн 21, 22, 24 дэх хэсэгт заасан зөрчил;

6.14.оюуны өмчийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 6.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 6.12 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, 6.18 дугаар зүйлийн 1, 3, 6 дахь хэсэг, 8.3, 8.4, 8.5 дугаар зүйл, 9.10 дугаар зүйлийн 2.4 дэх заалт, 10.1 дүгээр зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.5 дахь заалт, 10.18 дугаар зүйл, 11.3 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 11.5 дугаар зүйлийн 3.3 дахь заалт, 11.10 дугаар зүйлийн 2.1, 5.4, 12.4 дэх заалт, 11.12 дугаар зүйлийн 11 дэх хэсэг, 11.26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.16.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.10, 10.1, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.5 дахь заалт, 10.7, 10.8 дугаар зүйл, 10.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 10.27 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 16.7 дахь заалт, 19 дэх хэсэгт заасан зөрчил;

6.21.архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.26 дугаар зүйлд заасан зөрчил;

6.22.нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.4 дүгээр зүйлийн 1, 5 дахь хэсэг, 9.8 дугаар зүйл, 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 11.1 дүгээр зүйл, 11.10 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, 11.13 дугаар зүйл, 11.18, 11.20, 11.25, 11.27 дугаар зүйл, 17.1 дүгээр зүйлийн 25, 27 дахь хэсэгт заасан зөрчил;



Зөрчлийн тухай хуулиас

7.10 дугаар зүйл.Газрын хэвлийн тухай хууль зөрчих

4.Газрын хэвлийг:

4.2.ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг зохих байгууллагад мэдэгдээгүй;

4.3.ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй;

4.4.ашиглах үед түүнийг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.13 дугаар зүйл.Газрын тосны тухай хууль зөрчих

16.Гэрээлэгч:

16.7.үйл ажиллагааных нь явцад түүх, соёлын олдвор, эд өлгийн зүйл илэрсэн тохиолдолд тухайн газарт явуулж байгаа үйл ажиллагаагаа зогсоож холбогдох байгууллагад даруй мэдэгдэх;

16.11.техникийн осол, саатал, алдагдал урт хугацаанд үргэлжлэн санхүүгийн хүнд байдалд орсон нь тогтоогдсон, эсхүл шүүхийн шийдвэр болон улсын байцаагчийн актаар үйл ажиллагааг зогсоосон, эсхүл давагдашгүй хүчин зүйл, бусад шалтгаанаар хайгуул, бүтээн байгуулалт, ашиглалт, экспортын үйл ажиллагааг зогсоохдоо газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад урьдчилан мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.5 дугаар зүйл.Номын сангийн тухай хууль зөрчих

1.Номын сангийн тухай хуулиар тогтоосон журам зөрчсөн, эсхүл номын заавал авах хувийг шилжүүлэх үүрэг бүхий этгээд зохих журмын дагуу номыг хүлээлгэн өгөөгүй бол зардлыг буруутай этгээдээр төлүүлж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.6 дугаар зүйл.Соёлын тухай хууль зөрчих

1.Соёлын зориулалтаар ашиглаж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламж, эзэмшил газрыг тухайн байгууллагын үндсэн чиг үүрэгт нь харшлах өөр зориулалтаар ашигласан, эсхүл эзэмшсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Музей, орон нутгийн номын сан болон орон нутаг судлах танхимын мэдээллийн үйлчилгээнд 16 хүртэлх насны хүүхдийг үнэ төлбөргүйгээр хамруулах журам зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгад эзлэх үндэсний болон хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, киноны эзлэх хувийг баримтлаагүй бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс нь зөвшөөрөл авалгүй, даатгалд даатгуулалгүйгээр соёлын гадаад үйл ажиллагаанд насанд хүрээгүй хүнийг оролцуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих

1.Хуульд заасны дагуу:

1.1.соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлээгүй, эсхүл уг сангийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдал, мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байх шаардлагыг хангаагүй;

1.2.соёлын өвийг хуульд заасан хугацаанд бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй;

1.3.соёлын өвийг зөөж тээвэрлэх журам зөрчсөн;

1.4.түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Соёлын өвийн судалгаа, шинжилгээ хийхдээ язгуур шинж, унаган төрх байдал, хүрээлэн байгаа орчны зохиомжийг эвдэж хуулиар тогтоосон журам, эсхүл стандартыг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах анхны саналыг төрд тавихгүйгээр худалдсан, эсхүл гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлсэн, эсхүл зуучилсан бол уг дурсгалт зүйлийг хураан авч улсын орлого болгон хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Соёлын биет өвийг сэргээн засварлах хуулиар тогтоосон журам, эсхүл стандартыг зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Соёлын биет өвийг хадгалах, хамгаалах, ашиглах талаар хуулиар тогтоосон хориглолт, журам, стандартыг зөрчсөн, эсхүл анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулсан, эсхүл зөвшөөрөлгүй хөдөлгөж, зөөж тээвэрлэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дэргэд байрлуулсан танилцуулга, тайлбар, тэмдэг, тэмдэглэгээг эвдэж устгасан, эсхүл дурсгал дээр ханын самбар, зурагт хуудас, түүнтэй адилтгах бусад хэрэгслийг байрлуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Соёлын өвийн, эсхүл түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын дэглэм зөрчсөн бол хүнийг таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад илэрсэн соёлын биет өвийг хамгаалах, мэдээлэх арга хэмжээ аваагүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Нийтийн өмчийн соёлын биет өвийг 1:1 масштабаар зөвшөөрөлгүй хувиран олшруулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийхдээ:

10.1.геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, усны эх, рашаан, булаг, бүрд зэрэг байгалийн унаган тогтоц, эмзэг хэсгийг гэмтээсэн;

10.2.тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэсэн;

10.3.судалгааны үр дүнд хохирол учруулж болзошгүй техник, тоног төхөөрөмж ашигласан;

10.4.малтлага, судалгааны явцад үүссэн нүх, хонхор болон хүрээлэн байгаа орчны үзэмжийг эвдсэн элс, шороо, чулуун овоолго үлдээсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.Түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий олдворыг хадгалах, хамгаалах, судлахдаа түүний анхны төрх байдал, хэлбэр, шинж чанарыг алдагдуулж гэмтээсэн, олдворыг стандартын шаардлага хангаагүй

өрөө тасалгаа, орчинд хадгалсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

12.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа гэмтээсэн, эсхүл үрэгдүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

13.Соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын болон орчны бүсэд хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй палеонтологи, археологийн олдвор, дурсгалаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үзэсгэлэн гаргасан, эсхүл музей байгуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураан авч улсын орлого болгож хүнийг зургаан зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг зургаан мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.10 дугаар зүйл.Монгол хэлний тухай хууль зөрчих

1.Монгол хэлний тухай хуулиар тогтоосон хориглосон зохицуулалт, эсхүл журам зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Монгол хэлний тухай хуулиар тогтоосон:

2.1.хот, суурин газрын гудамж, талбайн нэр, хаяг, төрийн байгууллагын нэрийг төрийн албан ёсны хэлээр бичих;

2.2.хуульд тусгайлан заасан суралцагчдад боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан хөтөлбөрийн дагуу төрийн албан ёсны хэлний мэдлэгийг эзэмшүүлэх;

2.3.хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх иргэдэд үндэсний, төрийн албан ёсны хэлийг зааж сургахад дэмжлэг үзүүлэх;

2.4.төрийн албан ёсны хэлээр гарч байгаа олон нийтэд зориулсан хэвлэл, мэдээлэл нь орчин цагийн монгол утга зохиолын хэлний хэм хэмжээ, нэр томъёог баримтлах тухай журам зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Монгол Улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаад улсын хуулийн этгээд, төрийн бус байгууллага нь Монгол Улсын төрийн байгууллагатай төрийн албан ёсны хэлээр харилцах, санхүү, татвар, хөдөлмөр, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой баримт бичгийг төрийн албан ёсны хэлээр хөтлөх журам зөрчсөн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.12 дугаар зүйл.Музейн тухай хууль зөрчих

1.Музейн ерөнхий бүртгэл болон сан хөмрөгийн дэлгэрэнгүй бүртгэлийг музейгээс өөр газарт хадгалсан, музейн захирлын зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулсан, хэсэгчлэн болон бүтнээр нь хувиран олшруулсан, засварласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Гарал үүсэл нь тодорхойгүй соёлын үнэт зүйлийг музейн сан хөмрөгт авсан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.13 дугаар зүйл.Кино урлагийг дэмжих тухай хууль зөрчих

1.Монгол Улсын нутаг дэвсгэрт кино бүтээх зорилгоор гадаадын иргэн, хуулийн этгээд зураг авалт хийх зөвшөөрөл авахгүйгээр зураг авалт хийсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.18 ба түүнээс дээш насныханд зөвшөөрөх ангиллын киног өргөн нэвтрүүлгийн болон кабелийн телевизээр өдрийн буюу 06.00-22.00 цагт нэвтрүүлсэн, эсхүл кино театр, үзвэрийн цэг, үзвэрийн танхимаар насанд хүрээгүй хүнд үзүүлсэн бол хүнийг арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.4 дүгээр зүйл.Эрдэнэсийн сангийн тухай хууль зөрчих

2.Эрдэнэсийн санд үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэл, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг нэг эд хариуцагчаас нөгөөд шилжүүлэхдээ нэг бүрчлэн тоолж, жинлэж, бүртгэлтэй тулган тооцож, удирдлагын хяналттайгаар хүлээлцэх журам зөрчсөн бол хүнийг жаран нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг зургаан зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

17.1 дүгээр зүйл.Сонгуулийн хуулийг зөрчих

3.Сонгуулийн уулзалт, хурал, цуглаан хийхэд зориулж өөрийн эзэмшиж байгаа соёлын төв, биеийн тамирын болон хурлын заал, бусад байр, танхимыг үнэ төлбөргүй ашиглуулах үүргээ биелүүлээгүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



Зөвшөөрлийн тухай хуулиас

2.1 дүгээр зүйл. Зөвшөөрлийн ангилал

1. Зөвшөөрлийг түүний зорилго, олгох нөхцөл, үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн түвшнээс хамааруулан доор дурдсанаар ангилна:

1.1. тусгай зөвшөөрөл;

1.2. энгийн зөвшөөрөл.

2. Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүй үйл ажиллагаа, эсхүл тусгай болзол, шаардлагыг хангасны үндсэн дээр хэрэгжүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа, эсхүл ашиг олох зорилгоор болон үйлдвэрлэлийн зориулалтаар байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахад тусгай зөвшөөрөл олгоно.

3. Нэг удаагийн шинжтэй үйл ажиллагаа, эсхүл тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх нэмэлт үйл ажиллагаа, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ахуйн хэрэгцээний зориулалтаар ашиглуулахад энгийн зөвшөөрөл олгоно.

4. Тусгай зөвшөөрлийг хуульд заасан тохиолдолд түүнд тавигдах нөхцөл, шаардлагыг бүрэн хангуулах үүднээс урьдчилсан байдлаар олгож болно.

8.1 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийн жагсаалт

7. Соёл, боловсролын чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
7.5. музейн үйл ажиллагаа эрхлэх	Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

8.2 дугаар зүйл. Энгийн зөвшөөрлийн жагсаалт

6. Соёл, боловсролын чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
6.1. түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл, эх олдворыг сэргээн засварлах, сурталчлах зорилгоор улсын хилээр нэвтрүүлэх	Засгийн газар
6.6. Монгол Улсын нутаг дэвсгэрт палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх	Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
6.7. Монгол Улсын нутаг дэвсгэрт соёлын биет бус өвийн судалгаа хийх	Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
6.8. нийтийн өмчийн соёлын биет өвийг хувиран олшруулах	Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
6.9. соёлын биет өвийг сэргээн засварлах	Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
6.10. соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх	Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
6.11. соёлын биет өвийг зөөж тээвэрлэх	Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
6.12. түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, палеонтологи, археологийн олдворыг судалж шинжлүүлэх, сэргээн засварлах, гадаад улсад үзэсгэлэнд гаргах, өмчлөгч өөрөө язгуур зориулалтаар нь ашиглах зорилгоор улсын хилээр нэвтрүүлэх	Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
6.13. Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэн, хуулийн этгээд кино зураг авалт хийх	Кино урлагийн зөвлөл



Иргэний хуулиас

21.5. Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хор учирсан гэж үзвэл тухайн этгээд гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.

118 дугаар зүйл. Дарагдмал үнэт зүйл

118.1. Хуульд өөрөөр заагаагүй бол өмчлөгчийг буюу эрх бүхий этгээдийг тогтоох боломжгүй болтол удаан хугацаагаар газарт булагдсан, эсхүл дарагдаж орхигдсон үнэт зүйл /дарагдмал үнэт зүйл/ олдсон бол түүнийг олсон болон тухайн зүйл олдсон газар буюу эд хөрөнгийн өмчлөгч нар хоорондоо өөрөөр тохиролцоогүй бол тэнцүү хэмжээгээр хувааж өмчлөх эрхтэй.

118.2. Дарагдмал үнэт зүйл олдсон газар буюу эд хөрөнгийн өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр, дарагдмал үнэт зүйлийг олох зорилгоор эрэл хайгуул хийж түүнийг олсон бол тухайн үнэт зүйл нь уг үнэт зүйл олдсон газрын буюу эд хөрөнгийн өмчлөгчид бүрэн хэмжээгээр шилжинэ.

118.3. Дарагдмал үнэт зүйлс дотор түүх, соёлын дурсгалт зүйл байвал тэдгээрийг төрийн өмчлөлд шилжүүлнэ. Энэ тохиолдолд дарагдмал үнэт зүйл олдсон газрын буюу эд хөрөнгийн өмчлөгч болон эд юмсыг олсон этгээдэд түүний үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх мөнгөн шагналыг тэнцүү хувааж олгоно.

118.4. Хайгуул, малталт хийх албан үүрэг бүхий этгээд уг үүргээ гүйцэтгэх явцдаа илрүүлсэн дарагдмал үнэт зүйлс, археологийн болон палентологийн олдворт энэ зүйлд заасан журам хамаарахгүй.

338¹ дүгээр зүйл. Мерчандайзийн гэрээ

338¹.1. Мерчандайзийн гэрээгээр бие хүний нэр, төрх, дуу хоолой болон утга зохиол, урлагийн бүтээл, эд зүйлийн дүр, зургийг бүтээгдэхүүн, үйлчилгээнд ашиглах эрхийг өмчлөгч, эзэмшигчээс үйлдвэрлэгч, борлуулагчид олгох ба үйлдвэрлэгч, борлуулагч нь өмчлөгч, эзэмшигчид борлуулалтын орлогоос нэр, төрх, дуу, хоолой, дүр, зургийг ашигласны төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ.

338¹.2. Хуульд өөрөөр заагаагүй бол мерчандайзийн гэрээг бичгээр хийнэ.



Малын генетик нөөцийн тухай хуулиас

3.1. Энэ хууль нь Монгол Улсад үржүүлж байгаа мал, түүний үржүүлгийн бүтээгдэхүүн болон тэдгээртэй холбогдох уламжлалт мэдлэгт хамааралтай харилцаанд үйлчилнэ.

3.2. Малын генетик нөөцөд хамааралтай уламжлалт мэдлэгийг бүртгэх, түгээн дэлгэрүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэхээс бусад уламжлалт мэдлэгтэй холбогдох харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.3. “малын генетик нөөц” гэж мал, түүний үржүүлгийн бүтээгдэхүүн болон тэдгээртэй хамааралтай уламжлалт мэдлэгийг;

4.1.5. “уламжлалт мэдлэг” гэж малын генетик нөөцийг ашиглах явцад өвлөгдөн уламжлагдаж ирсэн арга, аман болон бичгэн хэлбэрийн мэдээлэл, дадал заншлыг;

5 дугаар зүйл. Малын генетик нөөцийн бүртгэл

5.1. Малын генетик нөөцийн бүртгэл дараахь хэлбэртэй байна:

5.1.4. малын генетик нөөцөд хамааралтай уламжлалт мэдлэгийн бүртгэл.

5.9. Энэ хуулийн 5.1.1, 5.1.3-т заасан бүртгэлийн журам, малын генетик нөөцөд хамааралтай уламжлалт мэдлэгийг бүртгэх үйл ажиллагааны аргачлалыг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.



Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиас

11.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах талаар төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, түүнчлэн эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, соёл урлаг, шинжлэх ухаан, боловсролын байгууллага болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага сурталчилгаа явуулах үүрэгтэй.

13.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараахь үйл ажиллагааг хориглоно:

13.1.2.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хэрэглэхийг аргачлан заах, тэдгээрийн хууль бус эргэлт, хэрэглээг сурталчилсан кино, дуу, дүрс бичлэгт хуурцаг, ном товхимол, хэвлэмэл зургийг нийтэд түгээх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, компьютерийн сүлжээг ашиглан сурталчлах;



Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулиас

15.2.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд харьяа агентлаг, аймаг, нийслэл /дүүрэг/-ийн цэргийн штаб, батлан хамгаалах чиглэлийн улсын үйлдвэрийн газар, цэргийн сургууль, судалгаа шинжилгээ, сургалт-үйлдвэрлэл, туршилт, соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, хэвлэл мэдээллийн байгууллагатай байна.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиас

39.3.Дараах байгууллага, хуулийн этгээд нь сонгуулийн уулзалт, хурал, цуглаан хийхэд нь зориулж өөрийн эзэмшиж байгаа соёлын төв, биеийн тамирын болон хурлын заал, бусад байр, танхимыг үнэ төлбөргүйгээр ашиглуулах үүрэгтэй:

39.3.1.төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага;

39.3.2.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

39.3.3.төрийн болон орон нутгийн өмчийн 51 хувь ба түүнээс дээш оролцоотой хуулийн

этгээд.

67 дугаар зүйл.Санал авах өдөр хориглох үйл ажиллагаа

67.1.Санал авах өдөр дараах үйл ажиллагааг хориглох бөгөөд аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох шийдвэр гарган хяналт тавьж ажиллана:

67.1.2.соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээг зохион байгуулах;



Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиас

20 дугаар зүйл.Орон нутгийн чиг үүрэг

20.1.Орон нутгийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна:

20.1.13.хөшөө дурсгалын зохицуулалт;

20.1.14.нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж;

20.1.15.орон нутгийн аялал жуулчлалын бодлого, менежмент;

20.1.18.төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ;

21 дүгээр зүйл.Аймгийн чиг үүрэг

21.1.Аймгийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна: 21.1.11.гудамж, талбайн нэр, хаягжилтын нийтлэг зохицуулалт;

21.1.13.аймгийн аялал жуулчлалын бодлого, менежмент;

21.1.16.мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, нэгдсэн эмнэлэг, аймгийн музей, театр, номын сан, соёлын ордон, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар.

22 дугаар зүйл.Сумын чиг үүрэг

22.1.13.нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт;

22.1.14.аялал жуулчлалын үйл ажиллагааны зохицуулалт;

22.1.17.сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар;

24 дүгээр зүйл.Нийслэлийн чиг үүрэг

24.1.8.нийслэлийн музей, театр, номын сан, соёлын ордон, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар;

24.1.18.хөшөө дурсгалын нийтлэг зохицуулалт;

24.1.19.нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж, төлөвлөлт, хяналт;

25 дугаар зүйл.Дүүргийн чиг үүрэг

25.1.8.дүүргийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар;

25.1.10.нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн арчилгаа, хамгаалалт;

27 дугаар зүйл.Нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэг

27.1.Энэ хуулийн 27.5-д заасан төрийн зарим чиг үүргийг хууль, нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэхээр шилжүүлж болно.

27.2.Энэ хуулийн 27.1-д заасан нэгжийн удирдлагад төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэхээр шилжүүлэхдээ тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг хамтад нь шийдвэрлэнэ.

27.3.Өөр өөр шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэхээр шилжүүлэхдээ түүний хүрээ, хязгаарлалтыг нэгж тус бүрээр тодорхойлж, тайлагнах, хяналт тавих журмыг хууль, гэрээнд тодорхой заана.

27.4.Энэ хуулийн 27.1-д заасны дагуу төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэхээр шилжүүлэхдээ нэгж тус бүрийн чиг үүрэг, онцлогийг харгалзана.

27.5.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар дараах төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлнэ:

27.5.8.соёлын үйлчилгээ;

27.5.19.түүхэн дурсгалт зүйлийн хамгаалалт;

59.1.Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

59.1.20.хуульд өөрөөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллагууд эрх бүхий байгууллагаас тогтоосон стандарт, норм, нормативыг сахин мөрдөж байгаа эсэхэд тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр хяналт тавих;



Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиас

3 дугаар зүйл.Засгийн газар, түүний чиг үүрэг

2.Засгийн газар Монгол Улсын хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

9 дүгээр зүйл.Нийгмийн хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хүн амын нийгмийн хамгаалалтын талаархи Засгийн газрын бүрэн эрх

1.Соёл, урлагийг өмчийн олон хэлбэрт түшиглэн хөгжүүлэх бодлого, түүний эдийн засаг, эрх зүйн баталгааг хангах арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлнэ.

2.Ард түмний оюуны өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, уламжлалт зан заншлыг дэмжин хөгжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

20 дугаар зүйл.Засгийн газрын бүрэлдэхүүн

5.Засгийн газрын гишүүн доор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ

13/Соёлын сайд:

-соёл, урлагийг хөгжүүлэх асуудал;

-түүх, соёлын өвийг хамгаалах, сэргээх бодлого;

-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал;
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.



Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулиас

44.3.Дараах байгууллага, хуулийн этгээд сонгуулийн уулзалт, хурал, цуглаан хийхэд нь зориулж өөрийн эзэмшиж байгаа соёлын төв, биеийн тамирын болон хурлын заал, бусад байр, танхимыг үнэ төлбөргүй ашиглуулах үүрэгтэй:

44.3.1.төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага;

44.3.2.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

44.3.3.төрийн болон орон нутгийн өмчийн 51 хувь ба түүнээс дээш оролцоотой хуулийн этгээд.

70 дугаар зүйл.Санал авах өдөр хориглох үйл ажиллагаа

70.1.Санал авах өдөр дараах үйл ажиллагааг хориглох бөгөөд аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох шийдвэр гарган хяналт тавьж ажиллана:

70.1.2.соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах;



Монгол Улсын Их хурлын тухай хуулиас

24 дүгээр зүйл.Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээ

24.3.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо:

24.3.1.боловсрол;

24.3.2.соёл, урлаг;

24.3.3.ард түмний түүх, соёл, оюуны өвийг хамгаалах, сэргээх бодлого;

24.3.4.монгол хэл, бичиг, үндэсний цөөнхийн хэл, бичиг, ёс заншил;



Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиас

8.2.Нийслэл хот нь дараах тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.2.4.нийслэл дэх үндэсний хэмжээний түүх, соёлын дурсгалт газрын хадгалалт, хамгаалалт;

39.1.Тусгай бүсийг үйл ажиллагааны дараах чиглэлээр дагнан, эсхүл хослуулж байгуулж болно:

39.1.2.аялал жуулчлал, соёл амралт;



Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулиас

4 дүгээр зүйл. Зөвлөлийн чиг үүрэг

1. Зөвлөл нь дараахь асуудлаар үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагааг болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалтад хяналт тавих чиг үүрэгтэй:

3/үндэсний соёл иргэншил, оюуны өв уламжлал, чадавхийг хамгаалан хөгжүүлэх;



Монгол Улсын хилийн тухай хуулиас

34 дүгээр зүйл. Улсын хил хамгаалах байгууллагын тогтолцоо

34.1.Улсын хил хамгаалах байгууллагын үндсэн хүч хэрэгсэл нь хилийн цэрэг байх бөгөөд хилийн цэрэг нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай хилийн цэргийн штаб, анги, салбар, зэвсэглэл, техник, ар тал, хангалт, эмнэлэг, соёл урлаг, спорт, боловсрол, эрдэм шинжилгээний болон бусад нэгжтэй байна.



Нийтийн сонголын тухай хуулиас

21 дүгээр зүйл.Сонголыг нийтэд зарлах

5.1.1.“нийтийн сонгол” /цаашид “сонгол” гэх/ гэж хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг тогтоох, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, түүнчлэн хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг хэрэгжилтийг үнэлэх, нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар шийдвэр гаргахын өмнө төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээчээс санал сонсох, мэдээлэл авах үйл ажиллагааг;

21.3.Орон нутагт зохион байгуулах сонголын зарыг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг даргын Тамгын газар болон хүн ам олноор үйлчлүүлдэг соёлын ба үйлчилгээний газруудын зарын самбарт байрлуулна.



Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай

5.1.17.Үндэсний бичиг соёл, номын өдрүүд: 5 болон 9 дүгээр сарын гурав дахь долоо хоногийн Бямба, Ням гараг.

5.2.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдээс бусад ой, түүхэн үйл явдал, салбарын болон зарим ажил мэргэжлийн ажилтан, ажилчдын өдөр, энэ хуульд зааснаас бусад олон улсын байгууллагаас дэлхий нийтээр тэмдэглэхээр тогтсон тэмдэглэлт өдрийг Засгийн газар тогтооно.



Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиас

13 дугаар зүйл.Албан татвараас чөлөөлөх

- 13.1.Дараах барааг албан татвараас чөлөөлнө:
 13.1.22.соёлын өвийг судалж шинжлэх, сэргээн засварлахад ашиглах материал, техник, тоног төхөөрөмж, бодис, багаж хэрэгсэл;
 13.5.Дараах үйлчилгээг албан татвараас чөлөөлнө:
 13.5.15.соёлын өвийг сэргээн засварлах үйлчилгээ;



Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиас

- 8.1.Олон нийтийн радио, телевиз улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, боловсрол, соёл, урлаг, спорт зэрэг нийгмийн амьдралын олон талыг хамарсан хөтөлбөрийг техникийн болон мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэж нийтийн хүртээл болгоно.
 8.2.Олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ дараахь бодлого баримтална:
 8.2.3.үндэсний соёл, урлаг, түүх, ёс заншил, уламжлалыг хүндэтгэх, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх, хүрээлэн байгаа орчноо хамгаалахыг дэмжих;
 8.2.5.соёл, урлагийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулахуиц уран бүтээлийн бүх хэлбэрийг дэлгэрүүлэн хөгжүүлэх;
9 дүгээр зүйл.Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрт тавигдах тусгай шаардлага
 9.5.Хуулиар хориглоогүй боловч хүүхэд, залуучуудын бие махбодь, оюун санаа, зан суртахуунд сөргөөр нөлөөлж болохуйц агуулга бүхий нэвтрүүлэг, баримтат болон уран сайхны киноны дамжуулах цагийг зохицуулах, эсхүл техникийн бусад арга хэмжээг ашиглах замаар хязгаарлалт тогтоож болно.



Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиас

- 5.1.Өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:
 5.1.1.хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх;
 5.1.2.төрт ёс, түүх, соёл, хэл бичгийн уламжлал, үндэсний үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх;
 5.1.3.хүн төрөлхтний соёл иргэншлийн ололт, өв, үнэт зүйлсийг хүндэтгэх;
20 дугаар зүйл.Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх
 20.1.Төрөөс өргөн нэвтрүүлгийн хөгжлийг дэмжих, радио, телевизийн үндэсний бүтээл үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангаар дамжуулан дараах чиглэлээр дэмжлэг үзүүлнэ:
 20.1.2.үйлдвэрлэхэд өртөг өндөр үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн хүргэх;
 20.1.3.өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн бүтээл үйлдвэрлэлийг дэмжих.
23 дугаар зүйл.Хөтөлбөрт тавигдах ерөнхий шаардлага
 23.1.Радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч нь хөтөлбөрөө төрийн албан ёсны хэл болох Монгол хэлээр бэлтгэн дамжуулна.
 23.2.Гадаад нэвтрүүлгийг дамжуулахдаа Монгол хэлээр дуу оруулсан, эсхүл бичгэн орчуулгатай байна.
 23.3.Өөрийн бүтээсэн болон зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй бүтээлийг дамжуулна.
 23.5.Энэ хуулийн 21.3-т заасан шаардлагад дараах бүтээлийн хувь хэмжээг тодорхойлно:
 23.5.1.үндэсний бүтээл;
 23.5.2.орон нутгийн бүтээл;
 23.5.3.өөрийн бүтээл;
 23.5.4.хадмал тайлбар, дохионы хэл бүхий нэвтрүүлэг;
 23.5.5.өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн хөтөлбөрт эзлэх үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг.
 23.6.Дамжуулж байгаа хөтөлбөр нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, эрх ашигт харшлахгүй байна.

- 23.9.Радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч нь бага, дунд, өсвөр насны хүүхдийг зохисгүй контентоос хамгаалах зорилгоор тодорхой хязгаарлалт хийх арга хэмжээг авна.



Өрсөлдөөний тухай хуулиас

- 13 дугаар зүйл.Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлахыг хориглох**
 13.1.Хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага аж ахуйн аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл олгох, бүртгэл явуулах, төлбөр, хураамж авахыг хориглоно.
 13.2.Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага хуульд зааснаас бусад тохиолдолд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
 13.2.1.аж ахуй эрхлэгчийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулахыг хориглосон буюу хязгаарласан;
 13.2.2.аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүнээ нэг зах зээлээс нөгөөд борлуулахыг хориглосон буюу хязгаарласан;
 13.2.3.тухайн зах зээлд өрсөлдөгч гарч ирэхийг хориглосон буюу хязгаарласан, эсхүл түүнийг зах зээлээс шахан гаргахад чиглэсэн;
 13.2.4.бараа бүтээгдэхүүний үнийг бууруулахад, эсхүл нэг хэмжээнд барихад чиглэсэн;
 13.2.5.зах зээлийг нутаг дэвсгэр, эсхүл үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, барааны нэр, төрөл, худалдагч, худалдан авагчийн хүрээгээр хуваарилахад чиглэсэн;
 13.2.6.аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүнийг бусад байгууллага, аж ахуй эрхлэгчид зээлээр олгоход чиглэсэн;
 13.2.7.аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход чиглэсэн.
 13.3.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас учирсан хохирлыг нөхөх, эдийн засгийн хямралыг даван туулах, стратегийн гол бараа бүтээгдэхүүн тухайлбал, Улсын нөөцийн тухай хуульд[3] заасны дагуу Улсын Их Хурлаас тогтоосон бараа материалын эрэлт, нийлүүлэлтийн зохистой байдлыг бүрдүүлэн хэрэглэгчийн амьжиргааны түвшний тогтвортой байдлыг хангахад зориулж Засгийн газар, түүний эрх олгосон байгууллагаас зохицуулалт хийх, зээл олгох, тусламж үзүүлэхийг өрсөлдөөнийг хязгаарласанд тооцохгүй.



Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулиас

- 8 дугаар зүйл.Эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг үзүүлэхэд хориглох зүйл
 8.1.Эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг, тайчих урлаг, үзүүлэх тоглолт, уралдаан, тэмцээн, бусад үзвэрийг үзүүлэхэд дараахь зүйлийг хориглоно:
 8.1.1.соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас тусгайлан зөвшөөрснөөс бусад газарт энэ төрлийн кино, дүрс бичлэгийг үзүүлэх;
 8.1.2.телевизийн нийтийн сувгаар дамжуулах;
 8.1.3. 18 насанд хүрээгүй хүнд үзүүлэх.
 9 дүгээр зүйл.Эротикийн сурталчилгаанд тавих хяналт
 9.1.Эротик чиглэлийн хэвлэл, ном зохиол, кино, дүрс бичлэгт тавих хяналтыг эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, соёлын болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудын дэргэдэх зөвлөл /цаашид “Зөвлөл” гэнэ/ хэрэгжүүлнэ.
 9.2.Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

9.3.Эротик хэвлэл, ном зохиол, кино, дүрс бичлэгийг зөвхөн Зөвлөлөөр хянуулсны дараа хэвлэн нийтлэх, нийтэд үзүүлэхийг зөвшөөрнө.

10 дугаар зүйл.Эротик тоглолт явуулах

10.1.Эротик тоглолтыг зөвхөн шөнийн цэнгээний газарт явуулж болно.

10.2. 18 насанд хүрээгүй хүнийг шөнийн цэнгээний газарт оруулах болон эротик тоглолтод оролцуулахыг хориглоно.



Статистикийн тухай хуулиас

6 дугаар зүйл.Албан ёсны статистикийн мэдээллийн үзүүлэлт, түүнийг гаргах үндэслэл

1.Албан ёсны статистикийн мэдээлэлд дараахь үндсэн үзүүлэлт хамаарна:

2/хүн ам, нийгмийн статистикийн үзүүлэлт;

л/ музей, номын сангийн тоо, тэдгээрийн сан хөмрөг;

м/ сонин, сэтгүүл, үйлдвэрлэсэн киноны тоо;

3/үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологийн статистикийн үзүүлэлт;

м/ эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын зардал;

д/ дархан цаазтай амьтны тоо, агнуур.

2.Мөнгө, зээл, санхүү, гааль, татвар, байгаль орчин, соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухаан техник, технологи, хүн амын эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүнсний аюулгүй байдал, шүүхийн статистикийн мэдээллийг холбогдох яам, төрийн бусад албан газар тус тус эрхлэн гаргаж, Үндэсний статистикийн хороонд өгнө.

19 дүгээр зүйл.Яам, төрийн бусад албан газрын статистикийн мэдээллийн талаархи бүрэн эрх

Яам, төрийн бусад албан газар энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/албан ёсны статистикийн мэдээллийг тогтоосон хугацаанд Үндэсний статистикийн хороонд гаргаж өгөх;

2/Үндэсний статистикийн хорооноос холбогдох статистикийн мэдээллийг авч ашиглах;

3/салбарын удирдлагын үйл ажиллагаанд хэрэглэх зорилгоор захиргааны статистик мэдээлэл авах, мэдээллийн санг бий болгох;

4/улсын хэмжээнд тухайн мэдээллээр давхардал гаргахгүйн тулд захиргааны статистик мэдээллийн үзүүлэлт, аргачлал, зааврыг Үндэсний статистикийн хорооноос зөвшөөрснөөр батлах;

5/үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн мэдээллийг ерөнхий дүнгээр гаргах.

6/хуулийн этгээдийг бүртгэх байгууллага нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалт дахь шаардлагатай мэдээлэл, түүнд орсон өөрчлөлтийг Үндэсний статистикийн хороонд тухай бүрт мэдээлэх.



Тамхины хяналтын тухай хуулиас

8.1.Дараахь хэлбэрээр тамхи сурталчлахыг хориглоно:

8.1.1.тамхи, тамхи ороодог цаас, тамхины шүүр, тамхи орооход хэрэглэгддэг төхөөрөмж, тамхины бусад дагалдах хэрэгсэл, тамхи үйлдвэрлэгчийн нэр, лого, тамхин бүтээгдэхүүн, түүний брэндийн нэр, барааны тэмдэг, тамхи үйлдвэрлэгчтэй холбоотой өнгө, өнгөний хослол, үг хэллэг, дизайн, зураг, дүрс, үнэр, дуу авиаг ашиглах, алдартай жүжигчин, тамирчин, урлаг, соёлын ажилтан зэрэг олон нийтийн дунд нэр хүнд бүхий хүнийг оролцуулах замаар тамхийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, хувцасны загвар өмсөх үзүүлбэр, урлаг, спортын тоглолт, уралдаан, тэмцээн, гар утас, бусад шинэ технологи, ханын болон гудамжны самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз ашиглах болон бусад биет байдлаар сурталчлах;

8.1.4.тамхи үйлдвэрлэгчээс эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, биеийн тамир, спортын болон бусад олон нийтийн арга хэмжээнд ивээн тэтгэгчээр оролцох, төрөл бүрийн хандив, тусламж, тэтгэлэг үзүүлэх;



Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиас

4 дүгээр зүйл.Төр, сүм хийдийн харилцааны үндэс

2.Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ. Энэ нь иргэд бусад шашин шүтэхэд саад болохгүй.

8 дугаар зүйл.Шашны сургалт

2.Төрийн харьяалал бүхий сургууль, байгууллагуудад шашны сургалт, цугларалт зохион байгуулахыг хориглоно. Энэ заалт нь шашны соёл, мэдлэг ухааны өв уламжлалын тухай шинжлэх ухааны сургалтад үл хамаарна.

11 дүгээр зүйл.Сүм хийдийн өмч, аж ахуйн харилцааг зохицуулах

1.Сүм хийдийн өмч, аж ахуйн харилцааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

2.Сүм хийд өөрийн эзэмшилд болон өмчлөлд байгаа газраас үл салах түүх, соёлын үл хөдлөх дурсгал, бусад үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд, дурсгалын талаарх мэдээллийг соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлнэ.



Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиас

4 дүгээр зүйл. Төрийн нийтийн зориулалттай өмч

1.Үндсэн хууль, бусад хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар бүх ард түмний өмч болгон заасан зүйлсийг төрийн нийтийн зориулалттай өмч гэнэ.

2.Төрийн нийтийн зориулалттай өмчид дараахь үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө хамаарна:

1/ иргэдэд өмчлүүлснээс бусад газар;

2/ газрын хэвлий, түүний баялаг;

3/ ус, түүний доторх баялаг;

4/ ой, түүний дагалдах баялаг;

5/ ургамал, ан амьтны нөөц;

6/ түүх, соёлын үнэт цогцолбор, хөшөө дурсгал;

7/ археологийн болон палентологийн олдвор;

8/ хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар тогтоосон бусад эд хөрөнгө.

3.Төрийн нийтийн зориулалттай өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг Улсын Их Хурал хэрэгжүүлэх ба үүнтэй холбогдон үүсэх харилцаанд энэ хууль үйлчлэхгүй.

4.Төрийн нийтийн зориулалттай өмчлөлийн зүйлсийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу иргэн / Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн /, бусад өмчийн хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулж болно



Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиас

34 дүгээр зүйл.Гэрээ шууд байгуулах арга

34.1.Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараахь нөхцөлд хэрэглэж болно:

34.1.2.оюуны өмчийн эрх, соёлын биет өвийг хамгаалах шаардлагаар гэрээг зөвхөн нэг этгээдтэй байгуулах боломжтой бөгөөд түүнийг орлох этгээд байхгүй бол;

34.2.Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.



Төсвийн тухай хуулиас

25 дугаар зүйл.Тусламжийн орлого, түүгээр санхүүжих зарлага

25.1.Тусламжийн орлого нь дор дурдсан хэлбэртэй байна:

25.1.1.олон улсын гэрээний дагуу авах хөгжлийн тусламж;

25.1.2.төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авах тусламж, хандив.

25.2.Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно:

25.2.3.соёлын үйлчилгээ.

25.3.Төсвийн ерөнхийлөн захирагчийн авах тусламж, хандивын хэмжээ тухайн төсөвт байгууллагын батлагдсан төсвийн 50 хувиас хэтрэхгүй байна.

25.4.Төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно:

25.4.1.санхүүжүүлэх эх үүсвэр дутагдсан хөтөлбөр, арга хэмжээг үргэлжлүүлэх;

25.4.2.байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх.

25.5.Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглоно:

25.5.1.хандив, тусламж өгсөн этгээд нь төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх;

25.5.2.байгууллагын ажилтны энэ хуулийн 25.4.2-т зааснаас бусад нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой байх.

25.6.Тусламжийн орлогоос санхүүжүүлэхэд төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээнд тавигдах шаардлагыг нэгэн адил баримтална.

25.10.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно.

58 дугаар зүйл.Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг

58.1.Нийслэл өөрийн төсвөөр дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ:

58.1.19.соёлын үйлчилгээ;

58.2.Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ:

58.2.18.соёлын үйлчилгээ;



Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулиас

3 дугаар зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс

3.1.Дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт үзүүлж байгаа буюу үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, тухайн газар нутгийг хамгаалахад иргэдийн оролцоог өргөжүүлэх, тэдний ахуй амьдралаа баталгаажуулах, байгалийн баялгийг зохистой ашиглах шаардлагыг харгалзан тогтоосон газар нутгийг орчны бүс гэнэ.

3.2.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шаардлагатай гэж үзвэл байгалийн нөөц газар, дурсгалт газарт орчны бүс, түүний заагийг тогтоож болно.

3.3.Орчны бүс нь дархан цаазат газрын хилийн заагийн гадна байх бөгөөд байгалийн цогцолбор газрын хувьд түүний хилийн заагийн гадна буюу хязгаарлалтын бүстэй нь давхцсан байж болно.

4 дүгээр зүйл.Орчны бүсийг тогтоох шалгуур

4.1.Дараахь шалгуурыг харгалзан орчны бүсийг тогтооно:

4.1.3.а.байгалийн өвөрмөц тогтоц, онцлог бүхий газар нутаг;

4.1.3.б.түүх, соёлын дурсгалт зүйлс бүхий газар нутаг.



Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиас

13 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газар

Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн цогцолборт газар гэнэ.

14 дүгээр зүйл. Байгалийн цогцолборт газрын бүс

Байгалийн цогцолборт газрыг байгалийн хэв шинж, ургамал, амьтны аймгийн байршил, түүх, соёлын дурсгалыг нь хадгалах шаардлага, аялал, жуулчлал хөгжүүлэх нөхцөл зэргийг харгалзан дараахь бүсэд хуваана:

1/ онцгой бүс;

2/ аялал,жуулчлалын бүс;

3/ хязгаарлалтын бүс.

15 дугаар зүйл. Онцгой бүсийн дэглэм

Онцгой бүсэд байгалийн унаган төрхийг нь хадгалах шаардлагад нийцүүлэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ байгальд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулах, ургамал, амьтны өсч үржих нөхцөлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээ авна.

16 дугаар зүйл. Аялал, жуулчлалын бүсийн дэглэм

Аялал, жуулчлалын бүсэд байгаль орчинд нь сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгээр дараахь үйл ажиллагаа явуулж болно:

1/ энэ хуулийн 11,15 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа явуулах;

2/ зөвшөөрөгдсөн газар загас барих.

17 дугаар зүйл. Хязгаарлалтын бүсийн дэглэм

Хязгаарлалтын бүсэд дараахь үйл ажиллагаа явуулж болно:

1/ энэ хуулийн 11,15,16 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа;

2/ уламжлалт аргаар мал аж ахуй эрхлэх;

3/ аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн ашиглах барилга байгууламжийг батлагдсан зураг, төсөл, зөвшөөрлийн дагуу барих;

4/ батлагдсан зураг төсөл, зохих журмын дагуу зам тавих, тээврийн хэрэгслийн зогсоол гаргах;

5/ биеийн тамир, нийтийн арга хэмжээнд шаардагдах талбайг засч тохижуулах;

6/ тухайн нутаг дэвсгэр дэх сууринг экологийн магадлан шинжилгээ хийж баталсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх.

18 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газарт хориглох үйл ажиллагаа

Байгалийн цогцолборт газарт энэ хуулийн 15,16,17 дугаар зүйлд зааснаас өөр зориулалтаар дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1/ энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1-8, 11-т заасан үйл ажиллагаа явуулах;

2/ онцгой бүсэд энэ хуулийн 12 дугаар зүйлийн 9,10-т заасан үйл ажиллагаа явуулах;

3/ батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсвийг зөрчиж суурингийн нутаг дэвсгэрийг тэлэх, барилга байгууламж барих.

ТАВДУГААР БҮЛЭГ

Дурсгалт газар, түүний хамгаалалтын дэглэм

22 дугаар зүйл. Дурсгалт газар

Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын ул мөрийг уламжлагдан хадгалагдсан байгалийн байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дурсгалт газар гэнэ.

23 дугаар зүйл. Дурсгалт газрын төрөл

1. Дурсгалт газрыг дараахь төрөлд хуваана:

- 1/ байгалийн дурсгалт газар;
- 2/ түүх, соёлын дурсгалт газар;
- 3/дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газар.

/Энэ заалтыг 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/

2. Байгалийн дурсгалт газарт өвөрмөц тогтоц, илэрц бүхий газар, эртний ургамал, амьтны чулуужсан үлдэгдэл, давхаргазүйн тулгуур зүсэлт зэрэг эрдэс чулуулгийн ховор олдвор,хүрхрээ, хясаа, хавцал, агуй, хад цохио, явар, цонж, төгөл мод, рашаан булаг, баянбүрд, элсэн манхан, солир, солирын цар, өрх, галт уулын тогоо зэргийг хамааруулж болно.

3. Түүх, соёлын дурсгалт газарт эртний хүний оромж, отог, сууц, агуй, сүг зураг, хадны бичээс, буган ба хүн чулуун хөшөө, булш бунхан, эртний хот, суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз, суваг шуудуу, далан, эртний зэр зэвсэг хийж байсан орд, уламжлалт зан үйлтэй холбоотой уул, овоо, тахилга бүхий болон түүхэн чухал үйл явдал болсон газар зэргийг хамааруулж болно.

24 дүгээр зүйл. Дурсгалт газрын дэглэм

1. Дурсгал газарт хаалт, хашлага барих, сэрэмжлүүлсэн дохио, тэмдэг тавих, түүний хамгаалалтыг нутгийн оршин суугчдад хариуцуулан өгөх зэргээр хамгаалалтын арга хэмжээ авна.

2. Дурсгалт газар дахь байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлээс О,1-3,О км-ийн орчимд сүр бараа, үзэмжийг нь дарах барилга байгууламж барих, газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөх, эвдэх, буулгах, тэдгээрт хохирол учруулахуйц бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

3.Дэлхийн болон Үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын дэглэмийг хуулиар тогтооно.

30 дугаар зүйл. Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа

Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа /цаашид "хамгаалалтын захиргаа" гэж/ нь дараахь үйл ажиллагаа явуулна:

1/ тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх хууль тогтоомж, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын биелэлтийг хангуулах;

2/ судалгаа, шинжилгээ хийх зөвшөөрөл авсан байгууллагатай гэрээ байгуулах, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын хүрээнд явуулж болох үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт тавих;

3/ зохих журмын дагуу судалгаа, шинжилгээний зориулалтаар дээж, сорьц авах, ан амьтны сүргийн бүтцийг зохицуулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх;

6/ зөвшөөрөгдсөн аялал, жуулчлалын зам, чиглэлийг тэмдэгжүүлэх, шаардлагатай орон байр барих, тээврийн хэрэгслэлийн зогсоол гаргах, биеийн тамирын болон нийтийн бусад арга хэмжээ явуулах газар, журмыг тогтоох, эрүүл ахуйн нөхцөлийг нь хангах, тэдгээрийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран тохижуулах;

7/ зөвшөөрөгдсөн бүс дэх сууринг тохижуулах, барилга байгууламж барих ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байгаад хяналт тавих;

8/ уул, овоо тахиx,уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх ажиллагааг зохицуулах;

**Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиас****8 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

8.2.Улсын тусгай хамгаалалттай болон түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газраас бусад тусгай хэрэгцээний газарт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах асуудлыг шийдвэрлэнэ.

25 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг

25.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглахдаа энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан нийтлэг үүргийг биелүүлж ажиллах бөгөөд зөрчвөл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

25.4.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах явцад өөр төрлийн ашигт малтмал, түүх, соёлын олдвор, эд өлгийн зүйл илэрсэн тохиолдолд үйл ажиллагаагаа зогсоож аймаг, нийслэлийн Засаг даргад мэдэгдэнэ.

25.5.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.10-т заасан шаардлагыг хангаж ажиллана.

25.6.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Газрын хэвлийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж ажиллана.

**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиас****5 дугаар зүйл.Тэмдэгтийн хураамж хураах үйлчилгээний төрөл**

5.1.Тэмдэгтийн хураамжийг дор дурдсан үйлчилгээнд хураана:

5.1.25.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.6-д заасны дагуу гэрчилгээ олгох, мөн хуулийн 9.4, 10.5, 11.3, 17.10, 20.1, 20.3-г заасан үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох;

5.1.47.музейн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зөвшөөрөл олгох.

5.1.48.Соёлын тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу зөвшөөрөл олгох.

5.1.49.Кино урлагийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу зөвшөөрөл олгох.

22¹ дүгээр зүйл.Соёлын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

22¹.1.Соёлын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

22¹.1.1.түүх, соёлын хосгүй үнэт зүйлийг бүртгэх, гэрчилгээ олгоход 1000-2000 төгрөг;

22¹.1.2.хот, суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход археологи, палеонтологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан судалгаа хийлгэж, түүнээс зөвшөөрөл олгоход 40 000-300 000 төгрөг;

22¹.1.3.соёлын өвийг хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход 20 000-50 000 төгрөг, шаардлагатай бол хугацааг сунгахад 12 000-30 000 төгрөг.

22¹.1.4.соёлын өвийг сэргээн засварлах, палентологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөл олгоход 300 000-500 000 төгрөг.

22¹.1.5.музейн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 300 000- 500 000 төгрөг.

22¹.1.6.соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгоход 400 000-600 000 төгрөг.

22¹.1.7.кино бүтээх зорилгоор гадаадын иргэн, хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийх зөвшөөрөл олгоход 300 000-500 000 төгрөг.

35 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

35.1.Аймаг, сум, нийслэл, дүүрэг дэх төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

35.1.10.нэн ховор, ховор амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, гоо зүйн зориулалтаар /ажиглаж судлах, тэмдэг тавих, зурах, зураг авах зэрэг хэлбэрээр/ амьтныг гэмтээлгүйгээр амьдрах орчныг нь алдагдуулалгүйгээр ашиглах зөвшөөрөл олгоход 40 000-200 000 төгрөг;

41.3.Дараахь нөхцөлд гадаадын иргэнд олгох визийн хураамжийг чөлөөлөх буюу хөнгөлнө:

41.4.15.түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлага, судалгаа хийх үйл ажиллагаа.

**Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулиас****44 дүгээр зүйл.Барьцааны зүйлийг шүүхээс гадуур худалдах**

44.4.Дараахь барьцааны зүйлийг шүүхээс гадуур худалдахыг хориглоно:

44.4.1.газар;

44.4.2.улсын бүртгэлд бүртгүүлсэн буюу бүртгүүлбэл зохих үл хөдлөх хөрөнгө болох түүх, урлаг, соёлын үнэт зүйлс.



Үндэсний аюулгүй байдлын тухай хуулиас

3.1.“Үндэсний аюулгүй байдал” гэж /цаашид “үндэсний аюулгүй байдал” гэнэ/ Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ.

3.2.“Үндэсний язгуур ашиг сонирхол”-д Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана.

3.3.“Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа” гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлэх тал бүрийн баталгаа бий болгоход чиглэсэн төрийн бодлогыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнээс хэрэгжүүлж буй арга хэмжээг хэлнэ.

3.4.Үндэсний аюулгүй байдал нь дараахь бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

3.4.7.монгол соёл иргэншлийн аюулгүй байдал;



Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулиас

7 дугаар зүйл. Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдаа

7.1.Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг ашиг олох зорилгоор худалдаалахыг хориглоно.

7.2. Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг зөвхөн судалгаа, шинжилгээ хийх, музей, амьтны хүрээлэнд байршуулах, циркэд тоглуулах зориулалтаар олон улсад худалдаалж болно.

10 дугаар зүйл. Хөнгөлөлт

10.5. Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газарт бүртгэлтэй эрдэмтэн, эрдэм шинжилгээний байгууллагуудын хооронд ашиг олох зорилгогүйгээр түр ашиглах, бэлэглэх, хандивлах, солилцох, музейд хадгалуулах зориулалтаар Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг зөвшөөрөлгүй импортлоно.



Хот байгуулалтын тухай хуулиас

3.1.1.“хот байгуулалт” гэж түүх, соёл иргэншлийн уламжлал, бүсчилсэн хөгжлийн бодлого, хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн хүн амын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэхийн тулд бүс нутаг, хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах, барьж байгуулах, иж бүрэн тохижуулах цогцолбор үйл ажиллагааг;

12.4.Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь дараахь шаардлагыг хангасан байна:

12.4.1.хүн амын амьдрах, ажиллах таатай орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн, хот, тосгоны хөгжлийн чиглэлийг тодорхойлсон, хот, тосгоны хил хязгаар, газар нутгийн үүргийн бүсчлэл, инженер, зам тээвэр болон нийгмийн дэд бүтцийн хөгжил, түүх, соёлын дурсгалт байгууламж, архитектур-хот байгуулалтын шаардлага, экологийн болон эрүүл ахуйн таатай нөхцөлийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байх;

14 дүгээр зүйл. Нутаг дэвсгэрийн бүсчлэлд тавигдах шаардлага

14.1.Орон сууц, олон нийтийн бүсэд эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх үндсэн шаардлагыг хангаж, байгалийн гэрэлтүүлгийн холбогдох норм ба дүрэм, журамд заасны дагуу төлөвлөгдсөн орон сууц, сургалт, соёл, үзвэр, шинжлэх ухаан, эмнэлэг, амралт, сувилал, спорт, худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээ, тээвэр, холбооны чиглэлийн үйл ажиллагаа явуулах зориулалттай барилга байгууламж төлөвлөх

бөгөөд амьдрах, аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж болохуйц бусад барилга байгууламж төлөвлөхийг хориглоно.

23.1.Дараахь бүсэд хэрэгжүүлэх хот байгуулалтын үйл ажиллагаанд хязгаарлалт тогтооно:

23.1.1.түүх, соёлын дурсгалт барилга байгууламж бүхий газар нутаг болон тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд;



Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулиас

3.3.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3.1.2, 3.1.6, Хот байгуулалтын тухай хуулийн 3.1.17-д заасан барилга байгууламжийг дахин төлөвлөх, барилгажуулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

/СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ 3.1.2.“соёлын биет өв” гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгалыг; 3.1.6.“соёлын өвийн дурсгалт газар” гэж соёлын биет болон биет бус өв нь байгаль орчин, уламжлалт ахуйтайгаа харилцан шүтэлцсэн соёлын орон зай, газар нутгийг;/



Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиас

7 дугаар зүйл. Хот, тосгоны аж ахуй

Хот, тосгоны аж ахуй нь оршин суугчдын нийгэм, эдийн засаг, ахуй, соёлын хэрэгцээг хангахтай холбогдсон үйлдвэр, үйлчилгээний газар, орон сууц, зам, тээвэр, холбоо, дулаан, усан хангамж, цэвэрлэх байгууламж болон хот нийтийн аж ахуй зэргээс тус тус бүрдэнэ.

21 дүгээр зүйл. Оршин суугчдын нийгмийн хамгаалалт болон ахуйн соёлын хэрэгцээг хангах талаархи хот, тосгоны захирагчийн бүрэн эрх

1.Оршин суугчдын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

2.Боловсрол, соёл, эрүүлийг хамгаалах, нийгэм хангамж, биеийн тамир, спортын байгууллагаас үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

5.Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалж, тэдгээрийн ашиглалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.



Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиас

4.1.2.“хөгжлийн бэрхшээлтэй нь ялгаварлан гадуурхах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхгүйг;

6.5.Дараахь үйлдлийг бусад ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.5.1.хүнийг хөгжлийн бэрхшээлтэй нь доромжлох, тохуурхах, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүл, эцэг эхийг гадуурхах, олон нийтэд хөгжлийн бэрхшээлийн талаар буруу ойлголт төрүүлэхүйц мэдээлэл, зар сурталчилгаа явуулах, соёл урлагийн бүтээл хийх, хүний сүсэг бишрэл, итгэл үнэмшилд суурилан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд халдсан аливаа зөвлөгөө өгөх;

34 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний соёл, урлагийн үйл ажиллагааг дэмжих

34.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг өөрийн оронд зохиогдох соёл, урлаг, олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцоход төрөөс дэмжинэ.

34.2.Аж ахуйн нэгж, байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүн соёл, урлагийн арга хэмжээнд оролцох, өөрийн авьяас чадвараа нээн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

35 дугаар зүйл. Соёл, урлагийн бүтээлийн хүртээмж

35.1.Соёл, урлагийн бүтээл нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.

35.2.Уран зохиол, шинжлэх ухааны ном, сонин, сэтгүүлийг хөгжлийн бэрхшээлтэй хүн ашиглах, хэрэглэх боломжтойгоор орчин үеийн арга, техник, технологи ашиглан хэвлэх, бүтээх, түүнчлэн музей, номын сан, соёл, урлагийн бүтээлийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.

42.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар харьяалах нутаг дэвсгэртээ дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

42.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, түүний хэрэгжилтийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран зохион байгуулах, урлаг соёл, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээнд оролцуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрх, эрх чөлөөг хүндэтгэх нөлөөллийн арга хэмжээ авах.



Хөдөлмөрийн тухай хуулиас

37.1.Хамтын гэрээгээр зохицуулах харилцааг талууд харилцан тохиролцох бөгөөд ажилтны хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой дараах асуудлыг хамтын гэрээнд тусгаж болно:

37.1.10.аж ахуйн нэгж, байгууллагын орон сууц, хүүхдийн цэцэрлэг, ясли, нийгэм, соёлын зориулалттай барилга,байгууламж барих, ашиглах, олон хүүхэдтэй гэр бүл, өрх толгойлсон эх буюу ганц бие эцэг, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнтэй ажилтанд хөнгөлөлт үзүүлэх асуудал;



Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиас

8 дугаар зүйл.Үйл ажиллагааны орлого

8.1.Үйл ажиллагааны орлогод хуулийн этгээд байгуулахгүйгээр үйл ажиллагаа явуулж олсон дараах орлогыг хамруулна:

8.1.3.шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого;

12 дугаар зүйл.Бусад орлого

12.1.Энэ хуулийн 6.3.6-д заасан орлогод дараах орлогыг хамруулна:

12.1.1.урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого;

19.1.Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан орлогод албан татвар ногдуулах орлогыг дараах байдлаар тодорхойлно:

19.1.1.урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал болон тэдгээртэй адилтгах бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр;

21.2.Энэ хуулийн дараах зүйл, хэсэг, заалтад дурдсан орлогод доор дурдсан хувиар тооцож, албан татвар ногдуулна:

21.2.2.энэ хуулийн 19.1.1-д заасан орлогын дүнд 5 хувиар;

23.8.Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад зориулж өгсөн баримтаар нотлогдож байгаа хандивтай тэнцэх тухайн жилийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг албан татвар төлөгчид эдлүүлнэ.



Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиас

1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөхөөс өмнө соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэнд, хэвлэл мэдээллийн байгууллагаар

бүртгүүлсэн хуулийн этгээдийг тус байгууллагын хүсэлтийг үндэслэн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1.2-г заасан компани, эсхүл 7.1.3-г заасан холбоо /төрийн бус байгууллага/-ны, 7.1.4-г заасан сан хэлбэрээр бүртгэх ажлыг улсын бүртгэлийн байгууллага хариуцан зохион байгуулна.



Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиас

7 дугаар зүйл.Улсын бүртгэлд бүртгүүлэх хуулийн этгээд

7.1.Улсын бүртгэлийн байгууллага дараах хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэнэ:

7.1.2.компани;

7.1.3.холбоо /төрийн бус байгууллага/;

7.1.4.сан;



Хүүхдийн эрхийн тухай хуулиас

4.1.Хүүхдийн эрхийг хамгаалахад дараахь зарчмыг баримтална:

4.1.4.хүүхдийн эрхийг хангахад үндэсний уламжлалт зан заншил, ёс суртахууны үнэт зүйлд тулгуурлах;

6.1.Хүүхдийн бие махбодь, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзэх бөгөөд хүүхэд дараахь эрх эдэлнэ:

6.1.2.хүүхэд төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн эзэмших;

9.1.4.хууль ёсыг сахих, үндэсний өв уламжлалаа дээдлэн хүндэтгэх

12.1.Хүүхдийн эрхийг хангахад Засгийн газар дараахь шийдвэр гаргаж, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

12.1.5.хүүхдийн санаачилсан шинэ бүтээл, урлаг, спортын чиглэлээр улс, олон улс, тив, дэлхийн чанартай уралдаан, тэмцээнд оролцох болзол хангасан болон амжилт гаргасан хүүхэдэд дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох журам баталж, хэрэгжүүлэх



Хүүхэд хамгааллын тухай хуулиас

9 дүгээр зүйл. Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал

9.1.Худалдаа үйлчилгээ, соёлын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, арга хэмжээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал цуглаан, замын хөдөлгөөн, хүүхэд оролцсон шалгалт, уралдаан тэмцээний үед хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үүргийг зохион байгуулагч болон оролцогч талууд ханган ажиллана.

9¹ дүгээр зүйл.Соёл, спортын үйл ажиллагаан дахь хүүхэд хамгаалал

9¹.1.Хүүхдийг соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхгүй орчинд оролцуулна.

9¹.2.Хүүхдийг соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд оролцуулахдаа хичээл сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, хоцрогдлыг арилгах арга хэмжээг авна.

9¹.3.Хичээл сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, хоцрогдлыг арилгах арга хэмжээг эцэг, эх, асран хамгаалагч, арга хэмжээнд оролцуулсан этгээд хамтран, сургалтын хөтөлбөр, агуулгын хүрээнд болон төрийн захиргааны байгууллагаас улс, бүс, орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа арга хэмжээнд оролцсон бол сургуулийн удирдлага тус тус зохион байгуулна.

9¹.4.Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмыг соёлын болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж, мөрдүүлнэ.



Цагдаагийн албаны тухай хуулиас

38.1.Цагдаагийн байгууллага дараахь хүн, эд зүйлийг олох зорилгоор эрэн сурвалжлах ажиллагааг шүүхийн шийдвэр, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн даалгаврын дагуу, эсхүл өөрөө санаачлан явуулна:

38.1.8.алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, тээврийн хэрэгсэл, мал, амьтан, түүх соёлын дурсгалт, үнэт болон бусад эд зүйл;



Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиас

11.1.Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг дагнан болон сургалт, үйлдвэрлэлтэй хослон гүйцэтгэдэг хуулийн этгээдийг эрдэм шинжилгээний байгууллага гэнэ.

11.2.Эрдэм шинжилгээний байгууллагыг дор дурдсан хэлбэрээр байгуулж болно:

11.2.4.төрийн болон орон нутгийн музей, үндэсний соёлын байгууллага.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиас

54.7.Үндэсний мөнгөн тэмдэгт, гадаад валют, үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрийг оролцуулан бүтээсэн үнэт эдлэл, түүх, соёлын хосгүй болон бусад үнэт, дурсгалт зүйлийг хураан авна.

54.8.Хураан авсан үндэсний мөнгөн тэмдэгт, гадаад валютыг хураан авснаас хойш 24 цагийн дотор шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын банкна дахь дансанд, үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрийг оролцуулан бүтээсэн үнэт эдлэл, түүх соёлын хосгүй болон бусад үнэт, дурсгалт зүйлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үнэ бүхий эд зүйл хадгалах тусгай зориулалтын байранд даруй шилжүүлнэ.

55.2.Дараахь хөрөнгийг шинжээчээр үнэлүүлнэ:

55.2.5.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан түүх, соёлын өв, дурсгалд хамаарах эд зүйл;

65.1.Төлбөр төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, эдийн бус хөрөнгө, түүх, соёлын өвд хамаарах үнэт зүйл, тусгай зөвшөөрлийг энэ хуульд заасны дагуу хөрөнгийн албадан дуудлага худалдаа /цаашид “дуудлага худалдаа” гэх/-гаар худалдан борлуулна.



Шүүхийн шинжилгээний тухай хуулиас

6.1.1.“Шүүхийн шинжилгээ” гэж эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрх бүхий албан тушаалтны шийдвэр, мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид заасан тусгай мэдлэг шаардсан асуудал /шинжлэх ухаан, техник, урлаг, түүх, соёл, нягтлан бодох бүртгэл зэрэг/-ыг шийдвэрлэхийн тулд шинжилгээний объектод шинжилгээ хийж дүгнэлт гаргах ажиллагааг;



Эрдэнэсийн сангийн тухай хуулиас

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."эрдэнэс" гэж түүхий эд, хайлш, химийн нэгдэл, бүтээгдэхүүн зэрэг ямар ч байдалд байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйл, байгалийн төрцийг;

3.1.2."үнэт металл" гэж алт, мөнгө, платина болон түүний бүлэгт багтдаг палладий, иридий, родий, рутений, осмийг;

3.1.3."үнэт чулуу" гэж доржпалам, бадмаараг, маргад эрдэнэ, индранил, сувдыг;

3.1.4."Эрдэнэсийн сан" гэж төрийн нэрийн өмнөөс Монголбанк эрхэлж, бүрдүүлж, хамгаалж, эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж байгаа эрдэнэс, түүний дагалдах зүйл, хөрөнгийн хуримтлалыг;

3.1.5."байгалийн төрц" гэж онцгой чамин дүрс хэлбэртэй, ховор өнгөтэй, байгалийн тогтцоороо олдсон үнэт металл, эрдэнийн чулууг;

3.1.6."эрдэнийн чулуу" гэж олон улсад хэвшсэн ангилалыг харгалзан эрх бүхий байгууллагаас тодорхойлсон ангилалд хамрагдах үнэт, хагас үнэт чулууг.

4 дүгээр зүйл.Эрдэнэсийн сан, түүний ангилал

4.1.Эрдэнэсийн сан төрийн өмчид байна.

4.2.Эрдэнэсийн санг үндсэн болон гүйлгээ санд хуваана.

4.3.Үндсэн сан байнгын болон байнгын бус хэсгээс бүрдэнэ.

4.4.Үндсэн сангийн байнгын хэсэгт Монгол Улсын хуваагдашгүй өмч болох эрдэнэс байх бөгөөд тэдгээрийг худалдах, шилжүүлэх, захиран зарцуулахыг хориглоно.

4.5.Үндсэн сангийн байнгын бус хэсэгт олон улсын жишгээр цэвэршүүлсэн үнэт металл, засаж өнгөлсөн эрдэнийн чулуу, түүх, соёлын үнэт дурсгалт зүйл, үнэт болон бусад металаар хийж нөөцөд авсан зоос байна.

4.6.Үндсэн сангийн байнгын хэсэгт байх түүх, соёлын дурсгалт зүйл нь хосгүй үнэт зэрэглэлтэй байна.

4.7.Гүйлгээ санд энэ хуулийн 4.4, 4.5-д зааснаас бусад үйлдвэрлэл, судалгаа, дурсгалын зориулалтаар гүйлгээнд оруулах эрдэнэс хамаарна.

11 дүгээр зүйл.Эрдэнэсийн сангийн гүйлгээ сангийн зарлага

11.1.Эрдэнэсийн сангийн гүйлгээ сангаас дараах байдлаар зарлага гаргана:

11.1.1.үнэт металл, эрдэнийн чулуу, зоосыг Монгол банкнаас тогтоосон үнээр худалдах;

11.1.2.үнэт металл, эрдэнийн чулууг засах, цэвэршүүлэх явцад гарсан хорогдлыг хасах.

12 дугаар зүйл.Эрдэнэсийн сангийн бүртгэл

12.1.Монгол банк Эрдэнэсийн сангийн эрдэнэс, бусад хөрөнгийн хувийн хэргийг хөтөлж, Эрдэнэсийн сангийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэнэ.

12.2.Монгол банк Эрдэнэсийн сангийн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, өөрийн санхүүгийн тайланд тусгана.

12.3.Энэ хуулийн 12.1-д заасан бүртгэл, мэдээллийн сангийн журмыг Монгол банкны Ерөнхийлөгч батална.

13 дугаар зүйл.Эрдэнэсийн хадгалалт

13.1.Эрдэнэсийн чанар байдлыг нь алдагдуулахгүйгээр тусгай зориулалтын байр, саванд хадгална.

13.2.Монгол банк эрдэнэсийг эзэмшигч, өмчлөгч иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр хадгалах, түүнтэй холбоотой ажил, үйлчилгээг үзүүлж болно.

15 дугаар зүйл.Хүн, хуулийн этгээд, бусад байгууллагын эрх, үүрэг

15.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт эрдэнэс эзэмшигч хүн, хуулийн этгээд, бусад байгууллага нь эрдэнэсийн санд худалдах эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлийг сорьц тогтоох эрх бүхий хуулийн этгээд, эсхүл сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар сорьц тогтоолгон баталгаажуулсан байх үүрэгтэй.

15.2.Хүн, хуулийн этгээд, бусад байгууллага нь эрдэнэсийн санд худалдах болон хадгалуулах эрдэнэсийн үнийг хэлэлцэн тохирох, нэхэмжлэн авах эрхтэй.

15.3.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монгол банкны хүсэлтийн дагуу түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийн бүртгэл, мэдээллийг гаргаж өгнө.



Эрүүгийн хуулиас

17.1 дүгээр зүйл.Хулгайлах

1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж;

2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

18.5 дугаар зүйл.Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх

1.Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу хориглосон бараа, эрдэнэс, эрдсийг Монгол Улсын хилээр, гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.албан тушаалынхаа байдлыг ашиглаж;

3.Энэ гэмт хэргийг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ХОРИН ТАВДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ӨВИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

25.1 дүгээр зүйл.Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах

1.Түүх, соёлын дурсгалт зүйлийг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Үнэт зэрэглэлд хамаарах түүх, соёлын дурсгалт зүйлийг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Хосгүй үнэт зэрэглэлд хамаарах түүх, соёлын дурсгалт зүйлийг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

25.2 дугаар зүйл.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах

1.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Улс, орон нутгийн хамгаалалтад авсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан, эсхүл энэ гэмт хэргийг олон хүний амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж болох аргаар үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

25.3 дугаар зүйл.Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх

1.Соёлын биет өвийг завшсан, үрэгдүүлсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

25.4 дүгээр зүйл.Хууль бусаар археологи, палентологийн хайгуул, малтлага хийх

1.Хууль бусаар археологи, палентологийн хайгуул, малтлага, судалгаа хийсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Хууль бус археологи, палентологийн хайгуул, малтлага, судалгааг санхүүжүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

25.5 дугаар зүйл.Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах

1.Соёлын биет өвийн худалдааг хууль бусаар явуулсан, зуучилсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

25.6 дугаар зүйл.Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх

1.Түүх, соёлын дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй, эсхүл түүх, соёлын дурсгалт зүйлийг завшсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

25.7 дугаар зүйл.Эрдэнэсийн сангийн үндсэн санг хууль бусаар зарцуулах

1.Эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр Эрдэнэсийн сангийн байнгын бус хэсгээс эрдэнэсийг худалдсан, шилжүүлсэн, захиран зарцуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Эрдэнэсийн сангийн байнгын хэсгээс эрдэнэсийг худалдсан, шилжүүлсэн, захиран зарцуулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас

1.21.“тусгай мэдлэг” гэж тухайн хүний эзэмшсэн шинжлэх ухаан, түүх, соёл, техник, технологи, урлаг, гар урлалын салбарын болон хэргийн бодит байдлыг тогтооход шаардагдах бусад мэдлэгийг;

9.1 дүгээр зүйл.Шинжээч

1.Прокурор, мөрдөгч нь өөрийн санаачилгаар, эсхүл оролцогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах асуудлыг тодруулахаар, эсхүл эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоох шинжилгээ хийлгэхээр шинжээч томилно.

9.3 дугаар зүйл.Мэргэжилтэн

1.Шаардлагатай тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааны явцад, эсхүл шүүх хуралдаанд ул мөр, эд мөрийн баримт илрүүлэх, бэхжүүлэх, хамгаалах, техник хэрэгсэл, төхөөрөмж ашиглах, ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, хүний амь нас, эрүүл мэндэд аюул, эсхүл орчинд хөнөөл учруулж болзошгүй тэсэрч дэлбэрэх, химийн хортой бодис, бусад эд зүйл байвал тэдгээрийг аюулгүй болгох, зөвлөгөө авах зорилгоор тухайн хэрэгт хувийн сонирхолгүй тусгай мэдлэг, туршлага бүхий хүнийг шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэрээр мэргэжилтнээр оролцуулж болно.

24.4 дүгээр зүйл.Эд мөрийн баримт хураан авах

1.Мөрдөгч эд мөрийн баримтыг прокурорын зөвшөөрлөөр түр хураан авна.

5.Зарим онцлох эд зүйл, үнэт эдлэл, түүх, соёлын дурсгалт зүйлийг хураан авахад мэргэжилтнийг оролцуулж болно.

Гурав. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ҮЕД СОЁЛЫН ҮНЭТ
ЗҮЙЛСИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ

1954 оны 5 дугаар сарын 14-ний өдөр баталж,
1956 оны 8 дугаар сарын 7-ны өдөр хүчин төгөлдөр болсон

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд,
зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлс ноцтойгоор гэмтэж, дайны арга техник хөгжиж байгаагийн улмаас улам бүр устгах аюул нэмэгдэж байгааг хүлээн зөвшөөрч,
дэлхийн соёлд ард түмэн бүр өөрийн хувь нэмрээ оруулснаас үүдэн аливаа ард түмний соёлын үнэт зүйлст хохирол учруулах нь хүн төрөлхтөний соёлын үнэт зүйлст хохирол учруулна гэдэгт итгэл төгс байж,
соёлын өвийг хамгаалах нь дэлхийн бүх ард түмний хувьд чухал ач холбогдолтой бөгөөд эдгээр өвийг олон улсын хамгаалалтад авах нь чухал гэж үзэж,
Гаагийн 1899 болон 1907 оны конвенцууд, Вашингтоны 1935 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн тунхаглалд заасанчлан зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах зарчмуудыг удирдлага болгож,
тайван цагт соёлын үнэт зүйлсийг хамгаалах үндэсний болон олон улсын арга хэмжээ авахгүйгээр тийм хамгаалалт ямар ч үр дүнгүй болохыг анхааралдаа авч,

1.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд зэвсэгт мөргөлдөөний үед өөрсдийн болон хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын нутаг дэвсгэрт байгаа соёлын үнэт зүйлсийг эвдэрч сүйдэх буюу гэмтээх аюул учруулахаас хамгаалах зорилгоор эдгээр үнэт зүйлс буюу түүний эргэн тойронд байгаа аливаа байгууламжийг ашиглахыг хориглох, эдгээр үнэт зүйлсийн эсрэг чиглэсэн дайсагнах аливаа үйлдлээс татгалзаж соёлын үнэт зүйлсийг хүндэтгэх үүрэг хүлээнэ.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргийг зөвхөн цэргийн зайлшгүй шаардлагын улмаас зөрчихийг шаардаж байгаа тохиолдолд л зөрчиж болно.

3.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд соёлын үнэт зүйлсийн эсрэг шууд чиглэсэн аливаа үйлдэл, хулгай, дээрэм буюу хууль бусаар эзэмших бусад хэлбэрийг хэрэв шаардлагатай бол зогсоох, урьдчилан сэргийлэх, хориглох үүрэг хүлээнэ. Тэд хэлэлцэн тохирогч эрхэм дээд нөгөө талын нутаг дэвсгэрт байрлаж буй соёлын хөдлөх үнэт зүйлсийг албадан шаардахаас татгалзах үүрэг хүлээнэ.

4.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд соёлын үнэт зүйлсийг дайны төлбөр болгоход чиглэсэн аливаа үйлдлээс татгалзах үүрэг хүлээнэ.

5.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд аль ч тал 3 дугаар зүйлд заасан хадгалж хамгаалах арга хэмжээг хэлэлцэн тохирогч эрхэм дээд нөгөө тал аваагүй байна гэсэн үндэслэлээр энэ зүйлд заасан үүргээс татгалзаж болохгүй.

1.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд нөгөө талын нутаг дэвсгэрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн эзэлсэн хэлэлцэн тохирогч аливаа эрхэм дээд тал соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалах болон хадгалах зорилгоор эзлэгдсэн улсын үндэсний эрх бүхий байгууллагыг боломжийн хэрээр дэмжинэ.

2.Хэрэв цэргийн ажиллагааны дүнд эзлэгдсэн нутаг дэвсгэрт байгаа соёлын үнэт зүйлс гэмтэж, эрх бүхий үндэсний байгууллага хадгалахад шаардлагатай арга хэмжээ авч чадахгүйн улмаас соёлын үнэт зүйлсыг хадгалах талаар яаралтай арга хэмжээ авах шаардлага гарвал эзлэгч гүрэн эдгээр үнэт зүйлсийг хадгалж хамгаалах талаар дурдсан байгууллагатай нягт хамтран ажиллах шаардлагатай арга хэмжээг боломжтой бол нэн даруй авна.

3.Эсэргүүцлийн хөдөлгөөний гишүүдээс бүрдсэн засгийн газрыг хууль ёсны гэж үзэж буй хэлэлцэн тохирогч эрхэм дээд аливаа тал хэрэв боломжтой бол, соёлын үнэт зүйлстэй холбоотой конвенцийн заалтуудыг биелүүлэх үүрэгт тэдгээрийн анхаарлыг хандуулна.

1.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийг дагаж мөрдөх заалтууд бүхий цэргийн журам буюу зааварчилгааг тайван цагт таниулах, өөрийн зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд ард түмнүүдийн соёл болон соёлын үнэт зүйлсийг хүндэтгэн үзэх үзэл санааг төлөвшүүлэх үүрэг хүлээнэ.

2.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд өөрсдийн зэвсэгт хүчний хүрээнд соёлын үнэт зүйлсийг хүндэтгэх явдлыг хангах зорилготой алба, эсхүл мэргэшсэн албан хаагчдыг тайван цагт томилж, соёлын үнэт зүйлсийг хамгаалах үүрэг бүхий энгийн байгууллагатай хамтран ажиллах үүрэг хүлээнэ.

1.Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын хөдлөх үнэт зүйлсийг хамгаалах зориулалт бүхий хязгаарлагдмал тооны байр, соёлын бусад ихээхэн чухал ач холбогдолтой үл хөдлөх үнэт зүйлсийг төвлөрүүлэх төвийг дараахь тохиолдолд тусгай хамгаалалтад авна:

2.Соёлын хөдлөх үнэт зүйлсийн хоргодох байрыг хаана байгаагаас үл хамааран тийнхүү баригдсан бол бөмбөгдөлтөд өртүүлж сүйрүүлэхгүй байхаар тусгай хамгаалалтад авна.

3.Соёлын үнэт зүйлсийн цогцолбор төвийг цэргийн бие бүрэлдэхүүн, эсхүл цэргийн материал шилжүүлэх, түүнчлэн дамжуулахад ашигласан бол түүнийг цэргийн зорилгоор ашигласан гэж үзнэ. Уг төвийг цэргийн ажиллагаанд шууд хамаарах үйл ажиллагаа, цэргийн бие бүрэлдэхүүнийг байршуулах, эсхүл уг төвд цэргийн материал үйлдвэрлэвэл түүнийг мөн цэргийн зорилгоор ашигласан гэж үзнэ.

4.Дээрх 1 дэх хэсэгт дурдсан соёлын үнэт зүйлсийг тийнхүү хамгаалахаар томилогдсон цэргийн харуулаар, эсхүл соёлын тухайн үнэт зүйлсийн ойролцоо байгаа нийтийн хэв журам сахиулах ердийн үүрэгтэй цагдаагийн хүчнээр хамгаалуулж байвал соёлын үнэт зүйлсийг цэргийн зорилгоор ашиглаж байна гэж үзэхгүй.

5.Хэрэв энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан соёлын үнэт аливаа зүйлс нь дээрх хэсэгт тодорхойлсон цэргийн чухал объектын ойролцоо байрлаж байгаа бөгөөд хэрэв хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал зэвсэгт мөргөлдөөний үед уг объектыг аль ч тохиолдолд ашиглахгүй байх, ялангуяа уг объект нь далайн боомт, төмөр зам, эсхүл нисэх онгоцны буудал бол тэнд үүсэх хөдөлгөөнийг саатуулах үүрэг хүлээж хамгаалалтад авахыг хүсвэл уг үнэт зүйлсийг тусгай хамгаалалтад авна. Ийм нөхцөлд хөдөлгөөн саатуулах талаар авах арга хэмжээг тайван цагт бэлтгэсэн байна.

6.Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйлсийн олон улсын бүртгэлд орсон соёлын үнэт зүйлст л тусгай хамгаалалтыг олгоно. Энэхүү конвенцийн заалт болон конвенцийг хэрэгжүүлэх журамд заасан нөхцлийн дагуу бүртгэлийг хийнэ.

1.Хэрэв хэлэлцэн тохирогч эрхэм дээд аль нэг тал тусгай хамгаалалтад байгаа соёлын үнэт зүйлсийн хувьд 9 дүгээр зүйлд заасан үүргийг зөрчсөн тохиолдолд эсрэг тал нь уг зөрчлийг арилтал тухайн үнэт зүйлсийн халдашгүй байдлыг хангах үүргээс чөлөөлөгдөнө. Гэхдээ боломжтой үед сүүлчийн тал зохих хугацаанд дурдсан зөрчлийг арилгуулахыг эхэлж шаардана.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд цэргийн зайлшгүй шаардлага байгаа болон үргэлжлэх нөхцөлд л тусгай хамгаалалтад байгаа соёлын үнэт зүйлсийн дархан эрхийг түдгэлзүүлж болно. Тийм шаардлагыг зэвсэгт хүчний дивиз, эсхүл түүнтэй тоогоор буюу хэмжээгээр адил, эсхүл илүү байх хэсгийг удирдаж буй офицер тодорхойлно. Аль ч тохиолдолд нөхцөл байдал шаардаж байвал эсрэг тал нь дархан эрхийг түдгэлзүүлэх тухайгаа боломжтой хугацаанд урьдчилан мэдэгдэнэ.

3.Дархан эрхийг түдгэлзүүлж буй тал конвенцийг хэрэгжүүлэх журамд заасан соёлын үнэт зүйлсийн асуудал эрхэлсэн Ерөнхий комиссарт энэ тухайгаа аль болох богино хугацаанд шалтгааныг зааж, бичгээр мэдэгдэнэ.

1.Хэлэлцэн тохирогч холбогдох эрхэм дээд талын хүсэлтээр зөвхөн соёлын үнэт зүйлсийг тухайн нутаг дэвсгэр дотор, эсхүл өөр талын нутаг дэвсгэрт гүйцэтгэх тээвэрлэлтийг конвенцийг хэрэгжүүлэх журамд заасан нөхцлийн дагуу тусгай хамгаалалтын дор хийнэ.

2.Конвенцийг хэрэгжүүлэх журамд заасан нөхцлийн дагуу тусгай хамгаалалт бүхий олон улсын хяналтын дор гүйцэтгэх тээвэрлэлтийг 16 дугаар зүйлд заасан бэлгэ тэмдгээр илэрхийлнэ.

3.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд тусгай хамгаалалттай тээвэрлэлтийн эсрэг чиглэсэн дайсагнах аливаа үйлдлээс татгалзана.

1.Хэрэв хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал соёлын зарим үнэт зүйлсийн аюулгүй байдлыг хангах үүднээс түүнийг тээвэрлэх, ийнхүү хийх тээвэрлэлтийг яаралтай гүйцэтгэх, 12 дугаар зүйлд заасан журмыг ялангуяа

зэвсэгт мөргөлдөөний эхэн үед мөрдөх боломжгүй гэж үзвэл тухайн тээвэрлэлтийг 16 дугаар зүйлд тодорхойлсон бэлгэ тэмдгээр илэрхийлж болох бөгөөд 12 дугаар зүйлд заасан дархан эрхийг олгох тухай хүсэлт өмнө нь гаргаагүй буюу татгалзсан гэж үзнэ. Хэрэв боломжтой бол тээвэрлэлтийг тухай эсрэг талдаа мэдэгдэнэ. Дархан эрх тусгайлан олгогдоогүй бол соёлын үнэт зүйлсийг өөр улсын нутаг дэвсгэрт тээвэрлэх аль ч тохиолдолд бэлгэ тэмдэг ашиглахгүй.

2.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан бэлгэ тэмдэг бүхий тээвэрлэлтийн эсрэг чиглэсэн дайсагнах үйлдлийг таслан зогсооход шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн даруй авна.

1.Дор дурдсан зүйлд албадан хураах, шагналын журмаар хураах, олзлохын эсрэг дархан эрхийг олгоно:

2.Энэ зүйлийн аль ч заалт үзлэг болон хяналт хийх эрхийг хязгаарлахгүй.

1.Конвенцийн бэлгэ тэмдэг нь цэнхэр, цагаан өнгөөр дөрөв хуваасан доошоо шовх бамбай хэлбэртэй (бамбай нь дараахь зүйлээс бүрдэнэ: нэг өнцөг нь бамбайн шовх хэсэг рүү харсан цэнхэр өнгийн кавдрат, уг кавдратын дээр цэнхэр өнгийн гурвалжин байх бөгөөд уг квадрат, гурвалжин нь хоёр хажуугаараа цагаан өнгийн гурвалжингаар хүрээлэгдсэн байна) байна.

2.Бэлгэ тэмдгийг дангаар нь, эсхүл 17 дугаар зүйлд заасан нөхцлийн дагуу гурвалжин хэлбэртэйгээр гурваар нь хэрэглэнэ.



1.Гурван удаа давтсан бэлгэ тэмдгийг зөвхөн дараахь тохиолдолд хэрэглэнэ:

2.Дангаар нь хэрэглэх бэлгэ тэмдгийг дараахь тохиолдолд хэрэглэнэ:

3.Зэвсэгт мөргөлдөөний үед энэ зүйлийн өмнөх хэсэгт зааснаас бусад бүх тохиолдолд бэлгэ тэмдгийг хэрэглэх, эсхүл конвенцийн бэлгэ тэмдэгтэй аливаа байдлаар төстэй тэмдгийг ямар ч зорилгоор ашиглахыг хориглоно.

4.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын эрх бүхий байгууллагаас гарын үсэг зурж, өдөрлөсөн холбогдох зөвшөөрөлгүйгээр соёлын хөдлөх аливаа үнэт зүйлст бэлгэ тэмдгийг байрлуулахгүй.

1.Тайван цагт хүчин төгөлдөр байх заалтуудаас бусад тохиолдолд энэхүү конвенцийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд хоёр буюу түүнээс дээш талуудын хооронд зарласан дайн, эсхүл тэдгээрийн хооронд үүсэж болох зэвсэгт мөргөлдөөнд, уг дайн нэг буюу хэд хэдэн улсын хувьд хүлээн зөвшөөрөгдөөгүй байсан ч хэрэглэнэ.

2.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын нутаг дэвсгэрийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд эзэлсэн бүх тохиолдолд, түүнчлэн дурдсан эзлэлт нь цэргийн ямар ч эсэргүүцэлтэй тулгараагүй байсан ч энэхүү конвенцийг мөн адил хэрэглэнэ.

3.Хэрэв мөргөлдөөнд оролцож буй улсуудын нэг нь энэхүү конвенцийн оролцогч тал биш байсан ч энэхүү конвенцийн оролцогч тал болох улсуудын хувьд өөр хоорондын харилцаандаа түүний заалтуудыг хэвээр мөрдөнө. Үүнээс гадна дурдсан улс энэхүү конвенцийг батлах талаар мэдэгдэл хийж, түүний заалтуудыг биелүүлж байвал бусад улс тухайн улстай цаашид харилцах харилцаандаа энэхүү конвенцийг хэрэглэнэ.

1.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын аль нэгний нутаг дэвсгэрт гарч буй олон улсын шинж чанартай бус зэвсэгт мөргөлдөөний үед мөргөлдөөнд оролцогч тал бүр соёлын үнэт зүйлсийг хүндэтгэхэд хамаарах энэхүү конвенцийн хамгийн наад захын хэм хэмжээг хэрэглэх үүрэг хүлээнэ.

2.Мөргөлдөөнд оролцогч талууд энэхүү конвенцийн заалтуудыг бүхэлд буюу хэсэгчлэн хэрэгжүүлэх талаар тусгай хэлэлцээр байгуулахад бүхий л хүчин чармайлтаа дайчлана.

3.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага мөргөлдөөнд оролцогч талуудад өөрийн үйлчилгээг санал болгож болно.

4.Дээр дурдсан заалтуудыг хэрэглэх нь мөргөлдөөнд оролцогч талуудын хууль эрх зүйн байдлыг хөндөхгүй.

1.Соёлын үнэт зүйлст хамгаалах ашиг сонирхолд нийцнэ гэж үзэж болох бүхий тохиолдол тухайлбал, энэхүү конвенц буюу түүнийг хэрэгжүүлэх журмын заалтуудыг хэрэглэх буюу тайлбарлахад мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд саналын зөрүү гарсан тохиолдолд хамгаалагч гүрэн сайн санааны үүднээс үйлчилгээ үзүүлнэ.

2.Эл зорилгоор хамгаалагч гүрэн бүр аль нэг тал, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын урилгаар, эсхүл өөрийн санаачлагаар хэрэв шаардлагатай гэж үзвэл төвийг сахисан улсын нутаг дэвсгэрийг сонгон соёлын үнэт зүйлсийг хамгаалах үүрэгтэй байгууллагууд, тэдгээрийн төлөөлөгчид оролцох зөвлөлдөөн хийхийг мөргөлдөөнд оролцогч талуудад санал болгож болно. Мөргөлдөөнд оролцогч талууд зөвлөлдөөн хийх саналыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Хамгаалагч гүрэн уг зөвлөлдөөнд даргалагчийн хувьд оролцох этгээдийг төвийг сахисан улсын харьяат нь байх, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирлаас санал болгосон хүнээр батлуулах саналыг мөргөлдөөнд оролцогч талуудад тавина.

1.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд соёлын үнэт зүйлсийг хамгаалах ажлын зохион байгуулах, энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журмыг хэрэглэхэд үүсэх аливаа бусад асуудлыг шийдвэрлэхэд техникийн туслалцаа үзүүлэхийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас хүсч болно. Уг байгууллага нь өөрийн хөтөлбөр болон боломжийн хүрээнд эл туслалцааг үзүүлнэ.

2.Уг байгууллага нь өөрийн санаачлагаар хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудад энэ асуудлаар санал гаргах эрхтэй.

1.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд тусад нь заалт гаргах шаардлагатай гэж үзэх бүхий л асуудлаар тусгай хэлэлцээр байгуулж болно.

2.Соёлын үнэт зүйлс болон түүнийг хамгаалах үүрэг бүхий ажилтанд энэхүү конвенцийн дагуу олгосон хамгаалалтыг бууруулах ямар ч тусгай хэлэлцээрийг байгуулж болохгүй.

1.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журмын албан ёсны орчуулгыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирлаар дамжуулан өөр хоорондоо хүргүүлнэ.

2.Тиймээс хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журмыг биелүүлэхэд өөрсдийн холбогдох байгууллагаас авсан, бэлтгэсэн буюу төлөвлөсөн аливаа арга хэмжээтэй холбоотой өөрсдийн шаардлагатай гэж үзсэн мэдээллийн талаарх илтгэлийг дөрвөн жилд нэг удаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд хүргүүлнэ.

1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал Гүйцэтгэх зөвлөлөөс зөвлөсний дагуу хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын төлөөлөгчдийн зөвлөлдөөнийг зарлан хуралдуулна. Тэрбээр уг зөвлөлдөөнийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын тавны нэг хүсэлт гаргасан тохиолдолд зарлан хуралдуулах ёстой.

2.Энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журамд заасан аливаа үүргийг хөндөхгүйгээр, зөвлөлдөөний зорилго нь конвенц, түүнийг хэрэгжүүлэх журмыг хэрэглэх болон түүнд холбогдох зөвлөмжийг бэлтгэх асуудлыг судлахад оршино.

3.Хэрэв хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын олонхи нь зөвлөдөөнд хүрэлцэн ирсэн бол зөвлөдөөний явцад 39 дүгээр зүйлийн дагуу конвенц, түүнийг хэрэгжүүлэх журамд өөрчлөлт оруулж болно.

1.Энэхүү конвенцийг англи, франц, орос, испани хэлээр үйлдсэн бөгөөд дөрвөн эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

2.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага нь түүний Ерөнхий бага хурлын албан ёсны бусад хэлнээ конвенцийг орчуулах ажлыг зохион байгуулна.

1.Энэхүү конвенцийг гарын үсэг зурсан улсууд өөрсдийн үндэсний хууль тогтоомжийн дагуу соёрхон батална.

2.Соёрхон батласан батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд хадгалуулна.

1.Энэхүү конвенц нь түүнийг соёрхон батласан тухай таван батламж жуух бичгийг хадгалуулснаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

2.Түүнээс хойш хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүрийн хувьд соёрхон батласан батламж жуух бичиг, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулснаас хойш гурван сарын дараа энэхүү конвенц хүчин төгөлдөр болно.

3.18 болон 19 дүгээр зүйлд заасан нөхцлийн хувьд мөргөлдөөнд оролцогч талууд дайтах ажиллагаа буюу эзлэгдэхээсээ өмнө, эсхүл хойно соёрхон батласан батламж жуух, эсхүл нэгдэн орсон баримт бичгээ хадгалуулсан бол энэхүү конвенц нэн даруй хүчин төгөлдөр болно. Тийм тохиолдолд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал аль болох богино хугацаанд 38 дугаар зүйлд заасан мэдээллийг хийнэ.

1.Энэхүү конвенцийн оролцогч тал болсон улс бүр түүнийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сарын дотор Конвенцийн үйлчилгээг эхлүүлэхэд шаардагдах бүхий л арга хэмжээг авна.

2.Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш соёрхон батласан батламж жуух, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулсан бүх улсын хувьд тухайн хугацаа нь соёрхон батласан батламж жуух, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулснаас хойших мөн зургаан сар байна.

1.Хуурай газраар дайтах хууль, зан заншил (IV), 1899 7 дугаар сарын 29 буюу 1907 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Дайны үед тэнгисийн цэргийн бөмбөгдөлтэй (IX) холбоотой Гаагийн конвенцуудын дагуу үүрэг хүлээсэн болон энэхүү конвенцийн оролцогч болсон гүрнүүдийн хоорондын харилцаанд энэхүү конвенц нь дээр дурдсан (IX) конвенц болон (IV) конвенцийн хавсралт болох журамд нэмэлт болох бөгөөд энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журамд бэлгэ тэмдгийг хэрэглэхээр заасан тохиолдол бүрт (IX) конвенцийн 5 дугаар зүйлд заасан бэлгэ тэмдгийг энэхүү конвенцийн 16 дугаар зүйлд заасан бэлгэ тэмдэг орлоно.

2.Шинжлэх ухааны болон урлагийн байгууллага, түүхийн дурсгалт хөшөөг хамгаалах тухай 1951 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн Вашингтоны пакт (Рерихийн пакт)-ын дагуу үүрэг хүлээсэн болон энэхүү конвенцийн оролцогч болсон гүрнүүдийн хоорондын харилцаанд энэхүү конвенц нь Рерихийн пактын нэмэлт болох бөгөөд энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журамд бэлгэ тэмдгийг хэрэглэхээр заасан тохиолдол бүрт Пактын 3 дугаар зүйлд заасан ялгах далбааг энэхүү конвенцийн 16 дугаар зүйлд заасан бэлгэ тэмдэг орлоно.

1.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр өөрийн нэрийн өмнөөс, эсхүл олон улсын харилцаанд үүрэг хүлээх аливаа нутаг дэвсгэрийн нэрийн өмнөөс энэхүү конвенцийг цуцалж болно.

2.Цуцлах тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд бичгээр мэдэгдэнэ.

3.Цуцлах тухай баримт бичгийг хүлээн авснаас хойш нэг жилийн дараа энэхүү цуцлалт нь хүчин төгөлдөр болно. Хэрэв энэ хугацаа дуусахад цуцалсан улс зэвсэгт мөргөлдөөний оролцогч тал байвал, уг цуцлалт нь дайтах ажиллагаа дуусах хүртэл, эсхүл соёлын үнэт зүйлсийг эх оронд буцаах ажиллагаа дуусах хүртэл үйлчлэхгүй.

1.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг тавьж болно. Нэмэлт өөрчлөлт оруулахыг санал болгосон аливаа эх бичвэрийн талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд мэдэгдэх бөгөөд тэрбээр хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүрт түүнийг хүргүүлж, тухайн талаас дараахь асуудалд дөрвөн сарын дотор хариу ирүүлэх хүсэлт гаргана:

2.Ерөнхий захирал энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хүлээн авсан хариуг хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талд хүргүүлнэ.

3.Хэрэв хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх тал дурдсан хугацаанд энэ зүйлийн 1 дэх хэсгийн "b"-д заасны дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд Бага хурал хийхгүйгээр санал болгосон нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байгаага мэдэгдвэл Ерөнхий захирал тэдгээрийн шийдвэрийн талаархи мэдэгдлийг 38 дугаар зүйлийн дагуу хийнэ. Нэмэлт өөрчлөлт нь тухайн мэдэгдлийг хийсэн өдрөөс ерэн (90) хоногийн дараа хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талын хувьд хүчин төгөлдөр болно.

4.Нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэх Бага хурлыг зарлан хуралдуулахыг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын гуравны нэгээс доошгүй улс санал болговол хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын Бага хурлыг Ерөнхий захирал зарлан хуралдуулна.

5.Өмнөх заалтанд дурдсан журмын дагуу энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журамд оруулах нэмэлт өөрчлөлт нь Бага хуралд оролцсон хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудаас түүнийг нэгэн зэрэг баталж, хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр хүлээн зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болно.

6.Энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журамд оруулах 4 болон 5 дахь хэсэгт заасан Бага хурлаас батласан нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд хүлээн зөвшөөрөх тухай баримт бичиг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд хадгалуулснаар хүчин төгөлдөр болно.

7.Энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журамд оруулсан нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараа нэмэлт өөрчлөлт орсон энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журмын эх бичвэр нь соёрхон батлах, эсхүл нэгдэн ороход нээлттэй байна.

1.Соёлын үнэт зүйлсийг хамгаалах ерөнхий комиссарыг түүний томилох тал, эсрэг талуудын нэрийн өмнөөс үйл ажиллагаагаа явуулж буй хамгаалагч талын хамтарсан тохиролцоогоор хүмүүсийн олон улсын жагсаалтаас сонгоно.

2.Энэ асуудлаар хэлэлцээ эхлүүлснээс хойш гурван долоо хоногийн дотор талууд тохиролцоонд хүрэхгүй тохиолдолд тэд Олон улсын шүүхийн даргаас ерөнхий комиссарыг томилохыг хүснэ. Энэ комиссар нь түүний томилогдох тал томилгоог зөвшөөрөх хүртэл үүрэгт ажилдаа орохгүй.

1.Соёлын үнэт зүйлсийг хамгаалах ерөнхий комиссар конвенцийн хэрэгжилттэй холбогдолтой түүнд оногдсон бүх асуудлыг томилогдсон талын төлөөлөгч болон холбогдох төлөөлөгчидтэй хамтран эрхэлнэ.

2.Энэхүү журамд тусгагдсан асуудлаар шийдвэр гаргах, томилох эрх мэдэлтэй байна.

3.Томилогдсон талын зөвшөөрөлтэйгээр мөрдөн байцаалт эхлүүлэх, эсхүл өөрөө мөрдөн байцаалт явуулах эрхтэй байна.

4.Конвенцийн хэрэгжилтэнд хэрэгтэй гэж үзсэн аливаа төлөөллийг мөргөлдөөнд оролцогч тал буюу тэдний хамгаалагч гүрэнд бий болгоно.

5.Конвенцийн хэрэгжилтэд шаардлагатай байж болох илтгэлийг бэлтгэж холбогдох талуудад илгээнэ. Илтгэлийн хувийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд илгээж, тэрбээр илтгэлийн зөвхөн техникийн агуулгыг ашиглаж болно.

6.Хамгаалагч гүрэн байхгүй тохиолдолд Ерөнхий комиссар Конвенцийн 21, 22 дугаар зүйлд заасны дагуу хамгаалагч гүрний үүрэг гүйцэтгэнэ.

1.Соёлын үнэт зүйлсийг хамгаалах ерөнхий комиссар шаардлагатай гэж үзэх, эсхүл холбогдох төлөөлөгчдийн хүсэлтээр буюу тэдэнтэй зөвлөлдсөний дараа томилогдсон талд тусгай үүрэгтэй соёлын үнэт зүйлсийг хамгаалах байцаагчийг батлуулахаар санал болгоно.

2.Ерөнхий комиссар, төлөөлөгчид болон байцаагчид дээрх хэсэгт дурдсаны адил санал болгож болох шинжээч томилж болно.

1.Зэвсэгт мөргөлдөөний үеэр хэлэлцэн тохирогч эрхэм дээд аливаа тал урдчилан харах боломжгүй нөхцөл байдлын улмаас түр хугацаагаар хорогдох байр байгуулах шаардлагатай болсон бөгөөд түүнийг тусгай хамгаалалтад байрлуулах хүсэлтэй байх тохиолдолд энэ талаар тухайн талд томилогдсон Ерөнхий комиссарт мэдэгдэнэ.

2.Хэрэв Ерөнхий комиссар ийм арга хэмжээг тухайн нөхцөл байдалд болон тухайн түр хугацаагаар хорогдох байрт байрлаж буй соёлын үнэт зүйлсийг ач холбогдлын хувьд шаардлагатай гэж үзвэл ийм түр хугацаагаар хорогдох байранд Конвенцийн 16 дугаар зүйлд заасан бэлгэ тэмдгийг байрлуулахыг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудад зөвшөөрч болно. Тэрбээр шийдвэрээ холбогдох хамгаалагч гүрнүүдийн төлөөлөгчдөд цаг алдалгүй илгээж, төлөөлөгч бүр 30 хоногийн хугацаанд багтааж бэлгэ тэмдгийг буцаахыг тушаана.

3.Ийм төлөөлөгчид зөвшөөрлөө илэрхийлсэн, эсхүл 30 хоногийн хугацаанд холбогдох төлөөлөгчид татгалзлаа илэрхийлээгүй тохиолдолд, эсхүл Ерөнхий комиссар хорогдох байранд Конвенцийн 8 дугаар зүйлд заасан шаардлага хангасан гэж үзвэл Ерөнхий комиссар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирлыг түр орогнох байрыг тусгай хамгаалалтад авсан соёлын үнэт зүйлсийн жагсаалтад оруулахыг хүснэ.

1.Тусгай хамгаалалтад авсан соёлын үнэт зүйлсийн олон улсын жагсаалтыг бэлтгэнэ.

2.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал энэ бүртгэлийг хөтлөнө. Тэрбээр бүртгэлийн хуулбарыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий захирал болон хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудад хүргүүлнэ.

3.Бүртгэлийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын нэрээр ангилна. Хэсэг бүрийг дараахь гарчигтай гурван дэд хэсэгт хуваана: Түр хугацаагаар орогнох байр, хөшөө бүхий төвүүд, соёлын бусад үл хөдлөх үнэт зүйлс. Ерөнхий захирал хэсэг бүрт тусгах зүйлийг нарийвчлан тодорхойлно.

1.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд аливаа тал өөрийн нутаг дэвсгэрт байрлаж буй тодорхой түр хугацаагаар орогнох байр, хөшөө бүхий төвүүд, хөдлөшгүй бусад соёлын бусад үл хөдлөх үнэт зүйлсийг бүртгэлд оруулах өргөдлийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд өгч болно. Ийм өргөдөлд уг үнэт зүйлсийн байрлалын тодорхойлолт болон тухайн үнэт зүйлс нь Конвенцийн 8 дугаар зүйлийн заалттай нийцэж байгааг нотлоно.

2.Эзлэгдсэн тохиолдолд эзлэгч гүрэн нь ийм өргөдөл гаргах эрхтэй байна.

3.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал бүртгүүлэх өргөдлийн хуулбарыг хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүрт цаг алдалгүй илгээнэ.

1.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд аливаа тал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд захидал илгээж соёлын үнэт зүйлсийг бүртгэхээс татгалзаж болно. Энэ захидлыг Ерөнхий захирал бүртгүүлэх өргөдөл илгээснээс хойш Г4 сарын дотор хүлээн авсан байх ёстой.

2.Ийм татгалзалд татгалзах болсон шалтгааныг дурдах бөгөөд үүнд гагцхүү дараахь үндэслэлийг хүчинтэйд тооцно:

3.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал татгалзсан тухай захидлын хуулбарыг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудад цаг алдалгүй илгээнэ. Шаардлагатай тохиолдолд тэрбээр Хөшөө, урлагийн болон түүхийн барилга, археологийн малтмалын олон улсын хорооны болон зохистой гэж үзвэл бусад эрх бүхий аливаа байгууллага буюу хүний зөвлөгөөг авна.

4.Бүртгүүлэхийг хүссэн Ерөнхий захирал, эсхүл хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал татгалзлыг буцаалгуулах зорилгоор шаардлагатай гэж үзсэн аливаа төлөөллийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд татгалзсан талд бий болгож болно.

5.Хэрэв бүртгүүлэх өргөдлийг тайван цагт гаргасан хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүртгэлээс өмнө зэвсэгт мөргөлдөөнд оролцвол нотлох, буцаах, эсхүл хийж болох буюу хийсэн татгалзлыг хүчингүй болгох хүртэл Ерөнхий захирал тухайн үнэт зүйлсийг бүртгэлд түр хугацаагаар оруулна.

6.Хэрэв татгалзсан тухай захидал хүлээн авснаас хойш 6 сарын хугацаанд хэлэлцэн тохирогч эрхэм дээд талаас татгалзлыг буцаасан тухай мэдэгдэл хүлээн авахгүй бол бүртгүүлэх өргөдөл гаргасан хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал дараахь хэсэгт заасан журмын дагуу арбитрын шүүхээр шийдвэрлүүлэх хүсэлт гаргаж болно.

7.Арбитрын шүүхээр шийдвэрлүүлэх хүсэлтийг Ерөнхий захирал татгалзсан тухай захидал хүлээн авснаас хойш нэг жилийн хугацаанаас хойшгүй гаргана. Маргаанд оролцогч тал бүр нэг арбитрч томилоно. Хэрэв нэгээс илүү татгалзал байх тохиолдолд татгалзсан хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд нийтийн тохиролцоогоор нэг арбитрч томилоно. Эдгээр хоёр арбитрч нь энэхүү журмын 1 дүгээр зүйлд дурдсан олон улсын жагсаалтаас арбитрын даргыг сонгоно. Хэрэв эдгээр арбитрч тохиролцоонд хүрэхгүй бол тэд Олон улсын шүүхийн даргаас арбитрын даргыг томилохыг шаардах бөгөөд энэ тохиолдолд түүнийг олон улсын жагсаалтаас сонгох шаардлагагүй. Ийнхүү байгуулагдсан арбитрын шүүх үйл ажиллагааны журмаа өөрөө тодорхойлно. Арбитрын шүүхийн шийдвэрийг давж заалдахгүй.

8.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр түүнийг хамарсан маргаан гарах үед өмнөх хэсэгт заасан арбитрын журмыг хэрэглэхийг хүсэхгүй байгаага мэдэгдэж болно. Ийм тохиолдолд бүртгүүлэх өргөдлийн татгалзлыг Ерөнхий захирал хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудад дамжуулна. Татгалзлыг зөвхөн санал асуулгад оролцсон хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын гуравны хоёрын олонхийн саналаар батална. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал Конвенцийн 27 дугаар зүйлээр түүнд олгосон эрхийн дагуу уулзалт зарлан хуралдуулахгүй бол санал асуулгыг захидал харилцаагаар явуулна. Хэрэв Ерөнхий захирал санал асуулгыг захидал харилцаагаар явуулахыг шийдвэл тэрбээр хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудыг санал өгөхөөр уригдсанаас хойш 6 сарын хугацаанд саналаа лацадсан захидлаар ирүүлэхийг хүсэлт болгоно.

1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд татгалзал хүлээн аваагүй бол бүртгүүлэх өргөдөл өгсөн үнэт зүйл бүрийг серийн дугаартайгаар бүртгэлд оруулна.

2.Татгалзал илэрхийлсэн бөгөөд 14 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн заалтыг хөндөхгүйгээр Ерөнхий захирал татгалзлыг буцаасан, эсхүл 14 дүгээр зүйлийн 7, эсхүл 8 дахь хэсэгт заасан журмын дагуу батлагдаагүй тохиолдолд л үнэт зүйлсийг бүртгэлд оруулна.

3. 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг хэрэглэх үед Соёлын үнэт зүйлсийг хамгаалах ерөнхий комиссар хүсэлт гаргах тохиолдолд Ерөнхий захирал соёлын үнэт зүйлсийг бүртгэлд оруулна.

4.Ерөнхий захирал өвийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд болон бүртгүүлэх өргөдөл гаргасан талын хүсэлтээр Конвенцийн 30 болон 32 дугаар зүйлд заасан бусад бүх улсад бүртгэлд оруулсан үнэт зүйлсийн баталгаат хуулбарыг цаг алдалгүй илгээнэ.

1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал бүртгүүлсэн аливаа үнэт зүйлсийн бүртгэлийг дараахь тохиолдолд хүчингүй болгоно:

2. Ерөнхий захирал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга болон бүртгэлд оруулсаны хуулбарыг хүлээн авсан бүх улсад татгалзлын хуулбарыг цаг алдалгүй илгээнэ. Ийм хуулбарыг илгээсний дараа 30 хоногийн дараа татгалзал хүчин төгөлдөр болно.

1.Конвенцийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хүсэлтийг Соёлын үнэт зүйлсийг хамгаалах ерөнхий комиссарт илгээнэ. Тэрбээр хүсэлтийн үндэслэл, шилжүүлэх зүйлийн ойролцоо тоо болон ач холбогдол, тэдгээрийн одоо байрлаж буй байрлал, зөвөрлөх зам, шилжүүлэх өдрийн санал болон бусад аливаа мэдээллийг дурдана.

2.Ерөнхий комиссар шаардлагатай гэж үзсэн саналыг сонссоны дараа ийм шилжүүлгийг зохистой гэж үзвэл тэрбээр гүйцэтгэхээр санал болгосон арга хэмжээний асуудлаар хамгаалагч холбогдох гүрнүүдийн төлөөлөгчидтэй зөвлөлдөнө.

3.Ерөнхий комиссар зөвхөн хүсэлтэд дурдсан үнэт зүйлсийг шилжүүлэх гэж буй бөгөөд тээвэрлэлийг зөвшөөрсөн аргаар явуулах бөгөөд бэлгэ тэмдэгтэй байгааг баталгаажуулах нэг, эсхүл түүнээс илүү байцаагч томилоно. Байцаагч буюу байцаагчид хүрэх газарт нь очтол үнэт зүйлсийг дагалдаж явна.

1.Бэлгэ тэмдгийг байрлуулах буюу түүнийг харагдах хэмжээг хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүрийн эрх бүхий байгууллагууд тодорхойлно. Үүнийг далбаа, гарын туузанд байрлуулж болно. Түүнийг байгууламж дээр будах, эсхүл бусад аливаа аргаар илэрхийлж болно.

2.Гэхдээ илүү тод тэмдэглэлээг хөндөхгүйгээр бэлгэ тэмдгийг зэвсэгт мөргөлдөөний үед болон Конвенцийн 12 болон 13 дугаар зүйлд заасан тохиолдолд өдрийн гэрэлд агаараас болон газраас тод харагдахаар тээврийн хэрэгслийн дугуйн дээр байрлуулна. Бэлгэ тэмдэг нь газраас дараахь тохиолдолд харагдах ёстой:

1.Конвенцийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн (b) болон (c) дэд хэсэгт дурдсан этгээдүүд эрх бүхий байгууллагаас тамгалж олгосон бэлгэ тэмдэг бүхий гарын тууз зүүж болно.

2.Ийм этгээдүүд таних бэлгэ тэмдэг бүхий тусгай биеийн байцаалт авч явна. Ийм биеийн байцаалтад наад зах нь эзэмшигчийн овог, нэр, төрсөн он, сар, өдөр, зэрэг, цол болон чиг үүргийг тусгана. Биеийн байцаалтад эзэмшигчийн зураг, эсхүл гарын үсэг, эсхүл аль аль нь байна. Биеийн байцаалт эрх бүхий байгууллагын товгор тамгатай байна.

3.Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр хавсралт загвар, аргачлалын дагуу өөрийн биеийн байцаалтын хэлбэрийг боловсруулна. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд ашиглаж буй загвараа бие биедээ өгнө. Биеийн байцаалтыг боломжийн хэрээр наад зах нь хоёр хувь үйлдэж нэгийг нь олгогч гүрэн хадгална.

4.Уг этгээдүүдээс хууль ёсны шалтгаангүйгээр биеийн байцаалтыг авч явах, эсхүл гарын тууз зүүж явах эрхээс нь түдгэлзүүлж болохгүй.



ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200А (XXI) дугаар тогтоолоор баталж, 1976 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон*

Энэхүү Пактад оролцогч улсууд,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тунхагласан зарчмын дагуу хүн төрөлхтөний бүлийн бүх гишүүнд угаас заяасан нэр төр болон тэдний тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс болохыг анхааралдаа авч,

эдгээр эрх нь хүнд угаас заяасан нэр төрөөс үүдэн гарч байгааг хүлээн зөвшөөрч,

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд зааснаар хүн бүр эдийн засаг, нийгэм соёлын эрхээ улс төр, иргэний эрхийн адил эдлэх нөхцлөөр хангагдсан үед л айх аюулгүй, гачигдах зүйлгүй байх чөлөөт бие хүний туйлын хүслэн биелэгдэхийг хүлээн зөвшөөрч,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм ёсоор улсууд хүний эрх, эрх чөлөөг бүх нийтээр хүндэтгэх хийгээд сахиж явдлыг хөхиүлэн дэмжих үүрэгтэйг анхааралдаа авч,

хувь хүн бүр бусад хүн болон хамт олныхоо өмнө үүрэг хүлээхийн сацуу энэхүү Пактад хүлээн зөвшөөрсөн эрхийг хөхиүлэн дэмжүүлэх, сахиулах ёстойг анхааралдаа авч,

дор дурдсан зүйлийг тохиролцов:

I ХЭСЭГ

1 дүгээр зүйл

1. Бүх ард түмэн өөрөө засан тохинох эрхтэй. Энэ эрхийнхээ дагуу тэд улс төрийн байдлаа чөлөөтэй тогтоож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлөө чөлөөтэй хангана.

2. Бүх ард түмэн зорилгодоо хүрэхийн тулд харилцан ашигтай байх зарчим дээр тулгуурласан олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа болон олон улсын эрх зүйгээр хүлээсэн аливаа үүрэгт хохиролгүйгээр байгалийн баялаг, эх нөөцөө чөлөөтэй эзэмшинэ. Аливаа ард түмнийг ямар ч тохиолдолд оршин тогтнох хэрэглүүрээс нь салгаж үл болно.

3. Энэхүү Пактад оролцогч бүх улс, түүний дотор өөрөө захиргаагүй болон асрамжийн нутаг дэвсгэрийг захирах хариуцлага хүлээсэн улс, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн заалтын дагуу өөрөө засан тохинох эрхийг хэрэгжүүлэхийг хөхиүлэн дэмжиж, энэ эрхийг хүндэтгэх ёстой.

II ХЭСЭГ

2 дугаар зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улс бүр дангаараа болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар, тухайлбал эдийн засаг, техникийн салбарт, энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг дэвшилтгүйгээр хангахын тулд хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, зохистой арга хэмжээг байгаа бүх боломжийнхоо хэрээр авах үүрэгтэй.

2. Энэхүү Пактад оролцогч улсууд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн болон бусад нөхцөл байдлаар алагчилахгүйгээр энэхүү Пактад тунхагласан эрхийг хэрэгжүүлэх баталгааг бий болгох үүрэгтэй.

3. Хөгжиж байгаа улсууд хүний эрх болон үндэсний эдийн засгаа зохих ёсоор харгалзан үзсэний үндсэн дээр энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эдийн засгийн эрхийг өөрийн улсын иргэн бус хүмүүст хэрэгжүүлэх баталгааг ямар хэмжээгээр бий болгохоо тодорхойлж болно.

3 дугаар зүйл

Энэхүү Пактад оролцогч улсууд түүнд заасан эдийн засаг, нийгэм, соёлын бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эдлүүлэх нөхцлийг хангах үүрэгтэй.

4 дүгээр зүйл

Аливаа улсаас энэхүү Пактын дагуу хангах ёстой эрхийг эдлүүлэхдээ эдгээр эрхэд зөвхөн хуульд тодорхойлсон ёсоор хязгаарлалт тогтоож болох бөгөөд энэ нь тэдгээр эрхийн уг чанарт нийцсэн, ардчилсан нийгэмд гагцхүү нийтийн сайн сайхан байдалд туслах зорилготой байх ёстой гэдгийг энэхүү Пактад оролцогч улсууд хүлээн зөвшөөрнө.

5 дугаар зүйл

1. Аливаа улс, бүлэг болон этгээд энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн аливаа эрх, эрх чөлөөг устгахад чиглэсэн, эсхүл түүнд зааснаас илүү хэмжээгээр хязгаарлахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа явуулах, аливаа үйлдэл хийх эрхтэй байх мэтээр Пактын аливаа заалтыг мушгин тайлбарлаж болохгүй.

2. Аливаа улсад хууль, конвенц, журам, заншлаар хүлээн зөвшөөрсөн буюу тогтоосон хүний үндсэн эрхийг энэхүү Пактад бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй буюу бүрэн бус хүлээн зөвшөөрсөн гэдэг шалтгаанаар хязгаарлаж, багасгаж хэрхэвч болохгүй.

III ХЭСЭГ

6 дугаар зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр аж төрөхдөө чөлөөтэй сонгох, чөлөөтэй тохиролцох боломжийг олгосон хөдөлмөрлөх эрхийг хүлээн зөвшөөрч, энэ эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зохистой алхам хийнэ.

2. Энэ эрхийг бүрэн хэрэгжүүлэх зорилгоор энэхүү Пактад оролцогч улсуудын авах арга хэмжээ нь техник мэргэжлийн дадлага, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, эдийн засаг, нийгэм, соёлын хэлбэрэлтгүй хөгжлийг хангах арга замыг хэрэгжүүлэх хувь хүний улс төр, эдийн засгийн үндсэн эрх чөлөөг баталгаажуулах нөхцөлд үр ашигтай ажлаар бүрэн хангах алхмыг хамаарна.

7 дугаар зүйл

Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр хөдөлмөрийн шударга, таатай нөхцлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд тухайлбал:

(a) бүх хөдөлмөр эрхлэгчдэд наад зах нь дараахь байдлыг хангахуйц цалин хөлс олгох:

i/ цалин хөлсийг шударгаар тогтоох, аливаа ялгаваргүйгээр адил үнэлгээтэй хөдөлмөрт тэгш цалин хөлс олгох, чингэхдээ, тухайлбал, эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс доргүй хөдөлмөрлөх нөхцлийг бий болгох, тэдний адил хөдөлмөрт нь тэгш цалин хөлс олгох;

ii/ энэхүү Пактын заалтын дагуу хөдөлмөр эрхлэгч, түүний гэр бүлийн гишүүдэд хангалуун амьдрах боломж олгох.

(b) аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон ажлын нөхцлийг бүрдүүлэх;

(c) гагцхүү ажилласан хугацаа, мэргэшилд үндэслэн зохих дээд шатны ажилд дэвших адил боломжийг хүн бүрт олгох;

(d) амрах, зав чөлөөтэй байх, ажлын цагийг зохистойгоор хязгаарлах, ээлжийн амралтыг цалин хөлстэйгээр эдлүүлэх, баярын өдөрт цалин хөлс олгохыг хамаарна.

8 дугаар зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улсууд дор дурдсан эрхийг хангах үүрэгтэй:

(a) хүн бүр эдийн засаг, нийгмийн ашиг сонирхлоо хамгаалах, хэрэгжүүлэхийн тулд үйлдвэрчний эвлэл байгуулах, журмыг нь сахиж үндсэн дээр сонгосон байгууллагадаа элсэн орох эрхтэй. Дээр дурдсан эрхийг эдлэхэд хуульд заасан буюу ардчилсан нийгэмд шаардагдах үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхлоос бусад ямарваа хязгаарлалт тогтоохыг хориглоно;

(b) үйлдвэрчний эвлэлээс үндэсний холбоо, нэгдэл байгуулах эрх, түүнчлэн үндэсний холбоо, нэгдлээс олон улсын үйлдвэрчний байгууллагыг үүсгэх буюу түүнд нэгдэн орох эрх;

(c) үйлдвэрчний эвлэл хуулиар тогтоосон бөгөөд ардчилсан нийгэмд шаардагдах үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхлоос бусад ямарваа хязгаарлалтгүйгээр үйл ажиллагаагаа саадгүй явуулах эрх;

(d) ажил хаях эрхтэй бөгөөд түүнийгээ тухайн улсын хуульд нийцүүлэн эдлэнэ.

2. Энэ зүйлийн заалт нь зэвсэгт хүчин, цагдаагийн газар, төрийн захиргааны бүрэлдэхүүнд орсон этгээдээс энэ эрхийг эдлэхэд нь хууль ёсны хязгаарлалт тогтооход саад болохгүй.

3. Энэ зүйлийн аливаа заалт Чөлөөтэй эвлэлдэн нэгдэх болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 1948 оны конвенцид заасан баталгаанд хохирол учруулахуйц хууль тогтоомжийг батлах буюу эдгээр баталгаанд хохирол учруулахаар хуулийг хэрэглэх эрхийг дурдсан Конвенцид оролцогч улсуудад олгохгүй.

9 дүгээр зүйл

Энэхүү Пактад оролцогч улсууд нийгмийн даатгалыг оролцуулан, хүн бүрийн нийгмийн хангамжинд хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрнө.

10 дугаар зүйл

Энэхүү Пактад оролцогч улсууд дор дурдсан зүйлийг хүлээн зөвшөөрнө:

1. Нийгмийн жам ёсны үндсэн нэгж болсон гэр бүлд, ялангуяа түүний үүсэх үед, бие дааж амжаагүй хүүхдийг халамжлах, хүмүүжүүлэх хариуцлага хүлээж байгаа үед, боломжийн хэрээр халамжлан хамгаалж тусална. Гэрлэгсэд чөлөөтэй, харилцан зөвшөөрөлцсөний үндсэн дээр гэрлэнэ.

2. Эхчүүдийг хүүхэд төрүүлэхийн өмнөх болон дараахь тодорхой хугацаанд онцгойлон хамгаална. Ажиллаж байгаа эхчүүдэд энэ хугацаанд цалинтай чөлөө буюу нийгмийн хангамжийн зохих тэтгэмж олгоно.

3. Бүх хүүхэд, өсвөр насныхны тухайд гэр бүлийн гарал буюу бусад үндэслэлээр алагчилахгүйгээр хамгаалах, тусламж үзүүлэх онцгой арга хэмжээ авч байх ёстой. Хүүхэд, өсвөр насныхныг эдийн засаг, нийгмийн дарлал мөлжлөгөөс хамгаалж байх ёстой. Тэднийг ёс суртахуун, эрүүл мэндэд нь харш, амь насанд нь аюултай буюу хэвийн өсөлт хөгжилтөд нь хор болохуйц салбарт ажиллуулсан бол хуулийн дагуу шийтгэнэ.

Үүнээс гадна төр хүүхдийг ажиллуулах насны хязгаарыг тогтоож, үүнээс доош насны хүүхдийг хөлслөн ажиллуулахыг хориглож, зөрчсөн тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж байна.

11 дүгээр зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн болон түүний өрх гэрийн хүрэлцээтэй хоол хүнс, хувцас, орон сууцыг оролцуулан, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, амьдралынхаа нөхцлөө байнга сайжруулах эрхийг нь хүлээн зөвшөөрнө. Оролцогч улсууд энэ талаар чөлөөтэй зөвшилцөлд үндэслэсэн олон улсын хамтын ажиллагаа чухал ач холбогдолтойг хүлээн зөвшөөрч, энэ эрхийн хэрэгжилтийг хангах зохистой арга хэмжээ авна.

2. Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн өлсгөлөнгөөс ангид аж төрөх үндсэн эрхийг хүлээн зөвшөөрч, тодорхой хөтөлбөр хэрэгжүүлэхийг оролцуулан, дангаараа буюу олон улсын хамтын ажиллагааны хэлбэрээр шаардлагатай арга хэмжээг дараахь зорилгоор авна:

(а) байгалийн эх нөөцийг хамгийн үр ашигтай эзэмших, ашиглах зорилгоор техник, шинжлэх ухааны мэдлэгийг өргөн ашиглах, хүнс тэжээлийн тухай мэдлэгийг дэлгэрүүлэх, газар тариалангийн тогтолцоог боловсронгуй болгох, шинэтгэл хийх замаар хоол хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, хуваарилах арга ажиллагааг сайжруулах;

(б) хүнсний бүтээгдэхүүн экспортлогч буюу импортлогч улсын асуудлыг анхааралдаа авч харгалзан дэлхийн хоол хүнсний нөөцийн шударга хуваарилалтыг хангах.

12 дугаар зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн бие бялдрын болон сэтгэцийн эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх эрхийг хүлээн зөвшөөрнө.

2. Энэхүү Пактад оролцогч улсууд энэ эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах дараахь арга хэмжээг авна:

(а) нялхсын эндэгдлийг багасгах, хүүхдийн эрүүл чийрэг өсөлтийг хангах;

(б) гадаад орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйг бүх талаар сайжруулах;

(с) халдварт өвчин, тухайн нутгийн өвчин, мэргэжлийн болон бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, тийм өвчинтэй тэмцэх;

(д) өвчилсөн тохиолдолд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, сувилах нөхцлийг бүгдэд бий болгох.

13 дугаар зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө. Боловсрол хүний хувийн зан чанарыг бүхэлд нь бүрэн хөгжүүлэх, нэр төрөө ухамсарлахад чиглэгдэж, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэн бэхжүүлэх ёстойг зөвшөөрч байна. Боловсрол хүн бүрт чөлөөт нийгмийн тустай гишүүн байх, бүх үндэстэн, арьс үндэстэн, угсаа, шашин шүтлэгээрээ ялгавар бүхий бүлгийн хувьд харилцан ойлголцох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагаас энх тайвныг сахих талаар явуулж байгаа үйл ажиллагаанд дөхөм үзүүлэхэд бүгдэд боломж олгох ёстойг зөвшөөрч байна.

2. Энэхүү Пактад оролцогч улсууд энэ эрхийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд:

(а) хүн бүрт бага боловсролыг заавал, үнэ төлбөргүй олгох;

(б) үнэ төлбөргүй боловсрол олгохыг дэвшилттэйгээр нэвтрүүлэх бүхий л шаардлагатай арга хэмжээ авах замаар, техник-мэргэжлийн дунд сургуулийн боловсролыг оролцуулан, дунд боловсролын төрөл бүрийн хэлбэрийг бүгдэд боломжтой, хүртээмжтэй болгох;

(с) үнэ төлбөргүй боловсрол олгохыг дэвшилттэйгээр нэвтрүүлэх бүхий л шаардлагатай арга хэмжээ авах замаар, авъяас чадварыг нь харгалзан, дээд боловсролыг бүгдэд ижил хүртээмжтэй болгох;

(д) бага боловсролтой бүрэн болоогүй буюу бага сургуулийг бүрэн төгсөөгүй хүн суурь боловсролтой болохыг хөхиүлэн дэмжих буюу эрчимжүүлэх;

(е) бүх шатны сургуулийн тогтолцоог эрчимтэй хөгжүүлэх, хангалттай тэтгэлэгийн тогтолцоотой болох, багш нарын материаллаг нөхцлийг байнга сайжруулах арга хэмжээг авах ёстой.

3. Энэхүү Пактад оролцогч улсууд эцэг эх болон зохих нөхцөлд хууль ёсны асран хамгаалагчаас хүүхэддээ төрийн байгууллагаас байгуулсан сургууль төдийгүй, боловсрол олгох талаар улсаас тогтоосон буюу батласан наад захын шаардлагыг хангаж байгаа бусад сургуулийг сонгох, өөрийн хувийн итгэл, үнэмшлийн дагуу шашин шүтлэг болон ёс суртахууны боловсрол олгох боломжийг хангана.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зарчмыг хатуу баримталсан бөгөөд тэр сургуулиар олгож байгаа боловсрол нь төрөөс тогтоосон наад захын шаардлагын доод хэмжээг хангасан нөхцөлд, хувь этгээд буюу байгууллагаас сургууль байгуулах, удирдах эрх чөлөөг хязгаарласан утгаар энэ зүйлийн аливаа хэсгийг тайлбарлаж болохгүй.

14 дүгээр зүйл

Энэхүү Пактад оролцогч улс бүр түүнд оролцогч болох үедээ өөрийн эзэмшлийн нутаг дэвсгэр дээр буюу шүүхийн харьяалалд нь хамаарах бусад нутаг дэвсгэр дээр бага боловсролыг заавал, үнэ төлбөргүй болгох журам тогтоож чадаагүй байсан бол, бүх нийтийн боловсролыг заавал, үнэ төлбөргүй болгох зарчмыг зохих хугацаанд, дэвшилттэйгээр хэрэгжүүлэх арга хэмжээний тодорхой төлөвлөгөөг хоёр жилийн дотор боловсруулан, батлах үүрэг хүлээнэ.

15 дугаар зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр дараахь эрх эдлэхийг хүлээн зөвшөөрнө:

(а) соёлын амьдралд оролцох;

(б) шинжлэх ухааны дэвшлийн үр дүнг ашиглах, түүнийг хэрэглэх;

(с) өөрийнхөө туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны аливаа бүтээлтэй холбогдон үүссэн ёс суртахууны болон эд материалын ашиг сонирхлыг хамгаалуулах.

2. Энэхүү Пактад оролцогч улсуудаас энэ эрхийг бүрэн хэрэгжүүлэх үүднээс авч явуулбал зохих арга хэмжээнд шинжлэх ухаан, соёлын ололтыг хамгаалах, хөгжүүлэх, дэлгэрүүлэхэд шаардагдах арга хэмжээ багтана.

3. Энэхүү Пактад оролцогч улсууд шинжлэх ухааны судалгааны болон уран бүтээлийн үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардагдах эрх чөлөөг хүндэтгэх үүрэгтэй.

4. Энэхүү Пактад оролцогч улсууд шинжлэх ухаан, соёлын салбарт олон улсын харилцаа, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж, хөгжүүлэх нь үр ашигтай гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

IV ХЭСЭГ

16 дугаар зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улсууд энэ хэсэгт заасны дагуу Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, хүрсэн дэвшлийнхээ тухай тайлан гаргаж байх үүрэг хүлээнэ.

2. (а) Бүх тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлэх бөгөөд тэрээр тайлангийн хувийг энэхүү Пактын заалтын дагуу Эдийн засаг, нийгмийн зөвлөлд хэлэлцүүлэхээр илгээнэ.

(б) төрөлжсөн байгууллагын гишүүн бөгөөд энэхүү Пактад оролцогч улсаас ирүүлсэн тайлан буюу түүний хэсэг нь тухайн байгууллагын үндэслэн байгуулсан баримт бичгийн дагуу түүний үйл ажиллагаатай холбоотой байвал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга тайлан буюу түүний хэсгийг холбогдох байгууллагад хүргүүлнэ.

17 дугаар зүйл

1. Энэхүү Пактыг хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн хугацаанд Эдийн засаг, нийгмийн зөвлөл энэхүү Пактад оролцогч улсууд болон холбогдох төрөлжсөн байгууллагуудтай зөвлөлдөн хөтөлбөр боловсруулж гаргах бөгөөд энэхүү хөтөлбөрийн дагуу оролцогч улсууд зохих үе шатаар тайлан гарган өгч байна.

2. Энэхүү Пактаар хүлээсэн үүргийг биелүүлэхэд нөлөөлж байгаа хүчин зүйл, бэрхшээлийг тайланд тусгаж болно.

3. Хэрэв энэхүү Пактад оролцогч улсууд Нэгдсэн Үндэстний Байгууллага болон аливаа төрөлжсөн байгууллагад зохих мэдээлэл урьд нь өгсөн бол, тэрхүү мэдээлэл дахин өгөх шаардлагагүй бөгөөд харин тийнхүү өгсөн мэдээллийг иш татан дурдахад л хангалттай.

18 дугаар зүйл

Эдийн засаг, нийгмийн зөвлөл нь хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд төрөлжсөн байгууллагуудаас үйл ажиллагааны хүрээнд хамаарах, энэхүү Пактын заалтыг биелүүлэх явцад хүрсэн дэвшлийн талаар тайлан гаргуулан авах тухай тэдгээр байгууллагатай тохиролцож болно. Тайланд дээрх байгууллагуудаас Пактын заалтыг хэрэгжүүлэх талаар гаргасан шийдвэр, зөвлөмжийн тухай тодорхой оруулж болно.

19 дүгээр зүйл

Эдийн засаг, нийгмийн зөвлөл 16, 17 дугаар зүйлд заасны дагуу оролцогч улсуудаас ирүүлсэн хүний эрхтэй холбогдол бүхий тайлан болон 18 дугаар зүйлд заасны дагуу төрөлжсөн байгууллагуудаас ирүүлсэн хүний эрхийн холбогдолтой тайланг Хүний эрхийн комисст судалгаа хийлгэх болон ерөнхий зөвлөмж гаргуулахаар, эсхүл зарим тохиолдолд мэдээлэхээр шилжүүлж болно.

20 дугаар зүйл

Энэхүү Пактад оролцогч улсууд болон холбогдох төрөлжсөн байгууллагууд 19 дүгээр зүйлийн дагуу гаргасан ерөнхий зөвлөмжийн талаар буюу Хүний эрхийн комиссын аль нэг тайлан, түүний иш татаж байгаа аль нэг баримт бичгийн талаар Эдийн засаг, нийгмийн зөвлөлд саналаа илэрхийлж болно.

21 дүгээр зүйл

Эдийн засаг, нийгмийн зөвлөл ерөнхий зөвлөмж болон энэхүү Пактад оролцогч улсууд, төрөлжсөн байгууллагуудаас энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүх нийтээр хангах талаар авсан арга хэмжээ, хүрсэн үр дүнгийн талаар ирүүлсэн мэдээллийн тухай хураангуй тайланг Ерөнхий Ассамблейд үе үе оруулж байна.

22 дугаар зүйл

Эдийн засаг, нийгмийн зөвлөл нь техникийн тусламж үзүүлэх асуудал эрхэлсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын бусад байгууллага, тэдгээрийн туслах байгууллага болон төрөлжсөн байгууллагуудын анхаарлыг энэхүү Пактыг амьдралд аажмаар, үр ашигтай хэрэгжүүлэхэд өөрийн эрх хэмжээний дагуу олон улсын арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг шийдэхэд нь тэдгээр байгууллагад дөхөм үзүүлэхүйц хийгээд Пактын энэхүү хэсэгт дурдсан тайлантай холбоотой аливаа асуудалд хандуулж болно.

23 дугаар зүйл

Энэхүү Пактад оролцогч улсууд түүгээр хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлэх олон улсын арга хэмжээнд конвенц байгуулах, зөвлөмж гаргах, техникийн тусламж үзүүлэх, зөвлөлдөх зорилгоор бүсийн болон мэргэжлийн зөвлөгөөн хийх, түүнчлэн засгийн газруудтай хамтран судалгаа хийх зэрэг арга хэмжээ багтана гэж үзэж байна.

24 дүгээр зүйл

Энэхүү Пактад тусгагдсан асуудлын талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөл бүрийн газар болон төрөлжсөн байгууллагуудын гүйцэтгэвэл зохих үүргийг тодорхойлсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм, төрөлжсөн байгууллагуудын дүрмийн заалтуудын ач холбогдлыг бууруулсан мэтээр энэхүү Пактын аливаа заалтыг тайлбарлаж болохгүй.

25 дугаар зүйл

Байгалийн баялаг, нөөцийг бүрэн чөлөөтэй эзэмших, ашиглах бүх ард түмний салшгүй эрхийг хязгаарласан мэтээр энэхүү Пактын аливаа заалтыг мушгин тайлбарлаж болохгүй.

V ХЭСЭГ

26 дугаар зүйл

1. Энэхүү Пакт нь Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын гишүүн аливаа улс, Олон улсын шүүхийн дүрэмд оролцогч аливаа улс, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас энэхүү Пактад оролцохыг урьсан бусад аливаа улс гарын үсэг зурахад нээлттэй байна.

2. Энэхүү Пактыг соёрхон баталбал зохино. Батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

3. Энэхүү Пакт энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аливаа улс нэгдэн ороход нээлттэй байна.

4. Нэгдэж орсон тухай батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулснаар нэгдэн орсон гэж үзнэ.

5. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга соёрхон батласан буюу нэгдэн орсон батламж жуух бичгийг хадгалуулсан бүрийг энэхүү Пактад гарын үсэг зурсан буюу нэгдэж орсон бүх улсад мэдээлж байна.

27 дугаар зүйл

1. Энэхүү Пакт нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад соёрхон батласан болон нэгдэн орсон тухай гучин тав дахь батламж жуух бичгийг хадгалуулснаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

2. Соёрхон батласан болон нэгдэж орсон тухай гучин тав дахь батламж жуух бичгийг хадгалуулсны дараа энэхүү Пактыг соёрхон батласан буюу түүнд нэгдэн орсон улсын хувьд батламж жуух бичгээ хадгалуулснаас хойш гурван сарын дараа энэхүү Пакт хүчин төгөлдөр болно.

28 дугаар зүйл

Энэхүү Пактын заалтууд холбооны улсуудын бүх хэсэгт ямар нэгэн хязгаарлалтгүйгээр адил үйлчилнэ.

29 дүгээр зүйл

1. Энэхүү Пактад оролцогч аливаа улс нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж, энэ тухайгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж болно.

Ерөнхий нарийн бичгийн дарга дэвшүүлсэн аливаа нэмэлт өөрчлөлтийн утхай саналыг энэхүү Пактад оролцогч улсуудад хүргүүлж, түүнийг хэлэлцэж, санал хураах зорилгоор энэхүү Пактад оролцогч улсуудын бага хурал хуралдуулах саналтай эсэхээ мэдэгдэхийг хүснэ. Хэрэв оролцогч улсуудын гуравны нэгээс доошгүй нь бага хурал хуралдуулах саналтай байвал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Нэгдсэн Үндэстний Байгууллагын ивээл дор бага хурлыг хуралдуулна. Энэхүү бага хуралд оролцсон хийгээд саналаа өгсөн оролцогч улсын олонхийн дэмжсэн аливаа нэмэлт өөрчлөлтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейд батлуулахаар оруулна.

2. Эдгээр нэмэлт өөрчлөлт нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей баталж, энэхүү Пактад оролцогч улсуудын гуравны хоёр нь үндэсний хууль тогтоомжийнхоо дагуу тэдгээрийг баталмагц хүчин төгөлдөр болно.

3. Хүчин төгөлдөр болсон нэмэлт өөрчлөлт нь түүнийг хүлээн зөвшөөрсөн оролцогч улсуудын хувьд заавал дагаж мөрдөх зүйл болно. Харин бусад оролцогч улсуудын хувьд энэхүү Пактын заалт болон тэдгээр улсаас урьд өмнө хүлээн зөвшөөрсөн аливаа нэмэлт өөрчлөлт заавал дагаж мөрдөх хүчинтэй хэвээр байна.

30 дугаар зүйл

26 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу хийсэн мэдээллийг үл харгалзан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга мөн зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан бүх улсад дараахь зүйлийн талаар мэдээлж байна:

(a) 26 дугаар зүйлийн дагуу гарын үсэг зурсан, соёрхон батласан, нэгдэн орсон тухай;

(b) 27 дугаар зүйлийн дагуу энэхүү Пактын хүчин төгөлдөр болсон огноо, 29 дүгээр зүйлд зааснаар аливаа нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсон огнооны тухай.

31 дүгээр зүйл

1. Энэхүү Пактын хятад, англи, франц, орос, испани хэлээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй бөгөөд түүнийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын архивт хадгална.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү Пактын баталгаат хуулбарыг 26 дугаар зүйлд заасан бүх улсад хүргүүлнэ.



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

1991 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр

Дугаар 2

КОНВЕНЦИ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. "Соёлын үнэт зүйлийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай" 1970 оны конвенцийг соёрхон баталсугай.
2. Энэхүү конвенцээс үүдэн гарах БНМАУ-ын үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай.

БНМАУ-ЫН БАГА ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ЫН БАГА ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.ЧИМИД



МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛСИЙН ХУУЛЬ БУС ЭКСПОРТ, ИМПОРТ, ТҮҮНЧЛЭН ӨМЧЛӨХ ЭРХИЙГ ШИЛЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОХ, ТЭДГЭЭРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ КОНВЕНЦ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага 1970 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Парис хотноо баталж, 1972 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр хүчин төгөлдөр болсон □

Удиртгал

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий бага хурал Парис хотноо 1970 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 11 дүгээр сарын 14-ний өдрүүдэд болсон арван зургаадугаар чуулганаараа,

Ерөнхий бага хурлаас арван дөрөвдүгээр чуулганаараа батласан Олон улсын соёлын хамтын ажиллагааны зарчмуудын тунхаглалд тусгасан заалтууд чухал болохыг эргэн санаж,

шинжлэх ухаан, соёл, боловсролын зорилгод үндэстэн хоорондын соёлын үнэт зүйлсийн солилцоо нь хүн төрөлхтний иргэншлийн тухай мэдлэгийг нэмэгдүүлэх, бүх ард түмний соёлын амьдралын баяжуулах, үндэстэн хоорондын харилцан хүндэтгэл, талархлыг төлөвшүүлнэ гэж үзэж,

соёлын үнэт зүйлс нь иргэншил, үндэсний соёлын үндсэн бүрэлдэхүүн хэсэг болдог бөгөөд түүний жинхэнэ үнэ цэнийг зөвхөн түүний үүсэл, түүх болон уламжлалт орчны талаархи бүрэн мэдээлэлтэй холбогдуулан гаргаж болно гэж үзэж,

улс бүр өөрийн нутаг дэвсгэрт буй соёлын үнэт зүйлсийг хулгай, нууцаар ухаж авах болон хууль бус экспортын аюулаас хамгаалах үүрэгтэй гэж үзэж,

эдгээр аюулыг таслан зогсооход улс бүр өөрийн болон бүх үндэстний соёлын өвийг хүндэтгэх ёс суртахууны үүргийг ухамсарлах шаардлагатай гэж үзэж,

соёлын байгууллага болох музей, номын сан болон архивт байгаа цуглуулга нь бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны зарчмын дагуу цуглуулагдсан байх явдлыг хангах ёстой гэж үзэж,

соёлын үнэт зүйлсийн хууль бус импорт, экспорт болон өмчлөх эрхийг шилжүүлэх нь ЮНЕСКО-оос зөвлөмж болгох замаар дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий олон улсын холбогдох конвенцуудын оролцогч сонирхогч улсуудын үндэстэн хоорондын ойлголцолд саад учруулж байна гэж үзэж,

соёлын үнэт өвийг хамгаалах нь гагцхүү хоёр талын болон олон улсын хооронд нягт хамтын ажиллагааг зохион байгуулах тохиолдолд үр дүнтэй байж чадна гэж үзэж,

энэ зорилгоор ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлаас 1964 онд гаргасан зөвлөмжийг анхааралдаа авч,

соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай чуулганы хэлэлцэх хэргийн 19 дэх асуудал болох цаашдын саналыг хүлээн авч,

15 дугаар чуулганаар энэ асуудал нь олон улсын конвенцоор зохицуулах асуудал болно гэж шийдвэрлэж,

1970 оны 11 дүгээр сарын арван дөрөвний өдөр энэхүү конвенцийг батлав.

1 дүгээр зүйл

Энэхүү конвенцийн зорилгод “Соёлын үнэт зүйлс” гэдэгт археологи, түүхийн өмнөх үе, түүх, утга зохиол, урлаг, шинжлэх ухааны ач холбогдолтой гэж улс бүр үзэж байгаа шашны буюу шашны бус шинж чанартай бөгөөд дор дурдсан ангилалд хамаарагдах үнэт зүйлсийг ойлгоно:

а) ургамал, амьтан, эрдэс, анатомын ховор дээжис, цуглуулга болон палеонтологийн ач холбогдолтой үнэт зүйлс;

б) түүхийн үнэт зүйлс, тухайлбал, шинжлэх ухаан болон техникийн түүх, дайн болон нийгмийн түүх, түүнчлэн үндэсний нэрт зүтгэлтэн, сэтгэгчид, эрдэмтэд, жүжигчид болон үндэсний томоохон үйл явдалд холбоотой үнэт зүйлс;

с) археологийн (ердийн болон нуугдмал) олдворууд буюу археологийн нээлтүүд;

д) урлагийн болон түүхийн хөшөө дурсгал, археологийн ач холбогдол бүхий газрын бүрэлдэхүүн хэсгүүд;

е) 100 жилээс өмнөх үеийн бичээс, цутгамал, зоос, тамга тэмдэг зэрэг хуучны эд юмс;

f) угсаатны зүйн материалууд;

g) урлагийн дараахь үнэт зүйлс:

(i) аливаа эд зүйл дээр юугаар үйлдсэнийг үл харгалзан бүхэлд нь гараар үйлдсэн бүх төрлийн зураг, уран зураг, зураасан зураг (барааны тэмдэг болон гараар үйлдсэн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг оруулахгүй);

(ii) аливаа эдээр хийсэн баримал, уран баримлын эх бүтээлүүд;

(iii) сийлбэр, бар, цутгамлын эх бүтээлүүд;

(iv) аливаа эдээр хийсэн уран сайхны сонгомж, эвлүүлэг.

h) ховор гар бичмэлүүд, хэвлэмэл зүйлс, эртний ном судар, баримт бичиг болон (түүх, уран сайхан, шинжлэх ухаан, уран зохиол зэрэг) онцгой сонирхол татаж байгаа дангаараа буюу цуглуулгаараа байгаа хэвлэмэл бүтээл;

i) дангаараа буюу цуглуулгаараа байгаа шуудангийн марк, татварын буюу түүнтэй адилтгах марк;

j) дууны бичлэг, гэрэл зураг болон киноны архивуудыг оролцуулан бусад төрлийн архив;

k) 100 жилээс өмнөх үеийн эртний модон тавилга болон хөгжмийн эртний зэмсгүүд.

2 дугаар зүйл

1. Энэхүү конвенцид оролцогч улсууд соёлын үнэт зүйлсийн хууль бус импорт, экспорт, түүнийг өмчлөх эрхийг хууль бусаар шилжүүлэх нь уг үнэт зүйлсийн гарлын улсын соёлын өвийг ядууралд хүргэдэг гол хүчин зүйлсүүдийн нэг болон соёлынхоо үнэт зүйлсийг дээрхтэй холбоотой бүх аюулаас хамгаалах хамгийн үр нөлөөтэй аргуудын нэг нь олон улсын хамтын ажиллагаа гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

2. Энэ зорилгоор оролцогч улсууд дээрх үйлдлийг таслан зогсоох, шалтгааныг нь арилгах, шаардлагатай бол хохирлыг барагдуулахад туслалцаа үзүүлэх зэрэг арга хэмжээг өөрсдийнхөө бололцооны хэрээр авах үүрэг хүлээнэ.

3 дугаар зүйл

Энэхүү конвенцийн дагуу оролцогч улсуудаас батласан журмыг зөрчин соёлын үнэт зүйлсийг импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхийг хууль бус гэж үзнэ.

4 дүгээр зүйл

Энэхүү конвенцийн зорилгын дагуу дор дурдсан зүйлс нь улс бүрийн соёлын үнэт зүйлсэд хамаарна гэж энэхүү конвенцид оролцогч улсууд хүлээн зөвшөөрөв:

а) тухайн улсын харьяат этгээдийн дангаараа буюу бусад этгээдтэй хамтран бүтээсэн соёлын үнэт зүйлс, мөн тухайн улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэд буюу харьяалалгүй хүмүүсийн хийж бүтээсэн тухайн улсад чухал ач холбогдолтой соёлын үнэт зүйлс;

б) үндэсний нутаг дэвсгэрт олдсон соёлын үнэт зүйлс;

с) соёлын үнэт зүйлсийн гарлын улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр археологи, угсаатны зүй, байгалийн шинжлэх ухааны экспедицүүдийн олсон соёлын үнэт зүйлс;

д) сайн дурын солилцоогоор олж авсан соёлын үнэт зүйлс;

е) соёлын үнэт зүйлсийн гарлын улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр бэлгэнд, эсхүл хууль ёсоор худалдан авсан соёлын үнэт зүйлс.

5 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд соёлынхоо үнэт зүйлсийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхээс хамгаалах байгууллагагүй бол дор дурдсан үүргийг үр нөлөөтэй биелүүлэхэд шаардлагатай тооны мэргэшсэн хүмүүсээс бүрдсэн соёлын өвийг хамгаалах үндэсний нэг буюу хэд хэдэн байгууллагыг өөрийн нөхцөлдөө тохируулан байгуулах үүрэг хүлээнэ:

а) соёлын өвийг хамгаалах, ялангуяа соёлын чухал үнэт зүйлсийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхийг таслан зогсооход чиглэсэн хууль, журмын төслийг боловсруулахад туслалцаа үзүүлэх;

б) экспортлосноос үүдэж үндэсний соёлын өвд их хэмжээгээр хохирол учруулах улсын болон хувийн эзэмшлийн соёлын чухал үнэт зүйлсийн жагсаалтыг үндэсний хамгаалагдах өвийн бүртгэлийг үндэслэн гаргах болон шинэчлэх;

с) соёлын үнэт зүйлсийг хадгалах, сурталчилахад шаардлагатай шинжлэх ухаан болон техникийн байгууллагууд (музей, номын сан, архив, лаборатори, урлан гэх мэт)-ыг байгуулах, хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэх;

д) археологийн малталтад тавих хяналтыг зохион байгуулах, in situ (газар дээр нь) үлдээсэн соёлын тодорхой үнэт зүйлсийг болон ирээдүйд археологийн малталт хийхээр үлдээсэн газрыг хамгаалах;

е) энэхүү конвенцоор тодорхойлсон ёс суртахууны зарчимд нийцсэн дүрмийг сонирхогч этгээдүүдэд (хадгалагчид, цуглуулагчид эртний эдлэл цуглуулагчид гэх мэт) зориулж тогтоох, биелэлтийг хянах;

ф) бүх улсын соёлын өвийг хүндэтгэх үзлийг бий болгох, бэхжүүлэх, энэхүү конвенцийн заалтуудыг сурталчилах зорилгоор хүмүүжлийн үйл ажиллагаа явуулах;

г) соёлын үнэт зүйлс үрэгдэх бүхий л тохиолдолд зохих журмаар зарлагдаж байгаа эсэхэд хяналт тавих.

6 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд дараахь үүрэг хүлээнэ:

а) экспортлогч улс соёлын нэг буюу хэд хэдэн үнэт зүйлийг экспортлох зөвшөөрөл олгосноо батлах гэрчилгээ бий болгох. Уг гэрчилгээг журмын дагуу экспортлогдож буй нэг буюу соёлын хэд хэдэн үнэд зүйлд хавсаргана;

б) дээр дурдсан экспортын гэрчилгээг хавсаргаагүй соёлын үнэт зүйлсийг өөрийнхөө нутгаас экспортлохыг хориглох;

с) олон нийтэд, ялангуяа соёлын үнэт зүйлсийг экспортлох, импортлох боломжтой хүмүүст энэхүү хоригийг зохих хэлбэрээр танилцуулсан байх.

7 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд дараахь үүрэг хүлээнэ:

а) энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болсноо хойш энэхүү конвенцид оролцогч нөгөө улсаас гаралтай, хууль бусаар экспортлогдсон соёлын үнэт зүйлсийг өөрийн нутаг дээр байгаа музей болон түүнтэй адил төстэй байгууллагууд сандаа авахаас урьдчилан сэргийлэх бололцоотой бүх арга хэмжээг үндэснийхээ хууль тогтоомжийн дагуу авах. Холбогдох хоёр улсын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноо хойш энэхүү конвенцид оролцогч болох гарлын улсын нутаг дэвсгэрээс соёлынх нь үнэт зүйлсийг хууль бусаар экспортлох тохиолдолд түүнийг буцааж авах хүсэлтийн талаар боломжтой гэж үзвэл мэдэгдэх;

б) (i) холбогдох улсуудын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноо хойш энэхүү конвенцид оролцогч улсын музей, шашин шүтлэгийн болон иргэний түүхийн дурсгал, эсхүл түүнтэй адил төст байгууллагаас алдагдсан бөгөөд үнэт зүйлс уг байгууллагын эд юмсын бүртгэлд байгаа тохиолдолд тэдгээрийг импортлохыг хориглох;

(ii) тухайн хоёр улсын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноо хойш нутагт нь импортлох соёлын үнэт зүйлсийг илрүүлэх болон эгүүлэн өгөхөд чиглэсэн зохих арга хэмжээг оролцогч нөгөө улсын хүсэлтээр авах бөгөөд чингэхийн тулд уг хүсэлт гаргагч улс тус үнэт зүйлсийг шударгаар худалдан авсан буюу түүнийг эзэмших эрх бүхий этгээдэд зохих төлбөрийг төлсөн байвал зохино. Үнэт зүйлсийг эрэн сурвалжилгах болон эгүүлэн өгөх тухай хүсэлтийг дипломат шугамаар дамжуулна. Үнэт зүйлсийг эрэн сурвалжилгах, эгүүлэн өгөхийг шаардах эрхийг нь тогтооход шаардлагатай баримт бичиг болон бусад баталгааг хүсэлт гаргасан тал өөрийнхөө зардлаар хариуцна. Энэ зүйлийн дагуу буцаагдаж байгаа соёлын үнэт зүйлст талууд гаалийн болон бусад ямар нэг хураамж ногдуулахгүй. Дээр дурдсан нэг буюу хэд хэдэн соёлын үнэт зүйлийг буцаахтай холбогдсон бүх зардлыг хүсэлт гаргасан тал хариуцна.

8 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд конвенцийн 6 (b) болон 7(b)-д заасан хоригийг зөрчсөн аливаа этгээдэд эрүүгийн, эсхүл захиргааны хариуцлага хүлээлгэх үүрэг хүлээнэ.

9 дүгээр зүйл

Археологийн болон угсаатны зүйн материалыг хулгайлснаас үүдэж соёлын сан хөмрөг нь аюулд учирсан энэхүү конвенцид оролцогч аливаа улс холбогдох бусад оролцогч улсад хандаж болно. Энэ тохиолдолд конвенцид оролцогч улсууд шаардлагатай арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх, түүний дотор соёлын үнэт зүйлсээр худалдаа хийх, тэдгээрийг импортлох, экспортлоход хяналт тавих зэрэг олон улсын харилцан зохицуулсан үйл ажиллагаанд оролцох үүрэгтэй. Тийнхүү харилцан тохиролцоо хүртэл холбогдох улс бүр хүсэлт гаргагч улсын соёлын өвд нөхөшгүй хохирол учрахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг бололцооныхоо хэрээр авна.

10 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд дараахь үүрэг хүлээнэ:

а) мэдлэг олгох, мэдээлэл өгөх, сэрэмжлүүлэх замаар энэхүү конвенцид оролцогч аливаа улсаас хууль бусаар гаргасан соёлын үнэт зүйлсийн хөдөлгөөнийг хязгаарлах, улс бүр зохих ёсоор эртний эдлэлийн худалдаачдад эрүүгийн болон захиргааны хуулийн дагуу соёлын үнэт зүйл тус бүрийн гарал үүсэл, түүнийг өгсөн этгээдийн нэр болон хаяг, худалдсан эдлэл тус бүрийн төрх байдал, үнэ өртгийг тэмдэглэсэн бүртгэл хөтлөх, түүнчлэн соёлын үнэт зүйл худалдан авагчдад тухайн үнэт зүйлсийг экспортлохыг хориглох болзошгүйг сануулж байх үүрэг хүлээнэ;

б) соёлын үнэт зүйлсийн ач холбогдол, түүнчлэн тэдгээрийг хулгайлах, нууцаар малталт хийх, хууль бусаар экспортлох нь соёлын өвд аюултайг олон нийтэд сурганы хэрэгслээр ухамсарлуулан ойлгуулах.

11 дүгээр зүйл

Аливаа улсыг гадаад улс эзлэн түрэмгийлсний шууд буюу шууд бус уршгаар соёлын үнэт зүйлсийг хууль бусаар экспортолж, түүнийг өмчлөх эрхийг хүчээр шилжүүлсэн бол тэдгээр үйлдлийг мөн хууль бус гэж үзнэ.

12 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд олон улсын харилцаанд хариуцах нутаг дэвсгэртээ соёлын өвийг хүндэтгэж, тэдгээрийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөх эрхийг нь шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээ авна.

13 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд хууль тогтоомжийнхоо дагуу дараахь арга хэмжээ авах үүрэг хүлээнэ:

а) соёлын үнэт зүйлсийг хууль бусаар импортлох буюу экспортлоход хүргэх уг үнэт зүйлсийн өмчлөлийн эрхийг шилжүүлэх явдлаас зохих бүхий л аргаар урьдчилан сэргийлэх;

б) хууль бусаар экспортлосон соёлын үнэт зүйлсийг аль болох богино хугацаанд хууль ёсных нь өмчлөгчдөд буцааж өгөхийн тулд өөрсдийн эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг хангах;

с) алдагдсан буюу хулгайлагдсан соёлын үнэт зүйлсийг эгүүлэн өгүүлэх талаар хууль ёсны өмчлөгч болон түүний нэрийн өмнөөс зарга мэдүүлэх эрхийг зөвшөөрөх;

д) энэхүү конвенцид оролцогч улс бүр соёлын үнэт зүйлсийнхээ заримыг бусдад шилжүүлэхгүй гэж ангилан зарлаж, ipso facto экспортлохгүй байх салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд хэрэв соёлын тийм үнэт зүйлс өмнө нь экспортлогдсон бол тэдгээрийг холбогдох улсуудад буцааж өгөхөд туслалцаа үзүүлнэ.

14 дүгээр зүйл

Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар экспортлохоос урьдчилан сэргийлэх болон энэхүү конвенцийг хэрэгжүүлэхтэй холбоотой үүргээ биелүүлэхийн тулд энэхүү конвенцид оролцогч улс бүр соёлын өвийг хамгаалах үндэснийхээ байгууллагад бололцооныхоо хэрээр хангалттай хөрөнгө олгох ёстой бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх зорилгоор сан байгуулж болно.

15 дугаар зүйл

Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болохоос өмнө түүнд оролцогч улсууд гарлын нутаг дэвсгэрээсээ ямар нэгэн шалтгаанаар гарсан соёлын үнэт зүйлсийг буцааж авах талаар тусгай хэлэлцээр байгуулах буюу өмнө байгуулсан хэлэлцээрээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд энэхүү конвенцийн аль ч заалт саад болохгүй.

16 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд уг конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор батлан гаргасан хууль тогтоомж болон авсан бусад арга хэмжээ, түүнчлэн энэ салбарт хуримтлуулсан туршлагынхаа тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий бага хуралд зохих хугацаа, журмын дагуу тогтмол ирүүлдэг илтгэлдээ мэдээлж байна.

17 дугаар зүйл

1. Энэхүү конвенцид оролцогч улсууд ялангуяа дараахь асуудлаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас техникийн туслалцаа хүсч болно:

а) мэдээлэл болон боловсрол;

б) зөвлөлгөө болон мэргэжилтний туслалцаа авах;

с) зохион байгуулалтын болон сайн санааны үйлчилгээ хүртэх.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага өөрийн санаачлагаар соёлын үнэт зүйлсийг хууль бусаар дамжуулж байгаа асуудлаар судалгаа хийж, эрдэм шинжилгээний бүтээл гаргаж болно.

3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага дээрх зорилгоор төрийн бус эрх бүхий аль ч байгууллагатай хамтран ажиллаж болно.

4. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага энэхүү конвенцийг хэрэгжүүлэх талаар оролцогч улсуудад хандаж өөрийн санаачлагаар санал гаргаж болно.

5. Энэхүү конвенцид оролцогч хоёроос доошгүй улсын хооронд түүнийг хэрэгжүүлэх талаар санал зөрөлдвөл тэдгээрийн хүсэлтээр тохиролцоонд хүрэхэд ЮНЕСКО сайн санааны үйлчилгээ үзүүлэх талаар санал тавьж болно.

18 дугаар зүйл

Энэхүү конвенцийг эх бичвэр нь адил хүчинтэй байх англи, испани, орос, франц хэлээр дөрвөн эх хувь үйлдэв.

19 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын гишүүн улсууд өөрсдийн хууль тогтоомжийн дагуу соёрхон батлах буюу хүлээн зөвшөөрнө.

2. Батламж жуух бичиг буюу хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд хадгалуулна.

20 дугаар зүйл

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Гүйцэтгэх зөвлөлөөс энэхүү конвенцид нэгдэн орох урилга хүлээн авсан уг байгууллагын гишүүн бус аль ч улсын хувьд энэхүү конвенцид нэгдэн ороход нээлттэй байна.

2. Нэгдэн орох тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд хадгалуулснаар энэхүү конвенцид нэгдэн орсон гэж үзнэ.

21 дүгээр зүйл

Энэхүү конвенц нь гурав дахь батламж жуух бичиг буюу хүлээн зөвшөөрсөн, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа зөвхөн батламж жуух бичиг буюу хүлээн зөвшөөрсөн, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ тухайн өдөр буюу түүнээс өмнө хадгалуулахаар өгсөн улсуудын хувьд хүчин төгөлдөр болно. Бусад аль ч улс батламж жуух бичиг буюу хүлээн зөвшөөрсөн, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа энэхүү конвенц тэдний хувьд хүчин төгөлдөр болно.

22 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд энэхүү конвенц нь тэдгээрийн эзэмшлийн нутаг дэвсгэрт байдаг төдийгүй олон улсын харилцаанд хариуцдаг нутаг дэвсгэрт нэгэн адил үйлчлэхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү

конвенцийг дээрх нутаг дэвсгэрт хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай бол түүнийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх буюу нэгдэн орох үедээ, эсхүл түүнээс өмнө эдгээр нутаг дэвсгэрийн засгийн газар болон эрх бүхий бусад байгууллагатай зөвлөлдөх бөгөөд энэхүү конвенцийн үйлчлэх нутаг дэвсгэрийн талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд мэдэгдэх үүрэг хүлээнэ. Мэдэгдэл нь түүнийг хүлээж авснаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

23 дугаар зүйл

1. Энэхүү конвенцид оролцогч улс бүр өөрийнхөө нэрийн өмнөөс буюу олон улсын харилцаанд хариуцдаг нутаг дэвсгэрийн нэрийн өмнөөс энэхүү конвенцийг цуцалж болно.

2. Цуцалсан тухайгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд бичгээр мэдэгдэнэ.

3. Цуцалсан тухай баримт бичгийг хүлээн авснаас хойш арван хоёр сарын дараа цуцлалт нь хүчин төгөлдөр болно.

24 дүгээр зүйл

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал энэхүү конвенцийн 19, 20 дугаар зүйлүүдэд дурдсан соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн буюу нэгдэн орсон тухай бүх баримт бичиг, түүнчлэн 22, 23 дугаар зүйлүүдэд заасан цуцалсан тухай мэдэгдлийг хадгалуулахаар хүргүүлсэн тухай Байгууллагын гишүүд улсууд, 20 дугаар зүйлд дурдсан гишүүн бус улсууд, түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагад мэдээлнэ.

25 дугаар зүйл

1. Энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий бага хурлаар өөрчилж болно. Гэхдээ конвенцийн өөрчлөгдсөн эх хувь гагцхүү өөрчлөлт оруулсан конвенцийн оролцогч тал болсон улсуудад үүрэг хүлээлгэнэ.

2. Ерөнхий бага хурал энэхүү конвенцийг бүхэлд нь буюу хэсэгчилэн өөрчилж шинэ конвенц батласан тохиолдолд шинэ конвенцид өөрөөр заагаагүй бол өөрчилсөн эх бичвэр бүхий шинэ конвенцийг хүчин төгөлдөр болсон өдрөөс энэхүү конвенц соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх буюу нэгдэн ороход хаалттай болно.

26 дугаар зүйл

Энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирлын хүсэлтээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Берн хотноо 1886 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр батлагдсан "Утга зохиол, уран сайхны бүтээлийг хамгаалах тухай" Бернийн конвенци, тус Конвенцийн нэмэлт хэсэгт нэгдэн орсугай.

2 дугаар зүйл. Дээрх конвенци, түүний нэмэлт хэсэгт Монгол Улс нэгдэн орсонтой холбогдуулан тус Конвенцийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүрэг хүлээхгүй, Конвенцийн нэмэлт хэсгийн II, III зүйлд заасан хөнгөлөлтүүд эдлэхээр шийдвэрлэсэн болохыг мэдэгдсүгэй.

/энэ зүйлд 1997 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ
УТГА ЗОХИОЛ, УРЛАГИЙН БҮТЭЭЛИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ БЕРНИЙН КОНВЕНЦ

(1886 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн) 1896 оны 5 дугаар сарын 4-ний өдөр Парист эцэслэж,

1908 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Берлинд хянан өөрчилж,
1914 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Бернд эцэслэж,
1928 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Ромд,
1948 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Брюссельд,
1967 оны 7 дугаар сарын 14-ний өдөр Стокгольмд,
1971 оны 7 дугаар сарын 24-ний өдөр Парист хянан өөрчилж,
1979 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан байдлаар

Тус холбооны гишүүн орнууд,
Утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчийн эрхийг бололцооны хирээр үр ашигтай, нэгдмэл хэлбэрээр хамгаалах талаар адил байгаад урамшин,

Стокгольм хотноо 1967 онд хуралдсан хянан өөрчлөх бага хурлын ажлын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч,

Стокгольмын бага хурлаас баталсан актын 1-20 дугаар болон 22- 26 дугаар зүйлийг өөрчлөлгүйгээр тус актыг хянан өөрчлөхөөр шийдвэрлэж,

Үүнтэй холбогдуулан өөрсдийн бүрэн эрхийг зохих журмаар илэрхийлж бүрэн эрхт төлөөлөгчид дор гарын үсэг зуран,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Холбоо байгуулах

Энэхүү конвенцийг хэрэглэж буй орнууд утга зохиол болон урлагийн бүтээлийн зохиогчийн эрхийг хамгаалахад холбоо байгуулна.

2 дугаар зүйл

1. "Утга зохиол ба урлагийн бүтээл"; 2. Хамгаалалтад авахгүй байхаар тогтоож болох нөхцөл; 3. Үүсмэл бүтээл; 4. Албан ёсны эх бичвэр; 5. Эмхэтгэл; 6. Хамгаалах үүрэг, хамгаалалтын үр ашиг хүртэгчид; 7. Хавсарга урлагийн бүтээл, бүтээгдэхүүний загвар;

8. Шинэ мэдээ.

(1) "Утга зохиол ба урлагийн бүтээл" гэсэн нэр томъёонд бүтээсэн арга, хэлбэрийг үл харгалзан утга зохиол, шинжлэх ухаан, урлагийн бүх бүтээл, тухайлбал ном товхимол болон бусад бичмэл зохиол; лекц, хэлсэн үг, номлол болон ийм төрлийн бусад бүтээл; жүжгийн ба хөгжимт-жүжгийн зохиол; жүжгийн бүтээл болон үггүй жүжиг; үгтэй ба үггүй хөгжмийн бүтээл; кино зураг болон түүнтэй ижил аргаар бүтээсэн бүтээл; зураг, уран зургийн, уран барилгын, уран баримлын зураасан зургийн болон барын бүтээл; гэрэл зургийн ба түүнтэй ижил аргаар бүтээсэн бүтээл; хавсарга урлагийн бүтээл; номын зураг, газрын зураг, төлөвлөгөө; үлгэрчилсэн зураг; газар зүй, байр зүй, уран барилгын болон шинжлэх ухаанд холбогдох гурван хэмжээст бүтээл хамаарна.

(2) Гэхдээ бодит хэлбэрээр илэрхийлээгүй аливаа нэгэн утга зохиол, урлагийн бүтээл буюу түүний ямар нэгэн тодорхой хэсгийг хамгаалалтад авахгүй байхаар холбооны гишүүн орон хууль тогтоомжоороо тогтоох эрхээ хадгална.

(3) Утга зохиолын ба урлагийн бүтээлийн орчуулга, найруулга, мөн хөгжмийн зохиолын тохируулсан найруулга болон бусад өөрчлөлт нь эх бүтээлийн зохиогчийн эрхийг хөндөхгүйгээр хамгаалагдана.

(4) Хууль тогтоох, захиргааны болон шүүхийн хууль зүйн шинжтэй албан ёсны бичиг баримт, мөн тэдгээрийн албан ёсны орчуулгыг хамгаалах асуудлыг холбооны гишүүн орон нь хууль тогтоомжоороо тодорхойлох эрхээ хадгална.

(5) Материалыг сонгосон, байрлуулснаараа оюуны бүтээлийн үр дүн болохуйц нэвтэрхий толь, цоморлиг зэрэг утга зохиол болон урлагийн бүтээлийн эмхэтгэл тэдгээр эмхэтгэлийг бүрдүүлж буй бүтээлийн зохиогчийн эрхийг хөндөхгүйгээр хамгаалагдана.

(6) Энэ зүйлд дурдсан бүтээл нь холбооны гишүүн бүх оронд энэ хамгаалалт зохиогч болон түүний эрх залгамжлагчдад ашигтайгаар хамгаалагдана.

(7) Холбооны гишүүн орон энэхүү конвенцийн 7 дугаар зүйлийн (4) дэх хэсэгт заасныг харгалзан хавсарга урлагийн бүтээл, бүтээгдэхүүний загвар ба зургийг хамгаалах хэмжээ хүрээ, нөхцөлийг өөрийн хууль тогтоомждоо заах эрхтэй. Гарлын оронд гагцхүү загвар, зургийн хувиар хамгаалагддаг бүтээлийн талаар

холбооны гишүүн бусад оронд загвар, зурагт олгох тусгай хамгаалалтыг шаардаж болох бөгөөд тухайн оронд ийм тусгай хамгаалалт олгодоггүй бол дээрх бүтээлийг урлагийн бүтээлд хамааруулан хамгаална.

(8) Өдрийн шинэ мэдээ буюу сонин хэвлэлийн энгийн сонордуулгын чанартай үйл явдлын мэдээлэл энэхүү конвенцоор хамгаалагдахгүй.

2 bis зүйл

Тодорхой бүтээлийн хамгаалалтыг хязгаарлаж болох тухай:

1.Хэлсэн үг; 2.Лекц, уриалгыг тодорхой байдлаар ашиглах;

3.Ийм бүтээлийн эмхэтгэл бэлтгэх эрх

(1) Холбооны гишүүн орон нь төрийн асуудлаар хэлсэн үг, шүүх хурал дээр хэлсэн үгийг 1 дүгээр зүйлд дурдсан хамгаалалтад бүрэн буюу хэсэгчлэн хууль тогтоомжоороо хамааруулахгүй байх эрхийг хадгална.

(2) Түүнчлэн холбооны гишүүн орон нь лекц, уриалга болон олны өмнө хэлсэн иймэрхүү төрлийн бүтээлийг мэдээллийн зориулалтаар сонин хэвлэлд нийтлэх, телевиз, радиогоор нэвтрүүлэх, утсан холбоогоор дамжуулах ба энэхүү конвенцийн 11 bis дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт зааснаар нийтэд сонордуулах нөхцөлийг хууль тогтоомжоор тодорхойлох эрхээ хадгална.

(3) Харин зохиогч нь өмнөх хэсэгт дурдсан өөрийн бүтээлийн эмхэтгэлийг бэлтгэж гаргах онцгой эрх эдэлнэ.

3 дугаар зүйл

Хамгаалалт олгох хэмжүүр: 1.Зохиогчийн иргэний харьяалал; бүтээлийг туурвисан газар; 2.Зохиогчийн оршин суугаа газар; 3."Нийтийн хүртээл болсон" бүтээл; 4."Нийтийн хүртээл нэгэн зэрэг болгосон бүтээл

(1) Энэхүү конвенцид заасан хамгаалалтыг:

(a) зохиогч нь холбооны гишүүн аль нэг орны харьяат бол түүний туурвисан бүтээл нийтийн хүртээл болсон эсэхээс үл хамаарч;

(b) зохиогч нь холбооны гишүүн орны харьяат биш боловч түүний бүтээлийг холбооны гишүүн аль нэгэн оронд анх удаа буюу холбооны гишүүн болон холбооны гишүүн бус оронд нэгэн зэрэг нийтийн хүртээл болгосон тохиолдолд тус тус олгоно.

(2) холбооны гишүүн аль нэг орны харьяат биш боловч дээрх орны аль нэгэнд байнга оршин суудаг тохиолдолд энэхүү конвенцийн дагуу тухайн орны харьяатын нэгэн адил эрх эдэлнэ.

(3) "Нийтэлсэн бүтээл" гэж зохиогчийн зөвшөөрлөөр, бүтээлийн шинж байдлыг харгалзан нийтийн боломжийн хэрэгцээг хангаж чадахуйц хувиар хувилагдсан бүтээл ямар ч аргаар хувилснаас хамаарахгүй нийтэлсэн бүтээлийг хэлнэ. Жүжгийн, хөгжмийн, хөгжимт-жүжгийн буюу киноны бүтээлийг тоглож үзүүлэх, утга зохиолын бүтээлийг нийтийн өмнө унших, утга зохиол болон урлагийн бүтээлийг утсан холбоогоор дамжуулах буюу телевиз, радиогоор нэвтрүүлэх, урлагийн бүтээлийг үзүүлэх, уран барилга барих зэргийг нийтийн хүртээл болгосонд үл тооцно.

(4) Бүтээлийг анх туурвиж гаргаснаас хойш гуч хоногийн дотор хоёр буюу түүнээс илүү оронд нийтийн хүртээл болгосон бол уг бүтээлийг хэд хэдэн оронд нэгэн зэрэг нийтийн хүртээл болгосонд тооцно.

4 дүгээр зүйл

Кино бүтээл, уран барилгын бүтээл болон уран сайхны тодорхой бүтээлийг хамгаалалтад авах хэмжүүр

3 дугаар зүйлд тусгасан нөхцөлд тохирсон эсэхийг үл харгалзан энэхүү конвенцид тусгасан хамгаалалтыг хэрэгжүүлнэ:

(a) ажлын байр буюу байнга оршин суудаг газар нь холбооны гишүүн орны аль нэгэнд байдаг кино бүтээл туурвигчид;

(b) уран барилгын бүтээл нь холбооны гишүүн аль нэг оронд барьж байгуулагдсан буюу байшин, бусад барилга байгууламжийн бүрэлдэхүүн хэсэг нь болсон урлагийн өөр бүтээл холбооны гишүүн аль нэг оронд байгаа зохиогчид хамаарна.

5 дугаар зүйл

Эрхийн баталгаа:

1. болон 2. Гарлын орны хилийн гадна;

3. Гарлын оронд; 4. "Гарлын орон"

(1) Энэхүү конвенцийн дагуу бүтээл нь хамгаалагдаж буй зохиогчид бүтээлийн гарлын орноос гадна холбооны гишүүн орны хууль тогтоомжийн дагуу өөрсдийн харьяатад одоо буюу цаашид эдлүүлэх эрх, түүнчлэн энэхүү конвенцид заасан онцгой эрхийг эдэлнэ.

(2) Ийм эрх эдлэх, хэрэгжүүлэхэд ямар нэгэн албан ёсны үйлдэл хийхийг шаардах ёсгүй бөгөөд бүтээлийн гарлын оронд хамгаалалт байдаг эсэхийг үл харгалзана. Иймд зохиогчийн эрхээ хамгаалах арга хэрэгсэл, хэмжээ хүрээг энэхүү конвенцид тусгасан заалтаас гадна гагцхүү хамгаалалт хүссэн орны хууль тогтоомжоор зохицуулна.

(3) Уг хамгаалалтыг гарлын оронд тухайн орны хууль тогтоомжоор зохицуулна. Энэхүү конвенцийн заалтын дагуу бүтээл нь хамгаалагдаж буй зохиогч уг бүтээлийн гарлын орны харьяат биш байвч тэр орны харьяат зохиогчдын нэгэн адил эрх эдэлнэ.

(4) Бүтээлийн гарлын орон гэдэг нь:

(а) холбооны гишүүн аль нэг оронд анх нийтийн хүртээл болсон тохиолдолд - тухайн орон; хамгаалалтын хугацааг янз бүрээр тогтоосон холбооны хэд хэдэн оронд нэгэн зэрэг нийтийн хүртээл болгосон бүтээлийн хувьд хууль тогтоомжид хамгаалалтын нь хамгийн богино хугацаа тогтоосон тэр орон;

(b) холбооны гишүүн бус орон болон холбооны гишүүн аль нэг оронд болон холбооны гишүүн бус оронд нэгэн зэрэг нийтийн хүртээл болсон тохиолдолд;

(c) нийтийн хүртээл болгоогүй бүтээл, түүнчлэн холбооны гишүүн бус оронд анх удаа нийтийн хүртээл болгосон бүтээлийг холбооны гишүүн аль нэг оронд нэгэн зэрэг гаргаагүй бол зохиогчийг харьяалах тэр орон;

(i) кино бүтээл туурвигчийн ажлын байр буюу оршин суугаа газар нь холбооны гишүүн аль нэг оронд байвал уг бүтээлийн гарлын орон нь тухайн орон байна;

(ii) зохиогчийн уран барилгын бүтээлийг холбооны гишүүн аль нэг оронд барьсан буюу байшин, бусад барилга байгууламжийн бүрэлдэхүүн хэсэг болсон урлагийн өөр бүтээл нь холбооны гишүүн аль нэг оронд байгаа бол уг бүтээлийн гарлын орон тухайн орон байна.

6 дугаар зүйл

Холбооны гишүүн зарим орны харьяатын тодорхой бүтээлийн

хамгаалалтыг хязгаарлаж болох тухай: 1. Анх удаа нийтийн хүртээл болгосон орон болон бусад орон,

2. Буцаан хэрэглэж үл болох, 3. Мэдэгдэл

(1) Хэрэв холбооны гишүүн бус ямар нэгэн оронд холбооны гишүүн аль нэг орны харьяат зохиогчийн бүтээлийн хамгаалалт хангалтгүй бол холбооны гишүүн тухайн орон нь бүтээлийг анх нийтийн хүртээл болгох үедээ холбооны гишүүн аль нэг оронд байнга байнга оршин суудаггүй өөр орны харьяат зохиогчийн бүтээлд хийх хамгаалалтыг хязгаарлаж болно. Хэрэв бүтээлийг анх нийтийн хүртээл болгосон орон энэ эрхээ хэрэгжүүлсэн бол холбооны гишүүн бусад орон ийм онцгой дэглэм тогтоогдсон бүтээлийн хувьд дээрх орноос илүү хамгаалалт хангах үүрэггүй.

(2) Дээрх хэсэгт дурдсан аль ч хязгаарлалт нь ийм хязгаарлалт тавихаас өмнө холбооны гишүүн аль нэг оронд нийтийн хүртээл болгосон бүтээлийн зохиогчийн эрхийг үл хөндөнө.

(3) Энэ зүйлийн дагуу зохиогчийн эрхийг хязгаарлаж, холбооны гишүүн орон Дэлхийн оюуны өмчийн байгууллагын ерөнхий захиралд (цаашид "ерөнхий захирал" гэнэ) энэ тухайгаа бичгээр мэдэгдэж, хязгаарлалтад хамаарагдах орон, түүнчлэн тухайн орны харьяат зохиогчийн бүтээлд тавих хязгаарлалтыг тодорхойлон дурдана. Ерөнхий захирал энэ мэдэгдлийг холбооны гишүүн бүх оронд нэн даруй мэдэгдэнэ.

6 bis зүйл

Эд хөрөнгийн бус амины эрх: 1.Зохиогч мөн болохыг хүлээн зөвшөөрөхийг

шаардах; Бүтээлийг өөрчилсөн буюу эрх зөрчсөн бусад үйлдлийг эсэргүүцэх; 2.Зохиогч нас барсны дараа, 3.Хамгаалах арга

(1) Зохиогч нь зохиогчийн эд хөрөнгийн эрхээс үл шалтгаалан, тэр ч атугай энэхүү эрхээ шилжүүлсэн тохиолдолд ч гэсэн тэрээр бүтээлийнхээ зохиогч мөн болохыг хүлээн зөвшөөрөхийг шаардах эрхтэйгээс гадна уг бүтээлийг гуйвуулах, гажуудуулах буюу өөрчлөх, түүнчлэн зохиогчийн нэр төрд хохирол учруулахуйц бусад аливаа халдлагыг эсэргүүцэх эрхтэй.

(2) Зохиогчийг нас барсны дараа наад зах нь түүний эд хөрөнгийн эрх дуусгавар болох хүртэл дээрх хэсэгт заасан эрх хүчин төгөлдөр байх бөгөөд хамгаалалт тогтоосон орны хууль тогтоомжоор эрх мэдэл олгогдсон этгээд буюу албан байгууллага уг эрхийг хэрэгжүүлнэ. Гэхдээ энэхүү конвенцийг соёрхон батлах буюу нэгдэн орох үед аль нэг орны хууль тогтоомжид зохиогчийг нас барсны дараа дээрх хэсэгт заасан бүх эрхийг хамгаалахаар заагаагүй бол тэдгээр эрхийн аль нэг нь хамгаалагдахгүй байхаар тогтоож болно.

(3) Энэхүү зүйлд дурдсан эрх хамгаалах аргыг хамгаалалт хүссэн орны хууль тогтоомжоор зохицуулна.

7 дугаар зүйл

Хамгаалах хугацаа: 1.Нийтлэг зүйл; 2.Кино бүтээлийн хувьд; 3.Нэргүйгээр буюу зохиомол нэрээр гаргасан бүтээл; 4.Гэрэл зургийн болон хавсарга урлагийн бүтээл; 5.Хугацаа тооцож эхлэх огноо; 6. Урт хугацаа; 7. Богино хугацаа; 8. Хэрэглэх хууль тогтоомж, хугацаа "харьцуулах"

(1) Зохиогч энэхүү конвенцоор насан турш хамгаалалтад байх бөгөөд түүнийг нас барснаас хойш тавин жил үйлчилнэ.

(2) Харин зохиогчийн зөвшөөрөлтэйгөөр кино бүтээлийг нийтийн хүртээл болгосноос хойш тавин жилийн дараа, хэрэв нийтийн хүртээл болгоогүй бол уг бүтээлийн туурвиснаас хойш тавин жилийн дараа түүнийг хамгаалах хугацаа дуусахаар холбооны гишүүн орон тогтоох эрхтэй.

(3) Нэргүй буюу зохиомол нэрээр гаргасан бүтээлийг энэхүү конвенцид зааснаар хамгаалах хугацаа уг бүтээлийг эрх зүйн дагуу нийтийн хүртээл болгосноос хойш тавин жилийн дараа дуусгавар болно. Гэвч зохиомол нэр нь тухайн зохиогчийн болох нь эргэлзээгүй бол (1) дэх хэсэгт заасан хугацаагаар хамгаална. Хэрэв нэргүйгээр буюу зохиомол нэрээр гаргасан бүтээлийг зохиогч дээр дурдсан хугацаанд жинхэнэ нэрээ тайлбал мөн (1) дэх хэсэгт заасан хугацааг хэрэглэнэ. Нэргүй буюу зохиомол нэрээр гаргасан бүтээлийг зохиогч нас барснаас хойш тавин жил өнгөрсөн гэж үзэх бүрэн үндэслэлтэй бол холбооны гишүүн орон уг бүтээлийг хамгаалах үүрэггүй.

(4) Урлагийн бүтээлд тооцогдох гэрэл зургийн болон хавсарга урлагийн бүтээл хамгаалах хугацааг холбооны гишүүн орон хууль тогтоомжоороо тогтоох эрхтэй; гэхдээ энэ хугацаа ийм бүтээл туурвиснаас хойш хорин таван жилээс богино байж үл болно.

(5) Зохиогчийг нас барсны дараа бүтээлийг нь хамгаалах хугацаа, түүнчлэн (2), (3), (4) дэх хэсэгт заасан хугацааг зохиогчийн нас барсан буюу дээрх хэсэгт заасан үйл явдал болсны дараахь жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тооцно.

(6) Холбооны гишүүн орон хамгаалалтын хугацааг дээрх хэсэгт дурдсанаас илүүгээр тогтоох эрхтэй.

(7) Энэхүү конвенцийн Ромын актыг хүлээн зөвшөөрсөн, холбооны гишүүн орны үндэсний хууль тогтоомжид дээрх дэд зүйлд дурдсанаас богино хугацаа заасан бол энэхүү конвенцийг гарын үсэг зурах буюу түүнийг соёрхон батлахдаа дээрх хугацааг хэвээр үлдээх эрхтэй.

(8) Аль ч тохиолдолд дээрх хугацааг хамгаалалт тогтоосон орны хуулиар тодорхойлно. Гэхдээ тухайн орны хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол энэ хугацаа нь уг бүтээлийн гарлын оронд тогтоосноос илүү байж үл болно.

7 bis зүйл

Хамтын бүтээлийг хамгаалах журам

Зохиогчийг нас барснаас хойш тоолох хугацааг хамтран зохиогчдоос амьд үлдсэн сүүлчийн хүн нас барснаас эхлэн тооцсон тохиолдолд өмнөх зүйлийн заалтыг уг хамтын бүтээлийн хувьд хэрэглэнэ.

8 дугаар зүйл

Орчуулах эрх

Энэхүү конвенцоор хамгаалагдсан утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогч нь жинхэнэ эх бүтээлийн хувьд өөрийн эрх эдлэх бүх хугацааны туршид түүнийг өөрөө орчуулах, орчуулахыг зөвшөөрөх онцгой эрхтэй.

9 дүгээр зүйл

Хуулбарлах эрх: 1.Нийтлэг үндэслэл; 2. Гарч болох онцгой тохиолдол;

3. Дууны болон дүрс бичлэг

(1) Энэхүү конвенцоор хамгаалагдах утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогч нь уг бүтээлийг аливаа хэлбэрээр хуулбарлахыг зөвшөөрөх онцгой эрх эдлэнэ.

(2) Ийм бүтээлийг хэвийн ашиглахад хохиролгүйгээр, мөн зохиогчийн хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр хохироохгүйгээр зарим онцгой тохиолдолд хуулбарлахыг зөвшөөрсөн заалт хууль тогтоомжоороо тогтоох эрхтэй.

(3) Энэхүү конвенцийн агуулгын үүднээс аливаа дууны ба дүрс бичлэг нь бүтээлийг хуулбарласанд тооцно.

10 дугаар зүйл

Бүтээлийг чөлөөтэй ашиглах тодорхой тохиолдол;

1.Ишлэл; 2.Сургалтад ашиглах тайлбар зураг, эх сурвалж, зохиогчийн нэрийг заах

(1) Хэвлэлийн тоймд сонин, сэтгүүлийн нийтлэлээс хэсэгчлэн ашиглах зэргээр зорилгодоо тохирсон хэмжээгээр уламжлалт заншлыг баримтлан хууль ёсоор нийтийн хүртээл болгосон бүтээлээс ишлэл хийж болно.

(2) Шударга ёсыг баримтлан утга зохиол, урлагийн бүтээлийг зорилгодоо тохирсон хэмжээгээр ном хэвлэл, радио-телевизийн нэвтрүүлэг, дууны бичлэг буюу сургалтын чанартай үзүүлэнд ашиглахыг холбооны гишүүн орны хууль тогтоомж болон тэдний хооронд байгуулсан эсхүл байгуулах тусгай хэлэлцээрээр зөвшөөрч болно.

(3) Өмнөх хэсэгт дурдсанаар бүтээл ашиглахдаа эх сурвалж болон зохиогчийн нэрийг дурдана.

10 bis зүйл

Бүтээлийг чөлөөтэй ашиглаж болох бусад тохиолдол.

1. Эфирт дамжуулсан тодорхой нийтлэл, бүтээл; 2. Цаг үеийн үйл явцад

үзүүлсэн буюу сонордуулсан бүтээл

(1) Эдийн засаг, улс төр болон шашны тулгамдсан асуудлаар сонин, сэтгүүлд нийтлэгдсэн өгүүлэл, түүнчлэн эфирт дамжуулсан ийм төрлийн бүтээлийн зохиогчийн эрхийг онцлон заагаагүй бол түүнийг сонин хэвлэлд дахин хэвлэх, эфирт буюу утсан холбоогоор дамжуулах зэргээр хуулбарлан ашиглаж нийтийн хүртээл болгохыг холбооны гишүүн орон хууль тогтоомжоороо тодорхойлох эрхээ хадгална. Гэхдээ эх сурвалжийг заавал тодорхой дурьдах бөгөөд энэ үүргийг зөрчсөний эрх зүйн үр дагаврыг хамгаалалт тогтоосон орны хууль тогтоомжоор тодорхойлно.

(2) Түүнчлэн цаг үеийн үйл явдлын явцад үзүүлсэн буюу сонордуулгын чанар агуулсан утга зохиол, урлагийн бүтээлийг мэдээллийн зорилгод тохирох хэмжээгээр гэрэл зураг, дүрс бичлэг үзүүлэх, эфирт буюу утсан холбоогоор дамжуулах зэргээр дахин ашиглаж нийтэд мэдээлэх нөхцөлийг холбооны гишүүн орон хууль тогтоомжоороо тодорхойлох эрхээ хадгална.

11 дүгээр зүйл

Жүжгийн болон хөгжмийн бүтээлийг ашиглах тодорхой эрх:

1.Нийтийн өмнө тоглох, тоглуулахаар өгөх эрх; 2.Орчуулгын талаар

(1) Жүжгийн, хөгжимт-жүжгийн ба хөгжмийн бүтээлийн зохиогч нь

(i) аливаа арга хэрэгслээр өөрийн бүтээлийг нийтийн өмнө тоглох;

(ii) өөрийн бүтээлийг аливаа арга хэрэгслээр дамжуулан нэвтрүүлж нийтийн хүртээл болгох зөвшөөрөл олгох онцгой эрхийг эдэлнэ.

(2) Жүжгийн буюу хөгжимт-жүжгийн бүтээлийн зохиогч нь түүнийг бусад хэл рүү орчуулах талаар жинхэнэ эх зохиолын хувьд эдлэх эрхийн хугацаа дуустал мөн ийм эрх эдэлнэ.

11 bis зүйл

Эфирт дамжуулах ба үүнтэй холбогдсон эрх;

1.Эфирт дамжуулах болон утасгүй холбооны бусад арга хэрэгслээр дамжуулах,

эфирт дамжуулсан бүтээлийг утсан холбоогоор дамжуулах буюу

эфирт дахин дамжуулах замаар нийтийн хүртээл болгох, эфирт дамжуулсан бүтээлийг чанга яригч болон ийм төрлийн бусад хэрэгслээр нийтийн хүртээл болгох

2.Албадан олгох лиценз; 3. Бичлэг: богино хугацаанд ашиглах бичлэг

(1) Утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчид нь дараахь зүйлийг зөвшөөрөх онцгой эрхийг эдэлнэ:

(i) өөрийн бүтээлийг эфирт дамжуулах, буюу тэмдэг, авиа, дүрсийг утасгүй холбоогоор дамжуулах аливаа бусад арга хэрэгслээр нийтийн хүртээл болгох;

(ii) анхны байгууллагаас өөр байгууллага урьд эфирт цацсан бүтээлийг утсан буюу утасгүй холбооны аливаа хэрэгслээр давтан дамжуулж олонд хүртээх;

(iii) эфирт дамжуулсан бүтээлийг чанга яригч болон тэмдэг, авиа буюу дүрс дамжуулах аливаа бусад хэрэгслийн тусламжтайгаар нийтэд хүртээх.

(2) Дээрх хэсэгт дурьдсан эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг холбооны гишүүн орны хууль тогтоомжоор тодорхойлж болох бөгөөд энэхүү нөхцөл, шаардлага нь гагцхүү тухайн орны хувьд үйлчилнэ. Аль ч тохиолдолд энэхүү нөхцөл нь зохиогчийн эд хөрөнгийн бус амины эрх, түүнчлэн хэлэлцээр байгуулаагүй тохиолдолд бол зохих эрх бүхий байгууллагаас тогтоосон шударга шагнал авах эрхийг хохироож үл болно.

(3) (1) дэх хэсэгт заасан зөвшөөрөл нь хэрэв өөрөөр тогтоогоогүй бол эфирт дамжуулсан бүтээлийг дууны болон дүрс бичлэгийн хэрэгсэлд буулгаж авах зөвшөөрөл болохгүй. Гэхдээ радиогийн өргөн нэвтрүүлгийн байгууллага өөрийн хэрэгслээр өөрийн нэвтрүүлэгт зориулан богино хугацаанд ашиглах бичлэг хийх журмыг холбооны гишүүн орны хууль тогтоомжоор ийм бичлэгийг гагцхүү баримтат шинжтэйн хувьд албан ёсны архивт хадгалахыг зөвшөөрч болно.

11 ter зүйл

Утга зохиолын бүтээлийн хувьд эдлэх тодорхой эрх:

1.Нийтийн өмнө унших ба холбооны хэрэгслээр дамжуулан нийтэд хүртээх;

2.Орчуулах

(1) Утга зохиолын бүтээлийг зохиогчид нь:

(i) аливаа арга хэрэгслээр өөрсдийн бүтээлийг нийтийн өмнө унших;

(ii) өөрийн бүтээлийг уншсан нэвтрүүлгийг аливаа арга хэрэгслээр дамжуулж нийтийн хүртээл болгохыг зөвшөөрөх онцгой эрхтэй.

(2) Утга зохиолын бүтээлийг зохиогч нь түүнийг орчуулах талаар жинхэнэ эх зохиолын хувьд эдлэх эрхийн үйлчлэх хугацаа дуусах хүртэл мөн ийм эрх эдэлнэ.

12 дугаар зүйл

Нэг төрөл зүйлээс нөгөөд шилжүүлэх, зохиомжлох болон

бусад нэмэлт, өөрчлөлт оруулах эрх

Утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогч нь өөрийн бүтээлд засвар оруулах, тохируулан найруулах болон бусад өөрчлөлт хийхийг зөвшөөрөх онцгой эрх эдэлнэ.

13 дугаар зүйл

Хөгжмийн бүтээл, түүнд хамаарах эх бичвэрийн бичлэг хийх эрхийг хязгаарлах

боломжийн тухай: 1.Албадан олгох лиценз, 2.Завсрын арга хэмжээ; 3.Зохиогчийн зөвшөөрөлгүйгээр гадаадаас оруулсан хувийг хураах

(1) Холбооны гишүүн орон бүр хөгжмийн бүтээлийн зохиогч, түүнтэй хамт бичлэг хийхийг зөвшөөрсөн аливаа эх бичвэрийн зохиогчдод олгох онцгой эрхийн талаар зохих тайлбар, нөхцөл өөрөө тогтоох, хэрэв байгаа бол ийм эх бичвэрээр хөгжмийн зохиолын бичлэг хийхийг зөвшөөрч болно; гэхдээ ийм тайлбар, нөхцөлийг гагцхүү түүнийг тогтоосон оронд сахин баримтлах бөгөөд хэлэлцээр байгуулаагүй үед зохих эрх бүхий байгууллагаас тогтоосон шагнал авах дээрх зохиогчдын эрхийг зөрчиж хэрхэвч үл болно.

(2) Ром хотноо 1928 оны 6 дугаар сарын 2-ны өдөр, мөн Брюссельд 1948 оны 6 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурсан конвенцийн 13 дугаар зүйлийн (3) дахь хэсгийн дагуу холбооны гишүүн аль нэг оронд бүтээсэн хөгжмийн бүтээлийн бичлэгийг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хоёр жилийн хугацаа өнгөрсний дараа тухайн оронд хөгжмийн зохиолчийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлаж болно.

(3) Энэ зүйлийн (1), (2) дахь хэсэгт заасны дагуу хийсэн бөгөөд түүнийг хууль бус гэж үздэг оронд сонирхогч талын зөвшөөрөлгүйгээр оруулсан бичлэгийг хураан авбал зохино.

14 дүгээр зүйл

Кино найруулга ба түүнд хамаарах эрх: 1.Кино зохиол болгон найруулах ба сэргээн найруулах; тараах; ийнхүү найруулсан буюу хуулбарласан бүтээлийг олны өмнө үзүүлэх ба утсан холбоогоор дамжуулан нийтэд хүртээх; 2.Кино зохиолын найруулгад засвар оруулах; 3.Албадан олгосон лицензийг үл хэрэглэх

(1) Утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогч нь:

(i) өөрсдийн бүтээлийг кино болгон найруулах, хуулбарлах, ийнхүү өөрчлөн найруулсан буюу хуулбарласан бүтээлээ тараах;

(ii) өөрчлөн найруулсан буюу хуулбарласан бүтээлээ олны өмнө тоглож үзүүлэх болон утсан холбоогоор дамжуулан нийтийн хүртээл болгохыг тус тус зөвшөөрөх онцгой эрх эдэлнэ.

(2) Кино болгон найруулсан утга зохиол, урлагийн бүтээлийг урлагийн бусад аливаа хэлбэрээр өөрчлөн найруулахад кино найруулагчаас гадна жинхэнэ эх бүтээлийн зохиогчийн зөвшөөрөл шаардагдана.

(3) Энэ тохиолдолд 13 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн заалтыг үл хэрэглэнэ.

14 bis зүйл

Кино зургийн бүтээлийн талаарх тусгай заалт: 1.Жинхэнэ эх бүтээлтэй адилтгах; 2.Эрх эзэмшигчид: бүтээл туурвихад хувь нэмэр оруулсан тодорхой хүмүүсийн зарим эрхийг хязгаарлах; 3. Бусад хувь нэмэр оруулагчид

(1) Өөрчлөн найруулах буюу хуулбарлаж болох аливаа бүтээлийн зохиогчийн эрхийг үл хөндөн кино зургийн бүтээлийг жинхэнэ эх бүтээлийн нэгэн адил хамгаалбал зохино. Кино зургийн бүтээлийн зохиогчийн эрх эзэмшигч нь өмнөх зүйлд заасан эрхийг оролцуулан жинхэнэ эх бүтээлийн зохиогчийн нэгэн адил эрх эдэлнэ.

(2) (a) Кино зургийн бүтээл, зохиогчийн эрх эзэмшигч этгээдийг хамгаалалт тогтоосон тэр орны хууль тогтоомжоор тодорхойлно.

(b) Харин кино зургийн бүтээлийг туурвихад оролцсон зохиогчдыг уг бүтээлийг зохиогчийн эрх эзэмшигчдийн тоонд оролцуулахаар хууль тогтоомждоо заасан холбооны гишүүн оронд уг бүтээлийг хуулбарлах, тараах, нийтийн өмнө тоглож үзүүлэх, утсан холбоогоор дамжуулж нийтэд хүртээх, эфирт цацах буюу бусад аргаар нийтэд таниулах, түүнчлэн түүний эх бичвэрийг дэлгэцнээ буюу хөрвүүлэх аргаар эсрэг буюу онцгой нөхцөл тогтоосноос бусад тохиолдолд татгалзах эрхгүй.

(c) Дээрх зүйлсийг хэрэглэхдээ түүнд дурьдсан үүргийг хэлэлцээр буюу түүнтэй адил бичмэл акт байгуулах эсэх тухай асуудлыг кино зургийн бүтээл туурвигчийн ажлын байр буюу байнга оршин суух газар байгаа орны хууль тогтоомжоор зохицуулна. Гэхдээ хамгаалалт тогтоосон холбооны гишүүн орон энэхүү үүргийг хэлэлцээр буюу дүйцэхүйц бичмэл актаар тодорхойлон хууль тогтоомжоор заах эрхээ хадгална. Энэ эрхийг хэрэгжүүлсэн орон энэ тухайгаа ерөнхий захиралд бичгээр мэдэгдэж, тэрээр түүнийг холбооны бусад бүх оронд нэн даруй мэдэгдэнэ.

(d) "Эсрэг буюу онцгой нөхцөл" гэдэг ойлголтод дээр дурсан үүрэгт хамаарах хязгаарлалтын бүх нөхцөл багтана.

(3) Хэрэв үндэсний хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол кино зохиол туурвигч, киноны хөгжмийг зохиогч, эх бичвэрийг зохиогч, найруулагч нарын хувьд дээрх (2) дахь хэсгийн (b) дэд хэсэгт үл хэрэглэнэ. Хэдийгээр дээр дурьдсан (2) дахь хэсгийн (b) дэд хэсгийг киноны найруулагчид хэрэглэхээр хууль тогтоомждоо заагаагүй бол холбооны гишүүн орон энэ тухайгаа ерөнхий захиралд бичгээр мэдэгдэж, тэрээр түүнийг холбооны гишүүн бусад бүх оронд нэн даруй мэдэгдэнэ.

14 ter зүйл

Урлагийн бүтээл, жинхэнэ эх бүтээлийг борлуулахад "хувь тогтоож оролцох эрх":

1.Худалдаж борлуулсны орлогоос хувь хүртэх эрх;

2.Хэрэглэх хууль тогтоомж. 3.Журам

(1) Урлагийн жинхэнэ эх бүтээл болон зохиогч, хөгжмийн зохиолчдын гар бичмэлийн жинхэнэ эхийн хувьд зохиогч өөрөө, түүний нас барсны дараа үндэсний хууль тогтоомжоор эрх олгогдсон этгээд буюу байгууллага уг бүтээлийг зохиогч өөрөө шилжүүлэн өгснөөс хойш худалдан борлуулах бүрт хувь хүртэх салшгүй эрх эдэлнэ.

(2) Хэрэв зохиогчийн харьяалах орны хууль тогтоомжоор зөвшөөрсөн бол дээрх хэсэгт заасан хамгаалалтыг холбооны гишүүн аливаа оронд хэрэглэж болох бөгөөд түүний хүрээ хязгаарыг хамгаалалт тогтоосон орны хууль тогтоомжоор зохицуулна.

(3) Хураамж авах журам болон мөнгөний хэмжээг үндэсний хууль тогтоомжоор тодорхойлно.

15 дугаар зүйл

Хамгаалах эрхийг дагаж мөрдөхөд хангах эрх:

1.Зохиогчийн нэрийг бичих буюу зохиомол нэр нь эргэлзээ үл төрүүлэх;

2.Кино бүтээлийн хувьд;

3.Нэргүй буюу зохиомол нэрээр гаргасан бүтээлийн хувьд;

4.Зохиогч нь үл мэдэгдэх хэвлэгдээгүй бүтээлийн тодорхой тохиолдолд

(1) Тухайн этгээд энэхүү конвенцоор хамгаалагдсан утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогч мөн эсэхийг тогтоож, үүний үндсэн дээр зохиогчийн эрхийн аливаа зөрчлийг холбооны гишүүн оронд шүүхээр хэлэлцэн шийдвэрлэхийн тулд уг зохиогчийн нэрийг тухайн бүтээл дээр ердийн журмаар бичиж хэвлэсэн байвал хангалттай. Зохиогчийн сонгосон зохиомол нэр нь түүний талаар ямар ч эргэлзээ төрүүлэхгүй тохиолдолд энэхүү хэсгийн заалтыг хэрэглэж болно.

(2) Үүний эсрэг нотолгоо байхгүй бол кино зохиол дээр ердийн байдлаар нэр нь бичиж тэмдэглэгдсэн хувь хүн, хуулийн этгээдийг уг бүтээл туурвигчид тооцно.

(3) Дээрх (1) дэх хэсэгт зааснаас бусад нэргүй буюу зохиомол нэрээр гаргасан бүтээл дээр заасан хэвлэн нийтлэгч, хэрэв өөр эсрэг нотолгоо байхгүй бол, зохиогчийн эрхийг хамгаалж, түүний хэрэгжилтийг

хангах бүрэн эрхтэй. Зохиогч жинхэнэ нэрээ илчилж уг бүтээлийн зохиогчийн эрхээ мэдэгдсэн үед тухайн хэсгийн заалт дуусгавар болно.

(4) (а) Хэвлэгдэж гараагүй бүтээлийн зохиогч нь үл мэдэгдэх боловч тэрээр холбооны гишүүн аль нэг оронд харьяат гэж үзэх бүрэн үндэслэлтэй бол энэхүү орны хууль тогтоомжоор уг зохиогчийг төлөөлөн түүний эрхийг хамгаалж, холбооны гишүүн оронд эрхийн хэрэгжилтийг хангах эрх мэдэл бүхий байгууллагыг тохоон томилж болно.

(b) Энэ заалтын дагуу ийм байгууллага тохоон томилсон холбооны гишүүн орон нь энэ тухайгаа ерөнхий захиралд бичгээр мэдэгдэж, уг байгууллагын тухай бүрэн тодорхой танилцуулна. ерөнхий захирал үүнийг холбоонд орсон бусад бүх оронд нэн даруй мэдэгдэнэ.

16 дугаар зүйл

Хууль бусаар хуулбарлаж тараасан бүтээл:

- 1.Хураах;
- 2.Хилээр оруулахад хураах;
- 3.Хэрэглэх хууль тогтоомж

(1) Бүтээлийг эрх зүйн хамгаалалтад авсан холбооны гишүүн аль ч оронд хууль бусаар хуулбарлан тараасан уг бүтээлийн хувийг хураан авбал зохино.

(2) Түүнчлэн өмнөх хэсгийн заалт нь аливаа бүтээлийг хамгаалалтад аваагүй буюу хамгаалалтын хугацаа дууссан оронд хуулбарласан хувиудад нэгэн адил хамаарна.

(3) Хураах ажиллагааг орон бүрийн хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.

17 дугаар зүйл

Бүтээлийг тараах, тоглох, үзүүлэхэд хяналт тавих боломж

Энэхүү конвенцийн дагуу эрх бүхий байгууллага уг эрхийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн бол аливаа бүтээлийг тараах, тоглох, үзүүлэхэд хууль тогтоомжоор буюу журмаар хяналт тавих, эсхүл хориглоход холбооны гишүүн аль ч орны засгийн газрын эрхийг ямар нэгэн байдлаар хөндөхгүй.

18 дугаар зүйл

Конвенцийг хүчин төгөлдөр болох үед түүнд хамаарах бүтээл:

- 1.Гарлын оронд хамгаалах хугацаа дуусаагүй бүтээлийг хамгаалах;
- 2.Хамгаалалт тогтоосон орны хамгаалах хугацаа дууссан бүтээлийг хамгаалахгүй байх;
- 3.Эдгээр зарчмыг хэрэглэх;
- 4.Тусгай тохиолдол

(1) Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болох үед гарлын орны хамгаалалтын хугацаа дуусаагүйн улмаас нийтийн хүртээл болоогүй байсан бүх бүтээлийн талаар энэхүү конвенцийн заалтыг хэрэглэнэ.

(2) Хэрэв ямар нэгэн бүтээлийн өмнөх хамгаалалтын хугацаа дуусаж хамгаалалт тогтоосон оронд нийтийн хүртээл болсон бол түүнийг тухайн оронд дахин хамгаалалтад авахгүй.

(3) Дээр дурдсан зарчмыг холбооны гишүүн орны хооронд энэ зорилгоор байгуулсан буюу байгуулах хэлэлцээрийн дагуу хэрэгжүүлнэ. Ийм хэлэлцээр байгуулаагүй тохиолдолд зохих орон бүр уг зарчмыг хэрэглэх нөхцөлийг тус тусдаа тогтооно.

(4) Холбооны гишүүн аль нэг орон шинээр элссэн, түүнчлэн 7 дугаар зүйлд заасны дагуу хамгаалалтын хүрээ өргөжсөн болон тайлбараасаа татгалзсан тохиолдолд дээрх заалтыг нэгэн адил хэрэглэнэ.

19 дүгээр зүйл

Конвенцид зааснаас илүү өргөн хамгаалалт

Холбооны гишүүн аль нэг орон илүү өргөн хүрээтэй хамгаалалтыг хууль тогтоомжоороо тогтооход энэхүү конвенцийн заалт саад болохгүй.

20 дугаар зүйл

Холбооны гишүүн орны хооронд байгуулах тусгай хэлэлцээр

Холбооны гишүүн орны засгийн газар энэхүү конвенцид тусгаснаас илүү өргөн хүрээтэй эрх зохиогчдоод олгох буюу энэхүү конвенцид үл харшлах бусад заалт агуулсан тусгай хэлэлцээр хоорондоо байгуулах эрхээ хадгалан үлдэнэ. Эдгээр шаардлагыг хангаж байгуулсан хүчин төгөлдөр хэлэлцээрийн заалтыг биелүүлбэл зохино.

21 дүгээр зүйл

Хөгжиж буй оронд хамаарах тусгай заалт:

- 1.Нэмэлт бүлгийг иш татах;
- 2.Нэмэлт бүлэг энэхүү конвенцийн нэгэн хэсэг

(1) Хөгжиж буй оронд хамаарах тусгай заалтыг нэмэлт бүлэгт тусгасан болно.

(2) Энэхүү конвенцийн 28 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт зааснаар нэмэлт нь энэхүү конвенцийн салшгүй хэсэг болно.

22 дугаар зүйл

Ассамблей:

1. Ассамблейг байгуулах, түүний бүрэлдэхүүн; 2.Зорилт;
- 3.Кворум, санал хураалт, ажиглагчид;
- 4.Зарлан хуралдуулах; 5.Ажиллагааны журам

(1) (ай) Холбоо нь 22-26 дугаар зүйлийг дагаж мөрдөх холбооны гишүүн орнуудаас бүрдсэн Ассамблейтай байна.

(b) Орон бүрийн засгийн газрыг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэрээр орлогч, зөвлөгч, шинжээчтэй байж болно.

(c) Төлөөлөгч тус бүрийн зардлыг түүнийг томилсон засгийн газар хариуцна.

(2) (a) Ассамблей нь:

(i) холбоог удирдах, хөгжүүлэх болон энэхүү конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бүх асуудлыг эрхэлнэ;

(ii) Дэлхийн оюуны өмчийн байгууллага (цаашид “байгууллага” гэнэ) байгуулах тухай конвенцид заасан Оюуны өмчийн олон улсын товчоонд (цаашид “олон улсын товчоо” гэнэ) хянан өөрчлөх бага хурлын бэлтгэл ажлын талаар чиглэл өгөх бөгөөд ингэхдээ 22-26 дугаар зүйлийг заавал дагаж мөрдөхгүй холбооны гишүүн орнуудын саналд зохих анхаарал тавина;

(iii) байгууллагын ерөнхий захирлаас холбооны талаар явуулсан үйл ажиллагааны тайланг хянаж батлах, холбооны эрх мэдэлд багтах бүх асуудлаар шаардлагатай бүх зааврыг түүнд өгнө;

(iv) Ассамблейн гүйцэтгэх хорооны гишүүдийг сонгоно;

(v) гүйцэтгэх хорооны тайлан болон үйл ажиллагааг хянаж баталж, түүнд чиглэл өгнө;

(vi) холбооны хөтөлбөрийг тодорхойлж, хоёр жилийн төсөв болон түүний санхүүгийн тайланг батална;

(vii) холбооны санхүүгийн дотоод журмыг батална;

(viii) холбооны зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзэх шинжээчдийн хороо, ажлын хэсэг байгуулна;

(ix) холбооны гишүүн бус ямар орон, түүнчлэн ямар засгийн газар хоорондын болон олон улсын засгийн газрын бус байгууллагыг түүний чуулганд ажиглагчаар оролцуулж болохыг тодорхойлно;

(x) 22-26 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлтийг батална;

(xi) холбооны зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн аливаа шаардлагатай бусад арга хэмжээ авна;

(xii) энэхүү конвенцийн дагуух бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ;

(xiii) Ассамблей өөрөө зөвшөөрсөн нөхцөлд байгууллага байгуулах тухай конвенцоор тогтоосон эрхийг хэрэгжүүлнэ.

(b) Түүнчлэн Ассамблей нь байгууллагын зохицуулах хорооны саналыг сонсоод байгууллага захиргааны үүргийг гүйцэтгэдэг бусад холбооны сонирхсон асуудлаар шийдвэр гаргана;

(3) (a) Ассамблейн гишүүн орон бүр нэг санал өгөх эрхтэй.

(b) Ассамблейн гишүүн орны тэн хагас нь кворум бүрдүүлнэ.

(c) (b) дэд хэсгийг үл харгалзан аль нэг чуулганд Ассамблейн нийт гишүүн орны тэн хагасаас бага боловч гуравны нэг буюу түүнээс илүү гишүүн орон төлөөлөгчдөө ирүүлсэн бол Ассамблей өөрийн ажиллагааны журамд хамаарахаас бусад бүх шийдвэр гаргаж болно. Ийм шийдвэрийг гагцхүү дор дурдсан нөхцөл бүрдсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно. Олон улсын товчоо нь чуулганд оролцоогүй Ассамблейн гишүүн орнуудад дээр дурдсан шийдвэрийг илгээж, уг шийдвэрийг илгээснээс хойш гурван сарын дотор эдгээр шийдвэрт санал өгч, түдгэлзсэн эсэх тухай саналаа бичгээр ирүүлэхийг хүснэ. Тогтоосон хугацаа өнгөрөх үед энэ журмаар саналаа өгсөн буюу түдгэлзсэнээ мэдэгдсэн орны тоо чуулганд хүчинтэй болоход дутуу байсан тоонд хүрч байвал зохих олонхи байна гэж үзэж шийдвэр хүчин төгөлдөр болно.

(d) 26 дугаар зүйлийн (2) дахь хэсгийг хэрэглэх тохиолдолд Ассамблей нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар шийдвэрээ гаргана.

(e) Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.

(f) Төлөөлөгч зөвхөн нэг орныг төлөөлж, зөвхөн түүний нэрийн өмнөөс санал өгнө.

(g) Ассамблейн гишүүн бус холбооны гишүүн орны төлөөлөгчдийг түүний чуулганд ажиглагчаар оролцуулна;

(4) (a) Онцгой тохиолдлоос бусад тохиолдолд ерөнхий захирал Ассамблейн ээлжит чуулганыг байгууллагын Ерөнхий Ассамблейн чуулдаг газарт болон хугацаанд хоёр жилд нэг удаа зарлан хуралдуулна.

(b) Ерөнхий захирал гүйцэтгэх хорооны буюу Ассамблейн гишүүн орны дөрөвний нэгийн хүсэлтийн дагуу онцгой чуулганыг зарлан хуралдуулна.

(5) Ассамблей өөрийн ажиллагааны журмыг батална.

23 дугаар зүйл

Гүйцэтгэх хороо:

1. Байгуулах; 2. Бүрэлдэхүүн;
- 3.Гишүүдийн тоо; 4.Газар зүйн байршил; тусгай хэлэлцээр;
- 5.Улиран сонгох хугацаа, хязгаар, сонгуулийн дүрэм;
- 6.Зорилт, 7.Зарлан хуралдуулах;
- 8.Кворум, санал хураах;
- 9.Ажиглагчид; 10.Ажиллагааны журам

(1) Ассамблей гүйцэтгэх хороотой байна.

(2) (а) Гүйцэтгэх хороо нь Ассамблей Ассамблейн гишүүн орнуудаас сонгосон орнуудаас бүрдэнэ. Байгууллагын төв байр нутаг дэвсгэр дээр нь байрладаг орон 25 дугаар зүйлийн (7) дахь хэсгийн (b) дэд хэсгийн дагуу гүйцэтгэх хороонд нэг суудалтай байна.

(b) Гүйцэтгэх хорооны гишүүн орны засгийн газрыг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэрээр орлогч, зөвлөх, шинжээчтэй байж болно.

(c) Төлөөлөгч тус бүрийн зардлыг түүнийг томилсон засгийн газар хариуцна.

(3) Гүйцэтгэх хорооны гишүүн орны тоо нь Ассамблейн гишүүн нийт орны дөрөвний нэгтэй тэнцүү байна. Эзэлбэл зохих суудлын тоог тодорхойлохдоо дөрөвт хуваасны дараахь үлдэгдлийг тооцоонд авахгүй.

(4) Гүйцэтгэх хорооны гишүүдийг сонгохдоо Ассамблей газар зүйн шударга хуваарилалт болон холбоотой байгуулсан тусгай хэлэлцээрт оролцогч орнууд гүйцэтгэх хороог бүрдүүлж буй орнуудын тоонд багтах шаардлагад зохих анхаарлыг хандуулна.

(5) (a) Гүйцэтгэх хорооны гишүүн бүр түүнийг сонгосон Ассамблейн чуулган хааснаас хойш Ассамблейн дараагийн ээлжит чуулган хаах хүртэл үүргээ хэрэгжүүлнэ.

(b) Гүйцэтгэх хорооны гишүүд дахин сонгогдож болох бөгөөд гэхдээ тоо нь уг бүрэлдэхүүний гуравны хоёроос хэтэрч болохгүй.

(c) Гүйцэтгэх хорооны гишүүдийг сонгох, дахин сонгох тухай тодорхой дүрмийг Ассамблей тогтооно.

(6) (a) Гүйцэтгэх хороо:

(i) Ассамблейн хэлэлцэх асуудлын дэгийн төслийг бэлтгэнэ;

(ii) ерөнхий захирлын бэлтгэсэн холбооны хоёр жилийн төсөв, хөтөлбөрийн төслийн талаарх саналыг Ассамблейд оруулна;

(iii) /хасагдсан/;

(iv) ерөнхий захирлын ээлжит тайлан, санхүүгийн аудитын жилийн тайланг зохих саналын хамт Ассамблейд оруулна;

(v) Ассамблейн шийдвэрийн дагуу болон Ассамблейн ээлжит хоёр чуулганы хооронд буй болсон нөхцөл байдлыг харгалзан ерөнхий захирлаас холбооны хөтөлбөрийг биелүүлэх явдлыг хангахад шаардагдах бүх арга хэмжээ авна;

(vi) энэхүү конвенцийн дагуу түүнд оноосон бусад бүх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

(b) Гүйцэтгэх хороо нь захиргааны үүргийг нь байгууллага хэрэгжүүлдэг бусад холбооны сонирхолд хамаарах асуудлаар байгууллагын зохицуулах хорооны саналыг сонссоны дараа шийдвэр гаргана.

(7) (a) Ерөнхий захирал гүйцэтгэх хорооны ээлжит хуралдааныг аль болохоор байгууллагын зохицуулах хорооны хуралдгаг газарт болон хугацаагаар жилд нэг удаа зарлан хуралдуулна.

(b) Ерөнхий захирал өөрийн санаачилгаар эсхүл хорооны даргын эсхүл гүйцэтгэх хорооны гишүүдийн дөрөвний нэгийн хүсэлтийн дагуу гүйцэтгэх хорооны онцгой хуралдааныг зарлан хуралдуулна.

(8) (a) Гүйцэтгэх хорооны гишүүн орон бүр нэг санал өгөх эрхтэй.

(b) Гүйцэтгэх хорооны гишүүн орны тэн хагас нь кворум бүрдүүлнэ.

(c) Санал хураалтад оролцогсдын энгийн олонхын саналаар шийдвэр гаргана.

(d) Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.

(e) Төлөөлөгч зөвхөн нэг орныг төлөөлж, зөвхөн түүний нэрийн өмнөөс санал өгнө.

(9) Гүйцэтгэх хорооны гишүүн бус холбооны гишүүн орнуудыг хуралдаанд ажиглагчаар оролцуулна.

(10) Гүйцэтгэх хороо өөрийн үйл ажиллагааны дүрмийг батална.

24 дугаар зүйл

Олон улсын товчоо:

1. Нийтлэг зорилт, ерөнхий захирал; 2. Ерөнхий мэдээлэл; 3. Сэтгүүл;

4. Бусад оронд мэдээлэх; 5. Судалгаа, үйлчилгээ; 6. Хуралдаанд оролцох;

7. Хянан өөрчлөх бага хурал; 8. Бусад зорилт

(1) (a) Холбооны захиргааны зорилтыг Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай олон улсын конвенцоор байгуулагдсан холбооны товчоотой нэгдсэн холбооны товчоог залгамжилсан олон улсын товчоо хэрэгжүүлнэ.

(b) Түүнчлэн олон улсын товчоо холбооны төрөл бүрийн байгууллагын нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэнэ.

(c) Байгууллагын ерөнхий захирал холбооны гүйцэтгэх тэргүүн болох бөгөөд холбоог төлөөлнө.

(2) Олон улсын товчоо зохиогчийн эрхийг хамгаалахтай холбоотой мэдээллийг цуглуулж хэвлэн нийтэлнэ. Холбооны гишүүн орон бүр зохиогчийн эрхийг хамгаалахтай холбоотой өөрийн шинэ хууль, албан ёсны баримт бичгийг олон улсын товчоонд цаг алдалгүй өгнө.

(3) Олон улсын товчоо сар бүрийн хэвлэл гаргана.

(4) Олон улсын товчоо зохиогчийн эрхийг хамгаалах талаар холбооны гишүүн аль нэг орны хүсэлтээр мэдээллээр хангана.

(5) Олон улсын товчоо зохиогчийн эрхийг хамгаалах талаар судалгаа явуулж, зохиогчийн эрхийг хамгаалах асуудлыг дэмжихийг чиглэсэн үйлчилгээ үзүүлнэ.

(6) Ерөнхий захирал болон түүний томилсон аливаа этгээд Ассамблей, гүйцэтгэх хорооны болон аливаа бусад шинжээчдийн хороо, ажлын хэсгийн бүх хуралдаанд санал өгөх эрхгүйгээр оролцоно. Ерөнхий

захирал болон түүний томилсон аливаа этгээд өөрийн албан тушаалын дагуу эдгээр байгууллагын нарийн бичгийн дарга байна.

(7) (a) Олон улсын товчоо Ассамблейгаас өгсөн чиглэлийн дагуу болон гүйцэтгэх хороотой хамтран конвенцийн 22-26 дугаар зүйлээс бусад заалтыг хянан өөрчлөх бага хурлын бэлтгэл ажлыг хангана.

(b) Олон улсын товчоо хянан өөрчлөх бага хурлын бэлтгэл ажилтай холбогдуулан олон улсын засгийн газар хоорондын болон олон улсын засгийн газрын бус байгууллагуудтай зөвлөлдөж болно.

(c) Ерөнхий захирал болон түүний томилсон этгээд тэдгээр бага хурлын хэлэлцүүлэгт санал өгөх эрхгүйгээр оролцож болно.

(8) Олон улсын товчоо түүнд оногдуулсан бусад бүх даалгаврыг гүйцэтгэнэ.

25 дугаар зүйл

Санхүү:

1. Төсөв; 2. Бусад холбоотой ажиллах;

3. Эх сурвалж; 4. Татвар: Өмнөх төсвийн хэмжээг үргэлжлүүлэх;

5. Хураамж ба төлбөр; 6. Эргэлтийн хөрөнгийн сан; 7. Зохицуулагч орны засгийн газраас олгох

урьдчилгаа; 8. Аудитын шалгалт

(1) (a) Холбоо төсөвтэй байна.

(b) Холбооны төсөв нь холбооны орлого, зарлага, холбооны зардлаас холбоодод хамаарах нийтийн зардлын төсөвт орох хандив, тэрчлэн байгууллагын бага хурлын төсөвт орох зардал зэргээс бүрдэнэ.

(c) Холбоонд бус харин байгууллагын удирдлаган дор ажилладаг нэг буюу хэд хэдэн бусад холбоодод хамаарах зардлыг холбоодод хамаарах нийтийн зардал гэж үзнэ. Энэхүү нийтийн зардлаас холбоонд оногдох хувь нь тэдгээр холбоод дахь холбооны сонирхлын эзлэх хэмжээтэй адил байна.

(2) Холбооны төсвийг байгууллагын удирдлаган дор ажилладаг бусад холбоодын төсөвтэй зохицуулах шаардлагыг харгалзан тогтооно.

(3) Холбооны төсөв дараахь эх үүсвэрээс санхүүжнэ:

(i) холбооны гишүүдийн татвар;

(ii) холбоонд хамаарах олон улсын товчооноос үзүүлсэн үйлчилгээний төлбөр, хураамж;

(iii) холбоонд хамаарах олон улсын товчооны хэвлэлийн борлуулалтын үнэ, түүнийг ашиглуулсны хураамж;

(iv) бэлэг, гэрээслэлээр шилжүүлсэн зүйл, татаас;

(v) түрээс, хувь болон бусад орлого.

(4) (a) Төсөвт төлөх татварын хэмжээг тогтоох зорилгоор холбооны гишүүн орон бүр тодорхой ангилалд хамаарах бөгөөд өөрийн жилийн татварыг дараахь байдлаар тогтоосон нэгжийн дагуу төлнө:

ангилал I 25

ангилал II 20

ангилал III 15

ангилал IV 10

ангилал V 5

ангилал VI 3

ангилал VII 1

(b) Аль ангилалд орохоо урьдчилан тогтоогүй бол орон бүр батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгөхийн хамт хамаарахыг байхыг хүсэж байгаа ангиллыг заана. Аливаа орон бүр өөрийн ангиллыг сольж болно. Хэрэв тухайн орон доогуур ангиллыг сонговол, энэ өөрчлөлтийн тухайгаа Ассамблейд ээлжит чуулганы үеэр мэдэгдэнэ. Уг өөрчлөлт нь тэр тухай мэдэгдсэн чуулганы дараачийн хуанлийн жилийн эхнээс хүчин төгөлдөр болно.

(c) Орон бүрийн жилийн татвар нь түүний нэгжийн тоог татвар төлж байгаа бүх орны нэгжийн нийлбэрт харьцуулах хэлбэрээр тогтоосон, холбооны төсөвт төлөх нийт татварт эзлэх хувьтай тэнцүү байна.

(d) Татварыг жил бүрийн нэгдүгээр сарын нэгнээс эхэлж төлнө.

(e) Өмнөх хоёр бүтэн жилд өгөх ёстой татварын хэмжээтэй тэнцүү буюу түүнээс дээш өртэй орон холбооны аливаа байгууллагад санал өгөх эрхгүй. Гэхдээ төлбөрийг хойшлуулсан нь онцгой болон зайлшгүй нөхцөл байдлаас үүдэлтэй гэж үзэх тохиолдолд тэрхүү хугацаанд холбооны аль нэг байгууллага тухайн оронд санал өгөх эрхээ үргэлжлүүлэн эдлэхийг зөвшөөрч болно.

(f) Хэрэв төсвийг санхүүгийн шинэ жил эхлэхээс өмнө батлаагүй бол, төсөв нь санхүүгийн журмын дагуу өмнөх жилийн төсөвтэй адил хэмжээтэй байна.

(5) Холбооны нэрийн өмнөөс олон улсын товчооны үзүүлсэн үйлчилгээний төлбөрт авах төлбөр, хураамжийн хэмжээг ерөнхий захирал тогтоож, Ассамблей болон гүйцэтгэх хороонд тайлагнана.

(6) (a) Холбоо нь холбооны гишүүн орон бүрээс өгөх нэг удаагийн төлбөрөөс бүрдэх эргэлтийн хөрөнгийн сантай байна. Хэрэв эргэлтийн хөрөнгийн сан хангалтгүй бол Ассамблей түүнийг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

(b) Дурдсан санд орон бүрийн төлөх анхны татварын хэмжээ буюу энэ санг нэмэгдүүлэхэд төлөх орон бүрийн хувь хэмжээ нь санг байгуулсан жил, эсхүл түүнийг нэмэгдүүлэх тухай шийдвэр гаргасан жилд тухайн орноос төлөх татварын хувьтай адил байна.

(с) Энэ харьцаа, төлбөрийн нөхцөлийг ерөнхий захирлын саналын үндсэн дээр болон байгууллагын зохицуулах хорооны зөвлөмжийг авсны дараа Ассамблей тогтооно.

(7) (а) Байгууллагын төв байр нь нутаг дэвсгэрт нь байрладаг оронтой байгуулах төв байрны тухай хэлэлцээрт эргэлтийн хөрөнгийн сан хүрэлцэхгүй болох тохиолдолд тухайн орон урьдчилгаа олгох тухай тусгана. Энэ урьдчилгааны хэмжээ болон урьдчилгаа олгох нөхцөлийг тусдаа байгууллага, тухайн орон хоорондын хэлэлцээрээр зохицуулна. Тэр орон урьдчилгаа өгөх үүрэг өөртөө хүлээж байгаа хугацаандаа гүйцэтгэх хороонд суудалтай байна.

(b) (а) дэд хэсэгт дурдсан орон ба байгууллага аль аль нь урьдчилгаа өгөх үүргээ бичгээр мэдэгдэх замаар цуцлах эрхтэй. Цуцлалт мэдэгдэл үйлдсэн жилийн төгсгөлөөс хойш гурван жилийн дараа хүчин төгөлдөр болно.

(8) Санхүүгийн аудитыг санхүүгийн журмын дагуу холбооны нэг буюу хэд хэдэн орон эсхүл гадны байцаагч хийнэ. Тэднийг өөрсдийнх нь зөвшөөрлөөр Ассамблей томилно.

26 дугаар зүйл

Нэмэлт, өөрчлөлт:

1.Ассамблей нэмэлт, өөрчлөлт оруулж болох заалт, санал; 2. Батлах; 3.Хүчинтэй болгох

(1) 22, 23, 24, 25 дугаар зүйл болон энэхүү зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Ассамблейн гишүүн аль ч орон, гүйцэтгэх хороо эсхүл ерөнхий захирал гаргаж болно. Ерөнхий захирал ийм саналыг Ассамблейн чуулганаар хэлэлцэхээс наад зах нь зургаан сарын өмнө Ассамблейн гишүүн орон бүрт илгээнэ.

(2) (1) дэх хэсэгт дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг Ассамблей дөрөвний гуравын олонхын саналаар батална. Гэхдээ 13 дугаар зүйл болон энэхүү хэсэгт оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг санал хураалтын тавны дөрвийн олонхын саналаар батална.

(3) (1) дэх хэсэгт дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлт нь уг нэмэлт, өөрчлөлтийг баталсан үед Ассамблейн гишүүн байсан орны дөрөвний гурав нь өөрсдийн үндсэн хуулийн журмын дагуу тэдгээр нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай бичгээр гаргасан мэдэгдлийг ерөнхий захирал хүлээж авснаас хойш нэг сарын дараа хүчин төгөлдөр болно. Дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг түүнийг хүчин төгөлдөр болох хугацаанд Ассамблейн гишүүн байсан орнууд буюу түүнээс хойш Ассамблейн гишүүн болсон бүх орон заавал дагаж мөрдөнө. Гэхдээ холбооны гишүүн орны санхүүгийн хүлээх үүргийг өндөржүүлэх талаар аливаа нэмэлт, өөрчлөлтийг тэдгээр нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл гаргасан орон л дагаж мөрдөнө.

27 дугаар зүйл

Хянан өөрчлөх:

1.Зорилго; 2. Бага хурал; 3. Батлах;

(1) Холбооны тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор энэхүү конвенцийг хянан өөрчилж болно.

(2) Энэ зорилгоор холбооны гишүүн орон бүрт ээлж дараалан холбооны гишүүн орнуудын төлөөлөгчдийг оролцуулсан бага хурлыг зохион байгуулна.

(3) 22-26 дугаар зүйлд оруулах нэмэлттэй өөрчлөлттэй холбоотой 26 дугаар зүйлийн заалтыг харгалзан энэхүү акт болон түүний нэмэлт бүлгийг хянан өөрчлөхөд санал нэгтгэй шийдвэр шаардагдана.

28 дугаар зүйл

Энэхүү актыг хүлээн зөвшөөрөх бөгөөд акт холбооны гишүүн орны хувьд хүчин төгөлдөр болох:

1.Соёрхон батлах, нэгдэн орох; зарим заалтыг хасах, заалтыг буцаан хэрэглэх;

2. 1-21 дүгээр зүйл болон нэмэлт бүлэг хүчин төгөлдөр болох;

3. 22-38 дугаар зүйл хүчин төгөлдөр болох;

(1) (а) Энэхүү актад гарын үсэг зурсан холбооны гишүүн аливаа орон түүнийг соёрхон баталж болох ба хэрэв түүнд гарын үсэг зураагүй бол түүнд нэгдэн орж болно. Батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай баримт бичгийг ерөнхий захиралд хадгалуулахаар өгнө.

(b) Холбооны гишүүн аливаа орон нэгдэн орсон тухай баримт бичиг эсхүл батламж жуух бичигтээ ийнхүү соёрхон батлах буюу нэгдэн орох нь 1-21 дүгээр зүйл болон нэмэлт бүлэгт хамаарахгүй гэдгийг мэдэгдэж болно, гэхдээ тухайн орон урьд нь нэмэлт бүлгийн VI зүйлийн (1) дэх хэсэгт заасны дагуу мэдэгдэл хийсэн бол дээр дурдсан баримт бичигт тухайн орны соёрхон батлах буюу нэгдэн орох нь зөвхөн 1-20 дүгээр зүйлд хамаарахгүй гэж мэдэгдэж болно.

(с) (b) дэд хэсэгт заасны дагуу соёрхон батлах буюу нэгдэн орох нь дээр дурдсан заалтуудад хамаарахгүйг мэдэгдсэн холбооны гишүүн аливаа орон соёрхон баталсан буюу нэгдэн орсныгоо тэдгээр зүйлд хамааруулах болсноо хожим ямар ч үед мэдэгдэж болно. Энэ мэдэгдлийг ерөнхий захиралд хадгалуулахаар өгнө.

(2) (а) Дор дурдсан хоёр нөхцөл бүрдсэнээс хойш гурван сарын дараа 1-21 дүгээр зүйл болон нэмэлт бүлэг хүчин төгөлдөр болно. Үүнд:

(i) доод тал нь холбооны гишүүн таван орон 1 дүгээр зүйлийн (b) дэд хэсгийн заалтын дагуу мэдэгдэл хийхгүйгээр энэхүү актыг соёрхон батлах буюу нэгдэн орох;

(ii) Франц, Испани, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Америкийн Нэгдсэн Улс 1971 онд 7 дугаар сарын 24-ний өдөр Парис хотноо хянан өөрчилсөн Зохиогчийн эрхийн тухай түгээмэл конвенцид нэгдэн орох.

(b) (а) дэд хэсэгт зааснаар хүчин төгөлдөр болох нь (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт дурдсан мэдэгдлийг хийхгүйгээр батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ дээр дурдсанаар хүчин төгөлдөр болохоос гурван сараас доошгүй хугацааны өмнө хадгалуулахаар өгсөн холбооны гишүүн орнуудад хамаарна.

(с) 1-21 дүгээр зүйл, нэмэлт бүлэг нь (b) дэд хэсэгт үл хамаарах бөгөөд (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт дурдсан мэдэгдлийг хийхгүйгээр энэхүү актыг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон холбооны гишүүн аливаа орны хувьд батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичигтээ хожуу хугацаа заагаагүй тохиолдолд эдгээр баримтыг бичгийг хадгалуулахаар өгснийг ерөнхий захирал мэдэгдсэн өдрөөс хойш гурван сарын дараа энэхүү конвенцийн хүчин төгөлдөр болно. Хожуу хугацаа заасан орны хувьд 1-21 дүгээр зүйл болон нэмэлт бүлэг нь тухайн заасан хугацаанд хүчин төгөлдөр болно.

(d) Энэ зүйлийн (а) дэд хэсгээс (с) дэд хэсэг хүртэл заалт нь нэмэлт бүлгийн VI зүйлийг хэрэглэхэд нөлөөлөхгүй.

(3) 22-38 дугаар зүйл нь (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт дурдсан мэдэгдэл хийж буюу хийлгүйгээр энэхүү актыг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон холбооны гишүүн аливаа орны хувьд батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичигтээ хожуу хугацаа заагаагүй бол эдгээр баримт бичгийг хадгалуулахаар өгсөн тухай ерөнхий захирал мэдэгдсэн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Хожуу хугацаа заасан орны хувьд 22-38 дугаар зүйл болон нэмэлт бүлэг нь тухайн заасан хугацаанд хүчин төгөлдөр болно.

29 дүгээр зүйл

Холбооны гишүүн бус орон хүлээн зөвшөөрөх, тэдний хувьд хүчин төгөлдөр болох;

1.Хүлээн зөвшөөрөх; 2.Хүчин төгөлдөр болох;

(1) Холбооны гишүүн бус аливаа орон энэхүү актад нэгдсэн, конвенцид оролцогч тал болон холбооны гишүүн орон болж болно. Нэгдэн орсон тухай баримт бичгийг ерөнхий захиралд хадгалуулна.

(2) (а) Энэхүү конвенц нь (b) дэд хэсэгт заасныг харгалзан холбооны гишүүн бус орны хувьд нэгдэн орсон тухай баримт бичигтээ хожуу хугацаа заагаагүй тохиолдолд түүний нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн тухай ерөнхий захирал мэдэгдсэн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Хожуу хугацаа заасан орны хувьд энэхүү конвенц нь тухайн заасан хугацаанд хүчин төгөлдөр болно.

(b) 28 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (а) дэд хэсэгт заасны дагуу 1-21 дүгээр зүйл болон нэмэлт бүлэг нь (а) дэд хэсэгт зааснаас өмнө байвал тухайн орон энэ хооронд 1-21 дүгээр зүйл, нэмэлт бүлгийн оронд энэхүү конвенцийн Брюсселийн актын 1-20 дугаар зүйлийг дагаж мөрдөнө.

29 bis зүйл

ДООБ байгуулах тухай конвенцийн 14 дүгээр зүйлийн (2) дахь хэсгийн зорилгоор энэхүү актыг хүлээн зөвшөөрсний үр дагавар

Энэхүү конвенцийн Стокгольмын актын 22-38 дугаар зүйлийг дагаж мөрддөггүй аливаа орон энэхүү актыг соёрхон баталсан, эсхүл түүнд нэгдэн орсныг Байгууллага байгуулах тухай конвенцийн 14 дүгээр зүйлийн (2) дахь хэсгийн зорилгоор Стокгольмын актын 28 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсгийн (i)-д заасан хязгаарлалттай уг актад нэгдэн орсон буюу соёрхон баталсанд тооцно.

30 дугаар зүйл

Тайлбар:

1.Тайлбар хийхийг боломжийг хязгаарлах; 2.Өмнө нь хийсэн тайлбар; орчуулгын эрхийн талаарх тайлбар; тайлбарыг хасах

(1) Энэ зүйлийн (2) дахь хэсэг, 28 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсэг, 33 дугаар зүйлийн (2) дахь хэсэг болон нэмэлт бүлгийн дагуу зөвшөөрөгдсөн тохиолдлоос бусад тохиолдолд конвенцийг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон орон энэхүү конвенцийн бүх заалтыг хүлээн зөвшөөрсөнд тооцогдож, уг конвенцоор олгосон бүх давуу эрхийг эдэлнэ.

(2) (а) Энэхүү актыг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон холбооны гишүүн аливаа орон нэмэлт бүлгийн V зүйлийн (2) дахь хэсгийг харгалзан батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай бичгээ хадгалуулахаар өгөх үед өмнө нь хийсэн тайлбараа хэвээр үлдээх тухай мэдэгдэх тохиолдолд уг тайлбараа хадгалж болно.

(b) Холбооны гишүүн бус аливаа орон энэхүү конвенцид нэгдэн орохдоо болон нэмэлт бүлгийн V зүйлийн (2) дахь хэсгийг харгалзан орчуулгын талаарх энэхүү актын 8 дугаар зүйлийн оронд 1896 онд Парист эцэслэсэн 1886 оны холбооны тухай конвенцийн 5 дугаар зүйлийн заалтыг ядаж түр хугацаанд хэрэглэх саналтай байгаагаа мэдэгдэж болох бөгөөд эдгээр заалт нь гагцхүү тухайн оронд нийтлэг хэрэглэдэг хэлнээ орчуулахад хамаарна гэдгийг ойлгон зөвшөөрсөн байвал зохино. Нэмэлт бүлгийн I зүйлийн (б) дахь хэсгийн (b) дэд хэсгийг харгалзан холбооны гишүүн аливаа орон гарлын орон нь ийм тайлбар хийсэн орон байх бүтээлийн орчуулгын бүтээлийн хувьд гарлын орон болох тухайн орны олгож буй хамгаалалттай эн тэнцүү хамгаалалтыг эдлэх эрхтэй.

(с) Аливаа орон ерөнхий захиралд мэдэгдсэнээр ийм нэмэлт тайлбараа ямар ч үед буцааж болно.

31 дүгээр зүйл

Зарим нутаг дэвсгэрт хэрэглэх:

1.Мэдэгдэл; 2.Мэдэгдлээ буцаах; 3.Хүчинтэй хугацаа;

4. Бодит байдлыг хүлээн зөвшөөрсөнд үл тооцох;

(1) Аливаа орон батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичигтээ, эсхүл үүнээс хойш ямар ч үед ерөнхий захиралд мэдэгдэх бичиг илгээх замаар энэхүү конвенцийг мэдэгдэлд дурдсан түүний олон улсын харилцаанд хариуцлагын хүрээнд хариуцдаг нутаг дэвсгэрийн бүхэлд нь эсхүл хэсэгт нь хэрэглэх тухайгаа мэдэгдэж болно.

(2) Ийнхүү мэдэгдсэн аливаа орон энэхүү конвенцийг дээр дурдсан нутаг дэвсгэрийн бүхэлд нь эсхүл хэсэгт нь хэрэглэхээ болих тухайгаа ерөнхий захиралд ямар ч үед мэдэгдэж болно.

(3) (a) (1) дэх хэсгийн дагуу хийсэн аливаа мэдэгдэл нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон нь хүчин төгөлдөр болох өдөр хүчинтэй болох бөгөөд мөн хэсгийн дагуу илгээсэн мэдэгдэх бичгийг илгээсэн тухай ерөнхий захирал мэдэгдсэнээс хойш гурван сарын дараа хүчинтэй болно.

(b) (2) дахь хэсэгт заасны дагуу илгээсэн аливаа мэдэгдэх бичиг нь уг бичгийг ерөнхий захирал хүлээн авснаас хойш арван хоёр сарын дараа хүчин төгөлдөр болно.

(4) Энэхүү зүйлийг холбооны гишүүн орон (1) дэх хэсэгт заасны дагуу мэдэгдэл хийсний нь дагуу бусад холбооны гишүүн орон энэхүү конвенцийг хэрэглэх нутаг дэвсгэрийн талаарх бодит байдлыг аяндаа хүлээн зөвшөөрсөн буюу зөвшөөрсөнд тооцно гэж үзэхгүй.

32 дугаар зүйл

Энэхүү акт болон өмнөх актыг хэрэглэх:

1.Холбооны гишүүн болсон орнуудын хооронд; 2.Холбоонд элсэж байгаа аливаа орнууд болон холбооны гишүүн орнуудын хооронд; 3.Зарим харилцаанд нэмэлт бүлгийг хэрэглэх

(1) Энэхүү акт холбооны гишүүн орнууд хоорондын харилцааны хувьд болон уг актыг хэрэглэх хүрээнд 1886 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн Бернийн конвенц болон түүнийг хянан өөрчилсөн дараагийн актыг орлоно. Энэхүү актыг соёрхон батлаагүй, эсхүл түүнд нэгдэн ороогүй холбооны орнуудын хувьд өмнөх актууд бүхэлд нь, эсхүл дээр дурдсан өгүүлбэрийн дагуу орлогдохгүй хэсгийг үргэлжлүүлэн дагаж мөрдөнө.

(2) Энэхүү актад оролцогч тал болсон холбооны гишүүн бус орон (3) дахь хэсгийг харгалзан энэхүү актыг дагаж мөрддөггүй буюу дагаж мөрддөг хэдий ч 28 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт заасны дагуу мэдэгдэл хийсэн холбооны гишүүн аливаа орны хувьд энэхүү актыг хэрэглэнэ. Тухайн орон дээр дурдсан холбооны орон тухайн орны хувьд

(i) өөрийн дагаж мөрддөг хамгийн сүүлийн актын заалтыг хэрэглэж болно;

(ii) нэмэлт бүлгийн 1 дүгээр зүйлийн (6) дахь хэсгийг харгалзан хамгаалалтынхаа хэмжээг энэхүү актад заасан түвшинд нийцүүлэх эрхтэйг хүлээн зөвшөөрнө.

(3) Нэмэлт бүлэгт заасан аливаа эрх буюу боломжийг хэрэглэсэн орон бүр уг эрх буюу боломжид хамаарах нэмэлт бүлэгт тусгасан заалтыг энэхүү актад нэгдэн ороогүй холбооны аль ч орны хувь тухайн орон дээрх заалтыг хэрэглэхийг зөвшөөрсөн нөхцөлд хэрэглэж болно.

33 дугаар зүйл

Маргаан:

1.Олон улсын шүүхийн эрх мэдэл; 2.Энэ эрх мэдлийн талаарх тайлбар;

3.Тайлбарыг хасах

(1) Энэхүү конвенцийг хэрэглэх буюу тайлбарлах талаар холбооны хоёр буюу түүнээс илүү гишүүн орны хооронд гарсан аливаа маргааныг хэлэлцээрийн замаар шийдвэрлэж чадаагүй бөгөөд дээрх орон маргаанаа өөр аргаар зохицуулах талаар харилцан тохиролцоогүй бол холбогдох орны аль нэг нь Олон улсын шүүхийн дүрмийн дагуу мэдүүлэг гаргах замаар уг маргааныг Олон улсын шүүхэд шилжүүлж болно. Мэдүүлэг гаргасан орон энэ тухайгаа олон улсын товчоонд мэдэгдэж, тэрээр энэ тухай холбооны бусад оронд сонордуулна.

(2) Аливаа орон энэхүү актад гарын үсэг зурах, эсхүл батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгөх үед (1) дэх хэсгийн заалтыг дагаж мөрдөхгүйгээ мэдэгдэж болно. Ийм орон болон холбооны гишүүн бусад аливаа орон хоорондын маргаанд (1) дэх хэсгийн заалт хамаарахгүй.

(3) Энэ зүйлийн (2) дахь хэсэгт заасны дагуу мэдэгдэл гаргасан аливаа орон ерөнхий захиралд мэдэгдсэнээр ямар ч үед уг мэдэгдлээсээ татгалзаж болно.

34 дүгээр зүйл

Өмнө нь гарсан зарим актын талаар тавих хориг:

1.Өмнөх актын талаар; 2.Стокгольмын актын протокол

(1) 29 bis зүйлийг харгалзан аль ч орон 1-21 дүгээр зүйл болон нэмэлт бүлэг хүчин төгөлдөр болсноос хойш энэхүү конвенцийн өмнөх актыг соёрхон батлах буюу түүнд нэгдэн орж үл болно.

(2) 1-21 дүгээр зүйл болон нэмэлт бүлэг хүчин төгөлдөр болсноос хойш аль ч орон Стокгольмын актын нэмэлт протоколын хөгжиж буй оронд хамаарах 5 дугаар зүйлд заасан мэдэгдэл хийж үл болно.

35 дугаар зүйл

Конвенцийн үйлчлэх хугацаа:

1.Хязгааргүй хугацаа; 2.Цуцлах боломж;

3.Цуцлалт хүчин төгөлдөр болох хугацаа; 4.Цуцлахыг хойшлуулах

(1) Энэхүү конвенцийн хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацааг хязгаарлахгүй.

(2) Аливаа орон ерөнхий захиралд мэдэгдэх замаар энэхүү актыг цуцалж болно. Ийм цуцлалт нь өмнөх бүх актад хамаарахаас гадна зөвхөн мэдэгдэл гаргасан орны хувьд хүчинтэй бөгөөд холбооны бусад орны хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

(3) Энэ цуцлалт нь ерөнхий захирал мэдэгдлийг авснаас хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

(4) Энэ зүйлд заасан цуцлах эрхийг аль ч орон холбооны гишүүн болсон өдрөөсөө хойш таван жилийн хугацаанд эдлэхгүй.

36 дугаар зүйл

Конвенцийг хэрэглэх: 1.Шаардлагатай арга хэмжээ авах үүрэг. 2.Үүрэг үүсэх үе

(1) Энэхүү конвенцид оролцогч орон бүр өөрийн Үндсэн хуулийн дагуу энэхүү конвенцийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

(2) Энэхүү конвенцид нэгдэн орж буй орон бүр тухайн үед өөрийн үндэсний хууль тогтоомжийн дагуу энэхүү конвенцийн заалтыг хэрэгжүүлж чадахуйц байвал зохино.

37 дугаар зүйл

Төгсгөлийн заалт

1.Актын хэл; 2.Гарын үсэг; 3. Баталгаажуулсан хувь; 4. Бүртгэл; 5.Мэдэгдэл

(1) (a) Энэхүү актыг англи, франц хэлээр нэг хувь үйлдэж үзэгдэх бөгөөд (2) дахь хэсгийг харгалзан ерөнхий захиралд хадгалуулна.

(b) Албан ёсны эх бичвэрийг ерөнхий захирал сонирхогч засгийн газартай зөвлөлдсөний дараа араб, испани, итали, герман, португали хэл болон Ассамблейн тодорхойлох бусад хэлээр үйлдэнэ.

(c) Аливаа эх бичвэрийг тайлбарлахад санал зөрөлдвөл франц хэлээрх эх бичвэрийг баримтална.

(2) Энэхүү акт 1972 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр хүртэл гарын үсэг зурахад нээлттэй байна. Энэ өдрийг хүртэл 1 дүгээр зүйлийн (a) дэд хэсэгт заасан хувийг Франц Улсын Засгийн газарт хадгалуулна.

(3) Ерөнхий захирал нь энэхүү актыг үзэглэсэн хоёр хувийг холбооны бүх орны засгийн газарт, түүнчлэн өөрсдийн хүссэнээр бусад аливаа орны засгийн газарт илгээнэ.

(4) Ерөнхий захирал энэхүү актыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

(5) Ерөнхий захирал нь гарын үсэг зурсан, нэгдэн орсон тухай баримт бичиг буюу батламж жуух бичгээ хадгалуулахаар ирүүлсэн эдгээр баримт бичигт дурдсан буюу 28 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсэг, 30 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (a) болон (b) дэд хэсэг, мөн 33 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасны дагуу гаргасан мэдэгдлийн тухай, энэхүү актын аливаа зүйл хүчин төгөлдөр болсон тухай, цуцалсан тухай мэдэгдэх бичиг болон 30 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (c) дэд хэсэг, 31 дүгээр зүйлийн (1), (2) дахь хэсэг, 33 дугаар зүйлийн (3) болон 38 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт заасны дагуу илгээсэн мэдэгдэл, түүнчлэн нэмэлт бүлэгт дурдсан мэдэгдлийн тухай холбооны гишүүг бүх оронд сонордуулна.

38 дугаар зүйл

Шилжилтийн заалт:

1."Таван жилийн" онцгой эрх эдлэх; 2.Холбооны товчоо;

3.Холбооны товчоог залгамжлах

(1) Энэхүү актыг соёрхон батлаагүй буюу түүнд нэгдэн ороогүй бөгөөд энэхүү конвенцийн Стокгольмын актын 22-26 дугаар зүйлийг дагаж мөрддөггүй холбооны гишүүн орон, хэрэв хүсвэл, эдгээр зүйлээр олгосон эрхийг 1975 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр хүртэл дээрх зүйлийг дагаж мөрддөгийн адил эдэлж болно. Ийм эрх эдлэхийг хүссэн аливаа орон энэ тухай ерөнхий захиралд бичгээр мэдэгдэх бөгөөд ерөнхий захирал мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн мэдэгдэл хүчин төгөлдөр болно. Эдгээр орон дээрх хугацаа хүртэл Ассамблейн гишүүнд тооцогдоно.

(2) Холбооны гишүүн бүх орон байгууллагын гишүүн болох хүртэл байгууллагын олон улсын товчоо нь холбооны товчооны үүргийг, ерөнхий захирал нь дурдсан товчооны захирлын үүргийг тус тус гүйцэтгэнэ.

(3) Холбооны гишүүн бүх оронд байгууллагын гишүүн болмогц холбооны товчооны эрх, үүрэг, эд хөрөнгө нь байгууллагын олон улсын товчоонд шилжинэ.

НЭМЭЛТ БҮЛЭГ

ХӨГЖИЖ БУЙ ОРОНД ХАМААРАХ ЗААЛТ

I зүйл

Хөгжиж буй оронд үзүүлэх хөнгөлөлт:

1.Үзүүлэх хөнгөлөлт, мэдэгдэл; 2.Мэдэгдлийн хүчинтэй байх хугацаа; 3.Хөгжиж буй орны статусыг зогсоох; 4.Нөөц хувь; 5.Тодорхой нутаг дэвсгэрийн талаарх мэдэгдэл; 6.Харилцан үйлчлэх хязгаар

(1) Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейд тогтсон практикийн дагуу хөгжиж байгаад тооцогддог аливаа орон энэхүү нэмэлт бүлгийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь болсон энэхүү конвенцийг соёрхон батлах буюу түүнд нэгдэн орохдоо өөрийн эдийн засгийн байдал болон нийгэм, соёлын хэрэгцээг цэгнэж энэхүү актад тусгасан бүх эрхийг хамгаалах заалтыг нэн даруй хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл II зүйлд заасан хөнгөлөлт буюу III зүйлд заасан хөнгөлөлт эсхүл энэ хоёр хөнгөлөлтийн аль алийг нь ашиглах тухайгаа нэгдэн орсон тухай баримт бичиг буюу батламж жуух бичгээ ерөнхий захиралд хадгалуулахдаа мэдэгдэх, эсхүл V дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт заасан хожим дуртай цагтаа сонордуулах замаар мэдэгдэж болно. Тухайн орон II зүйлд заасан хөнгөлөлтийг ашиглахын оронд V дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (a) дэд хэсгийн дагуу мэдэгдэл гаргаж болно.

(2) (a) 1-21 дүгээр зүйл, энэхүү заалт нь 28 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болсноос хойш 10 жилийн дотор энэ зүйлийн (1) дэх хэсэгт зааснаар гаргасан аливаа мэдэгдэл нь уг хугацаа

дуустал хүчин төгөлдөр байна. Ийм мэдэгдлийг дараагийн 10 жил бүтнээр буюу хэсэгчлэн сэргээж болох бөгөөд гагцхүү тухайн 10 жилийн хугацаа дуусахаас 15-аас илүүгүй, 3-аас доошгүй сарын өмнө мэдэгдэх бичгээ ерөнхий захиралд хадгалуулахаар ирүүлсэн байвал зохино.

(b) 10 жилийн хугацаа дууссанаас хойш энэ зүйлийн (1) дэх хэсгийн дагуу гаргасан аливаа мэдэгдэл нь 1-21 зүйл болон нэмэлт бүлэг хүчин төгөлдөр болсны дараа 28 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт зааснаар тухайн 10 жилийн хугацаа дуусах хүртэл хүчинтэй байна. Аливаа ийм мэдэгдлийг (a) дэд хэсгийн 2 дахь өгүүлбэрт зааснаар сэргээж болно.

(3) Энэ зүйлийн (1) дэх хэсэгт заасны дагуу хөгжиж буй оронд тооцогдож байснаа больсон холбооны гишүүн аливаа орон (2) дахь хэсэгт заасны дагуу мэдэгдлээ сэргээж болохгүйгээс гадна өөрийн мэдэгдлийг албан ёсоор буцааж авах эсэхээс үл хамааран тухайн 10 жилийн хугацаа буюу хөгжиж байгаа орон гэж тооцогдохоо больсноос хойш 3 жилийн хугацаа өнгөрснөөс хойш хэдийгээр тухайн 10 жилийн хугацаа дуусаагүй байсан ч (1) дахь хэсэгт дурдсан хөнгөлөлтийг ашиглах эрхгүй.

(4) Энэ зүйлийн (1), (2) дахь хэсгийн дагуу гаргасан мэдэгдэл хүчингүй болох үеэр энэхүү нэмэлт бүлгийн дагуу олгосон лицензээр хэвлэсэн бүтээлийн нөөц хувь өөр газар байгаа бол түүнийг тарааж дуусгана.

(5) Энэхүү актын заалтыг хүлээн зөвшөөрч үүрэг хүлээсэн аливаа орон (1) дэх хэсэгт дурдсан оронтой адилтгаж үзэх нөхцөлтэй аль нэг нутаг дэвсгэрт хамааруулан хэрэглэх тухай 31 дүгээр зүйлийн (1) дэх хэсгийн дагуу мэдэгдэл буюу мэдэгдэх бичиг хадгалуулахаар өгсөн бол дээрх нутаг дэвсгэрийн талаар (1) дэх хэсэгт дурдсан мэдэгдэл гаргах болон (2) дахь хэсэгт дурдсанаар мэдэгдлээ шинэчлэх тухай мэдэгдэх бичиг ирүүлж болно. Ийм мэдэгдэл буюу мэдэгдэх бичиг хүчин төгөлдөр байх хугацаанд дээр дурдсан нутаг дэвсгэрийн хувьд энэхүү нэмэлт бүлгийн заалтыг хэрэглэнэ.

(6) (a) аливаа орон (1) дэх хэсэгт заасан хөнгөлөлтийг ашиглах нь тус оронд анх туурвисан бүтээлийн хувьд өөр аливаа орон 1-20 дугаар зүйлийн дагуу олгох үүрэгтэй хамгаалалтаас бага хэмжээтэй хамгаалалт хийх шалтгаан болох учиргүй.

(b) V зүйлийн (1) дэх хэсгийн (a) дэд хэсгийн мэдэгдэл гаргасан орон гарлын орон болох бүтээлийн хувьд 1 зүйлийн (1) дэх хэсгийн (3)-т зааснаар хэрэглэх хугацаа дуусах өдрөөс өмнө 30 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (b) дэд хэсгийн 2 дахь өгүүлбэрт дурдсан эн тэнцүү хамгаалалт хэрэглэх эрхийг ашиглаж үл болно.

II зүйл

Орчуулгын эрхийг хязгаарлах:

1.Эрх бүхий байгууллагаас олгох лиценз; 2-4. Лиценз олгох нөхцөл; 5.Лиценз олгох зорилго; 6.Лиценз хүчингүй болох; 7.Тайлбар зургаас бүрдсэн бүтээл; 8.Ашиглалтаас хассан бүтээл; 9.Эфирт нэвтрүүлэг хийдэг байгууллагад олгох лиценз

(1) Энэ зүйлд дурдсан хөнгөлөлтийг ашиглах тухайгаа мэдэгдсэн аливаа орон хэвлэсэн буюу өөр иймэрхүү хэлбэрээр хуулбарласан бүтээлийн хувьд 8 дугаар зүйлд заасан орчуулгын онцгой эрхээ IV зүйлийг харгалзан дор дурдсан нөхцөлтэйгөөр зохих эрх бүхий байгууллагаас олгох онцгой бус, бусдад үл шилжүүлэх лицензийн тогтолцоогоор сольж болно.

(2) (a) Энэ зүйлийн (3) дахь хэсэгт заасныг харгалзан хэрэв бүтээлийг анх хэвлэн гаргаснаас хойш 3 жил буюу үндэсний хууль тогтоомжоор илүү урт хугацаа дуусах хүртэл уг бүтээлийг тухайн оронд нийтлэг хэлээр орчуулан гаргаагүй бол орчуулах эрх бүхий этгээд буюу түүний зөвшөөрөлтэйгөөр тухайн орны аливаа харьяат дээр дурдсан бүтээлийг нийтлэг хэлээр орчуулж хэвлэх буюу ижил төстэйгөөр хуулбарлан гаргах лиценз авч болно.

(b) Түүнчлэн тухайн хэл рүү орчуулсан бүх номыг борлуулж тарааж дууссан бол энэ зүйлд заасан нөхцөлөөр лиценз олгож болно.

(3) (a) Холбооны гишүүн нэг буюу хэд хэдэн хөгжингүй оронд нийтлэг бус хэлээр орчуулга хийх тохиолдолд 2 дахь хэсгийн (a)-д заасан 3 жилийн оронд нэг жилийн хугацааг хэрэглэнэ.

(b) Энэ зүйлийн (1)-д дурдсан аливаа орон нийтлэг хэл бүхий холбооны гишүүн хөгжингүй оронтой санал нэгтэй харилцан тохиролцооноор тухайн хэл дээр хийсэн орчуулгын хувьд (2) дахь хэсгийн (a) дэд хэсэгт заасан 3 жилийн нэг жилээс доошгүй богино хугацаагаар сольж болно. Харин энэ нь англи, франц, испани хэлэнд үл хамаарна. Ийнхүү харилцан зөвшилдсөн засгийн газар аливаа ийм тохиролцооны тухай ерөнхий захиралд мэдэгдэнэ.

(4) (a) Энэхүү зүйлийн заалтын дагуу гурван жилийн дараа авах лицензийг дор дурдсан өдрөөс хойш 6 сар өнгөртөл, нэг жилийн дараа авах лицензийг мөн дор дурдсан өдрөөс хойш 9 сар өнгөртөл тус тус олгож үл болно. Үүнд:

(i) лиценз авахыг хүсэгч этгээд IV дүгээр зүйлийн (1) зүйлд дурдсан шаардлагыг биелүүлсэн өдөр;

(ii) хэрэв орчуулах эрх эзэмшигч этгээдийн нэр буюу хаяг мэдэгдэхгүй байвал лиценз авахыг хүсэгч этгээд лиценз олгох эрх мэдэл бүхий байгууллагад өгсөн мэдүүлгийнхээ хуулбарыг IV зүйлийн (2) дахь хэсэгт зааснаар явуулсан өдөр болно.

(b) Мэдүүлэгт дурдсан хэлээр хийсэн орчуулгыг орчуулах эрхтэй этгээд буюу түүний зөвшөөрөлтэйгөөр дээрх 6 буюу 9 сарын хугацаанд хэвлэж гаргасан бол энэ зүйлд заасан лиценз олгохгүй.

(5) Энэ зүйлд заасны дагуу аливаа лицензийг гагцхүү сургалт буюу эрдэм шинжилгээний зорилгоор олгоно.

(6) Орчуулах эрхтэй этгээд буюу түүний зөвшөөрөлтэйгөөр аль нэг бүтээлийн орчуулгыг хэвлэн гаргаж тухайн оронд иймэрхүү төрлийн бүтээгдэхүүнд тогтоосон ердийн үнээр борлуулж байгаа бол хэл агуулгаараа ойролцоо орчуулгын талаар энэхүү зүйлд заасны дагуу олгосон лиценз хүчингүй болох бөгөөд лиценз хүчингүй болохоос өмнө хэвлэн гаргасан бүх номыг тарааж борлуулж дуусгана.

(7) Гол төлөв тайлбар зургаас бүтсэн бүтээлийн хувьд гагцхүү III зүйлд заасан нөхцөлийг нэгэн адил биелүүлэх тохиолдолд эх бичвэрийг орчуулж хэвлэн гаргах, зургийг хэвлэх гаргах лиценз олгоно.

(8) Зохиогч өөрийн бүтээлийн бүх хувийг борлуулж тараахаа больж татан авсан бол энэ зүйлд зааснаар лиценз олгож үл болно.

(9) (a) Хэвлэлийн буюу дахин хуулбарлах өөр иймэрхүү хэлбэрээр гаргасан бүтээлийг орчуулах лицензийг (1) дэх хэсэгт заасан оронд ажлын төв байр бүхий радио нэвтрүүлгийн байгууллагад Энэхүү байгууллагаас дээр дурдсан орны эрх мэдэл бүхий байгууллагад гаргасан мэдүүлгийн үндсэн дээр олгож болох бөгөөд гагцхүү доорхи дурдсан нөхцөлийг биелүүлсэн байвал зохино. Үүнд:

(i) тухайн орны хууль тогтоомжийн дагуу хэвлэсэн болон олж авсан хувиас орчуулга хийх;

(ii) гагцхүү сургалт, боловсролын зорилготой эсхүл тусгай техникийн буюу эрдэм шинжилгээний судалгааны үр дүнг тодорхой мэргэжлийн мэргэжилтэн нарт түгээн хүргэх зориулалт бүхий радио нэвтрүүлэгт тухайн орчуулгыг ашиглах;

(iii) орчуулгыг гагцхүү (ii)-т заасан зорилго бүхий тухайн орны сонсогчдод зориулан хууль зүйн дагуу явуулах нэвтрүүлэгт түүнчлэн зөвхөн ийм нэвтрүүлэгт хэрэглэхийн тулд хийсэн дуун буюу дүрс бичлэгийн тусламжтайгаар явуулах нэвтрүүлэгт хэрэглэх;

(iv) аливаа орчуулгыг арилжааны зорилгоор үл ашиглах.

(b) Энэ хэсгийн дагуу олгосон лицензийн үндсэн дээр радио нэвтрүүлгийн байгууллагаас хийсэн орчуулгын дуун буюу дүрс бичлэгийг хэрэв тухайн байгууллага зөвшөөрсөн бол (a) дэд хэсэгт дурдсан зорилго нөхцөлийг баримтлан эрх мэдэл бүхий байгууллага нь лиценз олгосон оронд ажлын түр байр нь оршдог аливаа бусад радио нэвтрүүлгийн байгууллага ашиглаж болно.

(c) Түүнчлэн энэ зүйлийн (a) хэсэгт дурдсан бүх шаардлага нөхцөлийг биелүүлсэн тохиолдолд зөвхөн системтэй сургалтад хэрэглэхээр үйлдэж гаргасан дуун ба дүрс бичлэгт орсон аливаа эх бичвэрийг орчуулах лицензийг радио нэвтрүүлгийн байгууллагад олгож болно.

(d) Энэ зүйлийн (a)-(c) дэд хэсэгт дурдсаныг харгалзан өмнөх зүйлүүдийн заалтыг тус хэсгийн дагуу лиценз олгох, хэрэгжүүлэхэд хэрэглэнэ.

III зүйл

Хуулбарлан нийтлэх эрхийг хязгаарлах:

1.Эрх мэдэл бүхий байгууллагаас олгосон лиценз; 2-5.Уг лицензийг олгох нөхцөл; 6.Лиценз хүчингүй болгох; 7.Энэ зүйлд хамаарах

(1) Энэ зүйлд дурдсан хөнгөлөлтийг ашиглах тухайгаа мэдэгдсэн аливаа орон 9 дүгээр зүйлд заасан хуулбарлан нийтлэх дархан эрхээ IV зүйлийг харгалзан дор дурдсан нөхцөлтэйгөөр зохих эрх бүхий байгууллагаас олгох онцгой бус, бусдад үл шилжүүлэх лицензийн тогтолцоогоор сольж болно.

(2) (a) Хэрэв (7) дахь хэсэгт зааснаар энэ зүйлийг хамааруулан хэрэглэх бүтээлийн хувьд:

(i) тухайн хэвлэлийг анх нийтлэн гаргасан өдрөөс эхлэн тооцох 3 дугаар зүйлд заасан хугацаа;

(ii) Мөн өдрөөс эхлэн тооцох (1) дэх хэсэгт дурдсан орны үндэсний хууль тогтоомжоор тодорхойлсон аливаа өөр урт хугацаа тус тус дууссаны дараа ийм хэвлэлийн хувийг зургаан сарын дотор тухайн оронд нийтэд буюу түүний зөвшөөрөлтэйгөөр тухайн оронд ийм төрлийн бүтээлийн хувьд тогтоосон нийтэд буюу тогтмол сургалтад зориулан ийм төрлийн хэвлэлийн тогтоосон үнээр худалдаж борлуулаагүй бол түүнээс хямд үнээр хэвлэн тарааж болно.

(b) (a) дэд хэсэгт заасны дагуу тараасан хэвлэлийн хэвлэлийн хугацаа дууссанаас хойш зөвшөөрөгдсөн хувийг 6 сарын дотор тухайн оронд нийтэд буюу сургалтад зориулан ийм төрлийн хэвлэлийн тогтоосон үнээр худалдаж борлуулаагүй бол уг хэвлэлийг хуулбарлаж нийтлэн гаргах лицензийг энэхүү зүйлд заасны нөхцөлийн дагуу олгож болно.

3) Дор дурдсанаас бусад тохиолдолд (2) дахь хэсгийн (a) дэд хэсгийн (i)-т заасан хугацаа таван жил байна. Үүнд:

(i) математик, техникийг оролцуулан байгалийн ба нарийн шинжлэх ухааны бүтээлүүдийн хувьд энэ хугацаа 3 жил байна, эсхүл

(ii) урлагийн, яруу найргийн, жүжгийн ба хөгжмийн бүтээл, түүнчлэн урлагийн номын хувьд энэ хугацаа 7 жил байна.

(4) (a) Энэ зүйлийн дагуу 3 жилийн дараа олгож болох ямар ч лицензийг:

(i) IV зүйлийн (1) дэх хэсэгт заасан шаардлагыг биелүүлсэн өдрөөс;

(ii) хэрэв дахин нийтлэх эрхтэй этгээдийн овог нэр буюу хаяг мэдэгдэхгүй байвал IV зүйлийн (2) дахь хэсэгт заасанчлан өөр этгээд лиценз олгох эрх мэдэл бүхий байгууллагад гаргасан мэдүүлгийнхээ хуулбарыг илгээсэн өдрөөс хойш 6 сар өнгөртөл олгохгүй.

(b) Хэрэв өөр урт хугацааны дараа олгох лицензийн хувьд IV зүйлийн (2) дахь хэсгийг хэрэглэж болохоор байвал мэдүүлэг, мэдэгдлийн хуулбарыг илгээсэн өдрөөс хойш 3 сар өнгөртөл ямар ч лицензийг олгож үл болно.

(с) Дээр дурдсан зургаа, гурван сарын хугацаанд тухайн хэвлэлийг (2) (а)-д зааснаар тарааж борлуулсан бол ямар ч лиценз олгохгүй.

d) Хэрэв өөр этгээд дахин хэвлэж гаргах лиценз авахыг хүссэн аливаа бүтээлийн бүх хувийг зохиогч нь өөрөө борлуулж тараахаа больж татан авсан бол ямар ч лиценз олгохгүй.

(5) Дор дурдсан тохиолдолд аливаа бүтээлийн орчуулгыг дахин хэвлэж гаргах лицензийг энэ зүйлд зааснаар олгохгүй. Үүнд:

(i) орчуулгыг орчуулга хийх эрхтэй этгээд өөрөө буюу түүний зөвшөөрөлтэйгөөр гаргаагүй;

(ii) лиценз авах хүсэлт гаргасан оронд нийтлэг бус хэлээр орчуулга хийсэн тус тус болно.

(6) Дахин хэвлэх эрхтэй этгээд буюу түүний зөвшөөрөлтэйгөөр өөр этгээд (1) дэх хэсэгт заасан оронд ийм хувийг нийтэлд буюу тогтмол сургалтад зориулан тухайн оронд гол төлөв хэрэглэдэг үнээр борлуулан тараах тохиолдолд хэрэв ийм бүтээлийг лицензээр гаргасан хэвлэлийн адил хэл дээр, агуулга ойролцоогоор гаргасан бол, энэхүү зүйлийн дагуу олгосон лиценз хүчингүй болно. Лиценз хүчингүй болохоос өмнө хэвлэн гаргасан бүх хувийг борлуулан тарааж дуусгана.

(7) (а) Энэ зүйлийн (b) дэд хэсэгт заасныг харгалзан энэ зүйлийн заалтыг зөвхөн хэвлэлийн буюу хуулбарлан гаргах иймэрхүү өөр хэлбэрээр нийтэлсэн бүтээлд хамааруулан хэрэглэнэ.

(b) Түүнчлэн энэхүү зүйл зөвхөн тогтмол сургалтад зориулан үйлдэж хууль зүйн дагуу гаргасан дууны ба дүрс бичлэг, түүнд орсон зохиогчийн эрхээр хамгаалагдах аливаа бүтээл, түүнчлэн уг бичлэгт орсон аливаа эх бичвэрийн лиценз авахыг хүссэн оронд нийтлэг хэлнээ хөрвүүлсэн орчуулга тус тус хамаарна.

IV зүйл

II, III дугаар зүйлийн дагуу олгох лицензүүдэд хамаарах нийтлэг заалт:

1-2.Лиценз олгох журам; 3.Зохиогч бүтээлийн нэрийг заах;

4. Бүтээлийн хувийг гадаадад гаргах; 5.Мэдэгдэх бичиг; 6.Нөхөн төлбөр

(1) Лиценз авахыг хүссэн этгээд орчуулга хийж хэвлүүлэх буюу ном хэвлэл хуулбарлан нийтэлж гаргах эрх бүхий этгээдэд зөвшөөрөл авахаар хандаж татгалзсан хариу авсан эсхүл зохих ёсоор хүчин чармайлт гаргасан боловч ийм эрх эдлэх этгээдийг тогтоож чадаагүйгээ тухайн оронд тогтоосон журмаар нотолж чадсан гагцхүү энэ тохиолдолд II, III зүйлийн дагуу лиценз олгоно. Хүсэлт гаргагч лиценз авахаар хандахдаа (d) дэд хэсэгт дурдсан үндэсний буюу олон улсын аль нэг мэдээллийн төвд сонордуулна.

(2) Эрх эзэмшигч этгээдийг тогтоох бололцоогүй бол лиценз авахыг хүсэгч нь лиценз олгох эрх мэдэл бүхий байгууллагад гаргасан мэдүүлгийнхээ хувийг тухайн бүтээл дээр овог нэр нь бичигдсэн хэвлэгч, түүнчлэн харилцан мэдээлэх тусгай журамд дурдсан аливаа үндэсний буюу олон улсын төвд баталгаатай агаарын шуудангаар илгээхээс гадна нийтлэгчээс мэргэжлийн үйл ажиллагааны үндсэн хэсгийн явуулдаг Засгийн газарт уламжлуулахаар ерөнхий захиралд явуулна.

(3) II буюу III дугаар зүйлийн дагуу олгосон лицензээр хэвлэн гаргасан буюу орчуулж нийтэлсэн ном, хэвлэлийн бүх хувь дээр бүтээлийн гарчиг, зохиогчийн овог нэрийг заасан байвал зохино. Орчуулж нийтлэх аль ч тохиолдолд жинхэнэ гарчгийг бүх хувь дээр хэвлэсэн байвал зохино.

(4) (а) II буюу III дугаар зүйлийн дагуу олгосон аливаа лиценз нь бүтээлийг гадаадад гаргахад үл хамаарах бөгөөд гагцхүү лиценз авсан оронд орчуулж буюу хуулбарлаж хэвлэн гаргахад хүчин төгөлдөр байна.

(b) (а) дэд хэсгийн зорилгоор гадаадад гаргах гэдгийг бүтээлийн хувийг аливаа дэвсгэр нутгаас түүний талаар I зүйлийн (5) дахь хэсгийн дагуу мэдэгдэл хийсэн оронд илгээх гэж ойлговол зохино.

(с) Англи, испани францаас бусад аливаа хэлнээ орчуулга хийх лицензийг II зүйлийн дагуу олгосон орны засгийн газрын буюу өөр байгууллага ийм лицензээр хэвлэсэн орчуулгын хувийг өөр оронд илгээхдээ дор дурдсан 4 нөхцөлийг биелүүлсэн бол (а) дэд хэсэгт заасан утгаар гадаадад гаргасан гэж үзэхгүй. Үүнд:

(i) хүлээн авагч нь лиценз олгосон оронд, эсхүл ийм харьяатуудыг нэгтгэсэн байгууллага байх;

(ii) орчуулгын хувийг гагцхүү дунд, их сургуульд буюу судалгаа, шинжилгээний зорилгоор ашиглах;

(iii) арилжааны зорилгоор бус дээрх хувийг илгээн хүлээн авагчид тараах;

(iv) эдгээр хувийг хүлээн авч буй орон нь лиценз олгосон оронтой тохиролцож түүнийг хүлээн авч тараахдаа зөвшөөрсөн бөгөөд лиценз олгосон орны засгийн газар нь ийм хэлэлцээрийн тухай ерөнхий захиралд мэдэгдсэн байх.

(5) II буюу III зүйлд заасан журмаар олгосон лицензээр хэвлэн гаргасан бүх хувь нь гагцхүү уг лицензийн хамаарах орон буюу дэвсгэр нутагт тараах ёстойг зохих хэлээр дурдаж тэмдэглэсэн мэдэгдэх бичигтэй байна.

(6) (а) Тухайн орны хэмжээнд дор дурдсан болзлыг хангах шаардлагатай арга хэмжээ авна. Үүнд:

(i) зохих хоёр орны этгээд чөлөөтэй хэлэлцээр хийхдээ гол төлөв хэрэглэдэг шан харамжийн хэмжээнд тохирох шударга нөхөн төлбөр орчуулгын эрх буюу дахин хэвлэх эрх эзэмшигч этгээдэд өгөхөөр лицензэд заасан байх;

(ii) нөхөн төлбөрийг олгох ба гуйвуулах;

Хэрэв үндэсний тусгай валютын журам байдаг бол тухайн орны эрх бүхий байгууллага олон улсын механизмын тусламжтайгаар уг нөхөн төлбөрийг чөлөөтэй хөрвөх валютаар буюу түүний эквивалентаар гуйвуулах талаар бүх хүчин чармайлтаа дайчилна.

b) Тодорхой ном хэвлэлийг зөв орчуулах буюу хуулбарлан дахин хэвлэх талаар үндэсний хууль тогтоомжоор шаардлагатай арга хэмжээ авна.

V зүйл

Орчуулгын эрхийг хязгаарлах талаар шилж сонгох боломж:

1.Үүний тулд 1886 оны актуудад заасан дотоод журам; 2. II зүйлийн дагуу дотоод журмыг өөрчилж үл болох; 3.Шилж сонгох хугацаа

(1) (а) II зүйлд заасан хөнгөлөлтийг ашиглахаар мэдэгдэх эрх бүхий аливаа орон үүний оронд энэхүү актыг соёрхон батлах буюу шууд нэгдэн орох:

(i) хэрэв энэхүү конвенцийн 30 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (а) дэд хэсэгт тухайн оронд хамаарах бол энэ зүйлд заасан журмаар орчуулах эрхийнхээ талаар мэдэгдэл хийж болно;

(ii) хэрэв тухайн орны хувьд 30 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (а) дэд хэсэгт хамаарахгүй тэр ч бүү хэл холбооны гишүүн бус бол 30 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (b) дэд хэсгийн эхний ангид заасны дагуу мэдэгдэл хийж болно.

b) Энэхүү нэмэлт бүлгийн I зүйлийн (1) дэх хэсэгт заасны дагуу тухайн орон хөгжиж буй оронд тооцогдохоо больсон бол энэ хэсгийн дагуу гаргасан мэдэгдэл нь I дүгээр зүйлийн (3) дахь хэсэгт заасны дагуу хэрэглэх хугацаа дуусах хүртэл хүчин төгөлдөр байна.

(с) Энэ хэсгийн дагуу мэдэгдэл гаргасан аливаа орон уг мэдэгдлийг буцааж авсан тохиолдолд ч гэсэн II дугаар зүйлд заасан хөнгөлөлтийг цаашид ашиглах эрхгүй болно.

(2) Энэ зүйлийн (3) дахь хэсгийг харгалзан II дугаар зүйлд заасан хөнгөлөлтийг ашигласан аливаа орон (1) дэх хэсгийн дагуу цаашид мэдэгдэл гаргаж үл болно.

(3) I дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт зааснаар хөгжиж буй оронд тооцохоо больсон аливаа орон I дүгээр зүйлийн (3) дахь хэсэгт зааснаар хэрэглэх хугацаа дуусахаас 2 жилийн өмнө тухайн орон холбооны гишүүн бус байлаа ч гэсэн 30 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (b) дэд хэсгийн эхний ангид заасан зорилгоор мэдэгдэл гаргаж болно.

VI зүйл

Нэмэлт бүлгийн зарим заалтыг тухайн орон түүнд нэгдэн орохоос өмнө хэрэглэж болох боломж:

1.Мэдэгдэл; 2.Мэдэгдлийг хадгалуулахаар өгөх ба хүчин төгөлдөр болох хугацаа

(1) Холбооны гишүүн аливаа орон энэхүү актыг батлагдсан өдрөөс эхлэн 1-21 дүгээр зүйл болон энэхүү нэмэлт бүлгийн дагуу үүрэг хүлээх хүртэл дараахь мэдэгдлийг гаргаж болно. Үүнд:

(i) хэрэв тухайн орон 1-21 дүгээр зүйл болон энэхүү нэмэлт бүлгээр холбоотой нь хувьд I дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт дурдсан хөнгөлөлтийг ашиглах эрхтэй бол дараахь хэсгийн дагуу II буюу III дугаар зүйлийг хэрэглэхээр ямар нэг бүтээлийн гарлын орон доорх (ii)-т заасны дагуу зөвшөөрсөн тохиолдолд II буюу III зүйлийг хэрэглэхээ мэдэгдэж болно. Ийм мэдэгдэлд II зүйлийн оронд V зүйлийг иш татаж болно;

(ii) түүнчлэн энэхүү нэмэлт бүлгийг тухайн орон гарлын орон нь болох бүтээлийн хувьд дээрх хэсэгт зааснаар мэдэгдэх бичиг илгээсэн улсуудаас хэрэглэхийг зөвшөөрч байгаага мэдэгдэж болно.

(2) дээрх (i)-т заасны дагуу, эсхүл (1) дэх хэсгийн дагуу гаргасан аливаа мэдэгдлийг бичгээр үйлдэж ерөнхий захиралд хадгалуулна. Уг мэдэгдэл нь түүнийг хадгалуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно.



ГЭРЭЭНД НЭГДЭН ОРСОН ТУХАЙ

2002 оны 5 дугаар сарын 2-ны өдөр

1 дүгээр зүйл. Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагаас 1996 онд баталсан Зохиогчийн эрхийн гэрээнд Монгол Улс нэгдэн орсныг соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР



ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ДЭЛХИЙН ОЮУНЫ ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭРЭЭ

1996 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Женев хотноо баталж,
2002 оны 3 дугаар сарын 6-ны өдөр хүчин төгөлдөр болсон

Хэлэлцэн тохирогч талууд,

утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчийн эрхийг хамгаалах асуудлыг аль болох үр ашигтай, нэгдмэл байдлаар хөгжүүлэн хангахыг хүсэж,

эдийн засаг, нийгэм, соёл, технологийн хөгжилтэй уялдан гарч буй шинэ асуудлуудыг зохистой шийдвэрлэхийн тулд олон улсын шинэ дүрэм нэвтрүүлж, одоо мөрдөгдөж байгаа тодорхой дүрмийн тайлбарыг тодруулах шаардлагыг хүлээн зөвшөөрч,

утга зохиол, урлагийн бүтээлийг туурвих, хэрэглэхэд мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, дэвшлийн онцгой нөлөөг хүлээн зөвшөөрч,

зохиогчийн эрхийг хамгаалах нь утга зохиол, урлагийн бүтээлийг туурвих хөшүүрэг болдог чухал ач холбогдлыг онцолж,

Бернийн конвенцэд тусгагдсанаар зохиогчийн эрх ба өргөн олон нийтийн ашиг сонирхол, ялангуяа боловсрол, судалгаа, мэдээлэл олж авах боломж хоорондын тэнцвэрт байдлыг хадгалахын чухлыг хүлээн зөвшөөрч,

дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Бернийн конвенцтэй холбогдох нь

(1) Энэхүү гэрээ нь Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенцийн 20 дугаар зүйлийн утга агуулгын хүрээнд, тэрхүү конвенцийн дагуу байгуулагдсан Холбоонд нэгдсэн орнууд болох хэлэлцэн тохирогч талуудын хувьд тусгай хэлэлцээр болно. Энэхүү гэрээ нь Бернийн конвенцээс өөр аливаа бусад гэрээтэй холбоогүй бөгөөд бусад гэрээгээр хүлээсэн аливаа нэг эрх, үүргийг хөндөхгүй.

(2) Энэхүү гэрээний аль ч заалт хэлэлцэн тохирогч талуудын Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенцийн дагуу бие биеийнхээ өмнө хүлээсэн үүргийг үгүйсгэхгүй.

(3) Цаашид Бернийн конвенц гэж Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенцийн 1971 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн Парисын актыг ойлгоно.

(4) Хэлэлцэн тохирогч талууд Бернийн конвенцийн 1-21 дүгээр зүйл болон хавсралтыг мөрдөнө.

2 дугаар зүйл

Зохиогчийн эрхийг хамгаалах хүрээ

Зохиогчийн эрхийн хамгаалалт нь илэрхийлэлд хамаарах бөгөөд харин санаа, үйлдэл, үйл ажиллагааны арга барил эсхүл тоон ойлголт/математикийн үзэл баримтлалд хамаарахгүй.

3 дугаар зүйл

Бернийн конвенцийн 2-6 дугаар зүйлийг хэрэглэх нь

Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээгээр олгосон хамгаалалтын хүрээнд Бернийн конвенцийн 2-6 дугаар зүйлийн заалтуудыг хэрэглэнэ.

4 дүгээр зүйл

Компьютерийн программ/Цахим тооцоолуурын хөтөлбөр

Компьютерийн программыг/цахим тооцоолуурын хөтөлбөрийг Бернийн конвенцийн 2 дугаар зүйлийн утга агуулгын хүрээнд утга зохиолын бүтээлийн нэгэн адил хамгаална. Ийм хамгаалалт нь илэрхийллийн аль ч арга, хэлбэрийг үл харгалзан компьютерийн программд/цахим тооцоолуурын хөтөлбөрт хамаарна.

5 дугаар зүйл

Мэдээллийн эмхэтгэл (Мэдээллийн сан)

Агуулгын сонголт, зохиомжийнхоо улмаас оюуны бүтээл болж буй аливаа хэлбэрийн тоон мэдээ эсхүл бусад материалын эмхэтгэлийг мөн адил хамгаална. Энэ хамгаалалт нь тоон мэдээ болон материалд өөрт нь хамаарахгүй бөгөөд эмхэтгэлд орсон аливаа тоон мэдээ, материалын эх зохиогчийн эрхийг хөндөхгүй.

6 дугаар зүйл

Түгээх эрх

(1) Утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчид нь бүтээлийнхээ жинхэнэ эх болон хуулбарыг худалдах эсхүл өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх замаар олон нийтийн хүртээл болгохыг зөвшөөрөх онцгой эрх эдэлнэ.

(2) Энэхүү гэрээний аль ч заалт зохиогчийн зөвшөөрлөөр бүтээлийн жинхэнэ эх болон хуулбарыг анх удаа худалдах эсхүл өмчлөх эрхийг бусдад шилжүүлсний дараа (1) дэх хэсэгт заасан эрхийг хэрэглэх нөхцөлийг тодорхойлох тухай хэлэлцэн тохирогч талуудын эрх чөлөөг хөндөхгүй.

7 дугаар зүйл

Түрээслэх эрх

(1) (i) Компьютерийн программ/цахим тооцоолуурын хөтөлбөр;

(ii) кино урлагийн бүтээл;

(iii) хэлэлцэн тохирогч талын үндэсний хуулиар тодорхойлсны дагуу дуу авианы бичлэгээр илэрхийлэгдэх бүтээлийн зохиогч бүтээлийнхээ жинхэнэ эх буюу хуулбарыг олон нийтэд төлбөртэй хөлслүүлэх буюу түрээслэхийг зөвшөөрөх онцгой эрх эдэлнэ.

(2) (1) дэх хэсэг хэрэглэгдэхгүй тохиолдлууд:

(i) компьютерийн программын/цахим тооцоолуурын хөтөлбөрийн хувьд, программ нь өөрөө түрээслэх зайлшгүй гол зүйл биш бол;

(ii) кино урлагийн бүтээлийн хувьд, тийнхүү төлбөртэй түрээслэх нь хуулбарлан олшруулах онцгой эрхийг ноцтойгоор хөндөж тэдгээр бүтээлийг өргөнөөр хуулбарлахад хүргээгүй бол.

(3) (1) дэх хэсгийн заалтыг үл харгалзан, 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар дуу авианы бичлэг бүхий хуулбарын хувийг түрээслэсний төлөө зохиогчид нь зохих үнэ хөлс төлдөг тогтолцоо үйлчилж байсан бөгөөд үйлчилсээр байгаа хэлэлцэн тохирогч тал тэрхүү тогтолцоог хадгалж болох бөгөөд чингэхдээ дуу авианы бичлэг бүхий бүтээлийг түрээслэх нь хуулбарлан олшруулах зохиогчийн онцгой эрхийг ноцтойгоор хөндөхгүй байвал зохино.

8 дугаар зүйл

Олон нийтэд мэдээлэх эрх

Бернийн конвенцийн 11 дүгээр зүйлийн (1) дэх хэсгийн (ii) дэд хэсэг, 11 bis зүйлийн (1) дэх хэсгийн (i) ба (ii) дэд хэсэг, 11 ter зүйлийн (1) дэх хэсгийн (ii) дэд хэсэг, 14 дүгээр зүйлийн (1) дэх хэсгийн (ii) дэд хэсэг, 14 bis зүйлийн (1) дэх хэсгийн заалтыг хөндөхгүйгээр утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчид бүтээлээ шугаман болон шугаман бус холбоогоор нийтийн хүртээл болгохыг зөвшөөрөх онцгой эрхийг эдлэх бөгөөд үүнд олон нийтийн төлөөлөгчид дээрх бүтээлтэй өөрсдийн сонгосон газар, цагт танилцаж болох боломжтой байна.

9 дүгээр зүйл

Гэрэл зургийн бүтээлийг хамгаалах хугацаа

Гэрэл зургийн бүтээлийн хувьд, хэлэлцэн тохирогч талууд Бернийн конвенцийн 7 дугаар зүйлийн (4) дэх хэсгийн заалтыг хэрэглэхгүй.

10 дугаар зүйл

Хязгаарлалт, онцгой тохиолдол

(1) Хэлэлцэн тохирогч талууд үндэсний хууль тогтоомждоо бүтээлийн хэвийн ашиглалттай зөрчилдөхгүй, мөн зохиогчийн хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр үл хөндөх тохиолдолд энэхүү гэрээний дагуу утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчид олгосон эрхэд хязгаарлалт эсхүл онцгой тохиолдол тогтоож болно.

(2) Хэлэлцэн тохирогч талууд Бернийн конвенцийг хэрэглэхдээ түүгээр тогтоосон эрхийн талаарх хязгаарлалт, онцгой тохиолдлыг бүтээлийн хэвийн ашиглалттай зөрчилдөхгүй, мөн зохиогчийн хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр үл хөндөх тохиолдолд хэрэглэнэ.

11 дүгээр зүйл

Технологийн арга хэмжээтэй холбогдох үүрэг

Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээ болон Бернийн конвенцийн дагуу эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор зохиогчийн хэрэглэж байгаа бөгөөд бүтээлийнх нь хувьд тухайн зохиогчийн зөвшөөрөлгүй буюу хуулиар зөвшөөрөгддөггүй үйлдлийг хязгаарлаж байгаа техникийн үйл ажиллагаанаас зайлсхийхийн тулд эрх зүйн зүй зохистой хамгаалалт болон хуулийн үр ашигтай арга хэмжээ авна.

12 дугаар зүйл

Эрхийн удирдлагын мэдээлэлтэй холбогдох үүрэг

(1) Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээ буюу Бернийн конвенцээр хамгаалагдсан эрхийг зөрчихөд хүргэх, боломж олгох, туслах, ийм зөрчлийг нуусныг мэдсээр байж, эсхүл иргэний арга хэмжээний хувьд дээрхийг мэдэх бодит үндэслэлтэй байж доорх аль нэг үйлдлийг санаатайгаар хийж буй аливаа этгээдийн эсрэг хуулийн зүй зохистой, үр ашигтай арга хэмжээ авна:

(i) эрхийн удирдлагын талаарх цахим мэдээллийг зөвшөөрөлгүйгээр устгах буюу өөрчлөх;

(ii) эрхийн удирдлагын талаарх цахим мэдээллийг устгасан буюу өөрчилсөн гэдгийг мэдсэн хэр нь бүтээл болон хувийг нь олон нийтэд түгээх буюу түгээхээр импортлох, нэвтрүүлэх эсхүл мэдээлэх.

(2) Энэ зүйлд заасан “эрхийн удирдлагын талаарх мэдээлэл” гэж бүтээл, бүтээлийн зохиогч, бүтээлийн аливаа эрх эзэмшигчийг тодорхойлж буй мэдээлэл эсхүл бүтээлийг ашиглах нөхцөл, болзлын талаарх мэдээлэл, мөн бүтээлийн хуулбарт тавигдсан бүтээлийг олон нийтэд мэдээлэхтэй холбоотойгоор гарч байгаа тийм мэдээллийг илэрхийлж байгаа аливаа тоо болон код мэдээг хэлнэ.

13 дугаар зүйл

Хэрэглэх хугацаа

Хэлэлцэн тохирогч талууд Бернийн конвенцийн 18 дугаар зүйлийн заалтыг энэхүү гэрээнд заасан бүх хамгаалалтад хэрэглэнэ.

14 дүгээр зүйл

Эрхийн хэрэгжилтийн заалт

(1) Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээг хэрэглэхэд шаардлагатай арга хэмжээг өөрийн хуулийн тогтолцоотой уялдуулан авах үүрэг хүлээнэ.

(2) Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээнд заасан эрхийг зөрчиж байгаа аливаа үйлдлийн эсрэг үр ашигтай арга хэмжээ авахыг зөвшөөрөхүйц эрхээр хангах журмыг өөрийн хууль тогтоомжид тусгах бөгөөд ялангуяа цаашид гарч болох зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон цаашид эрх зөрчигдөхөөс сэргийлэх арга хэмжээг өөрсдийн хууль тогтоомжид тусгана.

15 дугаар зүйл

Ассамблей

(1) (a) Хэлэлцэн тохирогч талууд Ассамблейтай байна.

(b) Хэлэлцэн тохирогч тал тус бүрийг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэрээр орлогч, зөвлөх, шинжээчтэй байж болно.

(c) Төлөөлөгч тус бүрийн зардлыг түүнийг томилсон хэлэлцэн тохирогч тал хариуцна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тогтоосон журмын дагуу хөгжиж байгаа оронд тооцогддог эсхүл зах зээлийн эдийн засагт шилжиж буй орон болох хэлэлцэн тохирогч талын төлөөлөгчдийг хуралдаанд

оролцуулахыг дэмжих зорилгоор Ассамблей санхүүгийн туслалцаа үзүүлэхийг Дэлхийн оюуны өмчийн байгууллага (цаашид “ДООБ” гэнэ)-аас хүсэж болно.

(2) (a) Ассамблей энэхүү гэрээг сахих, хөгжүүлэх, хэрэглэх, түүний үйл явцтай холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

(b) Ассамблей засгийн газар хоорондын зарим тодорхой байгууллагыг энэхүү гэрээнд элсүүлэх асуудлыг хэлэлцэхдээ 17 дугаар зүйлийн (2) дахь хэсгээр түүнд ногдуулсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

(c) Ассамблей энэхүү гэрээг хянаж өөрчлөх зорилгоор аливаа дипломат бага хурал зарлан хуралдуулах шийдвэр гаргах бөгөөд тийм дипломат бага хуралд бэлтгэхэд шаардлагатай зааварчлагыг ДООБ-ын ерөнхий захиралд өгнө.

(3) (a) Хэлэлцэн тохирогч тал болох улс нэг санал өгөх эрхтэй бөгөөд зөвхөн өөрийн нэрийн өмнөөс санал өгнө.

(b) Засгийн газар хоорондын байгууллага болох хэлэлцэн тохирогч аливаа тал энэхүү гэрээний тал болох гишүүн улсынхаа тоотой тэнцүү тоогоор гишүүн улсынхаа оронд санал өгч болно. Хэрэв аль нэг гишүүн улс саналын эрхээ өөрөө хэрэгжүүлж байгаа бол засгийн газар хоорондын аль ч байгууллага санал өгөхөд оролцохгүй бөгөөд энэ журам мөн урвуугаар үйлчилнэ.

(4) ДООБ-ын ерөнхий захирал хоёр жил тутамд нэг удаа ээлжит Ассамблейн чуулганыг зарлан хуралдуулна.

(5) Ассамблей үйл ажиллагааныхаа журмыг тогтоох бөгөөд үүнд ээлжит бус чуулган зарлан хуралдуулах, чуулганы кворум, мөн энэхүү гэрээний заалтын дагуу төрөл бүрийн асуудлаар шийдвэр гаргахад шаардлагатай олонхын хэмжээг тогтооно.

16 дугаар зүйл

Олон улсын товчоо

ДООБ-ын Олон улсын товчоо нь энэхүү гэрээтэй холбогдох захиргааны үүргийг гүйцэтгэнэ.

17 дугаар зүйл

Гэрээнд оролцогч тал болох

(1) ДООБ-ын гишүүн аливаа улс энэхүү гэрээнд оролцогч тал болж болно.

(2) Ассамблей нь энэхүү гэрээгээр зохицуулж буй асуудлын талаар тодорхой эрх мэдэлтэй бөгөөд эдгээр асуудлаар гишүүн бүх улсад нь заавал биелүүлэх өөрийн хууль тогтоомжтой, мөн энэхүү гэрээнд нэгдэн орохыг нь зохих ёсоор дотоод журмынхаа дагуу зөвшөөрч эрх олгогдсон засгийн газар хоорондын байгууллагыг гишүүнээр элсүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

(3) Европын хамтын нийгэмлэг өмнөх хэсэгт заасан мэдэгдлийг энэхүү гэрээг баталсан Дипломат бага хурлын үед хийснээр энэхүү гэрээнд оролцогч тал болж болно.

18 дугаар зүйл

Гэрээний дагуу эдлэх эрх ба үүрэг

Энэхүү гэрээнд өөрөөр тусгайлан заагаагүй бол хэлэлцэн тохирогч тал тус бүр энэхүү гэрээгээр олгосон бүх эрхийг эдлэх ба үүргийг хүлээнэ.

19 дүгээр зүйл

Гэрээнд гарын үсэг зурах

Энэхүү гэрээ ДООБ-ын гишүүн аливаа улс болон Европын хамтын нийгэмлэг гарын үсэг зурахад 1997 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл нээлттэй байна.

20 дугаар зүйл

Гэрээ хүчин төгөлдөр болох

Энэхүү гэрээ нь гуч дахь батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг ДООБ-ын ерөнхий захиралд хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

21 дүгээр зүйл

Гэрээнд нэгдэн орох хугацаа

Энэхүү гэрээний заалтыг:

(i) 20 дугаар зүйлд дурдсан гучин улс энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлж;

(ii) бусад аливаа улс ДООБ-ын ерөнхий захиралд баримт бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа;

(iii) Европын хамтын нийгэмлэг, хэрэв батламж жуух бичиг буюу нэгдэн орсон баримт бичгээ энэхүү гэрээ 20 дугаар зүйлийн дагуу хүчин төгөлдөр болсны дараа хадгалуулсан бол тийнхүү хадгалуулснаас хойш гурван сарын дараа эсхүл тус баримт бичгээ энэхүү гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө хадгалуулсан бол гэрээг хүчин төгөлдөр болсноос хойш гурван сарын дараа;

(iv) энэхүү гэрээнд нэгдэж буй засгийн газар хоорондын өөр бусад байгууллага нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулснаас хойш гурван сарын дараа тус тус заавал биелүүлэх үүрэг хүлээнэ.

22 дугаар зүйл

Тайлбар хийхгүй байх

Энэхүү гэрээнд ямар нэг тайлбар хийхийг хориглоно.

23 дугаар зүйл

Гэрээг цуцлах

Аливаа хэлэлцэн тохирогч тал энэхүү гэрээг цуцлах тухай мэдэгдлээ ДООБ-ын ерөнхий захиралд өгснөөр цуцалж болно. ДООБ-ын ерөнхий захирал дээрх мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа гэрээг цуцалсанд тооцно.

24 дүгээр зүйл

Гэрээний хэл

(1) Энэхүү гэрээг англи, араб, хятад, франц, орос, испани хэлээр нэг эх хувь үйлдэж гарын үсэг зурсан эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

(2) (1) дэх хэсэгт дурдсанаас бусад хэлээр нийтлэх албан ёсны эх бичвэрийг сонирхогч бүх талтай зөвлөлдсөний дараа сонирхогч талын хүсэлтээр ДООБ-ын ерөнхий захирал үйлдэнэ. Энэ хэсгийн зорилгоор “сонирхогч тал” гэж албан ёсны хэл эсхүл албан ёсны хэлнүүдийн аль нэгээр нь хүсэлт гаргасан ДООБ-ын гишүүн улс, мөн аль нэг албан ёсны хэлээр нь хүсэлт гаргасан Европын хамтын нийгэмлэг буюу энэхүү гэрээнд нэгдэн орж болох засгийн газар хоорондын аливаа бусад байгууллагыг хэлнэ.

25 дугаар зүйл

Хадгалагч

ДООБ-ын ерөнхий захирал энэхүү гэрээний хадгалагч байна.



МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ГЭРЭЭНД НЭГДЭН ОРСОН ТУХАЙ

2002 оны 5 дугаар сарын 2-ны өдөр

1 дүгээр зүйл. Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагаас 1996 онд баталсан Тоглолт ба дуу авианы бичлэгийн тухай гэрээнд Монгол Улс нэгдэн орсныг соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР



ТОГЛОЛТ БОЛОН ДУУ АВИАНЫ БИЧЛЭГИЙН ТУХАЙ ДЭЛХИЙН
ОЮУНЫ ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭРЭЭ

1996 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Женев хотноо баталж,
2002 оны 5 дугаар сарын 20-ны өдөр хүчин төгөлдөр болсон

Удиртгал

Хэлэлцэн тохирогч талууд,
тоглогчид болон дуу авиа бүтээгчдийн эрхийг хамгаалах асуудлыг аль болох үр ашигтай, нэгдмэл байдлаар хөгжүүлэн хангахыг хүсч,
эдийн засаг, нийгэм, соёл, технологийн хөгжилтэй уялдан гарч буй шинэ асуудлуудыг зохистой шийдвэрлэхийн тулд олон улсын шинэ дүрэм журмыг нэвтрүүлэх шаардлагыг хүлээн зөвшөөрч,
тоглолт, дуу авианы бичлэг үйлдвэрлэх, ашиглахад мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, дэвшлийн онцгой нөлөөг хүлээн зөвшөөрч,
тоглогчид болон дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн эрх ба өргөн олон нийтийн ашиг сонирхол, ялангуяа боловсрол, судалгаа, мэдээлэл олж авах боломж хоорондын тэнцвэрт байдлыг хадгалахын чухлыг хүлээн зөвшөөрч,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

I БҮЛЭГ

НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1 дүгээр зүйл

Бусад конвенцтой холбогдох нь

(1) Энэхүү гэрээний аль ч заалт хэлэлцэн тохирогч талуудын 1961 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Ром хотноо үйлдсэн Тоглогчид болон дуу авианы бичлэг үйлдвэрлэгч, нэвтрүүлэгч байгууллагын тухай олон улсын конвенц (цаашид “Ромын конвенц” гэнэ)-ийн дагуу бие биеийнхээ өмнө хүлээсэн үүргийг үгүйсгэхгүй.

(2) Энэхүү гэрээгээр олгосон хамгаалалт утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчийн эрхийг хөндөхгүй. Үүний дагуу энэхүү гэрээний аль ч заалтыг тийм хамгаалалтыг хөндөнө гэж тайлбарлаж болохгүй.

(3) Энэхүү гэрээ аливаа бусад гэрээтэй ямарваа холбоогүй бөгөөд тэдгээрт тусгагдсан эрх, үүргийг хөндөхгүй.

2 дугаар зүйл

Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү гэрээний зорилгоор:

(a) “тоглогчид” гэж утга зохиол, уран сайхны болон ардын урлагийн бүтээлийг, дуулж, хөгжимдөх, жүжиглэх, бүжиглэх, унших зэргээр гүйцэтгэн тоглодог жүжигчин, дуучин, хөгжимчин, бүжигчин болон бусад этгээдийг;

(b) “дуу авианы бичлэг” гэж кино урлагийн бүтээл эсхүл дуу, дүрс бичлэгийн бүтээлд оруулсан хэлбэрээс бусад аливаа тоглолтын болон бусад дуу авианы бичлэгийг ;

(c) “бичлэг” гэж холбогдох төхөөрөмжөөр хүлээн авч, дахин үйлдвэрлэж дамжуулж болох дуу авиа буюу түүний илэрхийллийг бодит хэлбэрт шилжүүлэн биежүүлэхийг;

(d) “дуу авианы бичлэг үйлдвэрлэгч” гэж тоглолтын буюу бусад дуу авианы эсхүл тэдгээрийн илэрхийллийн бичлэгийг анх сэдэж хийсэн, хариуцлага хүлээх хувь хүн, хуулийн этгээдийг ;

(e) бичигдсэн тоглолт буюу дуу авианы бичлэгийг “нийтлэх” гэж бичигдсэн тоглолт буюу дуу авианы бичлэгийн хувийг эрх эзэмшигчийн зөвшөөрлөөр олон нийтэд санал болгох, чингэхдээ хувийг боломжит тоогоор нийтэд гаргахыг;

(f) “нэвтрүүлэх” гэж дуу авиа буюу тэдгээрийн дүрслэлийг шугаман бус холбоогоор нийтийн хүртээл болгон дамжуулахыг; мөн тэдгээрийг сансрын хиймэл дагуулаар дамжуулахыг хэлнэ; Кодлосон дохиог нэвтрүүлэгч байгууллагаас буюу түүний зөвшөөрөлтэйгээр тайлж унших түлхүүрийг олон нийтэд дамжуулах тохиолдолд мөн “нэвтрүүлэх” гэж болно;

(g) тоглолт буюу дуу авианы бичлэгийг “нийтийн хүртээл болгох” гэж тоглолтын бичлэгт бичигдсэн дуу авиа буюу түүний дүрслэлийг нэвтрүүлэхээс бусад аливаа хэрэгслээр олон нийтэд дамжуулахыг хэлнэ. 15 дугаар зүйлийн зорилгоор “нийтийн хүртээл болгох” гэдэгт дуу авианы бичлэгт бичигдсэн дуу авиа буюу түүний дүрслэлийг олон нийтэд сонсогдохуйц илэрхийлэн гаргахыг ойлгоно.

3 дугаар зүйл

Энэхүү гэрээгээр хамгаалагдах хүмүүс

(1) Хэлэлцэн тохирогч талууд хэлэлцэн тохирогч бусад талын харьяат болох тоглолт гүйцэтгэгч, дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийг энэхүү гэрээгээр олгосон хамгаалалтад хамруулна.

(2) Хэлэлцэн тохирогч бусад талын харьяат гэдэгт хэрэв энэхүү гэрээний хэлэлцэн тохирогч бүх тал Ромын конвенцийн хэлэлцэн тохирогч тал болж байвал Ромын конвенцоор олгосон хамгаалалтыг эдлэхэд тавих шаардлагын шалгуурыг хангахуйц тоглолт гүйцэтгэгч, дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийг ойлгоно. Дээрх шаардлагын шалгуурын хувьд хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээний 2 дугаар зүйлийн холбогдох нэр томъёоны тодорхойлолтыг хэрэглэнэ.

(3) Ромын конвенцийн 5 дугаар зүйлийн (3) дахь хэсэгт эсхүл мөн конвенцийн 5 дугаар зүйлийн зорилгод Конвенцийн 17 дугаар зүйлд тусгагдсан боломжийг ашиглаж байгаа хэлэлцэн тохирогч аливаа тал тэдгээр заалтад зааснаар Дэлхийн оюуны өмчийн байгууллага (ДООБ)-ын ерөнхий захиралд мэдэгдэл өгнө.

4 дүгээр зүйл

Үндэсний журам

(1) Хэлэлцэн тохирогч тал тус бүр энэхүү гэрээгээр тусгайлан олгосон онцгой эрх, түүнчлэн энэхүү гэрээний 15 дугаар зүйлд заасан зохих үнэ хөлс авах эрхийн хувьд өөрийн харьяатдаа олгож байгаа хамгаалалтыг 3 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт тодорхойлсон хэлэлцэн тохирогч бусад талын харьяатад мөн адил олгоно.

(2) (1) дэх хэсэгт заасан үүрэг нь хэлэлцэн тохирогч нөгөө тал энэхүү гэрээний 15 дугаар зүйлийн (3) дахь хэсгээр зөвшөөрсөн тайлбарыг ашиглах хэмжээнд хэрэглэгдэхгүй.

II БҮЛЭГ

ТОГЛОГЧИЙН ЭРХ

5 дугаар зүйл

Тоглогчийн эд хөрөнгийн бус эрх

(1) Тоглогчийн эдийн засгийн эрхээс үл хамаарч, түүнчлэн тэдгээр эрхийг бусдад шилжүүлснээс ч хойш тоглогчид нь амьд тоглолт буюу дуу авианы бичлэгт бичигдсэн тоглолтынхоо хувьд, тоглолтыг ашиглах арга барилын улмаас тоглолт гүйцэтгэгч гэж нэрлүүлэхгүйгээс бусад тохиолдолд өөрийн тоглолтын тоглогчид гэж нэрлүүлэхийг шаардах эрхтэй бөгөөд нэр хүндэд нь хохирол учруулахуйцаар өөрчлөх, гажуудуулахыг хориглох эд хөрөнгийн бус эрх эдлэнэ.

(2) (1) дэх хэсгийн дагуу тоглогчид олгосон эрх нь түүнийг нас барсны дараа дор хаяж эдийн засгийн эрх нь дуустал хадгалагдах бөгөөд уг эрхийг хамгаалалт шаардагдаж буй тухайн хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн хувь хүн буюу байгууллага хэрэгжүүлнэ. Гэхдээ энэхүү гэрээг соёрхон батлах буюу нэгдэн орох үед хууль тогтоомжид нь өмнөх хэсэгт тусгасан тоглогчдын бүх эрхийг нас барснаас нь хойш хамгаалах талаар заагаагүй хэлэлцэн тохирогч талууд дээрх эрхийн заримыг тоглогчийг нас барсны дараа хадгалахгүйгээр зааж болно.

(3) Энэ зүйлээр олгосон эрхийг хангах хамгаалалтын арга хэрэгслийг нь хамгаалалт шаардагдаж буй тухайн хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжоор зохицуулна.

6 дугаар зүйл

Бичлэг хийгдээгүй тоглолтын хувьд эдлэх

тоглогчийн эдийн засгийн эрх

Тоглогч нь тоглолтынхоо хувьд:

(i) бичлэг хийгдээгүй тоглолт нь урьд нэвтрүүлж байсан тоглолтоос бусад тохиолдолд уг тоглолтоо олон нийтэд нэвтрүүлэх буюу мэдээлэх; болон

(ii) бичлэг хийгдээгүй тоглолтоо бичүүлэхийг зөвшөөрөх онцгой эрх эдлэнэ.

7 дугаар зүйл

Хуулбарлах эрх

Тоглогч нь дуу авианы бичлэгт бичигдсэн тоглолтоо шууд буюу шууд бус аль ч хэлбэрээр хуулбарлан олшруулахыг зөвшөөрөх онцгой эрх эдлэнэ.

8 дугаар зүйл

Түгээх эрх

(1) Тоглогч нь дуу авианы бичлэгт бичигдсэн тоглолтынхоо жинхэнэ эх болон хувийг худалдах эсхүл өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх замаар олон нийтийн хүртээл болгохыг зөвшөөрөх онцгой эрх эдлэнэ.

(2) Энэхүү гэрээний аль ч заалт тоглогчийн зөвшөөрлөөр бичигдсэн тоглолтын жинхэнэ эх болон хуулбарыг анх удаа худалдах эсхүл өмчлөх эрхийг бусдад шилжүүлсний дараа (1) дэх хэсэгт заасан эрхийг хэрэглэх нөхцлийг тодорхойлох талаарх хэлэлцэн тохирогч талуудын эрх чөлөөг хөндөхгүй.

9 дүгээр зүйл

Түрээслэх эрх

(1) Тоглогч нь дуу авианы бичлэгт бичигдсэн тоглолтынхоо жинхэнэ эх болон хуулбарыг өөрсдийн зөвшөөрлийн дагуу түгээсний дараа ч хэлэлцэн тохирогч талын үндэсний хуулиар тодорхойлсны дагуу олон нийтэд төлбөртэй хөлслүүлэх буюу түрээслэх онцгой эрх эдлэнэ.

(2) (1) дэх хэсгийн заалтыг үл харгалзан, 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар дуу авианы бичлэгт бичигдсэн тоглолтынхоо хувийг хөлслүүлсний төлөө тоглогчид нь зохих үнэ хөлс төлдөг тогтолцоо үйлчилж байсан бөгөөд үйлчилсээр байгаа хэлэлцэн тохирогч тал тэрхүү тогтолцоог хадгалж болох бөгөөд чингэхдээ дуу авианы бичлэгийг хөлслүүлэх нь дахин хуулбарлан олшруулах тоглогчийн онцгой эрхийг ноцтойгоор хөндөхгүй байвал зохино.

10 дугаар зүйл

Бичигдсэн тоглолтыг нийтийн хүртээл болгох эрх

Тоглогч нь дуу авианы бичлэгт бичигдсэн тоглолтоо олон нийтийн төлөөлөгчид өөрөө сонгосон газар, цагт танилцаж болохуйцаар шугаман эсхүл шугаман бус холбоогоор нийтийн хүртээл болгохыг зөвшөөрөх онцгой эрх эдлэнэ.

III БҮЛЭГ

ДУУ АВИАНЫ БИЧЛЭГ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ЭРХ

11 дүгээр зүйл

Хуулбарлах эрх

Дуу авианы бичлэг үйлдвэрлэгч нь дуу авианы бичлэгээ шууд буюу шууд бус аль ч хэлбэрээр хуулбарлан олшруулахыг зөвшөөрөх онцгой эрх эдлэнэ.

12 дугаар зүйл

Түгээх эрх

(1) Дуу авианы бичлэг үйлдвэрлэгч нь дуу авианы бичлэгийнхээ жинхэнэ эх болон хуулбарыг худалдах эсхүл өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх замаар нийтийн хүртээл болгохыг зөвшөөрөх онцгой эрх эдлэнэ.

(2) Энэхүү гэрээний аль ч заалт авианы бичлэг үйлдвэрлэгчийн зөвшөөрлөөр дуу авианы бичлэгийн жинхэнэ эх болон хуулбарыг анх удаа худалдах эсхүл өмчлөх эрхийг бусдад шилжүүлсний дараа (1) дэх хэсэгт заасан эрхийг хэрэглэх нөхцлийг тодорхойлох талаарх хэлэлцэн тохирогч талуудын эрх чөлөөг хөндөхгүй.

13 дугаар зүйл

Түрээслэх эрх

(1) Дуу авианы бичлэг үйлдвэрлэгч нь дуу авианы бичлэгийнхээ жинхэнэ эх болон хуулбарыг түүний зөвшөөрлийн дагуу түгээсний дараа ч хэлэлцэн тохирогч талын үндэсний хуулиар тодорхойлсны дагуу нийтэд төлбөртэй хөлслүүлэх буюу түрээслэх онцгой эрх эдлэнэ.

(2) (1) дэх хэсгийн заалтыг үл харгалзан, 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар дуу авианы бичлэгийнхээ хуулбарыг хөлслүүлсний төлөө дуу авианы бичлэг үйлдвэрлэгчид нь зохих үнэ хөлс төлдөг тогтолцоо үйлчилж байсан бөгөөд үйлчилсээр байгаа хэлэлцэн тохирогч тал тэрхүү тогтолцоог хадгалж болох бөгөөд чингэхдээ дуу авианы бичлэгийг хөлслүүлэх нь хуулбарлан олшруулах дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн онцгой эрхийг ноцтойгоор хөндөхгүй байвал зохино.

14 дүгээр зүйл

Дуу авианы бичлэгийг нийтийн хүртээл болгох эрх

Дуу авианы бичлэг үйлдвэрлэгч нь дуу авианы бичлэгээ олон нийтийн төлөөлөгчид өөрөө сонгосон газар, цагт танилцаж болохуйцаар шугаман буюу шугаман бус холбоогоор нийтийн хүртээл болгохыг зөвшөөрөх онцгой эрх эдлэнэ.

IV БҮЛЭГ

НИЙТЛЭГ ЗААЛТ

15 дугаар зүйл

Нийтэд нэвтрүүлсэн болон

мэдээлсний төлөө үнэ хөлс авах эрх

(1) Тоглогчид болон дуу авианы бичлэг үйлдвэрлэгч нь худалдааны зорилгоор нийтлэсэн дуу авианы бичлэгийг олон нийтэд нэвтрүүлэх буюу мэдээлэхээр шууд буюу шууд бусаар ашигласны төлөө нэг удаагийн зохих үнэ хөлс авах эрх эдлэнэ.

(2) Нэг удаагийн зохих үнэ хөлсийг тоглогч буюу дуу авианы бичлэг үйлдвэрлэгч эсхүл хоёулаа дуу авианы бичлэгийг ашигласан этгээдээс шаардахаар хэлэлцэн тохирогч талууд үндэсний хууль тогтоомждоо тогтоож болно. Тоглогч болон дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн хооронд гэрээ байгуулаагүй тохиолдолд нэг удаагийн зохих үнэ хөлсийг хуваах нөхцлийг тогтоосон үндэсний хууль тогтоомжийг хэлэлцэн тохирогч талууд батлаж болно.

(3) Хэлэлцэн тохирогч аливаа тал ДООБ-ын Ерөнхий захиралд хадгалуулсан мэдэгдэлдээ (1) дэх хэсгийн заалтыг зөвхөн зарим тодорхой тохиолдолд хэрэглэх эсхүл тэрхүү заалтыг хэрэглэхийг өөр бусад замаар хязгаарлах болон огт хэрэглэхгүй тухайгаа мэдэгдэж болно.

(4) Энэхүү зүйлийн зорилгод, олон нийтийн төлөөлөгчид өөрөө сонгосон газар, цагт танилцаж болохуйцаар шугаман ба шугаман бус холбоогоор нийтийн хүртээл болсон дуу авианы бичлэгийг худалдааны зорилгоор нийтлэсэн хэмээн үзнэ.

16 дугаар зүйл

Хязгаарлалт, онцгой тохиолдол

(1) Хэлэлцэн тохирогч талууд утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчийн эрхийг хамгаалахтай холбоотойгоор үндэсний хууль тогтоомждоо тогтоосон хязгаарлалт буюу онцгой тохиолдолтой адил заалтуудыг тоглогч буюу дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн эрхийг хамгаалах зорилгоор үндэсний хууль тогтоомждоо тусгаж болно.

(2) Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээнд тогтоосон эрхийн хязгаарлалт болон онцгой тохиолдлыг тоглолт буюу дуу авианы бичлэгийн хэвийн ашиглалттай зөрчилдөхгүй, мөн тоглогч болон дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр хөндөхгүй тохиолдолд хэрэглэнэ.

17 дугаар зүйл

Хамгаалалтын хугацаа

(1) Энэхүү гэрээгээр тоглогчдод олгох хамгаалалтын үргэлжлэх хугацаа тоглолтыг дуу авианы бичлэгт бичсэн тухайн жилийн эцсээс хойш 50 жил байна.

(2) Энэхүү гэрээгээр дуу авианы бичлэг үйлдвэрлэгчдэд олгох хамгаалалтын хугацаа дуу авианы бичлэгийг нийтлэсэн жилийн эцсээс хойш 50 жил эсхүл дуу авианы бичлэгийг бичсэнээс хойш 50 жилийн хугацаанд нийтлэгдээгүй бол бичлэг анх хийсэн жилийн эцсээс хойш 50 жилийн хугацаа дуустал үргэлжилнэ.

18 дугаар зүйл

Технологийн арга хэмжээтэй холбогдох үүрэг

Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээний дагуу эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тоглогч буюу дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн хэрэглэж байгаа бөгөөд тэдний тоглолт, дуу авианы бичлэгийнх нь хувьд тухайн тоглогч болон дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн зөвшөөрөлгүй буюу хуулиар зөвшөөрөөгүй үйлдлийг хязгаарлаж байгаа техникийн үйл ажиллагаанаас зайлсхийхийн тулд эрх зүйн зүй зохистой хамгаалалт болон хуулийн үр ашигтай арга хэмжээ авна.

19 дүгээр зүйл

Эрхийн удирдлагын мэдээлэлтэй холбогдох үүрэг

(1) Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээгээр хамгаалагдсан эрхийг зөрчихөд хүргэх, боломж олгох, зөрчихөд туслах буюу ийм зөрчлийг нуусан үйлдлийг мэдсээр байж, эсхүл иргэний арга хэмжээний хувьд дээрхийг мэдэх бодит үндэслэлтэй байж доорхи аль нэг үйлдлийг санаатайгаар хийж буй аливаа этгээдийн эсрэг хуулийн зүй зохистой, үр ашигтай арга хэмжээ авна.

(i) эрхийн удирдлагын талаарх цахим мэдээллийг зөвшөөрөлгүйгээр устгах буюу өөрчлөх;

(ii) эрхийн удирдлагын талаарх цахим мэдээллийг устгасан буюу өөрчилсөн гэдгийг мэдсэн хэрнээ тоглолт, бичигдсэн тоглолтын хуулбар буюу дуу авианы бичлэгийг олон нийтэд түгээх, түгээхээр импортлох, нэвтрүүлэх, мэдээлэх эсхүл нийтийн хүртээл болгох.

(2) Энэ зүйлд заасан “эрхийн удирдлагын тухай мэдээлэл” гэж тоглогч, тоглогчийн тоглолт, дуу авианы бичлэг үйлдвэрлэгч, дуу авианы бичлэг, тоглолт буюу дуу авианы бичлэгийн аливаа эрх эзэмшигчийг тодорхойлж буй мэдээлэл эсхүл тоглолт буюу дуу авианы бичлэгийг ашиглах нөхцөл, болзлын талаарх мэдээлэл, мөн бичигдсэн тоглолт буюу дуу авианы бичлэгийн хуулбарт тавигдсан буюу тоглолт, дуу авианы бичлэгийг олон нийтэд мэдээлэх, нийтийн хүртээл болгохтой холбоотойгоор гарч байгаа тийм мэдээллийг илэрхийлж байгаа аливаа тоо болон код мэдээг хэлнэ.

20 дугаар зүйл

Хэлбэрийн хувьд тавигдах шаардлага

Энэхүү гэрээгээр олгосон эрхийг эдлэж, хэрэгжүүлэхэд хэлбэрийн хувьд ямар нэг шаардлага тавихгүй.

21 дүгээр зүйл

Тайлбар

15 дугаар зүйлийн (3) дахь хэсгийн заалтыг дагаж мөрдөхийн хамт энэхүү гэрээнд ямар нэг тайлбар хийхийг хориглоно.

22 дугаар зүйл

Хэрэглэх хугацаа

(1) Хэлэлцэн тохирогч талууд Бернийн конвенцийн 18 дугаар зүйлийн заалтыг энэхүү гэрээгээр олгосон тоглогч болон дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн эрхэд хэрэглэнэ.

(2) (1) дэх хэсгийг үл харгалзан хэлэлцэн тохирогч тал энэхүү гэрээний 5 дугаар зүйлийг хэрэглэхийг энэхүү гэрээ тухайн талын хувьд хүчин төгөлдөр болсны дараа гарсан тоглолтоор хязгаарлаж болно.

23 дугаар зүйл

Эрхийн хэрэгжилтийн тухай заалт

(1) Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээг хэрэглэхэд шаардлагатай арга хэмжээг өөрийн хуулийн тогтолцоотой уялдуулан авах үүрэг хүлээнэ.

(2) Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээнд заасан эрхийг зөрчиж байгаа аливаа үйлдлийн эсрэг үр ашигтай арга хэмжээ авахыг зөвшөөрөхүйц эрхээр хангах журмыг өөрийн хууль тогтоомжид тусгах бөгөөд ялангуяа эрх зөрчихөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг өөрсдийн хууль тогтоомжид тусгана.

V БҮЛЭГ

ЗАХИРГААНЫ БОЛОН ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

24 дүгээр зүйл

Ассамблей

(1) (a) Хэлэлцэн тохирогч талууд Ассамблейтай байна.

(b) Хэлэлцэн тохирогч тал тус бүрийг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэрээр орлогч, зөвлөх, шинжээчтэй байж болно.

(c) Төлөөлөгчдийн зардлыг тэдгээрийг томилсон хэлэлцэн тохирогч тал хариуцна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тогтоосон журмын дагуу хөгжиж байгаа оронд тооцогддог эсхүл зах зээлийн эдийн засагт шилжиж буй орон болох хэлэлцэн тохирогч талын төлөөлөгчдийг хуралдаанд оролцуулахыг хөнгөвчлөн дэмжих зорилгоор Ассамблей санхүүгийн туслалцаа үзүүлэхийг ДООБ-аас хүсч болно.

(2) (a) Ассамблей энэхүү гэрээг сахих, хөгжүүлэх, хэрэглэх, түүний үйлчлэлтэй холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

(b) Ассамблей засгийн газар хоорондын зарим тодорхой байгууллагыг энэхүү гэрээнд элсүүлэх асуудлыг хэлэлцэхдээ 26 дугаар зүйлийн (2) дахь хэсгээр түүнд ногдуулсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

(c) Ассамблей энэхүү гэрээг хянаж өөрчлөх зорилгоор аливаа дипломат бага хурал зарлан хуралдуулах шийдвэр гаргах бөгөөд тийм дипломат бага хуралд бэлтгэхэд шаардлагатай зааварчлагыг ДООБ-ын ерөнхий захиралд өгнө.

(3) (a) Хэлэлцэн тохирогч тал болох улс нэг санал өгөх эрхтэй бөгөөд зөвхөн өөрийн нэрийн өмнөөс санал өгнө.

(b) Засгийн газар хоорондын байгууллага болох хэлэлцэн тохирогч аливаа тал энэхүү гэрээний тал болох гишүүн улсынхаа тоотой тэнцүү тоогоор гишүүн улсынхаа оронд санал өгч болно. Хэрэв аль нэг гишүүн улс саналын эрхээ өөрөө хэрэгжүүлж байгаа бол засгийн газар хоорондын аль ч байгууллага санал өгөхөд оролцохгүй бөгөөд энэ журам мөн урвуугаар үйлчилнэ.

(4) ДООБ-ын ерөнхий захирал хоёр жилд нэг удаа Ассамблейн ээлжит чуулганыг зарлан хуралдуулна.

(5) үйл ажиллагааныхаа журмыг тогтоох бөгөөд үүнд ээлжит бус чуулган зарлан хуралдуулах, чуулганы кворум, мөн энэхүү гэрээний заалтын дагуу төрөл бүрийн асуудлаар шийдвэр гаргахад шаардлагатай олонхын хэмжээг тогтооно.

25 дугаар зүйл

Олон улсын товчоо

ДООБ-ын Олон улсын товчоо нь энэхүү гэрээтэй холбогдох захиргааны үүргийг гүйцэтгэнэ.

26 дугаар зүйл

Гэрээнд оролцогч тал болох

(1) ДООБ-ын гишүүн аливаа улс энэхүү гэрээнд оролцогч тал болж болно.

(2) Энэхүү гэрээгээр зохицуулж буй асуудлын талаар тодорхой эрх мэдэлтэй бөгөөд эдгээр асуудлаар гишүүн бүх улсад нь заавал биелүүлэх өөрийн хууль тогтоомжтой, мөн энэхүү гэрээнд нэгдэн орохыг нь дотоод журмынхаа дагуу зохих ёсоор эрх олгогдсон засгийн газар хоорондын байгууллагыг гишүүнээр элсүүлэхээр Ассамблей шийдвэрлэнэ.

(3) Европын хамтын нийгэмлэг өмнөх хэсэгт заасан мэдэгдлийг энэхүү гэрээг батласан Дипломат бага хурлын үеэр хийснээр энэхүү гэрээнд оролцогч тал болж болно.

27 дугаар зүйл

Гэрээний дагуу эдлэх эрх ба хүлээх үүрэг

Энэхүү гэрээнд өөрөөр тусгайлан заагаагүй бол хэлэлцэн тохирогч тал тус бүр энэхүү гэрээгээр олгосон бүх эрхийг эдлэж, бүх үүргийг хүлээнэ.

28 дугаар зүйл

Гэрээнд гарын үсэг зурах

Энэхүү гэрээ ДООБ-ын гишүүн аливаа улс болон Европын хамтын нийгэмлэг гарын үсэг зурахад 1997 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл нээлттэй байна.

29 дүгээр зүйл

Гэрээ хүчин төгөлдөр болох

Энэхүү гэрээ гуч дахь батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг ДООБ-ын ерөнхий захиралд хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

30 дугаар зүйл

Гэрээнд нэгдэн орох хугацаа

Энэхүү гэрээний заалтыг:

(i) 29 дүгээр зүйлд дурдсан гучин улс энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлж;

(ii) бусад аливаа улс ДООБ-ын ерөнхий захиралд баримт бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа;

(iii) Европын хамтын нийгэмлэг, хэрэв батламж жуух бичиг буюу нэгдэн орсон баримт бичгээ энэхүү гэрээ 29 дүгээр зүйлийн дагуу хүчин төгөлдөр болсны дараа хадгалуулсан бол тийнхүү хадгалуулснаас хойш гурван сарын дараа эсхүл тийм баримт бичгээ энэхүү гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө хадгалуулсан бол гэрээг хүчин төгөлдөр болсноос хойш гурван сарын дараа;

(iv) энэхүү гэрээнд нэгдэж буй засгийн газар хоорондын өөр бусад байгууллага нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулснаас хойш гурван сарын дараа тус тус заавал биелүүлэх үүрэг хүлээнэ.

31 дүгээр зүйл

Гэрээг цуцлах

Аливаа хэлэлцэн тохирогч тал энэхүү гэрээг цуцлах тухай мэдэгдлээ ДООБ-ын ерөнхий захиралд өгснөөр цуцалж болно. ДООБ-ын Ерөнхий захирал дээрх мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа гэрээг цуцалсанд тооцно.

32 дугаар зүйл

Гэрээний хэл

(1) Энэхүү гэрээг англи, араб, хятад, франц, орос, испани хэлээр нэг эх хувь үйлдэж гарын үсэг зурсан бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

(2) (1) дэх хэсэгт дурдсанаас бусад хэлээрх албан ёсны эх бичвэрийг сонирхогч бүх талтай зөвлөлдсөний дараа сонирхогч талын хүсэлтээр ДООБ-ын Ерөнхий захирал үйлдэнэ. Энэ хэсгийн зорилгод “сонирхогч тал” гэж албан ёсны хэл, эсхүл албан ёсны хэлнүүдийн аль нэгээр нь хүсэлт гаргасан ДООБ-ын гишүүн улс, мөн аль нэг албан ёсны хэлээр нь хүсэлт гаргасан Европын хамтын нийгэмлэг болон энэхүү гэрээнд нэгдэн орж болох Засгийн газар хоорондын аливаа бусад байгууллагыг хэлнэ.

33 дугаар зүйл



СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ
КОНВЕНЦИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий бага хурлаас 2003 оны 10 дугаар сарын 17-ны өдөр баталсан Соёлын биет бус өвийг хамгаалах тухай Конвенцийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН



СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ

Парис хот, 2003 оны 10 дугаар сарын 17

Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын байгууллагын (цаашид ЮНЕСКО гэх) Ерөнхий бага хурал 2003 оны 9 дүгээр сарын 27-оос 10 дугаар сарын 17-ны өдрүүдэд хуралдсан ээлжит 32 дугаар чуулганаараа:

1. Хүний эрхийн тухай олон улсын эрх зүйн одоо мөрдөгдөж буй баримт бичиг, ялангуяа Хүний эрхийн тухай 1948 оны түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай 1966 оны олон улсын пакт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай 1966 оны олон улсын пактыг иш үндэс болгон
2. Уламжлалт соёл болон ардын урлагийг хмагаалах тухай ЮНЕСКО-гийн 2001 оны түгээмэл тунхагла, соёлын сайд нарын дугуй ширээний 3 дугаар уулзалтаар баталсан Стамбулын 2002 оны тунхаглалд онцлон тэмдэглэсэнчлэн соёлын төрөл зүйлийн эх сурвалж, тогтвортой хөгжлийн баталгаа болсон соёлын биет бус өвийн ач холбогдолыг анхааралдаа авч
3. Соёлын биет бус өв, соёлын биет өв болон байгалийн өвийн харилцан нягт хамаарлыг харгалзан үзэж
4. Даяаршил, нийгмийн өөрчлөлтийн үйл явц нь бүлэглэлүүдийн хооронд шинэ харилцаа үүсгэх нөхцлийг бүрдүүлэхээс гадна үл тэвчих үзлийн нэгэн адил, ялангуяа соёлын биет бус өвийг хамгаалах арга хэрэгсэл дутмаг байгаа нь энэхүү өв устгах, мөхөх, эвдэрч сүйрэх ноцтой аюул үүсгэх эх сурвалж болж байгааг хүлээн зөвшөөрч
5. Хүн төрөлхтний соёлын биет бус өвийг хамгаалахад чиглэсэн бүх нийтийн хүсэл зориг болон нийтээр зовних эрмэлзлийг ухамсарлаж
6. Хамт олон, бүлэг хүмүүс, зарим тохиолдолд хувь хүмүүсийн соёлын биет бус өвийг бүтээх, хамгаалах, хадгалах, сэргээн бүтээхэд чухал үүрэг гүйцэтгэж, соёлын төрөл зүйлийг баяжуулан, хүний бүтээл туурвилыг тэтгэн дэмжиж байдгийг хүлээн зөвшөөрч
7. Соёлын өвийг хамгаалахад чиглэсэн эрх зүйн баримт бичиг, ялангуяа Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай 1972 оны Конвенцийг боловсруулахад ЮНЕСКО-гийн үйл ажиллагаа их ач холбогдолтой болохыг тэмдэглэж
8. Өнөөгийн нөхцөлд соёлын биет бус өвийг хмагаалах талаар эрх зүйн хүчин төгөлдөр олон талт баримт бичиг байхгүй байгааг цаашид тэмдэглэж
9. Соёлын болон байгалийн өвийн талаарх олон улсын хүчин төгөлдөрхэлэлцээр, зөвлөмж, тогтоолыг биет бус соёлын өвтэй холбогдох шинэ заалтуудаар баяжуулж, үр дүнтэй нэмэлт өөрчлөлт оруулах нь зайлшгүй гэж үзэж
10. Соёлын биет бус өв болон түүнийг хамгаалахын чухлыг ялангуяа залуу үеийнхэнд илүү гүнзгий ойлгуулахын зайлшгүйг харгалзаж
11. Олон улсын хамтын нийгэмлэг энэхүү Конвенцийн оролцогч улсуудтай хамтран ажиллаж, харилцан туслалцах үзүүл санаагаар тухайн өвийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх ёстой гэж үзэж
12. ЮНЕСКО-гийн соёлын биет бус өвийн талаарх хөтөлбөр, тухайлбал, Хүн төрөлхтний аман болон соёлын биет бус өвийн шилдэг дээжсийн тухай тунхаглалыг эргэн санаж
13. Хүмүүс хоорондоо ойртон нягтрах, харилцах, бие биеэ ойлгоход
14. нөлөөлөх хүчин зүйл болсон соёлын биет бус өвийн үнэлж баршгүй үүргийг анхааралдаа авч

Энэхүү Конвенцийг 2003 оны 10 дугаар сарын 17-ны өдөр батлав.



“СОЁЛЫН ИЛЭРХИЙЛЛИЙН ОЛОН ТӨРЛИЙГ ХАМГААЛАХ БОЛОН ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ ТУХАЙ” 2005 ОНЫ ЮНЕСКО-ГИЙН КОНВЕНЦЭД МОНГОЛ УЛС НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Францын Парис хотноо 2005 оны 10 дугаар сарын 25-ны өдөр баталсан “Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай” ЮНЕСКО-гийн Конвенцэд Монгол Улс нэгдэн орсныг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН



ХАРААГҮЙ, ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ, ЭСХҮЛ ХЭВЛЭМЭЛ БҮТЭЭЛ УНШИХ БЭРХШЭЭЛТЭЙ
ХҮМҮҮСТ ЗОРИУЛАН ХЭВЛЭН НИЙТЛЭГДСЭН БҮТЭЭЛИЙГ ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛГОХ ТУХАЙ
МАРРАКЕШИЙН ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. “Хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай Марракешийн гэрээ”-г Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД



ДЭЛХИЙН ОЮУНЫ ӨМЧИЙН
БАЙГУУЛЛАГА ХАРААГҮЙ, ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ, ЭСХҮЛ ХЭВЛЭМЭЛ БҮТЭЭЛ УНШИХ
БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ЗОРИУЛАН ХЭВЛЭН НИЙТЛЭГДСЭН БҮТЭЭЛИЙГ
ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛГОХ ТУХАЙ МАРРАКЕШИЙН ГЭРЭЭ

Дипломат бага хурлаар батлав

Удиртгал

Хэлэлцэн тохиролцогч талууд,

Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид тусгасан алагчлахгүй байх, тэгш боломж олгох, хүртээмжийг хангах, нийгмийн амьдралд тэгш, бүрэн, идэвхитэй оролцох зарчмыг эргэн санаж,
Харааны бэрхшээлтэй, эсхүл бусад хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн сонголтоор харилцааны бүхий л хэлбэрээр дамжуулан бусадтай адил тэгш байх үндсэн дээр бүх төрлийн мэдээлэл, үзэл бодлыг хайх, хүлээн авах, хуваалцах эрхийг хангах, сурч боловсрох, судалгаа шинжилгээ хийх эрхээ хэрэгжүүлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлан, тэдний бүх талын хөгжлийг бүрэн хангахад хохирол учруулж байгаа бэрхшээлийг анхааралдаа авч,

Зохиогчийн эрхийн хамгаалалт нь харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулан хүн бүрийн утга зохиол, урлагийн бүтээл туурвих хөшүүрэг, урамшуулал болдог, мөн нийгэм соёлын амьдралд оролцох боломж олгох, урлагийн бүтээл сонирхох, шинжлэх ухааны хөгжил дэвшлийн үр шимийг хүртэхийн ач холбогдлыг онцлон тэмдэглэж,

Харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүс хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг нийгэмд тэгш боломжтой хүртэхэд бэрхшээлтэй байдаг, түүнчлэн хүртээмжтэй хэлбэр бүхий хэвлэмэл бүтээлийн тоо, хэмжээг нэмэгдүүлэх, тухайн бүтээлийн түгээлтийг сайжруулах хэрэгцээг ухамсарлаж,
Харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүсийн дийлэнх нь хөгжиж буй болон буурай хөгжилтэй улсад амьдарч буйг анхааралдаа авч,

Улсын дотоодын зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомж харилцан адилгүй ч харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологийн үзүүлэх эерэг нөлөөлөл нь олон улсын түвшинд эрх зүйн орчинг бэхжүүлснээр сайжруулах боломжтойг хүлээн зөвшөөрч,

Олон тооны гишүүн улс зохиогчийн эрхийн тухай үндэсний хууль тогтоомждоо харааны бэрхшээлтэй болон хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан зохиогчийн эрхийн зөрчилд тооцохгүй байх зарим хязгаарлалт, чөлөөлөлтийг тогтоосон байдаг ч тийм бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй хэлбэрээр бүтээгдсэн бүтээлийн хүрэлцээ хангалтгүй, хүртээмжтэй болгоход ихээхэн хэмжээний нөөц, эх үүсвэр шаардагддаг, түүнчлэн хүртээмжтэй хэлбэрээр бүтээгдсэн бүтээлийг хил дамнуулан солилцох боломж хомс байгаа нь илүү их хүчин чармайлт гаргахад хүргэж буйг хүлээн зөвшөөрч,

Харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан бүтээлийг хүртээмжтэй хэлбэрээр хэвлэхэд зохиогчийн эрх эзэмшигчийн гүйцэтгэх үүргийн ач холбогдол, ялангуяа зах зээлээр ийм боломжийг бий болгох боломжгүй үед тухайн бүтээлийг хүртээмжтэй болгохыг дэмжсэн зохих хязгаарлалт, онцгой тохиолдол тогтоохын чухлыг хүлээн зөвшөөрч,

Зохиогчийн эрхийн үр дүнтэй хамгаалалт болон сурч боловсрох, судалгаа, шинжилгээ хийх, мэдээлэл олж авах зэрэг нийтийн нийтлэг ашиг сонирхлын тэнцвэрт байдлыг хангах, түүнчлэн уг тэнцвэрт байдал нь харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст үр дүнтэй, цагаа олсон бүтээл хүртэхтэй нөхцөлдсөн байх шаардлагыг хүлээн зөвшөөрч,

Зохиогчийн эрхийг хамгаалах тухай олон улсын гэрээний хэлэлцэн тохиролцогч талуудын гэрээгээр хүлээсэн үүрэг болон Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенцийн 9 дүгээр зүйлийн (2) дахь хэсэг ба олон улсын бусад баримт бичигт тусгагдсан хязгаарлалт болон онцгой тохиолдлыг шалгах гурван шатны шалгуурын ач холбогдлыг дахин баталгаажуулж,

Хөгжлийн хэлбэр нь байгууллагын бүтээлийн салшгүй хэсэг болохыг баталгаажуулахад чиглэсэн Дэлхийн оюуны өмчийн байгууллагын (цаашид “ДОӨБ” гэнэ) Ерөнхий ассемблейн 2007 онд баталсан Хөгжлийн хөтөлбөрийн зөвлөмжийн чухлыг эргэн санаж,

Олон улсын зохиогчийн эрхийн тогтолцооны ач холбогдол, хязгаарлалт болон онцгой тохиолдолыг харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох явдлыг хөнгөвчлөх

зорилгоор уялдуулан нийцүүлэхийг хүлээн зөвшөөрч, дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Бусад конвенци болон гэрээний уялдаатай байдал

Энэхүү гэрээгээр аливаа бусад гэрээний хэлэлцэн тохиролцогч талуудын хоорондоо гэрээгээр хүлээсэн аливаа үүргийг үгүйсгэхгүй ба бусад гэрээний хэлэлцэн тохиролцогч талуудын аливаа эрхийг хөндөхгүй.

2 дугаар зүйл

Тодорхойлолт

Энэхүү гэрээний зорилгод:

(а) " бүтээл ” гэж Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенцийн 2 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт тусгасан утгаар бичмэл, нот ба эсхүл зурган хэлбэрээр хэвлэн нийтлэгдсэн, эсхүл ямар нэгэн мэдээллийн хэрэгслээр нийтийн хүртээл болсон утга зохиол, урлагийн бүтээлийг хэлнэ [1];

(б) " Хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбар " гэж үр шим хүртэгч хүнд аливаа бүтээлийг харааны бэрхшээлгүй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлгүй хүмүүсийн адилаар чөлөөтэй хүлээн авахад нь зориулан бүтээсэн сонгох боломжтой төрөл, эсхүл хэлбэрт байх хуулбарыг хэлнэ.

Хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбарыг үр шим хүртэгч хүмүүс тусгайлан ашиглах бөгөөд бүтээлийг үр шим хүртэгч хүмүүсийн хэрэгцээнд зориулан хүртэх болон сонгох боломжтой хэлбэрт хөрвүүлэхдээ эх бүтээлийн халдашгүй байдлыг хүндэтгэн үзнэ;

(с) “ Эрх бүхий байгууллага ” гэж үр шим хүртэгч хүмүүст зориулсан боловсрол, мэргэшсэн сургалт, тэдэнд зохицсон уншлага, эсхүл мэдээллээр хангах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Засгийн газраас эрх олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн ашгийн бус байгууллагыг хэлнэ. Мөн үндсэн үйл ажиллагааны, эсхүл байгууллагын чиг үүргийн хүрээнд үр шим хүртэгч хүмүүст хандсан ижил төрлийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, эсхүл төрийн бус байгууллага үүнд хамаарна [2].

Эрх бүхий байгууллага нь дор дурьдсан үйл ажиллагааг тодорхойлж, хэрэгжүүлнэ:

(1) ү р шим хүртэгч хүмүүст зориулан дагнасан үйлчилгээ үзүүлэх;

(2) ү р шим хүртэгч хүмүүс, эсхүл эрх бүхий байгууллагын хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбарыг түгээх, нийтийн хүртээл болгоход хязгаар тогтоох;

(3) Зөрчилтэй хуулбарыг хуулбарлах, тараах болон нийтийн хүртээл болгох явдлыг хориглох;

(4) Энэхүү гэрээний 8 дугаар зүйлд заасны дагуу үр шим хүртэгч хүмүүсийн хувь хүний халдашгүй байдалд хүндэтгэлтэй хандахын сацуу бүтээлийг хуулбарлах, бичлэг хийх явцад анхаарал хандуулах зэрэг болно.

3 дугаар зүйл

Үр шим хүртэгч хүмүүс

Үр шим хүртэгч хүн гэж хөгжлийн бусад бэрхшээлийн хэлбэрээс үл хамааран:

(а) Хараагүй;

(б) Харааны, эсхүл хүртэхүйн, эсхүл унших бэрхшээлтэй, тийм бэрхшээлгүй хүмүүсийн хэмжээнд хүртэл харах чадвар нь сэргэх боломжгүй, эсхүл хэвлэмэл бүтээл уншихад тийм бэрхшээлгүй хүмүүсийн адил хэмжээнд хүртэл унших чадваргүй, эсхүл [3]

(в) өөр тохиолдолд, бие махбодийн бэрхшээлийн улмаас ном барих, эсхүл номын хуудас эргүүлэх боломжгүй, эсхүл унших хэмжээнд харааг төвлөрүүлэх, эсхүл хөдөлгөх боломжгүй хүмүүсийг хэлнэ.

[1]- 2(а) хэсэгтэй холбоотой талуудын зөвшилцсөн мэдэгдэл: Энэхүү гэрээний зорилго дээрх

тодорхойлолтын хүрээнд аудио хэлбэрийн бүтээл, тухайлбал аудио номыг хамааруулан ойлгоно.

[2]- 2(с) хэсэгтэй холбоотой талуудын зөвшилцсөн мэдэгдэл: Энэхүү гэрээний зорилгод, " засгийн газраас эрх олгосон

байгууллага " гэдэгт үр шим хүртэгч хүмүүст зориулан боловсрол, мэргэшсэн сургалт, тэдэнд зохицсон уншлага, мэдээллээр хангах зорилгоор Засгийн газраас санхүүждэг, ашгийн бус байгууллагыг хамааруулан ойлгож болно.

[3]- 3(б) хэсэгтэй холбоотой талуудын зөвшилцсөн мэдэгдэл: " сайжрах боломжгүй " гэсэн утгад боломжит бүх эрүүл мэндийн оношилгоо болон эмчилгээ шаардана хэмээх утгыг үл агуулна.

4 дүгээр зүйл

Хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбартай холбоотой үндэсний хууль тогтоомжийн хязгаарлалт болон онцгой тохиолдол

1. (а) Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч талууд аливаа бүтээлийг үр шим хүртэгч хүмүүст тохирох хэлбэрээр хүртээмжтэй болгох үүднээс зохиогчийн эрхийн тухай үндэсний хууль тогтоомжид ДООБ-ын Зохиогчийн эрхийн тухай гэрээнд тусгасан бүтээлийг хуулбарлах, түгээх болон нийтийн хүртээл болгох эрхтэй холбоотой хязгаарлалт, эсхүл онцгой тохиолдол тогтоосон заалт тусгана. Үндэсний хууль

тогтоомжид тусгасан хязгаарлалт, эсхүл онцгой тохиолдол тогтоосон заалтаар бүтээлийн хүртэх боломжтой сонгомол хэлбэрт хөрвүүлэхэд шаардагдах өөрчлөлт оруулахыг зөвшөөрнө.

(б) Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч талууд үр шим хүртэгч хүмүүст бүтээлийг хүртэхэд хялбарчлах зорилгоор нийтийн өмнө тоглох, үзүүлэх эрхэд хязгаарлалт, эсхүл онцгой тохиолдол тогтоож болно.

2. Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч тал зохиогчийн эрхийн тухай үндэсний хууль тогтоомжид дараах хязгаарлалт, эсхүл онцгой тохиолдол тогтоох замаар 4 дүгээр зүйлийн (1) дэх заалтыг хэрэгжүүлж болно.

(а) Эрх бүхий байгууллага нь дараах нөхцөлийг хангасан тохиолдолд зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр аливаа бүтээлийг хүртээмжтэй хэлбэрт оруулан хуулбарлах, бусад эрх бүхий байгууллагаас уг хуулбарыг олж авах, үр шим хүртэгч хүмүүст ашгийн бус зориулалтаар түрээслэх, эсхүл утсан болон утасгүй холбооны хэрэгслээр дамжуулан түгээх эрх эдэлнэ.

(1) энэхүү үйл

ажиллагааг хэрэгжүүлэхийг хүссэн эрх бүхий байгууллага тухайн бүтээл, эсхүл түүний хуулбарыг ашиглах хууль ёсны эрхтэй байх;

(2) аливаа бүтээлийг хүртээмжтэй хэлбэрт хөрвүүлэхдээ шаардагдах мэдээллийн дагуу хүртэж болох боломжтой хэлбэрт оруулж болох бөгөөд ингэхдээ тухайн бүтээлийг үр шим хүртэгч хүмүүст хүргэхэд зайлшгүй шаардагдах өөрчлөлтөөс бусад өөрчлөлтийг оруулахгүй байх;

(3) хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбарыг үр шим хүртэгч хүмүүсийн хэрэгцээнд тусгайлан нийлүүлсэн байх;

(4) энэхүү үйл ажиллагаа нь ашгийн бус зорилготой байх;

Түүнчлэн

(б) Ү р шим хүртэгч хүн, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэвджигчийг оролцуулан түүнийг төлөөлөх этгээд аливаа бүтээл, эсхүл түүний хуулбарыг ашиглах хууль ёсны эрхтэй тохиолдолд үр шим хүртэгч хүний хувийн хэрэгцээнд зориулан хүртээмжтэй хэлбэрт хөрвүүлэх, эсхүл өөрөөр үр шим хүртэгч хүнд бүтээлийг хүртэх боломжтой хэлбэрт хөрвүүлэхэд болон ашиглахад нь туслалцаа үзүүлж болно.

3. Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч тал 10, 11 дүгээр зүйлд заасны дагуу зохиогчийн эрхийн тухай үндэсний хууль тогтоомждоо бусад хязгаарлалт, эсхүл онцгой тохиолдол тогтоох замаар 4 дүгээр зүйлийн (1) дэх заалтыг хэрэгжүүлж болно [4].

4. Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч тал энэхүү заалтыг үндэслэн үр шим хүртэгч хүмүүс тухайн зах зээлээс үндэслэл бүхий нөхцөл байдлын улмаас худалдан авах боломжгүй бүтээлийн тодорхой хүртээмжтэй хэлбэрт тогтоосон хязгаарлалт, эсхүл онцгой тохиолдолд хязгаарлалт хийж болно.

Энэхүү боломжийг ашиглаж байгаа гэрээний хэлэлцэн тохиролцогч аливаа тал энэхүү гэрээг соёрхон батлах, нэгдэн орох, эсхүл үүнээс хойшхи аль ч хугацаанд ДООБ-ын Ерөнхий захиралд хадгалуулахаар мэдэгдэнэ [5].

5. Энэхүү заалтын хүрээнд оруулсан хязгаарлалт, эсхүл онцгой тохиолдол нь ямар нэгэн төлбөртэй байх эсэхийг үндэсний хууль тогтоомжоор шийднэ.

5 дугаар зүйл

Хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбарыг хил дамнуулан солилцох

1. Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч тал хэрэв хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбар нь хуулийн дагуу, эсхүл хязгаарлалт, эсхүл онцгой тохиолдлын дагуу хийгдсэн бол хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбарыг эрх бүхий байгууллагаар дамжуулан үр шим хүртэгч хүнд, эсхүл энэхүү гэрээний өөр бусад хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллагад түгээх, эсхүл хүртээл болгож болно [6].

2. Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч тал зохиогчийн эрхийн тухай үндэсний хууль тогтоомжид дараахь хязгаарлалт, эсхүл онцгой тохиолдол тогтоох замаар 5 дугаар зүйлийн (1) дэх заалтыг хэрэгжүүлж болно:

(а) эрх бүхий байгууллага нь эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр үр шим хүртэгч хүмүүсийн тусгай хэрэгцээнд зориулсан хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбарыг энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч бусад талын эрх бүхий байгууллагад түгээх, эсхүл хүртээл болгож болно;

(б) эрх бүхий байгууллага нь эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр болон 2 дугаар зүйлд заасны дагуу хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбарыг энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч бусад талын үр шим хүртэгч хүнд түгээх, эсхүл хүртээл болгохыг зөвшөөрнө.

Эдгээр нөхцөл нь эрх бүхий байгууллага хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбарыг түгээх, хүртээл болгохоос өмнө уг хуулбар үр шим хүртэгч хүмүүсээс гадна бусад бүлгийн

[4]- 4(3) хэсэгтэй холбоотой талуудын зөвшилцсөн мэдэгдэл: Энэхүү заалт нь Бернийн конвенциор хүлээн зөвшөөрсөн харааны бэрхшээлтэй, эсхүл бусад хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст хамаарах орчуулгын эрхийн хязгаарлалт болон онцгой тохиолдлын үйлчлэх хүрээг бууруулах болон өргөтгөх зорилгогүй болно

[5]- 4(4) хэсэгтэй холбоотой талуудын зөвшилцсөн мэдэгдэл: худалдан авах шаардлага нь энэхүү заалтын дагуу хийсэн хязгаарлалт, эсхүл онцгой тохиолдол нь гурван шатны шалгуурт нийцсэн эсэхээс үл хамааран

эхэд дурьдсан ашиг олох чиглэлээр ашиглах шаардлага нь гэрээнд тохирох хязгаарлалт болон онцгой тохиолдлын үйчлэлд нөлөөлөхгүй хэмээн ойлгоно.

[6]- 5(1) хэсэгтэй холбоотойгоор талуудын зөвшилцсөн мэдэгдэл: Энэхүү гэрээний аливаа заалт бусад гэрээгээр олгогдсон эрхийн үйлчлэх хүрээг багасгахгүй, эсхүл ихэсгэхгүй гэж цаашид ойлгоно.

хэрэгцээнд зориулсан тухай мэдээгүй эсхүл мэдэх хангалттай үндэслэл байгаагүй тохиолдолд мөн хэрэгжинэ [7].

1. Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч тал 5 дугаар зүйлийн (4)

дэх хэсэг, 10 болон

11 дүгээр зүйлд заасанчлан зохиогчийн эрхийн тухай үндэсний хууль тогтоомжид бусад хязгаарлалт, эсхүл онцгой тохиолдол тогтоох замаар 5 дугаар зүйлийн (1) дэх заалтыг хэрэгжүүлж болно.

2. (а) Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллага 5 дугаар зүйлийн (1) дэх заалтын дагуу хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбарыг хүлээн авсан тохиолдолд тухайн байгууллага Бернийн конвенцийн 9 дүгээр заалтын дагуу ямар нэгэн үүрэг хүлээхгүй бөгөөд энэ нь хэлэлцэн тохиролцогч тал өөрийн хууль, эрх зүйн үйлчлэх хүрээнд эрх зүйн тогтолцоо, практиктайгаа нийцүүлэн уг хуулбарыг зөвхөн үр шим хүртэгч хүмүүсийн хэрэгцээнд зориулан хуулбарласан, түгээсэн, эсхүл хүртээл болгосон нөхцөлд хангагдана.

(б) Энэхүү гэрээний 5 дугаар зүйлийн (1) дэх заалтын дагуу хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбарыг эрх бүхий байгууллага түгээх болон хүртээл болгох нь хэлэлцэн тохиролцогч тал ДООБ-ын Зохиогчийн эрхийн гэрээнд нэгдэн ороогүй, эсхүл уг гэрээг хэрэглэх үед түгээх, нийтийн хүртээл болгох эрхийн хязгаарлалт, онцгой тохиолдлыг тухайн бүтээлийн хэвийн ашиглалтыг зөрчөөгүй, эрх эзэмшигчийн хууль ёсны эрхийг хөндөөгүйгээс бусад тохиолдолд тодорхой нөхцлөөр хязгаарлаагүй бол тухайн улсын хууль тогтоомжоор хязгаарлана.[8] [9]

(с) Энэхүү заалт нь бүтээлийг түгээх, эсхүл нийтийн хүртээл болгох тухай ойлголтод ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй.

3. Энэхүү гэрээний аль ч заалт аливаа эрхийн дуусгавар болох харилцааг зохицуулахад ашиглагдахгүй.

6 дугаар зүйл

Хүртээмжтэй хэлбэр

бүхий хуулбарыг

импортлох

Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч талын үндэсний хууль тогтоомж нь үр шим хүртэгч хүн болон түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл эрх бүхий байгууллагад аливаа бүтээлийн хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбар хийхийг зөвшөөрч байгаа бол хэлэлцэн тохиролцогч талын үндэсний хууль тогтоомж нь эрх эзэмшигчийн

[7]- 5(2) хэсэгтэй холбоотойгоор талуудын зөвшилцсөн мэдэгдэл: Хэлэлцэн тохиролцогч талын үр Шим хүртэгч хүмүүст хүртэх боломжтой хэлбэрийн хувийг шууд түгээхийн тулд эрх бүхий байгууллагын хурьд 2

(с) дугаар зүйл дээр дурдсан өөрийн практикийг хэрэгжүүлэх тухайн хүн нь үр шим хүртэгч хүн эсэхийг тогтоох арга хэмжээ авах нь зохистой.

[8]- 5(4)(6) дугаар заалттай холбоотойгоор талуудын зөвшилцсөн мэдэгдэл: Энэхүү гэрээ нь хэлэлцэн тохиролцогч талд Зохиогчийн эрхийн тухай гэрээг батлах эсвэл үүний аль нэгэн заалтыг даган мөрдөх үүргийг ногдуулах, мөн зохиогчийн эрхийн тухай гэрээгээр олгогдсон ямар нэгэн эрх, хязгаарлалт болон онцгой тохиолдолд нөлөөлөхгүй хэмээн ойлгоно.

[9]- 5(4)(6) дугаар заалттай холбоотойгоор талуудын зөвшилцсөн мэдэгдэл: Энэхүү гэрээ нь хэлэлцэн тохиролцогч талыг энэхүү гэрээгээр болон бусад олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээс гадуур гурван түвшний шалгуурыг хэрэгжүүлэх үүргийг ногдуулахгүй.

зөвшөөрөлгүйгээр хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбарыг үр шим хүртэгч хүний хэрэгцээнд зориулан импортлохыг мөн зөвшөөрнө [10].

7 дугаар зүйл Технологийн арга хэмжээтэй холбогдох үүрэг

Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч талууд энэхүү гэрээний дагуу хязгаарлалт болон онцгой тохиолдлыг ашиглах эрхээ хэрэгжүүлж байгаа үр шим хүртэгч хүмүүст энэхүү эрхээ хэрэгжүүлэх үйлдлийг хязгаарлаж байгаа техникийн үйл ажиллагаанаас зайлсхийхийн тулд эрх зүйн зохистой хамгаалалт болон хуулийн үр ашигтай арга хэмжээ авна [11].

8 дугаар зүйл Хувийн нууцыг хүндэтгэх

Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч талууд гэрээгээр тодорхойлсон хязгаарлалт болон онцгой тохиолдлыг хэрэгжүүлэхдээ үр шим хүртэгч хүмүүсийн хувийн нууцлалыг бусадтай адил тэгш хэмжээнд хамгаална.

9 дүгээр зүйл Хил дамнасан солилцоог хөнгөвчлөх хамтын ажиллагаа

1. Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч талууд эрх бүхий байгууллагыг нэг нэгнээ олж тогтооход туслах зорилгоор харилцан сайн дураар мэдээлэл солилцох явдлыг хөхиүлэн дэмжих замаар хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбарын хил дамнасан солилцоог дэмжихийг эрмэлзэнэ. ДООБ-ын Олон улсын товчоо (цаашид "ОУТ" гэнэ) энэхүү зорилгыг хангах үүднээс мэдээллийн цэг байгуулна.

2. Эрх бүхий байгууллагын хооронд мэдээлэл солилцох, хүртэх боломжтой хэлбэр бүхий хуулбарыг хил дамнаулан солилцох үйл ажиллагааг хамруулан бодлого үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг түгээх 5 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагад 2 дугаар зүйлд заасан мэдээллээр хангах үүргийг гүйцэтгэхэд хэлэлцэн тохиролцогч талууд дэмжлэг үзүүлнэ.

3. ДООБ-ын ОУТ

боломжтой бүх тохиолдолд энэхүү гэрээний чиг үүргийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл солилцох арга хэмжээг дэмжинэ.

4. Хэлэлцэн тохиролцогч тал энэхүү гэрээний зорилго, зорилгыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх хүчин чармайлтыг дэмжих олон улсын хамтын ажиллагаа болон түүний нөлөөллийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрнө [12].

[10]- 6 дугаар

заалттай холбоотойгоор талуудын зөвшилцсөн мэдэгдэл: Хэлэлцэн тохиролцогч талууд нь 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэхдээ 4 дүгээр зүйлд заагдсан адил уян хатан байдлыг эдэлнэ хэмээн ойлгоно.

[11]- 7 дугаар

заалттай холбоотойгоор талуудын зөвшилцсөн мэдэгдэл: Эрх бүхий байгууллага олон төрөл нөхцөл байдалд хүртэх боломжтой хэлбэрийн хувийг хуулбарлах, түгээх болон хүртээл болгоход авах технологийн арга хэмжээг өөрсдөө сонгох ба энэхүү үйл ажиллагаа нь дотоодын хууль тогтоомжийг зөрчихгүй.

[12]- 9 дүгээр

заалттай холбоотойгоор талуудын зөвшилцсөн мэдэгдэл: 9 дүгээр зүйлээр эрх бүхий байгууллагыг заавал бүртгүүлэхийг шаардахгүй, мөн эрх бүхий байгууллагуудыг энэхүү гэрээнд заасан үйл ажиллагааг явуулах урьдчилсан нөхцөлийг бий болгохыг шаардахгүй, харин хүртээмжтэй хуулбарыг хил дамнаулан СоЛиЛцохОД зориулан мэдээлэл хуваалцах боломжийг бий болгоно.

10 дугаар зүйл

Хэрэгжүүлэх ерөнхий зарчим

1. Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч талууд нь гэрээний хэрэгжилтийг хангахад шаардагдах арга хэмжээг авах үүрэгтэй.

2. Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч талууд гэрээний заалтыг өөрийн эрх зүйн систем болон практикийн хүрээнд зохистой арга замыг тогтоон хэрэгжүүлэхдээ ямар ч зүйл саад үл хийнэ. [13]

3. Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч талууд нь энэхүү гэрээгээр хүлээсэн эрх болон үүргээ ялангуяа үр шим хүртэгч хүмүүсийн эрх ашгийн төлөөх хязгаарлалт, эсхүл онцгой тохиолдол, бусад хязгаарлалт, эсхүл онцгой тохиолдол, эсхүл эдгээрийг хослуулан өөрийн эрх зүйн тогтолцоо болон практикт нэвтрүүлэх замаар биелүүлж болно. Эдгээрт энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч талуудын Бернийн конвенци, бусад олон улсын гэрээ хэлэлцээр болон 11 дүгээр зүйлээр хүлээсэн эрх болон үүрэгт нийцсэн шаардлагыг хангах зорилгоор үр шим хүртэгч хүмүүст зориулсан шударга өрсөлдөөн, шударга гэрээ, шударга ашиглалттай холбоотой харилцаанд хамаарах шүүх эрх мэдлийн, захиргааны болон хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг хамруулна.

11 дүгээр зүйл

Хязгаарлалт болон онцгой тохиолдолтой холбоотой ерөнхий үүрэг

Энэхүү гэрээний хэрэгжилтийг хангах зайлшгүй шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч талууд нь Бернийн конвенци, Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр, Зохиогчийн эрхийн тухай ДООБ-ын гэрээ, тэдгээрийн тайлбар гэрээгээр хүлээсэн дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

1. Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч тал Бернийн конвенцийн 9 дүгээр зүйлийн (2) дахь хэсэгт заасны дагуу бүтээлийн хэвийн ашиглалт болон зохиогчийн хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр хохироохгүйгээр зарим онцгой тохиолдолд бүтээлийг хуулбарлахыг зөвшөөрч болно.

2. Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч тал нь Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрийн 13 дугаар зүйлд заасны дагуу тухайн бүтээлийн хэвийн ашиглалт болон эрх эзэмшигчийн хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр хохироохгүйгээр зарим онцгой тохиолдолд бүтээлийн онцгой эрхэд хязгаарлалт, эсхүл онцгой тохиолдол тогтоож болно.

[13]- 10(2) зүйлтэй холбоотойгоор талуудын зөвшилцсөн мэдэгдэл: Бүтээл нь 2(а) дээр заагдсан бүтээлийн буюу жишээ нь аудио хэлбэрээр байх шаардлагыг хангавал энэхүү гэрээгээр шаардсан хязгаарлалт болон онцгой тохиолдол нь тухайн хамаарах эрхэд зөвхөн тухайн хүртээмжтэй хэлбэрийн хувийг үр дүнг хүртэгч

хүмүүст зориулан хийхэд шаардлагатай өөрчлөлтийг зөвшөөрөх mutatis mutandis (зөвхөн өөрчлөх шаардлагатай зүйлийг өөрчлөх) зарчим үйлчилнэ.

3. Зохиогчийн эрхийн тухай Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээний 10 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт заасны дагуу хэлэлцэн тохиролцогч тал нь Зохиогчийн эрхийн тухай гэрээнд тусгасан зарим онцгой тохиолдолд бүтээлийн хэвийн ашиглалт болон зохиогчийн хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр хохироохгүйгээр зохиогчийн эрхэд хязгаарлалт, эсхүл онцгой тохиолдол тогтоож болно.

4. Дэлхийн оюуны өмчийн байгууллагын Зохиогчийн эрхийн тухай гэрээний 10 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэн тохиролцогч тал Бернийн конвенцийг хэрэглэхдээ түүгээр тогтоосон эрхийн талаарх хязгаарлалт, эсхүл онцгой тохиолдлыг бүтээлийг хэвийн ашиглалттай зөрчилдөхгүй, мөн зохиогчийн хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр үл хөндөх тохиолдолд хэрэглэнэ.

12 дугаар зүйл бусад хязгаарлалт болон онцгой тохиолдол

1. Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч талууд нь тухайн хэлэлцэн тохиролцогч талын эдийн засгийн нөхцөл байдал, нийгэм, соёлын хэрэгцээнээс хамааран үндэсний хууль тогтоомждоо нэгдэн орсон олон улсад хүлээсэн эрх болон үүрэгт нийцүүлэн гэрээнд заасан нөхцлөөс өөр зохиогчийн эрхийн бусад хязгаарлалт, эсхүл онцгой тохиолдлыг үр шим хүртэгч хүмүүсийн тусын тулд тогтоож болох ба буурай хөгжилтэй орны хувьд өөрийн тусгай хэрэгцээ, олон улсад хүлээх эрх болон үүргийн хүрээнд уян хатан хэрэгжүүлж болохыг хүлээн зөвшөөрнө.

2. Энэхүү гэрээ нь үндэсний хууль тогтоомжид тусгасан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандсан хязгаарлалт болон онцгой тохиолдлыг хөндөхгүй.

13 дугаар зүйл Ассемблей

1. (а) Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч талууд Ассемблейтай байна.

(б) Хэлэлцэн тохиролцогч тал бүрийг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэрээр орлогч, зөвлөх, шинжээчтэй байж болно.

(с) Төлөөлөгч тус бүрийн зардлыг түүнийг томилсон хэлэлцэн тохиролцогч тал хариуцна. Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий ассемблейн тогтоосон журмын дагуу хөгжиж байгаа оронд тооцогддог, эсхүл зах зээлийн эдийн засагт шилжиж буй улс болох хэлэлцэн тохиролцогч талын төлөөлөгчдийг хуралдаанд оролцуулахыг дэмжих зорилгоор Ассемблей санхүүгийн туслалцаа үзүүлэхийг Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас (ДООБ) хүсч болно.

2. (а) Ассемблей энэхүү гэрээг сахих, хөгжүүлэх, хэрэглэх, түүний үйл явцтай холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

(б) Ассемблей засгийн газар хоорондын зарим тодорхой байгууллагыг энэхүү гэрээнд элсүүлэх асуудлыг хэлэлцэхдээ

15 дугаар зүйлээр түүнд ногдуулсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

(с) Ассемблей энэхүү гэрээг хянаж өөрчлөх зорилгоор аливаа дипломат бага хурал зарлан хуралдуулах шийдвэр гаргах бөгөөд тийм дипломат бага хуралд бэлтгэхэд шаардлагатай зааварчлагыг ДООБ-ын Ерөнхий захиралд өгнө.

3. (а) Хэлэлцэн тохиролцогч тал болох улс нэг санал өгөх эрхтэй бөгөөд зөвхөн өөрийн нэрийн өмнөөс санал өгнө.

(б) Засгийн газар хоорондын байгууллага болох хэлэлцэн тохиролцогч аливаа тал энэхүү гэрээний тал болох гишүүн улсынхаа тоотой тэнцүү тоогоор гишүүн улсынхаа тоонд санал өгч болно. Хэрэв аль нэг гишүүн улс саналын эрхээ өөрөө хэрэгжүүлж байгаа бол засгийн газар хоорондын аль ч байгууллага санал өгөхөд оролцохгүй бөгөөд энэ журам мөн урвуугаар үйлчилнэ.

4. ДООБ-ын Ерөнхий захирал ээлжит Ассемблейн чуулганыг зарлан хуралдуулах бөгөөд онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд ДООБ-ын төв байранд Ерөнхий ассемблейн хуралдааны үеэр хуралдана.

5. Ассемблей үйл ажиллагааныхаа журамыг тогтоох бөгөөд үүнд ээлжит бус чуулган зарлан хуралдуулах, чуулганы кворум, мөн энэхүү гэрээний заалтын дагуу төрөл бүрийн асуудлаар шийдвэр гаргахад шаардлагатай олонхийн хэмжээг тогтооно.

14 дүгээр зүйл Олон улсын товчоо

ДООБ-ын Олон улсын товчоо нь энэхүү гэрээтэй холбогдох захиргааны үүргийг гүйцэтгэнэ.

15 дугаар зүйл Гэрээнд оролцогч тал болох

1. ДООБ-ын гишүүн аливаа улс энэхүү гэрээнд оролцогч тал болж болно.

2. Ассемблей нь энэхүү гэрээгээр зохицуулж буй асуудлын талаар тодорхой эрх мэдэлтэй бөгөөд эдгээр асуудлаар гишүүн бүх улсад нь заавал биелүүлэх өөрийн хууль тогтоомжтой, мөн энэхүү гэрээнд нэгдэн орохыг нь зохих ёсоор дотоод журмынхаа дагуу зөвшөөрч эрх олгогдсон засгийн газар хоорондын байгууллагыг гишүүнээр элсүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

3. Европын хамтын нийгэмлэг өмнөх хэсэгт заасан мэдэгдлийг энэхүү гэрээг баталсан Дипломат бага хурлын үед хийснээр энэхүү гэрээнд оролцогч тал болж болно.

16 дугаар зүйл Гэрээний дагуу эдлэх эрх ба үүрэг

Энэхүү гэрээнд өөрөөр тусгайлан заагаагүй бол хэлэлцэн тохиролцогч тал тус бүр энэхүү гэрээгээр ОЛГОСОН бүх эрхийг ЭДЛЭХ ба үүргийг хүлээнэ.

17 дугаар зүйл Гарын үсэг зурах

Энэхүү гэрээ Марракеш хотноо Дипломат бага хурлаар нэгдэн орохоор гарын үсэг зурсан болон цаашид ДООБ-ын төв байранд гэрээг баталснаас хойш нэг жилийн дараа нэгдэх орох эрх бүхий талууд гарын үсэг зурахад нээлттэй байна.

18 дугаар зүйл Гэрээ хүчин төгөлдөр болох

Энэхүү гэрээ нь 15 дугаар зүйлд заасан нэгдэн орох эрх бүхий

20 улс нэгдэн орсон тухай баримт бичгээ, эсхүл соёрхон баталсан тухай батламж жуух бичгээ хадгалуулснаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

19 дүгээр зүйл Гэрээнд нэгдэн орох хугацаа

Энэхүү гэрээний заалтыг:

(1) 18 дугаар зүйлд дурдсан нэгдэн орох эрх бүхий 20 улс энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлж;

(2) 15 дугаар зүйлд дурдсан нэгдэн орох эрх бүхий бусад аливаа улс ДООБ-ын Ерөнхий захиралд баримт бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа;

20 дугаар зүйл Цуцлах

Аливаа хэлэлцэн тохиролцогч тал Дэлхийн оюуны өмчийн байгууллагын Ерөнхий захиралд мэдэгдэл өгөх замаар энэхүү гэрээг цуцалж болно. Дэлхийн оюуны өмчийн байгууллагын Ерөнхий захирал мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа цуцлалт хүчин төгөлдөр болно.

21 дүгээр зүйл Гэрээний хэл

1. Энэхүү гэрээний англи, араб, хятад, франц, орос болон испани хэлээр үйлдсэн нэг эх хувьд гарын үсэг зурах бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

2. (1) дэх хэсэгт дурдсанаас бусад хэлээр нийтлэх албан ёсны эх бичвэрийг сонирхогч бүх талтай зөвлөлдсөний дараа сонирхогч талын ДООБ-ын Ерөнхий захирал үйлдэнэ. Энэ хэсгийн зорилгоор "сонирхогч тал" гэж албан ёсны хэл эсхүл албан ёсны хэлнүүдийн аль нэгээр нь хүсэлт гаргасан ДООБ-ЫН гишүүн улс мөн аль нэг албан ёсны хэлээр нь хүсэлт гаргасан Европын хамтын нийгэмлэг буюу энэхүү гэрээнд нэгдэн орж болох засгийн газар хоорондын аливаа бусад байгууллагыг хэлнэ.

Дөрөв. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 7 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БАТЛАХ ТУХАЙ

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1."Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ыг хавсралтаар баталсугай.
- 2.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэвлэлд нийтлэх найруулгыг Төрийн нууцын тухай хуульд нийцүүлэн бэлтгэж төрийн албан ёсны хэвлэлд нийтлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар /Ц.Шаравдорж/-т даалгасугай.
- 3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлал, цэргийн номлол батлах, нийтлэх тухай" Улсын Их Хурлын 1994 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 56 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2010 оны
48 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Үндэсний аюулгүй байдал

1.1.1.Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ.

1.1.2.Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана.

1.1.3.Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нэгдмэл байдлыг хамгаалан бататгах нь үндэсний аюулгүй байдлыг хангах анхдагч нөхцөл мөн.

1.1.4.Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн.

1.1.5.Монгол Улсын төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал баталгаажна.

1.1.6.Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн.

1.2.Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим

1.2.1.Эх оронч үндэсний үзлийг дээдлэх

Монгол Улсын иргэн бүрийн үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно.

1.2.2.Төр, иргэний хамтын ажиллагаа

Үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн анхдагч үүрэг мөн. Иргэдээ аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдээлэл, мэдлэгтэй байх, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоор хангах, хамтран ажиллахад төр онцгой анхаарна.

1.2.3.Аюулгүй байдлын бодлого цогц байх

Монгол Улсын "оршин тогтнохуйн аюулгүй байдал", "эдийн засгийн аюулгүй байдал", "дотоод аюулгүй байдал", "хүний аюулгүй байдал", "хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал", "мэдээллийн аюулгүй байдал" харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна.

1.2.4.Мэдлэгт суурилах

Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна.

1.2.5.Бодитой хандах

Болзошгүй аюул, сорилтыг бодитой тодорхойлж, тэдгээрийг гэтлэн давахад хязгаарлагдмал нөөц, боломжийг үр дүнтэй дайчилна.

1.2.6.Даяаршлын хүчин зүйлийг харгалзах

Даяаршил улс үндэстний бусдаас хамаарах эмзэг байдлыг нэмэгдүүлж, нөгөө талаас гадаад нөөц боломжийг ашиглан үндэсний ашиг сонирхлоо хамгаалж бататгах боломж олгож байна.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАДААД ОРЧИН, ТУЛГАМДАЖ БАЙГАА СОРИЛТ, ЭРСДЭЛ

ГУРАВ.ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ, ХАНГАХ АРГА ЗАМ

3.1. Оршин тогтнохуйн аюулгүй байдал

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн.

3.1.1. Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал

3.1.1.1. Төрийн гадаад бодлого нэгдмэл байх, гадаад харилцаанд үндэсний ашиг сонирхлыг дээдлэх зарчмыг тууштай хэрэгжүүлнэ.

3.1.1.2. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах үндсэн арга нь улс төр, дипломатын үйл ажиллагаа байна. Энэ хүрээнд олон тулгуурт гадаад бодлогын зарчмыг эрхэмлэж, дэлхийн улс орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

3.1.1.3. Энхийг эрхэмлэсэн гадаад бодлогоо тууштай баримталж, энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжинэ.

3.1.1.4. ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Чингэхдээ үндэсний эрх ашиг, харилцааны түүхэн уламжлалыг харгалзан бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг эрхэмлэж, бүхэлдээ тэнцвэртэй харилцахыг эрмэлзэнэ.

3.1.1.5. "Гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

3.1.1.6. Хөрш хоёр орон, АНУ, НАТО-гийн гишүүн орнууд, Европын Холбоо, Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлж, олон улсын энхийг дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно.

3.1.1.7. Монгол Улсын олон улсын аюулгүй байдлыг баталгаажуулах асуудлаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тогтоолуудын үзэл санааг хэрэгжүүлэх чиглэлд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн гишүүн орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллана.

3.1.1.8. Ази, Номхон далайн бүс нутаг Зүүн Ази, түүний дотор Зүүн хойд Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааны механизм бий болгоход чиглэсэн бүс нутгийн орнуудын бодлого, үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж оролцоно.

3.1.2. Хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдал

3.1.2.1. Нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зарчимтай уялдуулан Монгол Улсын газрын сангийн нэгдсэн бодлого, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоно.

3.1.2.2. Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах, зэвсэгт хүчний нэгдмэл тогтолцоог төлөвшүүлж, зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг баримжаатай, чадварлаг болгон хөгжүүлнэ. Улсын хилийн хамгаалалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, урамшуулах бодлого явуулна.

3.1.2.3. Гаднын дүрвэгсэд олноор хил даван орж ирэх, гэнэтийн хяналтгүй нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх бэлэн байдлын тогтолцоог бүрдүүлж, эрх зүй, улс төр, дипломатын цогц арга хэмжээ авна.

3.1.2.4. Хилийн хамгаалалт, хяналт шалгалтын үйл ажиллагаанд мэдээллийн нэгдмэл, шуурхай байдлыг баталгаатай хангах зохион байгуулалт, техник, технологийн шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

3.1.2.5. Хил орчмын бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхдээ үндэсний нэгдмэл ашиг сонирхлыг дээдэлж, Монгол Улсын бүрэн эрхт байдал, хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг бататгах зарчмыг үндэс болгоно.

3.1.2.6. Хил дээр боомт нээх, хаах, боомтын ажиллагааны горимд өөрчлөлт оруулах асуудлыг төрийн эрх барих дээд байгууллага шийдвэрлэнэ.

3.1.2.7. Хилийн дагуух орон нутгийн хөгжлийн бодлого, гадаад харилцаа нь төрийн нэгдсэн бодлогод захирагдана.

3.1.3. Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал

3.1.3.1. Монгол Улсын хүн амын өсөлтийг дэмжиж, монгол хүний хөгжил, амьдралын чанарт дэвшил гаргана.

3.1.3.2. Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа иргэддээ эх орондоо эргэн ирж ажиллаж, амьдрах таатай нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.

3.1.3.3. Гадаадад төрж тухайн улсын иргэний харьяалалтай болсон иргэд, тэдний үр хүүхдэд Монгол Улсад зорчих, оршин суух, суралцах, ажиллаж амьдрах, даатгалд хамрагдах таатай нөхцөлийг бүрдүүлнэ. Хоёрдмол харьяалал үүсч, төрөөс иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах баталгаа алдагдахаас сэргийлнэ.

3.1.3.4. Цус ойртолтыг багасгах, архиан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна.

3.1.3.5. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшинг хадгалж, бүртгэл, мэдээллийн тогтолцоо, эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.

3.1.4. Соёл иргэншлийн аюулгүй байдал

3.1.4.1. Монголын түүх, хэл, соёл, шашин, зан заншлыг хамгаалах, хөгжүүлэх, судлах ажлыг төр ивээлдээ авч, ном, сурах бичиг, кино урлагийн бүтээл туурвилыг онцгойлон урамшуулж, биет болон биет бус соёлын өвийг хамгаалан хөгжүүлнэ. Дэлхийн Монгол судлалын төвийг Улаанбаатарт байгуулж монголч эрдэмтдийг судалгааны ажлуудад татан оролцуулах, бусад оронд салбар байгуулах ажлыг зохион байгуулна.

3.1.4.2. Монгол хэл, бичгийн соёлоо хамгаалан хөгжүүлж, уламжлалт монгол бичгийн сургалт, хэрэглээг нэмэгдүүлнэ.

3.1.4.3. Хүүхэд, залуучуудад түүх, соёл, зан уламжлалаа гүнзгий таниулах, эх оронч үндэсний үзлийг төлөвшүүлэх ажлыг нийгэм, гэр бүл, боловсролын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

3.1.4.4. Үндэсний ёс заншил, соёл урлагийн нэртэй төлөөлөгчид, ардын авьяастнуудын уйгагүй хөдөлмөр, зүтгэлийг үнэлэх, алдаршуулах, эрдэм авьяасыг нь өвлүүлэх бодлого, үйл ажиллагааг төрөөс хэрэгжүүлнэ.

3.1.4.6. Дэлхийн бусад орон, түүний дотор гуравдагч хөрш орнуудтай соёлын салбарт өргөн харилцаа хөгжүүлж, дипломат төлөөлөл, иргэдээрээ дамжуулан монгол үндэстний соёл, түүхийг дэлхий дахинаа сурталчлах ажлыг эрчимжүүлнэ.

3.1.4.7. Түүх, соёлын үнэт зүйлс хууль бусаар гадаадад гарахаас сэргийлэх, хилийн чанад дахь монгол соёл иргэншлийн өвийг сурвалжлан олох, судлах, эх орондоо эгүүлэн залах, сэргээн засах чиглэлээр иргэдийн санал, санаачилгыг дэмжиж, гадаад оронтой идэвхтэй хамтран ажиллах эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээ авна.

3.1.4.8. Уламжлалт Бурханы шашин, соёлыг сэргээн хөгжүүлж, сүм хийдийн үйл ажиллагааг нийгмийн оюун санааг гэгээрүүлэх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, ядуурлыг бууруулах, зовлон гамшигт нэрвэгдсэн хүн ардад туслалцаа үзүүлэх, байгаль орчныг хамгаалах үйлсэд чиглүүлэхэд төрөөс анхаарч, дэмжлэг үзүүлнэ.

3.1.4.9. Монголын ард түмний олон зуун жилийн оюуны өвийг тээж, хадгалж ирсэн Монголын Бурханы шашны өв соёлын судалгааг төрөөс онцлон дэмжинэ.

3.2. Эдийн засгийн аюулгүй байдал

Эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн.

Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтална.

3.2.1. Эдийн засгийн олон тулгуурт бүтэц

3.2.1.1. Эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхийг бүрдүүлж, тодорхой салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгоно.

3.2.1.2. Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, санхүүгийн салбарыг олон улс, Европын Холбооны стандартад нийцүүлэн хөгжүүлнэ.

3.2.1.3. Ил тод, хариуцлагатай уул уурхай, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлж, түүнээс олох орлогыг ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн бие даасан хөгжлийг хангах олон тулгуурт бүтцийг бий болгох, хүний хөгжлийг дэмжиж, боловсрол, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд зарцуулна.

3.2.1.4. Дэд бүтцийн салбарын хөгжлийг үндэсний аюулгүй байдлын шаардлагад нийцүүлж, хөрөнгө оруулалтад эдийн засгийн үр ашгийг шалгуур болгоно. Төмөр замын сүлжээг байгуулахдаа Монгол Улсын үндэсний ашиг сонирхлыг эрхэмлэнэ.

3.2.1.5. Монгол орны цэвэр байгаль, оюуны нөөц, газар зүйн давуу талд түшиглэсэн, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай, агаарын тээвэр, мэдээллийн технологи ашиглан экспортлох боломжтой өндөр өртөг бүхий бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг түлхүү дэмжин хөгжүүлнэ.

3.2.1.6. Боловсролын салбарт олон улсын стандартыг мөрдүүлж, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, хүний хөгжлийг дээшлүүлэхэд чиглүүлнэ.

3.2.1.7. Шинжлэх ухааны шинжилгээ, судалгаа, инновацийг стратегийн ач холбогдолтой салбаруудад төвлөрүүлж, эдийн засгийн бүтээмж, өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлнэ.

3.2.1.8. Өндөр технологийн хөгжлийг дэмжиж, нанотехнологи, биотехнологи, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадавхийг хөгжүүлнэ.

3.2.1.9.Дотоодын хөдөлмөрийн зах зээлээ хамгаалж, иргэдээ ажлын байраар найдвартай хангах замаар ядуурлыг арилгах тууштай бодлого хэрэгжүүлнэ.

3.2.2.Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого

3.2.2.1.Үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь, оролцоог нэмэгдүүлэх, хамгаалах бодлого хэрэгжүүлж, бизнесээ өргөжүүлэх, олон улсын тавцанд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.

3.2.2.2.Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална.

3.2.2.3.Монгол Улсын үнэ цэнэтэй аж ахуйн нэгжүүдийн хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээлд борлуулахдаа гадаадын хөрөнгө оруулалтын чиглэлээр баримтлах бодлогын зарчим алдагдахгүй байх эрх зүйн орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2.2.4.Гадаадын хөрөнгө оруулалтыг өрсөлдөх чадвар, санхүү, менежментийн үр өгөөжийг дээшлүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, урт хугацааны хөгжлийн үндсийг тавих чухал хөшүүрэг, арга хэрэгсэл болгоно.

3.2.2.5.Гадаад худалдааны дамжин өнгөрөх тээврийн нөхцөлөөс хэт хараат байдлыг бууруулж, далайд гарцгүй орны хувьд тээврийн салбарт хөрш орнуудтай хоёр болон гурван талын урт хугацааны, харилцан ашигтай хэлэлцээр байгуулна. Эскпортын бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах далайн боомтуудтай болох, боомт хүртэл тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх тээврийн эргэлтийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2.3.Төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдал

3.2.3.1.Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, урт хугацааны өсөлт хөгжлийг дэмжих эрүүл, тогтвортой, сахилга баттай санхүүгийн салбарыг төлөвшүүлнэ.

3.2.3.2.Засгийн газрын авах зээл нь бодит эдийн засгийн салбарт чиглэгдэх бөгөөд эдийн засгийн аюулгүй байдлыг хангасан, зохистой харьцаанд байна.

3.2.3.3.Гадаад валют, алтны нөөцийг үндэсний импортын нэг жилийн хэрэгцээг хангах хэмжээнээс багагүй түвшинд байлгана. Цаашид нөөцийг нэмэгдүүлэх, удирдлагыг боловсронгуй болгох урт хугацааны арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2.3.4.Мөнгөний бодлогын үр дүнг дээшлүүлж, үндэсний мөнгөн тэмдэгтийн худалдан авах, хөрвөх чадварыг сайжруулж, тогтворжуулна. Дотоодын гүйлгээ, төлбөр, тооцоонд зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтийг хэрэглэж, үндэсний мөнгөн тэмдэгтийн дотоодын зах зээлд эзлэх хувь, хэмжээг зохистой хэмжээнд байлгана.

3.2.3.5.Банк дундын эрсдлийн сан байгуулж, санхүүгийн байгууллагын буруугаас үүдсэн аливаа хохирлыг төр харнуцах зарчмаас татгалзана.

3.2.3.6.Гадаад, дотоод томоохон төлбөр, тооцоо, зээл, аккредитивийн хөдөлгөөнд хяналт тавих, эдийн засаг, санхүүгийн салбарын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгаж шийдвэрлэх тогтолцоог хөгжүүлнэ.

3.2.4.Эрчим хүч, эрдэс баялгийн салбарын бодлого

3.2.4.1.Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхдээ үндэсний аюулгүй байдлын баталгааг хангахыг чухалчилж, түүхий эдийн хавсарга, гадаад, дотоодын улс төр, бизнесийн ашиг сонирхлын сөргөлдөөний талбар болох, байгаль орчныг доройтуулахаас сэргийлнэ. Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлж, орлогод тавих хяналтыг сайжруулна.

3.2.4.2.Эрчим хүчний дотоодын гол эх үүсвэр болох нүүрсийг импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, орон нутагт үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байраар хангах зорилгоор өргөнөөр ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. Байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, 2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана.

3.2.4.3.Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг багасгаж, улмаар 2020 он гэхэд дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээг бүрэн хангана. Үнийн хэт хэлбэлзэлд өртөх эрсдэлээс сэргийлж, улсын нөөцийг түүхий нефтээр 6 сараас доошгүй хэмжээнд байлгана.

3.2.4.4.Цөмийн эрчим хүчний салбарыг үндэсний ашиг сонирхол, энхийн зорилгоор ашиглах зарчимд нийцүүлэн хөгжүүлнэ. Цөмийн циклийг хөгжүүлж, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт, боловсруулалт, хөрвүүлэлт, баяжуулалт, эрчим хүчний үйлдвэрлэлийг бий болгож, бэхжүүлнэ.

3.2.5.Гадаад худалдаа, интеграцийн бодлого

3.2.5.1.Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна.

3.2.5.2.Гадаад худалдааны алдагдлыг багасгаж, тарифын болон тарифын бус арга хэрэгслийг дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зохистой хэрэглэнэ. Стратегийн бараа, түүхий эдээр үндэсний үйлдвэрлэлийг найдвартай хангаж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн импортын таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2.5.3.Нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримтална.Түүхий эд бэлтгэл, бөөний болон жижиглэн худалдаанд үнийн зохиомол хэлбэлзэл, монополий, шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулна. Дотоодын үйлдвэрлэл, зах зээлийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

3.2.5.4.Бүс нутгийн болон олон улсын интеграцид нэгдэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг эдийн засгийн аюулгүй байдал, хөгжлийн шаардлагыг харгалзан, судалгаа, тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлнэ.

3.3.Дотоод аюулгүй байдал

Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшилийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн.

3.3.1.Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлэх

3.3.1.1.Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон төрийн удирдлагын болон байгууламжийн хэлбэр, төрийн эрх мэдлийн хуваарилалт, ардчилал, эрх зүйт ёс, үндэсний эв нэгдлийг хангах зарчмыг тууштай хэрэгжүүлнэ.

3.3.1.2.Нутаг дэвсгэрийн хуваарь, сонгуулийн тогтолцоог үндэсний нийтлэг ашиг сонирхол, улс үндэсний нэгдмэл хөгжлийн зорилгод нийцүүлнэ.

3.3.1.3.Төрийн эрх мэдлийг Үндсэн хуулийн бус аргаар авахыг завдсан аливаа оролдлоготой шийдвэртэй тэмцэнэ. Энэ чиглэлд иргэний сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулж, сонгууль хараат бусаар явагдах нөхцөлийг хангана.

3.3.1.4.Гадаадын аливаа хүчний зүгээс Монгол Улсын сонгуулийн үр дүнд нөлөөлөх оролдлого гаргахаас сэргийлэх, илрүүлж таслан зогсоох эрх зүй, зохион байгуулалтын үндсийг бэхжүүлнэ.

3.3.1.5.Хүний эрх, эрх чөлөөг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлж, энэ чиглэлд институт хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулна.

3.3.1.6.Хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн байгууллагын эрх мэдлийн хяналт-тэнцлийг хангана.

3.3.1.7.Иргэн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх үзэл санааг дээдэлсэн хараат бус, хариуцлагатай шүүхийг төлөвшүүлнэ. Шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх эдийн засгийн баталгаа бий болгоно.

3.3.2.Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагыг бэхжүүлэх

3.3.2.1.Иргэдэд адил тэгш, хүртээмжтэй үйлчилдэг, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, төрийн албыг мэргэшсэн, чадварлаг хүмүүсээр бүрдүүлэх бодлого баримтална. Цахим засгийг хөгжүүлэх замаар төрийн алба, үйлчилгээг иргэндээ хандсан, үр нөлөөтэй, шуурхай, хэмнэлттэй болгоно.

3.3.2.2.Авлигатай хийх тэмцлийг үндэсний хэмжээнд өрнүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагын идэвхтэй оролцоог хангана. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлж, авлигыг үл тэвчих үзлийг нийгэмд төлөвшүүлнэ.

3.3.2.3.Төрийн бодлогын залгамж чанарыг хангах эрх зүй, зохион байгуулалтын үндсийг бүрдүүлнэ.

3.3.2.4.Бодлогын оновчтой арга, хэрэгслээр дамжуулан эдийн засгийн зохицуулалт хийх төрийн удирдлагын чадавхийг сайжруулна.

3.3.2.5.Төрөөс стратегийн ач холбогдолтой эдийн засгийн салбар дахь зайлшгүй үйл ажиллагаанаас бусад бизнест оролцохыг хязгаарлаж, аж ахуйн шинжтэй чиг үүргүүдийг иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх бодлого баримтална.

3.3.2.6.Төрийн албан хаагчид тавигдах ёс зүй, мэдлэг, чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, цалин, хангамжийг нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.3.2.7.Төрийн албан хаагчид аюулгүй байдлын мэдлэг олгож, мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх, шударгаар өрсөлдөх боломж, нөхцөлийг бүрдүүлж, сонирхлын зөрчлийг хуулиар хязгаарлана.

3.3.2.8.Эх орноосоо урван тэрсэлсэн, үндэсний ашиг сонирхлыг хохироосон төрийн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгоно.

3.3.3.Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх

3.3.3.1.Нийгмийн ёс суртахуун, сэтгэл зүйн төлөвшил, үнэт зүйлсийн нэгдмэл байдлыг хангах нь үндэсний аюулгүй байдал, эв нэгдэл, зөвшилцлийг хангах суурь болно.

3.3.3.2.Эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төрт ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх бодлогыг төр, иргэн, хэвлэл мэдээллийн салбар хамтран хэрэгжүүлнэ.

3.3.3.3.Үндэсний аюулгүй байдал, хөгжил дэвшлийн баталгаа болсон үндэсний эв нэгдэл, нийгмийн зөвшилцлийг бэхжүүлж, улс орон, нийгмийг хагалан бутаргах, дотоодын зөрчил, тэмцэлд хүргэх аливаа үйл явдлаас урьдчилан сэргийлнэ.

3.3.3.4.Иргэдийг үндэс угсаа, шашин шүтлэг, үзэл бодлоор ялгаварлан гадуурхах, нутгархах үзлийг дэврээх, энэ шалтгаанаар хүний эрх, эрх чөлөөг зөрчих, улмаар үндэсний эв нэгдлийг сарниулж, дотоодын тогтворгүй байдалд хүргэж болох илрэлтэй хатуу тэмцэл хийнэ.

3.3.3.5.Төв, орон нутгийн бүх түвшинд үндэсний нийтлэг ашиг сонирхол, төрийн бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг дээдэлнэ. Монгол Улсын нутаг дэвсгэрт төрийн албан хэргийг монгол хэлээр хөтлөн явуулна.

3.3.4.Нийгмийн тогтвортой байдал

3.3.4.1.Ардчилсан тогтолцооны тулгуур болох улс төрийн намуудын төлөвшил, дотоод ардчиллыг дэмжиж, улс үндэстэн хийгээд нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг нь өндөржүүлнэ. Үндэсний язгуур эрх ашгийн үүднээс улс төрийн намын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зөвшилцөлд хүрэх механизмыг хөгжүүлнэ.

3.3.4.2.Төрийн бодлого боловсруулах, төрд хяналт тавихад төрийн бус байгууллагын тэгш оролцоо, зөвшилцлийг хангах замаар иргэний нийгмийн төлөвшлийг дэмжинэ. Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлж, төр-иргэний нийгмийн хамтын ажиллагааны бүтээлч арга, хэлбэрүүдийг хөгжүүлнэ.

3.3.4.3.Хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, хариуцлагатай, мэргэшсэн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, нийгмийн тогтвортой байдлыг хангана.

3.3.4.4.Нийгэмд хууль ёс, дэг журам, сахилга, хариуцлага суларч эмх замбараагүй байдал бий болохоос сэргийлнэ.

3.4.Хүний аюулгүй байдал

Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн.

3.4.1.Эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэх

3.4.1.1.Нийгмийн эрүүл мэндийн салбарын хөгжлийг дэмжиж, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлыг бүх шатны боловсролын байгууллага, хэвлэл мэдээллээр дамжуулан хэрэгжүүлнэ.

3.4.1.2.Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх, бие бялдраа чийрэгжүүлэх орчин, нөхцөлийг хүүхэд, залуучууд, иргэн бүрт хүртээмжтэй хэлбэрээр хөгжүүлнэ.

3.4.1.3.Хүн амын дунд хоол тэжээлийн зохистой хэрэглээг төлөвшүүлж, зонхилох халдварт бус өвчнөөс сэргийлэн бичил тэжээлийн дутлыг бууруулна.

3.4.1.4.Өргөн тархалттай, шинэ болон сэргэж байгаа халдварт өвчний тандалт судалгааг өргөжүүлж, халдварыг эрт илрүүлэх, тархалтаас сэргийлэх арга хэмжээ авна.

3.4.1.5.Халдварт өвчний нийтийг хамарсан тархалт, гамшгийн үед авах арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, урьдчилан сэргийлэх эм, тарилга, вакцин, биобэлдмэлийн улсын нөөцийг бүрдүүлнэ.

3.4.1.6.Хорт хавдар болон бусад зонхилон тохиолдох халдварт бус өвчнийг эрт илрүүлж, оношлох, эмчлэх, осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулах арга хэмжээ авч, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

3.4.1.7.Эх нялхсын эндэгдлийг бууруулж, төрөлхийн хөгжлийн гажгийг эрт оношлох арга хэмжээ авна.

3.4.1.8.Хүн амд эрүүл мэндийн анхан шатны багц тусламж, үйлчилгээ, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх тогтолцоог бэхжүүлж нийгэд тэгш, хүртээмжтэй болгоно.

3.4.1.9.Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгож иргэдийг эмнэлгийн тусламж, үйлчилгээний улмаас үүсэх санхүүгийн эрсдэлээс хамгаална.

3.4.1.10.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэлтгэх тогтолцоонд олон улсын стандартыг мөрдүүлж, оношлогоо, эмчилгээний олон улсын дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлнэ.

3.4.1.11.Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед шаардлагатай эмнэлгийн тусламжийг хүн амд шуурхай хүргэх чадавхийг байнга дээшлүүлнэ.

3.4.1.12.Эмнэлгийн хэрэгсэл, эм, вакцин, биобэлдмэлийн үйлдвэрлэл, худалдаа, экспорт, импортод тавих стандартын шаардлага, хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгож, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлж, биотехнологийн цогцолбор байгуулах замаар чанар, аюулгүй байдлыг хангана.

3.4.2.Хүнсний аюулгүй байдал

3.4.2.1.Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн зохистой нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.4.2.2.Монгол хүний амьдралын зайлшгүй хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний 70-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэлээр тогтвортой хангах техник, эдийн засгийн арга хэмжээ авна.

3.4.2.3.Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулах урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах, гамшгийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц, хот, суурин газрын хүн амын хүнсний эрэлт нийлүүлэлтийг тогтвортой байлгах улирлын нөөцийг бүрдүүлэх замаар хүнсний хангамжийн баталгааг хангана.

3.4.2.4.Хүн амыг ундны усаар хүртээмжтэй хангах, чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг өндөржүүлэх арга хэмжээ авна.

3.4.2.5.Хүнсний түүхий эд бэлтгэл, үйлдвэрлэл, худалдаа-үйлчилгээ, хадгалалтын бүх үе шатуудад чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоог бий болгоно.

3.4.2.6.Мал эмнэлгийн тогтолцоог шинэчилж, малын халдварт өвчинтэй тэмцэх чадавхийг дээшлүүлж, халдвар, хамгаалал, биоаюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгоно. Монгол малын удмын сан, үр тарианы нутагшмал сортыг хамгаална. Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хүнсний сав, баглаа боодол, бордоо, ургамал хамгааллын бодис ашиглах хяналтыг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ.

3.4.2.7.Хүнсний чанар, аюулгүй байдлын техникийн шаардлагыг олон улсын стандарттай нийцүүлэн шинэчилж, хяналтын тогтолцоог бэхжүүлэн, олон улсын итгэмжлэлд хамруулах арга хэмжээ авна.

3.4.2.8.Хүнсний бүтээгдэхүүнийг зөвхөн аж ахуйн нэгж, байгууллагаар дамжуулан импортлох тогтолцоог бүрдүүлж, импортын хүнсний бүтээгдэхүүнд чанарын урьдчилсан хяналт, бүртгэлжүүлэлт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоо бий болгох, импортлох үеийн чанарын баталгаат байдалд эрсдэлийн үнэлгээ хийх замаар чанар, аюулгүй байдлын баталгааг хангана.

3.4.2.9.Нанотехнологи, биотехнологийн эрсдэлийг үнэлэх, хянах, түүний хор хөнөөлөөс хамгаалах арга хэмжээ авна.

3.4.3.Амьдрах орчны аюулгүй байдал

3.4.3.1.Иргэдийн амьдрах, ажиллах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний аюулгүй байдлыг баталгаажуулах чухал үндэс болно.

3.4.3.2.Нийслэлийн хүн амын төвлөрлийг тархаан байршуулах зорилгоор дагуул хотуудыг төлөвлөж, нийслэл орчмын бүс нутгийг өндөр хурдны авто зам, эрчим хүч, инженерийн барилга байгууламжаар найдвартай хангаж холбоно.

3.4.3.3.Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг иргэдийн аюулгүй ажиллаж амьдрах нөхцөлийг бий болгох зорилтод нийцүүлэн шинэчилж, хот байгуулалтад төлөвлөлтийг хатуу мөрдөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

3.4.3.4.Томоохон хот, суурин газарт агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, ариун цэврийн байгууламжийн бүтээмжийг нэмэгдүүлж, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгоно.

3.4.3.5.Орон сууц, үйлдвэрлэл, үйлчилгээний барилга, инженерийн байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэрлэлтэд үнэлгээ өгч, 8 баллын газар хөдлөлтийг тэсвэрлэх шаардлага хангахгүй барилга, байгууламжийг хүчитгэх, буулгаж шинээр барих зохицуулалт хийнэ.

3.4.3.6.Барилга, барилгын материалын чанар, эрүүл ахуйн стандартыг олон улсын стандартын түвшинд нийцүүлж, чанарын хяналтыг мэргэжлийн холбоод, хөндлөнгийн хяналтын байгууллагаар хийлгэх тогтолцоонд шилжинэ.

3.4.3.7.Амьдрах орчныг эрүүлжүүлэхэд иргэдийн үүрэг, хариуцлага, оролцоог нэмэгдүүлнэ.

3.4.4.Иргэдийг үндэстэн дамнасан гэмт хэргээс хамгаалах

3.4.4.1.Иргэдийн терроризм, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүчирхийллээс хамгаалагдах нөхцөлийг сайжруулна.

3.4.4.2.Хүүхэд, эмэгтэйчүүд, иргэдийг хүн худалдах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсохтой холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгож энэ чиглэлд бэхжүүлнэ.

3.4.4.3.Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус хэрэглээтэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлнэ.

3.4.4.4.Нийгэмд эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаархи сургалт, сурталчилгааг эрчимжүүлж, олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлнэ.

3.5.Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал

Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомсдлоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн.

3.5.1.Усны нөөцийн хомсдлоос сэргийлэх

3.5.1.1.Усны салбарын бүтэц, зохион байгуулалт, хяналтын механизмыг боловсронгуй болгож, ашиглагч нь хамгаалах, хариуцлага хүлээх тогтолцоог бий болгож, хүн амын ундны ус хангамж, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хүртээмжтэй, тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.5.1.2.Усны үнэлэмжийг нэмэгдүүлэх, нөөцийг хамгаалах, өсгөх ажлыг санхүүжүүлэх механизмыг тодорхой болгох, улсын төсвийн хөрөнгөөр хийсэн усны эрэл, хайгуулын зардлыг эргэн төлүүлэх чиглэлээр эрх зүйн зохицуулалт хийнэ.

3.5.1.3.Газрын доорх усны нөөцийг шинэчлэн тогтоох усны эрэл, гидрогеологийн зураглалын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хийж нөөцийг бүртгэлжүүлж мэдээллийн сан, хяналт-шинжилгээний сүлжээ, судалгаа шинжилгээний байгууллагын чадавхийг бэхжүүлнэ.

3.5.1.4.Газрын доорх цэнгэг усны томоохон ордууд, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах, цэвэр усны нөөц бүхий томоохон нуурын сав газарт аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах замаар усны нөөцийг хамгаална.

3.5.1.5.Усны сав газрын менежментийн тогтолцоог нэвтрүүлж, тухайн сав газрын хэмжээнд экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр ашиглах боломжтой гадаргын болон газрын доорх усны нөөцийг тогтоож, ашиглалтыг тогтоосон хэмжээнд нь хатуу барина. Аль нэг ашиглагчид давуу эрх олгохгүй байх эрх зүйн зохицуулалт бий болгоно.

3.5.1.6.Хангай, Хэнтийн нурууны усны эх, Хөвсгөл нуур орчмын газрыг Үндэсний парк байгуулах замаар улсын нөөцөд авч, уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

3.5.1.7.Гадаргын усны ашиглалтыг сайжруулах үүднээс томоохон гол, мөрөнд урсацын тохируулга хийж, бороо, цас, мөсний усыг хуримтлуулж нөөцлөх усан санг ууршил багатай, эрчим хүчний нөөц ихтэй бүс нутагт байгуулж, говь, тал хээрийн ууршил ихтэй бүсэд усыг нөөцлөх, дамжуулах далд систем барьж байгуулна.

3.5.1.8.Усны хэмнэлттэй хэрэглээ, технологийг нэвтрүүлэх, ус, эрчим хүчний ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх, газар тариалангийн усалгаанд газрын доорх усыг ашиглах болон хүнсний бус үйлдвэрлэлийн салбарт ундны цэвэр усыг ашиглах явдлыг хязгаарлах, хаягдал усыг дэвшилтэт технологиор цэвэршүүлэх, цэвэршүүлсэн хаягдал ус болон саарал усыг дахин ашиглахыг бодлогоор дэмжинэ.

3.5.2.Уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын үр дагаврыг бууруулах

3.5.2.1.Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтөд дасан зохицох, сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх бодлого тодорхойлох, чадавхийг бүрдүүлэх, уг бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндэсний бүтцийг бий болгох, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд олон улсын санхүүгийн механизмыг өргөн ашиглах, бүх талын оролцоог хангах арга хэмжээ авна.

3.5.2.2.Бэлчээр ашигласны төлбөр тогтоох, эзэмшүүлэх, хамгаалах болон нөхөн сэргээх хариуцлага хүлээлгэх чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээрийн одоогийн төлөв байдал, цаашдын хандлагад суурилсан бэлчээрийн даацыг бүс нутаг бүрээр шинэчлэн тогтоож малын тоо толгой, төрөл, сүргийн бүтцийн зохистой харьцааг хангана.

3.5.2.3.Бэлчээрийн нөөц газар, Мэнэнгийн тал, говийн баянбүрд, заган ойг улсын тусгай хамгаалалтад авч тал хээрийн эмзэг бүс нутгийн хөрс, ургамал өөрөө нөхөн төлжих боломжийг бий болгох, хөрсний үржил шим, чийгийг хамгаалах нөөц бололцоо бүрдүүлнэ.

3.5.2.4.Газар тариаланд хөрс хамгаалах, тордох, ойн зурвас байгуулах, усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар тус салбараас үүдэх газрын бүрхэвчийн доройтлыг бууруулна.

3.5.2.5.Бэлчээрийн мал аж ахуй, малчдын ахуй амьдралд шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, уламжлалт сэтгэлгээ, арга хэвшлийг сэргээж, хурдацтай явагдаж байгаа экосистемийн өөрчлөлтийг мэдэрч түүнд тохирсон амьдралын хэв маяг, аж ахуй эрхлэх менежментийн арга барилыг боловсруулж заан сургах, туршин нэвтрүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон нийтэд хүргэх сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ.

3.5.2.6.Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, газрын хэвлийг ашиглагч нь хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг үр дүнтэй болгоно.

3.5.2.7.Байгаль орчны боловсролыг олон нийтэд системтэйгээр олгож, газар дэлхий, уул усаа хайрлан хамгаалж ирсэн ардын болон шашны зан уламжлалыг түгээн дэлгэрүүлэх ажлыг сүм хийд, иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

3.5.3.Биологийн олон янз байдлыг хадгалах, нөөцийн хомсдлоос сэргийлэх

3.5.3.1.Ой, амьтан, ургамал зэрэг байгалийн нөөц баялгийг судлах, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэсэн арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй цогц байдлаар шийднэ.

3.5.3.2.Байгалийн баялгийн менежментэд экологийн үр дагаврыг нарийн тооцож байх зарчим баримталж хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хангана.

Байгалийн нөөц баялгийн экологи-эдийн засгийн үнэлгээг бодитой тогтоож, хохирол барагдуулах хариуцлагын тогтолцоог бий болгоно.

3.5.3.3.Байгалийн ургамал, ойн дагалт нөөцийн экспорт болон ойн үндсэн ашиглалтын огтлолтыг бүрэн хориглож, ойн сангийн нөөцийг 2 хувиар нэмэгдүүлнэ.

3.5.3.4.Мод орлох технологи нэвтрүүлэхийг дэмжих, энэ төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж түлшний асуудлыг цогц байдлаар шийдэх, мод, модон бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

3.5.3.5.Нэн ховор, ховор болон экосистемд онцгой үүрэгтэй амьтан, ургамал бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авч, тэдгээрийн амьдрах орчныг тэтгэхэд биотехникийн аргыг түлхүү хэрэглэнэ. Нэн ховор, ховор амьтан, ургамал болон бичил биетний омог, эд, эсийн өсгөврийн сан байгуулна.

3.5.3.6.Харь зүйлийн амьтан, ургамал, бичил биетнийг нутагшуулахдаа биологийн олон янз байдлын удмын санд өөрчлөлт гарахаас сэргийлэх, хяналт тавих тогтолцоог бүрдүүлнэ.

3.5.3.7.Хувиргасан амьд организмтай холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, биоаюулгүй байдлыг хангах, эрсдэлийг үнэлэх, хянах чадавхийг бэхжүүлнэ.

3.5.3.8.Байгаль орчныг хамгаалах талаар бодлогын чанартай шийдвэр гаргах, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, ялангуяа ойжуулах, нэн ховор, ховор, ховордож болзошгүй амьтан, ургамлыг хамгаалах, тарималжуулах, нөхөн сэргээх, хяналт-шинжилгээ хийх ажилд иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, нутгийн иргэдийг түлхүү татан оролцуулах зарчим баримтална.

3.5.4.Хүрээлэн байгаа орчны бохирдлыг бууруулах

3.5.4.1.Бохирдуулагч нь төлбөр төлөх, учруулсан хохирлоо барагдуулах хариуцлага хүлээх механизмыг хэрэгжүүлж, бохирдлын эх үүсвэрт хаягдлын хязгаарлалт тогтоож, байгальд халтай, хаягдал ихтэй техник, технологийг хориглож, хог хаягдлыг бууруулсан дэвшилтэт технологийг дэмжинэ.

3.5.4.2.Хил дамжсан агаар, усны бохирдлын асуудлаар олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхийг бэхжүүлнэ.

3.5.4.3.Хог хаягдлаас эрчим хүч, нөөц баялаг, түүхий эд бий болгох технологи бүхий үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ. Аюултай хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож хортой, аюултай хаягдал хуримтлагдахаас сэргийлнэ.

3.5.4.4.Түүхий нүүрсийг дулааны аргаар гүн боловсруулах, хийжүүлэх, шингэрүүлэх замаар эрчим хүч, дулааны үйлдвэрлэл, ахуйн хэрэглээний цэвэр түлш үйлдвэрлэх, аливаа үйлдвэрлэлийн технологид хэмнэлттэй, дэвшилтэт байх шаардлагыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр дамжуулан тавина. Нар, салхины сэргээгдэх эрчим хүч ашиглалтыг нэмэгдүүлж, цөмийн эрчим хүчийг ашиглана.

3.5.4.5.Химийн хорт болон аюултай бодис, биологийн гаралтай материал, ионжуулагч цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт ашигт малтмалтай холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хяналтын чадавхийг бэхжүүлнэ.

3.5.5.Байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах

3.5.5.1.Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авна.

3.5.5.2.Гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлж эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлж, чадавхийг бэхжүүлнэ.

3.5.5.3.Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, урьдчилан мэдээлэх арга, технологи нэвтрүүлэх, хяналт-шинжилгээний сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах техник хэрэгсэл, хүний нөөцийг системтэйгээр бэлтгэж, мэдээллийг хэрэглэгчид шуурхай хүргэх арга замыг боловсронгуй болгон эртнээс сэрэмжлүүлэх чадавхийг бүрдүүлнэ.

3.6.Мэдээллийн аюулгүй байдал

Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн.

3.6.1.Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах

3.6.1.1.Үндэсний аюулгүй байдлыг хангах, улс орны хөгжлийг дэмжих, үндэсний үнэт зүйлийг хэвшүүлэх, нийгмийн оюун санааг төлөвшүүлэхэд мэдээлэл, мэдээллийн аюулгүй байдал нэн чухал ач холбогдолтой.

3.6.1.2.Нийгмийн сэтгэл зүй, тогтвортой байдал, хувь хүний ухамсар, ёс зүйд хөндлөнгөөс нөлөөлөх оролдлогыг хязгаарлана. Дайсагнал, ялгаварлан гадуурхах үзэл, үзэн ядалтыг сурталчилсан, дэмжсэн сурталчилгаа, мэдээллийг таслан зогсоох, саармагжуулах чадавхийг бий болгож, үл зөвшөөрөх сэтгэхүйг нийгэмд төлөвшүүлнэ.

3.6.1.3.Үндэсний мэдээллийн дэд бүтцэд халдах аюулаас хамгаалах, эдийн засаг, нийгмийн чадавхийг сулруулах оролдлоготой тэмцэх чадавхийг бий болгоно.

3.6.1.4.Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай хэвлэл мэдээллийн хэрэгсэл үндэсний аюулгүй байдалд харшилсан үйл ажиллагаа явуулбал үйл ажиллагаа явуулах эрхийг нь хязгаарлаж болно. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх бөгөөд үйл ажиллагаа нь бодитой, тэнцвэртэй, хариуцлагатай байна. Мэдээллийн хэрэгслээр үндэсний үнэт зүйлийг түлхүү нийтлэх, сурталчлахыг дэмжиж, гадны шашин, соёл, төрийн бодлогыг сурталчилсан агуулгатай мэдээллийг зохистой түвшинд хязгаарлана.

3.6.1.5.Мэдээллийн аюулгүй байдлын үндэсний хэмжээний бодлого, эрх зүйн зохицуулалт, стандарт, удирдлага, зохион байгуулалт, сургалтын тогтолцоог бий болгож нийгэм дэх ойлголт, мэдлэгийг төлөвшүүлнэ.

3.6.1.7.Төр, хувийн хэвшлийн байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын бодлого, дэг, эрсдэлийн удирдлага, дотоод аудит, үнэлгээний чадавхийг бий болгоно.

3.6.1.8.Мэдээллийн аюулгүй байдлын орчин үеийн дэвшилтэт, өртөг багатай шийдлийг зөвхөн эрсдэлийн үнэлгээний үндсэн дээр сонгон ашиглана. Төрийн байгууллага, онц чухал дэд бүтцийн объектын мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг өндөр түвшинд бэлтгэгдэж, итгэмжлэгдсэн үндэсний мэргэжилтнээр гүйцэтгүүлнэ.

3.6.1.9.Өрсөлдөх чадвартай мэдээлэл, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэл болон мэдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах ажиллагааг дэмжин хөгжүүлж технологийн хараат байдлыг бууруулна.

3.6.1.10.Мэдээлэл, харилцаа холбооны технологи, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр үндэсний суурь болон хавсарга судалгаа, шинжилгээ, сургалтыг онцгойлон дэмжинэ.

3.6.1.11.Кибер орчин дахь гэмт явдалтай тэмцэх, аливаа гэмт хэргийг илрүүлэх, нотлоход тооцоолох хэрэгслийн криминалистик техникийн шинжилгээ ашиглах үндэсний чадавхийг бий болгоно.

3.6.1.12.Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн орчинд сөргөлдөх аюулаас сэргийлэх, кибер орчин дахь гэмт явдалтай тэмцэх чиглэлд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

3.6.2.Мэдээллийн бүрэн бүтэн байдал

3.6.2.1.Мэдээлэл, мэдээллийн орчин, түүний дэд бүтцэд хууль бусаар нөлөөлөх, өөрчлөх үйлчлэлээс хамгаалснаар мэдээллийн бүрэн бүтэн байдал хангагдана.

3.6.2.2.Төрийн мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангахын тулд үнэн, бодитой, цаг үеэ олсон, шаардлагатай мэдээллийг төрийн мэдээллийн санд төвлөрүүлж, эрх бүхий этгээд хамтран ашиглах, солилцох нөхцөлийг бүрдүүлнэ.

3.6.2.3.Хуулиар зөвшөөрсөн, өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд хувь хүний тухай мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, бусдад шилжүүлэхийг хориглоно.

3.6.2.4.Үндэсний мэдээллийн орчин, дэд бүтцийн эмзэг байдлыг бууруулах тогтолцоог бүрдүүлнэ.

3.6.2.5.Цахим мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангахын тулд тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг хөгжүүлэх, сүлжээ, систем, веб сайтын эмзэг байдлыг бууруулах, адилтган таних бат бэх систем, хортой кодоос хамгаалах удирдлага, өөрчлөлтийн удирдлагыг нэвтрүүлэх замаар дэд бүтэц, харилцаа холбоо, дамжуулалт, хандалтын нууцлал, хамгаалалтыг бүрдүүлнэ.

3.6.2.6.Мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг хөгжүүлэхэд төр-хувийн хэвшлийн түншлэлийн зарчмуудыг ашиглах, мэдээллийн аюулгүй байдлын дотоод аутсорсингийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

3.6.3.Мэдээллийн нууцлал

3.6.3.1.Мэдээлэл, түүний бүрдэл хэсэгт хууль бусаар хандах, халдах, задрахаас хамгаалагдсанаар нууцлал хангагдана.

3.6.3.2.Төрийн мэдээллийн ангилал, нууцын зэрэглэлийг оновчтой болгож, нууц хамгаалалтыг шинэ түвшинд гаргах эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.

3.6.3.3.Төрийн өгөгдөл мэдээллийг ангилж, үнэ цэнийг тогтоох, бүртгэх, хадгалах, дамжуулах, шилжүүлэх, хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгож мөрдөнө.

3.6.3.4.Харилцаа холбооны шугам, сувгаас мэдээлэл алдагдах, гадагш урсахаас урьдчилан сэргийлэх, төрийн сүлжээ, өгөгдөл солилцооны хамгаалагдсан дэд бүтцийг байгуулах, утасгүй холбооны аюулгүй байдлыг хангана.

3.6.3.5.Төрийн байгууллага, онц чухал дэд бүтцийн объектод чиг үүрэгт суурилсан хандалтын удирдлага, сүлжээний хяналт-шинжилгээ хийх, халдлагыг илрүүлж таслан зогсоох чадварыг бий болгоно.

3.6.3.6.Төрийн байгууллага, онц чухал дэд бүтцийн объектын цахим өгөгдлийг дамжуулах, хадгалахдаа шифрлэлт, тоон гарын үсэг, аюулгүй холболт ашиглана.

3.6.3.7.Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хувийн болон гэр бүлийн нууц, захидал харилцаа, мэдээллийн нууц, нэр төрөө хамгаалах эрх, эрх чөлөөнд халдахыг хориглоно.

3.6.4.Мэдээллийн хүртээмжтэй байдал

3.6.4.1.Хуулиар хориглоогүй мэдээллийг чөлөөтэй хайх, олж авах, үүсгэх, дамжуулах, түгээх эрх, эрх чөлөөг хангах, мэдээллийн дэд бүтэц, түүний бүрдэл хэсэг, үйлчилгээнд чөлөөтэй хандах боломжийг бүрдүүлснээр мэдээллийн хүртээмжтэй байдал хангагдана.

3.6.4.2.Улс үндэстний өмнө тулгамдаж байгаа аюул, заналхийлэл, эрсдэлийн талаар төрийн бодлого боловсруулагчид, нийт иргэн, ард түмэн өргөн мэдээлэл, нэгдмэл ойлголттой байх нь үндэсний аюулгүй байдлыг хангах суурь нөхцөл болно.

3.6.4.3.Үндэсний аюулгүй байдлын мэдээллийн сан бүрдүүлж, Улсын Их Хурал, орон нутгийн иргэдийн төлөөллийн байгууллага, хэвлэл мэдээллээр дамжуулан иргэдийг үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлуудаар өргөн хүрээтэй мэдээллээр хангах механизмыг бий болгоно. Төрийн мэдээллийн нээлттэй нөөцийг бүрдүүлэх ажиллагааг эрчимжүүлж, тэдгээрийг цахим засгийн үйлчилгээнд үр нөлөөтэй ашиглах боломжийг бүрдүүлнэ.

3.6.4.4.Нийгэмд мэдээллийг хүртээмжтэй, түргэн, шуурхай хүргэх мэдээллийн хэрэгсэл, дэд бүтцийн хөгжлийг дэмжиж найдвартай ажиллагааг хангана.

3.6.4.5.Хэвлэл мэдээллийн байгууллагад хуулиар хориглоогүй мэдээллийг эрэн сурвалжилж олж авах, нийгэмд түгээхэд таатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

3.6.4.6.Үндэсний мэдээллийн дэд бүтцийн бэлэн байдал, халдлагыг сөрөн зогсох, даван гарах чадварыг бий болгож, тасралтгүй ажиллагааг хангах, сэргээн ажиллуулах төлөвлөлтийг хэвшүүлж, сүлжээний хяналт шинжилгээ, анхааруулгын төв байгуулж, компьютерын онцгой байдлын үед хариу үйлдэл хийх үндэсний тогтолцоог дэмжин хөгжүүлнэ.

ДӨРӨВ.ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТОГТОЛЦОО

Хурдтай хувиран өөрчлөгдөж байгаа аюулгүй байдлын орчинд үндэсний ашиг сонирхлоо тууштай хамгаалах, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа бататгахын тулд үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгож хөгжүүлэх шаардлага тулгарч байна.

4.1.Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгох зорилт

4.1.1.Төрийн бүх шатны үйл ажиллагаанд үндэсний ашиг сонирхлыг дээдэлж, төрийн анхдагч үүрэг болсон үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг чухалчилна.

4.1.2.Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог нэгдмэл, үр нөлөөтэй, боловсронгуй болгох чиглэлд шаардлагатай эрх зүй, удирдлага, зохион байгуулалтын шинэчлэл хийнэ.

4.1.3.Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоо сайжруулж, ажил үүргийн давхцал, хийдлийг арилгаж, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгоно.

4.1.4.Аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчид тавих ёс зүй, мэргэжлийн чадвар, хариуцлага, хууль сахин биелүүлэх шаардлагыг өндөржүүлж, эрх зүй, нийгмийн хамгааллын баталгааг дээшлүүлнэ.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 10

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлал, цэргийн номлол батлах, нийтлэх тухай" Улсын Их Хурлын 1994 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 56 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

4.1.5. Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа бүхэлдээ мэдээлэл, дүн шинжилгээнд суурилсан байх нөхцөлийг бүрдүүлж, аюулгүй байдлаа төр-ард түмний нэгдмэл хүчээр хангана.

4.1.6. Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, төрийн холбогдох байгууллага, шийдвэр гаргагчид болон иргэдийг шаардлагатай мэдээллээр цаг тухайд нь хангах, үндэсний аюулгүй байдлын мэдээллийн сан байгуулах ажлыг чухалчилж, түүний бүрдүүлэлт, хамгаалалт, ашиглалтын горимыг шинэчилж хэрэгжүүлнэ.

4.1.7. Аюулгүй байдал, гадаад бодлогын салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын чадавхийг бэхжүүлж, төрийн бодлого боловсруулахад тэдний оролцоог нэмэгдүүлнэ.

4.1.8. Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын идэвх, оролцоог урамшуулж, хамтын ажиллагааны тодорхой арга, хэлбэрийг бэхжүүлж, үр дүнг дээшлүүлнэ.

4.1.9. Гамшиг, гэнэтийн аюул, халдлагатай тэмцэх үндэсний чадавхийг дээшлүүлж, эрсдэлийг бууруулна. Аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд болон төрийн бусад байгууллага онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллах бэлэн байдлын түвшинг шинэ шатанд гаргана.

4.2. Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны бүтэц, удирдлага

4.2.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах үүргийг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Засгийн газар, хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагууд, төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд гүйцэтгэнэ.

4.2.2. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд нь энэхүү үзэл баримтлалын үзэл санааг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомж болон эрх зүйн бусад холбогдох шийдвэрээр бэхжүүлж, тус тусын эрх хэмжээний дотор хэрэгжүүлэх үүрэгтэй.

4.2.3. Монгол Улсын иргэд, иргэний нийгмийн байгууллагууд үндэсний аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомж, энэхүү үзэл баримтлалыг чанд мөрдлөг болгож, тэдгээрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцоно.

4.2.4. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж, төрийн бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг улс орон даяар уялдуулан зохицуулах чиг үүргийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хариуцна.

4.2.5. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл энэхүү үзэл баримтлалыг хэрэгжүүлэх бодлого үйл ажиллагааны тодорхой стратеги, тактикийг уялдуулан зохицуулж, холбогдох дүрэм, журмыг баталж хэрэгжүүлнэ.

4.2.6. Нийслэл, аймаг, сум, дүүргийн Засаг дарга нар орон нутагтаа Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг хүлээнэ.

4.2.7. Холбогдох үүрэг хүлээсэн албан тушаалтнаас тогтоосон хугацаанд ирүүлсэн мэдээ, тайлан болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын шугамаар авсан бусад мэдээлэл нь Үндэсний аюулгүй байдлын мэдээллийн санг бүрдүүлнэ.

4.3. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, хяналт тавих тогтолцоо

4.3.1. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилтэд хяналт, дүн шинжилгээ хийх, аюулгүй байдлын нөхцөл байдалд үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтүүдийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл боловсруулна.

4.3.2. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх салбар зөвлөлийн гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга өөрийн хариуцсан чиглэлээрх мэдээ, тайланг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд ирүүлнэ.

4.3.3. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн биелэлтэд байнгын хяналт тавьж, үндэсний аюулгүй байдлын нөхцөл байдалд үнэлгээ өгнө.

4.3.4. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилт, үндэсний аюулгүй байдлын тухайн жилийн нөхцөл байдлын талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн жил бүр Монгол Улсын Их Хуралд хаалттай мэдээлэл хийнэ.

ТАВ. БУСАД

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаа нь тасралтгүй, хурдтай хувиран өөрчлөгдөх аюулгүй байдлын орчинд нийцэж, шинэчлэгдэн боловсронгуй болж байх шаардлагатай.

--- о0о ---

**Монгол Улсын Их Хурлын 2011 оны
10 дугаар тогтоолын хавсралт**

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

XXI зуун гарсаар дэлхий дахинд даяаршил улам бүр тэлж, шинжлэх ухаан, мэдээллийн технологи үсрэнгүй хөгжин, улс төр, эдийн засгийн интеграц өргөжиж, улс хоорондын харилцан хамаарал гүнзгийрч байна. Олон улсын харилцаа өнгөрсөн зууны сүүлийн хагасын хоёр туйлт үеийнхээс эрс өөрчлөгдлөө. Хөгжлийн шинэ томоохон төвүүд тодорч, олон улсын харилцаанд тэдгээрийн үзүүлэх нөлөө өсөх хандлагатай байна.

Нөгөөтэйгүүр, улс орнуудын хөгжлийн хурд, түвшин улам бүр ялгарч, буурай, эмзэг эдийн засагтай улсуудад ажилгүйдэл, ядуурал буурахгүй байна. Зарим улс, бүс нутагт цөмийн зэвсэгтэй болох оролдлого үргэлжилж, хурцадмал байдал намжихгүй байна. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол хийгээд олон улсын терроризм, хүний болон хар тамхины наймаа, гоц халдварт өвчний тархалт зэрэг аюул, сорилт нэмэгдэх болов.

Монгол Улс ардчилсан ёс, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, зах зээлийн эдийн засаг бүхий улс болж хөгжихийн хамт гадаад харилцаа, хамтын ажиллагаа улам бүр өргөжин тэлж, гадаадад ажиллаж, сурч байгаа иргэдийн тоо үлэмж нэмэгдэв.

Монгол Улс нөөц баялгаа ашиглан эдийн засгийн чадавхийг өсгөх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, хүн амын амьжиргааг дээшлүүлэх эрчимтэй хөгжлийн замд орж байна.

Дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд Монгол Улсын оруулж ирсэн хувь нэмрийг улам өсгөх, үндэсний хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд гадаад харилцааг өргөтгөн хөгжүүлж, түүний үр өгөөжийг улам нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.Монгол Улсын гадаад бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодорхойлон заасан үндэсний ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд тус улсын гадаад, дотоод нөхцөл байдал нь гадаад бодлогын зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох үндэс болно.

2.Монгол Улсын гадаад бодлогын зорилго нь дэлхийн улсуудтай найрсаг харилцаатай байж, улс төр, эдийн засгийн болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх, хөгжил дэвшлийг хурдасгах замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах явдал мөн.

3.Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн.

4.Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулна.

5.Гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангаж, залгамж чанарыг хадгална. Гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангах, төрийн захиргааны төв болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад харилцааг уялдуулан зохицуулах, хяналт тавих үүргийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ.

6.Монгол Улс бусад улстай харилцахдаа бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдал, өөртөө засан тогтнох бүрэн эрхийг харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох, маргаантай асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, эрх тэгш, харилцан ашигтай хамтран ажиллах зэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэмд тодорхойлж, нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ, түүнчлэн хоёр талын харилцааны үндсэн баримт бичгүүдэд заасан бусад зарчмыг удирдлага болгоно.

7.Дэлхий, бүс нутагт нөлөө бүхий улсуудтай харилцаа, хамтын ажиллагааг түлхүү хөгжүүлэхийг зорихын хамт аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэргэжлнэ.

8.Олон улсын харилцааны хөгжил, дэлхийн болон бүс нутгийн улс төрийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад бодлогын чиглэл, зорилтыг уян хатан тогтооно.

9.Монгол Улсын гадаад бодлого нь улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, соёл, хүмүүнлэгийн гадаад бодлого, гадаадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах, гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлого гэсэн харилцан уялдаа бүхий үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Улс төрийн гадаад харилцааны бодлого тодорхойлогч шинжтэй байна.

ХОЁР.УЛС ТӨРИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

10.Монгол Улсын улс төрийн гадаад харилцааны бодлогын зорилго нь тус улсын аюулгүй байдал, хөгжил дэвшлийг хангах таатай гадаад орчин бүрдүүлэх, дипломат болон консулын харилцаа хөгжүүлэх, нөлөө бүхий улсуудтай харилцааныхаа түвшинг дээшлүүлэх, олон улсын байгууллага дахь үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахад оршино.

11.Монгол Улсад гадны цэргийн аюул занал учраагүй нөхцөлд цэргийн аливаа холбоонд нэгдэхгүй, нутаг дэвсгэр, агаар мандаа аль нэг улсын эсрэг ашиглуулахгүй байх, гадаадын цэргийн хүчнийг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхгүй, байрлуулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй байх чиг шугам баримтална.

12.Монгол Улс олон улсын эрх зүйг хүндэтгэн сахиж, гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлнэ.

13.Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд бүс нутгийн болон дэлхийн чанартай тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бүх нийтийн үйл хэрэгт хувь нэмэр оруулахыг чармайна. Тухайлбал:

- ардчиллыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж, идэвхтэй оролцох;

- цөмийн болон үй олноор хөнөөх бусад зэвсэг үл дэлгэрүүлэх, зэвсэг хураах, олон улсын терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, НҮБ-ын болон олон улсын бусад энхийг дэмжих, сахиулах, сэргээн босгох үйл ажиллагаанд оролцох;

- уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сөрөг үр дагаврыг багасгах, байгаль орчныг доройтлоос хамгаалах, гоц халдварт өвчний тархалтаас сэргийлэхэд чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн хүч чармайлтыг дэмжин оролцох.

14.Монгол Улс улс төрийн гадаад харилцааны бодлого хэрэгжүүлэхдээ дараахь чиглэлийг баримтална:

14.1.ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзах;

14.2.АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;

14.3.Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцох;

14.4.Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд болон олон улсын санхүү, худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхтэй үргэлжлүүлэх, дэлхийн засаглал дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллах;

14.5.хөгжиж байгаа улсуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхийн зэрэгцээ Нэгдсэн Үндэстний Байгууллага, "77"-гийн бүлэг, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэг олон талын хүрээнд хамтран ажиллах.

15.Улс төрийн гадаад харилцааны бодлогын чиглэлүүдийг харгалзан тус улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын байршлыг тогтоож, гадаад бодлогыг хэрэгжүүлэх нөхцөлийг сайжруулна.

16.Хөгжлийн эрэлт хэрэгцээ, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгод нийцсэн гадаад бодлогын судалгаа, шинжилгээ, гадаад харилцааны мэргэшсэн хүний нөөцийн бэлтгэл, сургалтын тогтолцоо бүрдүүлнэ.

17.Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газарт дипломат алба, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, технологийн талаар өндөр мэдлэг, боловсролтой, мэргэшсэн ажилтанг оролцуулан томилж, сэлгэн ажиллуулах бодлого баримтална.

ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

18.Үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн аюулгүй байдлыг баталгаажуулах, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд гадаад харилцааны үр нөлөөг нэмэгдүүлэх нь эдийн засгийн гадаад харилцааны бодлогын зорилго мөн.

19.Эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэхдээ эрх тэгш, харилцан ашигтай байх зэрэг нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг чанд мөрдөнө. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтыг үндэс болгон эдийн засгийн аюулгүй байдлыг бүх талаар хангахыг эрмэлзэж, аль нэг улсаас хэт хараат байдалд орохоос сэргэжлнэ.

20.Эдийн засаг, худалдааны чөлөөт бүс, хамтарсан буюу гадаадын дагнасан хөрөнгө оруулалттай аж ахуйн томоохон нэгж байгуулах, концесс олгох, дэд бүтэц шинээр бий болгох зэрэг эдийн засгийн хөгжилд үлэмж нөлөө үзүүлэх төсөл, арга хэмжээг үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгод нийцүүлэн хэрэгжүүлнэ.

21.Эдийн засгийн гадаад харилцааны бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ. Үүнд:

21.1.эдийн засгийн салбаруудад тэргүүний технологи, менежмент нэвтрүүлж, ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар, стандартыг олон улсын жишиг, түвшинд ойртуулан нийцүүлэх замаар өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, экспортын хэмжээг өсгөхийг дэмжих;

21.2.уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эдийг бүрэн боловсруулж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн гаргах, импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байр нэмэгдүүлэх, түүнчлэн мэдлэгт суурилсан үйлдвэрлэл хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

21.3.түлш, эрчим хүч, зам, тээвэр, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн салбарыг хөгжүүлэхэд дөхөм үзүүлэх;

21.4.олон улс, бүс нутгийн эдийн засгийн интеграц болон дэд бүтцийн сүлжээнд нэгдэхийг эрмэлзэх, далайн боомт хүрэх, дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

25.4.Боловсрол, соёл, урлаг, спорт, олон нийт, мэдээллийн олон улсын байгууллагатай идэвхтэй харилцах, шаардлагатай гэрээнд нэгдэн орох, ижил төрлийн байгууллагуудын хооронд шууд харилцаа, солилцоо хөгжүүлэх, соёл, урлаг, спортын олон улсын арга хэмжээнд оролцох, ийм төрлийн арга хэмжээг эх орондоо зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

25.5.Бусад улс дахь монгол туургатнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хэл, соёл, уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

29.7.гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлогыг хэрэгжүүлэхэд ардын болон соёлын дипломатын арга хэлбэрийг хэрэглэх;

29.8.энх тайван, найрамдлын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих.

---oOo---

ЗУРГАА.ГАДААДАД БАЙГАА ИРГЭДИЙНХЭЭ

ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ БОДЛОГО

26.Гадаадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах бодлогын зорилго нь хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, эрх ашгийг хамгаалахад оршино.

27.Гадаадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

27.1.Монгол Улсаас гадаад улсад суугаа бүрэн эрхт төлөөлөгчийн газар өөрийн иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны эрх ашгийг үндэсний болон тухайн улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний хүрээнд хамгаалах;

27.2.Монгол Улсаас гадаад улсад суугаа бүрэн эрхт төлөөлөгчийн газар өөрийн суугаа болон хавсран суугаа улсад амьдарч, ажиллаж, суралцаж байгаа иргэдийнхээ бүртгэл, судалгааг хөтөлж, тэдэнд шаардлагатай үед туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

27.3.иргэд гадаадад зорчих эрх зүйн таатай нөхцөл бүрдүүлэхийг эрмэлзэхийн зэрэгцээ тэд эх орондоо эргэн ирж, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахыг дэмжсэн бодлого хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлэх;

27.4.гадаадад гэрээгээр ажиллаж байгаа иргэдийнхээ нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр тухайн улстай хамтран ажиллах;

27.5.гадаадад байгаа иргэн гэнэтийн осол, халдлага, аюул, албадлагад өртөх, хүнд өвчин тусах, нас барах зэрэг тохиолдолд Монгол Улсаас тухайн улсад суугаа бүрэн эрхт төлөөлөгчийн газар бололцоотой туслалцаа, дэмжлэг шуурхай үзүүлэх;

27.6.гадаадад зорчиж байгаа иргэдийг хар тамхи, хүний наймаа зэрэг ноцтой гэмт хэрэгт өртөхөөс сэрэмжлүүлэх, ийм төрлийн хэрэгт холбогдож хохирогсдын эрхийг хамгаалах чиглэлээр тухайн улсын болон олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

27.7.гадаадад байгаа иргэддээ тэдний хууль ёсны эрх, эрх чөлөө, үүрэг, хариуцлагын талаархи болон шаардлагатай бусад мэдээлэл, зөвлөлгөө өгч байх;

27.8.гадаадад буй иргэдийн үүсгэл санаачилгын байгууллага, холбоодын үйл ажиллагааг дэмжиж ажиллах.

ДОЛОО. ГАДААД СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ

ХАРИЛЦАХ БОДЛОГО

28.Гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлого нь Монгол Улсын дотоод, гадаад бодлого, ардчилал, шинэчлэлийн үйл явцыг улс түмэнд сурталчлан таниулах, тэдэнд улс орныхоо талаар эерэг ойлголт, сэтгэгдэл төрүүлэх, найрсгаар хандан талархагчдын хүрээг өргөтгөх, иргэд хоорондын харилцаа, харилцан зорчих явдлыг нэмэгдүүлэхэд оршино.

29.Гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

29.1.Монгол Улсын түүх, соёлын уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын ололт амжилтыг гадаадад сурталчлах үйл ажиллагааг идэвхжүүлэх, гадаад сурталчилгааны бүтэц бий болгохыг дэмжих;

29.2.монголын түүх, байгаль, зан заншил, ахуй амьдрал, хөгжил дэвшлийг харуулсан сурталчилгааны ном, товхимол, нэвтрүүлэг, кино, цомог зэргийг бэлтгэн бусад улс түмэнд түгээх, сурталчлах;

29.3.хоёр талын харилцааны хүрээнд гадаадад Монгол Улсыг сурталчилсан өдрүүд зохион байгуулах, үзэсгэлэн, яармаг гаргах, кино, урлагийн тоглолт үзүүлэх, уулзалт, ярилцлага зохион байгуулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

29.4.гадаад сурталчилгааг сайжруулахын тулд бусад улс, олон улсын байгууллагын нэр хүндтэй хүмүүс, улс төр, нийгэм, соёлын зүтгэлтэн, сэтгүүлч болон хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;

29.5.Монгол Улсын талаар гадаадын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарч байгаа мэдээ, мэдээллийг судалж байх;

29.6.Монгол Улсын гадаад бодлого, гадаад харилцааны талаар олон нийт, хэвлэл, мэдээллийн байгууллагуудыг бодит мэдээллээр хангах, тэдний хүч бололцоог бусад улстай харилцаа, хамтын ажиллагаа хэвийн хөгжүүлэхэд чиглүүлэх;



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 13 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

Дугаар 52

**"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БАТЛАХ
ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1."Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ыг 1 дүгээр хавсралтаар, ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-г 2 дугаар хавсралтаар, ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-г 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
- 2."Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн дараагийн үе шатны хүрэх үр дүнтэй нийцүүлэн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг боловсруулж, Монгол Улсын Их Хурлаар батлуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай.
- 3.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай:

1/Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх;

2/Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах байнгын бүтэц, тогтолцоог бий болгох;

3/Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас баталсан дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэх арга хэмжээг авах;

4/"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцад 5 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Монгол Улсын Их Хуралд танилцуулах.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /С.Бямбацогт/-нд даалгасугай.

5."Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтууд нь агуулгаараа ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад тусгагдсан тул "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

6.Энэ тогтоолыг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

Хавсралтыг харах холбоос: ["Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай](#)



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 08 сарын 28 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

Дугаар 23

**МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ
ТУХАЙ**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1."Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг 1 дүгээр хавсралтаар, Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн, шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний болон техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт бүхий Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
- 2.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тухайн жилийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.
- 3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Л.Энх-Амгалан/-нд үүрэг болгосугай.
- 4.Энэ тогтоолыг 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

Хавсралтыг харах холбоос: [Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай](#)



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 08 сарын 28 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

Дугаар 24

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР
БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1."Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.
- 2.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:
 - 1/Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хамт баталж, хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах;
 - 2/Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилгыг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;
 - 3/Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийн үнэлгээ болон өрийн тогтвортой байдлын шинжилгээ хийх;
 - 4/Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан экспортыг нэмэгдүүлж, ажлын байр бий болгон иргэдийн орлогыг нэмэгдүүлж, эдийн засагт нөлөө үзүүлэх 10 томоохон төслийг санхүүгийн боломжит бүх арга хэрэгслийг ашиглан санхүүжүүлэх.
- 3.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт заасан шаардлагын дагуу Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.
- 4.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газартай үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллахыг Монголбанкны Ерөнхийлөгч, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг холбогдох бусад байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.
- 5.Энэ тогтоолыг 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

Хавсралтыг харах холбоос: [Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай](#)



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 30 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

Дугаар 106

ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1.Коронавируст халдвар /КОВИД-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийн суурийг тэлэх, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2 дугаар хавсралтаар, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хөгжлийн төслийн жагсаалтыг 3 дугаар хавсралтаар, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх хуулийн төслийн жагсаалтыг 4 дүгээр хавсралтаар, Монгол Улсын Их Хуралд 2022 онд үе шаттайгаар өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх хуулийн төслийн жагсаалтыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
- 2."Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүжилтийг улс болон орон нутгийн төсөв, бусад санхүүжилтийн эх үүсвэртэй уялдуулан төр-хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулагчдын идэвхтэй оролцоонд тулгуурлан зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д тус тус даалгасугай.
- 3."Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.
- 4."Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилтын хүрээнд төр, төр-хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх Хөгжлийн төслийн жагсаалтад тусгагдаагүй бусад төслийг дэмжиж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.
- 5.Энэ тогтоолыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

Хавсралтыг харах холбоос: [Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай](#)



Монгол Улсын Соёлын Яам

7-р хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол улс

Хэвлэл, мэдээллийн асуудлаар
холбоо барих: И-мэйл: info@mos.gov.mn

Ерөнхий асуудлаар хандах:
И-мэйл: info@mos.gov.mn

Шуурхай утас: 51265622
Факс: 976-11-51265622

